

С.Түмэндэлгэр, Э.Гэрэлт-Од, М.Дорж, Н.Мягмарцоож, Т.Нэмэхжаргал,
О.Өнөрцэцэг, Ц.Сэлэнгэ, У.Туяа, Э.Чулуунцэцэг, С.Энхцэцэг

НИЙГЭМ СУДЛАЛ XI

Ерөнхий боловсролын 12 жилийн
сургуулийн 11 дүгээр ангийн сурх бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

ННА 74.2
ДАА 373
Н-588

Нийгэм судлал XI: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 11 дүгээр ангийн сурх бичиг (С.Түмэндэлгэр., ба бус; Ред. О.Пүрэв - УБ. 2018. -196 х)

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурх бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурх бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99978-61-85-6

I БҮЛЭГ	НИЙГЭМ, НИЙГМИЙН ХАРИЛЦАА	5
Сэдэв 1.1	Нийгмийн давхраажилт	6
Сэдэв 1.2	Нийгмийн өөрчлөлт	29
	Бүлгийн дүгнэлт	37
II БҮЛЭГ	СОЁЛ	40
Сэдэв 2.1	Соёлын үйлдвэрлэл	41
Сэдэв 2.2	Соёлын даяаршил	47
Сэдэв 2.3	Соёлын адилсал гэж юу вэ?	56
Сэдэв 2.4	Соёлын эрх чөлөө	60
	Бүлгийн дүгнэлт	67
III БҮЛЭГ	ЭРХ ЗҮЙ	71
Сэдэв 3.1	Хүний эрх ба Үндсэн хууль	71
Сэдэв 3.2	Өмчлөх эрхийг хуулиар хамгаалах нь	76
Сэдэв 3.3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь	81
Сэдэв 3.4	Захиргаа, иргэдийн хоорондын маргааныг хянан шийдвэрлэх нь ...	86
Сэдэв 3.5	Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизм	92
	Бүлгийн дүгнэлт	103
IV БҮЛЭГ	ЭДИЙН ЗАСАГ	106
Сэдэв 4.1	Төр эдийн засгийг ямар бодлогоор зохицуулдаг вэ?	107
Сэдэв 4.2	Төрийн мөнгө, зээлийн бодлогын зорилго юу вэ?	110
Сэдэв 4.3	Гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого	115
Сэдэв 4.4	Гадаадын хөрөнгө оруулалт	121
Сэдэв 4.5	Эдийн засгийн хөгжил	129
	Бүлгийн дүгнэлт	134
V БҮЛЭГ	УЛС ТӨР	139
Сэдэв 5.1	Иргэний нийгэм, түүний мөн чанар, үндсэн шинж	140
Сэдэв 5.2	Сонгууль, сонгуулийн тогтолцоо	143
Сэдэв 5.3	Орчин үеийн нийгэм, улс төрийн үйл явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийн үзүүлэх нөлөө	150
Сэдэв 5.4	Улс төрийн институт	153
	Бүлгийн дүгнэлт	165
VI БҮЛЭГ	ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА	167
Сэдэв 6.1	Олон улсын харилцааны улс бус оролцогч	168
Сэдэв 6.2	Монгол улс ба ОУХ-ны улс бус оролцогчдын хамтын ажиллагаа	176
Сэдэв 6.3	Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого	179
Сэдэв 6.4	Зөөлөн хүчний бодлого	186
	Бүлгийн дүгнэлт	191

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж	МУИС	Монгол Улсын Их Сургууль
АОХН	Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг	НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
АНД	Ази, Номхон Далайн	НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр
АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ОУ	Олон улс
АПЕК	Ази, Номхон Далайн эдийн засгийн хамтын ажиллагаа	ОУБ	Олон улсын байгууллага
АСЕАН	Зүүн өмнөд Азийн бус нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг	ОУХ	Олон улсын харилцаа
АТГ	Авлигатай Тэмцэх Газар	ОХУ	Оросын Холбооны Улс
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс	ТТБ	Төрийн бус байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс	ТУХН	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс	ҮИХ	Улсын Их Хурал
БНТУ	Бүгд Найрамдах Турк улс	УША	Үрдьчилан шийдвэрлэх ажиллагаа
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг улс	ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ЕЭЗХ	Евразийн Эдийн Засгийн Холбоо	ХБО	Хөгжиж байгаа орон
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага	ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ЗХШ	Захиргааны хэргийн шүүх	ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс	ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага	ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны байгууллага
ИУТЭП	Иргэний улс төрийн эрхийн пакт	ШХАБ	Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар	ЭҮНХ	Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
		ЭСЯ	Элчин Сайдын Яам

ТАНИХ ТЭМДЭГ



Үйл ажиллагаа



Гэртээ хийгээрэй



Тулгуур ойлголт



Нэмж судлаарай



Даалгавар гүйцэтгээрэй



Өөрийгөө сориорой



Суралцахуйн зорилт	Тулгуур ойлголт
Нийгмийн судалгаа	
a. Нийгмийн талаарх тоон болон чанарлаг мэдээлэл цуглуулахыг мэдэж, тодорхой сэдэвт судалгаанд ашиглах	Статистикийн шинжилгээ
b. Нийгмийн талаарх өгөгдөл статистикийн болон чанарлаг судалгааны аргачлалаар дүн шинжилгээ хийх, хүснэгт, график, бүдүүвч, зураглалаар нэгтгэн илэрхийлэх	Чанарын судалгааны шинжилгээ
v. Нийгмийн талаарх баримтуудын тайлбар бичих	Нийгмийн тэгш бус байдал
g. Нийгмийн үзэгдэл, үйл явцад шинжилгээ ухаанч болон олон өнцгөөр хандаж байгаагаа аман, бичгэн хэлбэрээр нотлон харуулах	
Нийгмийн бүтэц, тогтвортой тал	
a. Нийгмийн давхраажилтын талаарх онолын тайлбаруудад тулгуурлан, нийгэмд өөрийн эзлэх байр суурь, түүнийг өөрчлөх суваг, боломжийг тодорхойлох	Нийгмийн давхраажилт
b. Монголын нийгмийн давхраажилтад холбогдох асуудлыг түүхчлэн судлах, холбогдох мэдээлэлд статистикийн болон чанарын шинжилгээ, дүгнэлт хийх	Нийгмийн нийтлэг
v. Нийгмийн категориуд (угсаатан, жендэр г.м)-ын талаар эх сурвалжийг судлан, тоон болон чанарын шинжилгээ хийн, тогтсон үзлийн талаарх нотлох, няцаах үндэслэлгээг дэвшүүлэх	Нийгэм, эдийн засгийн байр суурь
g. Өөрт болон бусдад тохиолдсон тэгш бус байдалд холбогдох асуудлыг шүүмжлэлт хандлагаар тодорхойлж, асуудлыг хэрхэн шийдэх тухай тодорхой саналаа нотлох	Байр суурийн эшилжилт
Нийгмийн өөрчлөлт	
a. Нийгмийн өөрчлөлтийн тухай онолын тайлбаруудын батлах, няцаах үндэслэлийг баримт түшиглэн дэвшүүлэх	Нийгмийн өөрчлөлт
b. Эх сурвалжийг судлан, нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөгч хүчин зүйлийг тодруулан, эрэмбэлэх, өөрийн үзэл бодлын үндэслэлийг хамгаалах	Хувьсал
v. Эх сурвалжийг судалж, нийгмийн хэв маяг тус бүрт илрэх онцлог хийгээд нийтлэг талыг тодруулан, шалгууруудын талаар санал дэвшүүлэх	Хувьсгал
g. Нийгмийн өөрчлөлт нь хувийн амьдралд хэрхэн нөлөөлөхийг ойлгож, хувийн амьдрал хийгээд нийгмийн дэвшлийн төлөөх өөрийн оролцооны боломж, хувилбаруудыг дэвшүүлэх	Нийгмийн хэв маяг

СЭДЭВ 1.1 НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ

Бид өмнөх ангидаа хувь хүний үйлдэл, нийгэм, нийгмийн бүтцийн уялдаа холбоог байр суурь, үүрэг, үүргийг хүлээн авах, институт зэрэг ойлголтыг ашиглан тайлбарлах, өөрт тохиолдсон хүндрэл бэрхшээлийг даван туулах боломж өөрөөс нь болон нийгмээс шалтгаалдаг болохыг ялган тодорхойлж, өөрийн дүгнэлтэд хүрэх чадварт суралцсан билээ. Энэхүү мэдлэг, чадвартай тулгуурлан XI ангидаа нийгмийн гарлын ялгаа нь хувь хүний байр суурь, боломж, хүндрэл бэрхшээлд хэрхэн нөлөөлдөг болохыг судалж, өөрийн давхраажилт, нийтлэгийн байр сууриа тодорхойлох, байр сууриа өөрчлөх суваг, боломж, асуудал, хүндрэл бэрхшээлээ тодорхойлох, дүгнэлт, саналаа хамгаалах чадварт суралцана.

ХҮМҮҮС ХООРОНДЫН ЯЛГАА ЮУНААС УЛБААТАЙ ВЭ?



Үйл ажиллагаа 1.1 Эх сурвалжийг шинжлээрэй.

Америкийн судлаач Θ.Күүс 1990-ээд онд нийгэм, эдийн засгийн ялгаа бүхий гурван ангийн хүмүүс өөрсдийн өвчиний шинж тэмдгийг хэрхэн тайлбарладаг болохыг судалжээ. Тэрээр нэг дэх анgid өдийн засаг, санхүүгийн хувьд хамгийн амжилттай байгаа, хоёр дахь ангид цалингаараа амьдардаг дундаж хэсгийнхнийг, гурав дахь ангид ур чадвараар бага, даржин амьдралтай хэсгийнхнийг багтаан судалсан байна. Нэг дэх ангийн хүмүүс өвчиний нэг шинж тэмдэг илрэхэд эмчид хандаж эрүүл мэндийн үйлчилгээ авахаар эрэлхийлэхэд бэлэн байсан бол харин гурав дахь ангийн хүмүүсийн 75 хувь нь өвчиний 17 шинж тэмдгийн 10 шинж тэмдгийг эмнэлэгт үзүүлэх ноцтой шинж биш гэж үзжээ. 2013 онд ЭМШУИС-аас хийсэн судалгаагаар бага орлоготой хүн ам, хөдөөгийн малчид, оюутан залуус эрүүл мэндийн үйлчилгээний бодит хэрэгцээ тулгарах үед эмнэлгээр үйлчлүүлдэг болох нь тогтоогджээ (Эх сурвалж: С.Мөнхбаатар, О.Мөнхбат, 2017: 92-93).

Асуулт:

1. Нийгмийн гишүүдийн эрүүл мэндийн үйлчилгээ авах зан үйлд юу нөлөөлж байна вэ?
2. Θ.Күүс нийгмийн гишүүдийг гурван ангид хуваан судалсны учир юу вэ?
3. Анги гэдгийг юу гэж ойлгож байна вэ?

Бие махбодид бактери, вирус нэвтэрснээр “Өвчин эмгэг” үүсдэг гэх нь зөвхөн физиологи, биологийн талаас хийж буй тайлбар, харин түүнд нөлөөлөгч нийгмийн хүчин зүйлсийг орхигдуулж буй хэрэг юм. Судлаач Θ.Күүсийн судалгаа нь ангийн ялгаа эрүүл мэндийн үйлчилгээ авах үйлдэл, хандлагын ялгаанд хүргэдэг болохыг нотолсон олон судалгааны эхлэл болжээ. Тухайлбал, социологич Д.Датон ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ бага эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа нь нэгдүгээрт санхүүгийн боломж, хоёрдугаарт, ядуусын соёл, гуравдугаарт, нийгмийн институтийн саад бэрхшээлтэй холбоотой хэмээн дүгнэжээ.

Эрүүл мэндийн үйлчилгээ авах эсэх, өвчин эмгэг нь нийгмийн ангийн харьяллаас хамааралтай гэж үзэж байгаагийн учир юу вэ? Та бүхэн 10 дугаар ангидаа хүн бүр нийгэмд янз бүрийн байр суурь эзэлж, түүнээс хамаарсан эрх эдэлж, үүрэг хүлээж, бусад хүмүүс тэрхүү байр сууриас тань хамааруулан харилцдаг тухай судалсан билээ. Ямар байр суурь эзэлж байгаагаасаа хамааран шийдвэр гаргахад оролцох боломжоор нийгмийн гишүүд харилцан адилгүй байна. Жишээ нь, үйлдвэрт ямар

машин техник авах вэ гэдгийг шийдэхэд жирийн ажилчин хүн оролцох боломжоор хомс бол инженер техникийн ажилтан, менежерүүдийн хувьд саналаа илэрхийлэх, цаашлаад шийдвэр гаргахад шууд оролцож байдаг.

Эзэлж буй байр суурь нь цалин хөлс, орлогын хэмжээнд нөлөөлж байна. Жишээ нь, менежер, мэргэжилтний ажлын байранд ажиллагсдын дундаж цалин улсын дунджаас 100 мянган төгрөгөөр илүү байна. Ямар байр суурь эзэлж байгаагаасаа хамаараад хүмүүсийн хүндэтгэлийг хүлээх нь харилцан адилгүй. Цалин орлогоор өндөр биш ч, эмч, багшийг олон хүн хүндэтгэдэг. Ийнхүү байр сууриуд нь баялаг, алдар хүнд, нөлөөлөл, хүндэтгэл, эрх мэдэл зэрэг үнэ цэнтэй бүхнийг олж авах адил бус боломжороо ялгаатай, тэгш бус нөхцөлд байрладаг.




Үйл ажиллагаа 1.2 Зургийг ажиглаж асуултад хариулаарай.

Асуулт:

Үнэ цэнтэй зүйлд хүрэхэд дараах хүчин зүйл ямар нөлөөтэй вэ?

- a. Нийгмийн гарал
- b. Боловсрол
- c. Шаргуу хөдөлмөр, хичээл зүтгэл



Бид 10 дугаар ангидаа нийгмийн гишүүд нь харилцан адилгүй байр суурь эзлэн, үүргээ хэрэгжүүлэх замаар амьдардаг нь харилцан бие биенийхээ хэрэгцээг хангаж, эмх цэгц, зохион байгуулалттайгаар амьдрах нөхцөлийг бурдуулдэг тухай судалсан. Эх сурвалж 1.2-ыг ажиглахад нийгмийн гишүүд ялгаатай байр суурь эзэлж, үүрэг гүйцэтгэх нь гарцаагүйн адил байр суурийн ялгаа нь боломжийн ялгаа буюу тэгш бус байдалд хүргэх зайлшгүй мөн чанартай болохыг харуулж байна. Нөгөө талаас ямар байр суурьд хүрэх вэ гэдэг нь хувийн болон институтийн хүчин зүйлсээс хамаардаг. Тодруулбал, зарим хүн спорт, урлагийн авьяастай төрж, түүнийгээ хичээл зүтгэл, хөдөлмөрөөрөө тэтгэсний үр дүнд түмэн олноо гайхшуулсан амжилтад хүрдэг. Энэ нь түүний авьяас чадвар, хичээл зүтгэл, шаргуу хөдөлмөр гэсэн хувийн хүчин зүтгэлээс хамаарч байна. Гэтэл маш олон хүн ямар авьяастайгаа мэдэхгүй, мэдсэн ч ашиглаж чадалгүй өнгөрөх нь бий.

Хувь хүнээс өөрөөс нь үл шалтгаалсан нөлөөлөгч хүчин зүйлийг *институтийн (нийгмийн) хүчин зүйл* гэдэг. Эх сурвалж 1.1-д өгүүлсэн эрүүл мэндийн үйлчилгээг авах зан үйл нь институтийн хүчин зүйлээс хамаарч, ангиудад ялгаатай илэрч байна.



Үйл ажиллагаа 1.3 Асуултын дагуу ярилцаарай.

Үйл ажиллагаа 1.1 дэх эх сурвалжийг дахин уншаад дараах асуултад хариулаарай.

Асуулт:

1. **Нийгмийн гишүүдийн эрүүл мэндийн үйлчилгээ авах зан үйлд ангийн ялгаа илэрч байгааг ямар хүчин зүйлстэй холбон тайлбарлаж болох вэ?**
2. **Нийгмийн гишүүдийн ангийн ялгаа эрүүл мэндийн үйлчилгээ эрэлхийлэх зан үйлд нөлөөлж байгаа нь ямар үр дагавартай байж болох вэ?**

Тэгш бус байдал хүний нийгмийн бүхий л түүхийн үед оршсоор ирсэн. Эртний хүмүүсийн хооронд хөрөнгө чинээний ялгаа бараг байгаагүй ч, хэн илүү бяр чадалтай, зоригтой, овсгоотой эсвэл дээд тэнгэр, эзэн сүлдтэй харилцаж, ид шидийг үзүүлж чадаж байна тэр бусдаасаа илүү хүндэтгэл хүлээдэг байв. Их Монгол улсын үед Чингис хааны удмын язгууртнууд өндөр байр суурь эзэлж, үндэсний төдийгүй улс дамнасан шийдвэрийг гаргаж байв. Ийнхүү тэгш бус байдал нь түгээмэл, зайлшгүй мөн чанартай.



Тулгуур ойлголт

Нийгмийн ялгарал гэдэг нь нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдахыг хэлнэ.

Тэгш бус байдал гэдэг нь эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдлыг хэлнэ.

Нийгмийн давхраажилт гэдэг нь тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо.

Нийгмийн давхраа гэдэг нь баялаг, нэр хүнд, эрх мэдлийн хувьд ялгаатай, тодорхой хэв шинжит харилцаа бүхий нийгмийн нийтлэг.


Нийгмийн нийтлэг гэдэг нь ижил төстэй шинж бүхий хүн амын статистик нэгдэл.

Хүмүүс хоорондын тэгш бус байдлыг институтийн (бүтцийн) хүчин зүйлстэй холбон авч үзэхдээ нийгмийн давхраажилт гэдэг ойлголтыг социологид хэрэглэдэг. Нийгмийн давхраажилт нь тэгш бус байдал бэхжиж, тэгш бус бүлгүүдийн хооронд тодорхой хэв шинж бүхий харилцаа бүрэлдэн тогтсоны үр дүн юм. Зарим социологичид нийгмийн гишүүдийн хоорондын тэгш бус нөхцөл байдал нэг үеэс нөгөө үед залгамжлагдсанаар давхраажилт бүрэлдэн тогтдог гэж үзсэн бөгөөд тэдгээр бүлгүүдийн хооронд институтийн (бүтцийн) ялгаа бүрэлдэн тогтсоноор тодорхой хэв маягийн давхраажилтын тогтолцоо төлөвшин тогтдог байна. Та бүхэн түүхийн хичээлээр дундад

зууны үед өрнө дахинд газрын эзэн хийгээд тариачин хооронд газрын түрээсийн, аж үйлдвэржсэн нийгэмд ажилчин хийгээд капитальын эзэн хооронд хөлсний хөдөлмөрийн харилцаа оршин байдаг тухай судалсан. Дурдсан давхраа хоорондын харилцаанд тодорхой бичигдмэл хийгээд бичигдмэл бус хэм хэмжээ, зохицуулалт хэвшин тогтсон байх ба энэ нь хүний амьдрал, үйл ажиллагаанд хувийн хүчин зүйлийг даван нөлөөлдөг. Энэ бүгд бол давхраажилтын үндсэн шинж мөн.

НИЙГЭМД ДАВХРААЖИЛТ ТОГТОХ УЧИР ШАЛТГААН ЮУ ВЭ?

Нийгэмд тэгш бус байдал, давхраажилт оршин байгаагийн шалтгааныг социологийн онолын хандлагууд ялгаатай тайлбарладаг. Юуны түрүүнд социологийн сонгодог үеийн төлөөлөгч болох К.Маркс, М.Вебер нарын үзэл баримтлалыг авч үзье. Тэдний дэвшүүлсэн үзэл санаа нь орчин үеийн социологи дахь нийгмийн давхраажилтын онолын ялгаатай хандлагуудыг төлөвшүүлэхэд нөлөө үзүүлсэн юм.



К.Маркс. Капитал (1867-1894), Коммунист намын тунхаг (1848) зэрэг бүтээлдээ К.Маркс давхраажилтын асуудлыг хөндсөн байдаг. Түүнийхээр анги бол үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцаа (өмчлөх харилцаа), түүнээс хамааруулан амьдрах нөхцөлөө бүрдүүлэх аргаараа ялгаатай нийгмийн томоохон бүлэг юм. Жишээ нь, капиталист нийгэмд үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөгч капиталист, амь зуухын тулд хөдөлмөрөө капиталистуудад зарж буй ажилчин анги гэсэн үндсэн хоёр том анги, шилжилтийн буюу завсрлын бусад анги оршин байна. Капиталистууд өөрийн өмч болох үйлдвэрлэлийн хэрэгсэл дээрээ ажилчдыг хөлслөн ажиллуулж, баялгийг бүтээдэг бөгөөд тэрхүү баялгийн ихэнх хувийг өөртөө үлдээж, харин ажилчдад өчүүхэн хувийг хөдөлмөрийн хөлс нэрийн дор өгөх замаар мөлждөг хэмээн үздэг. Ангийн ялгаа нь ашиг сонирхлын ялгаанд хүргэдэг. Энэ нь ангийн зөрчилд хүргэх ба ангийн зөрчил нь нийгмийн өөрчлөлтийн хөдөлгөгч хүч болдог гэжээ. Капитализм дахь цөөнх баяжиж, олонх ядуурсан төлөв нь ангийн зөрчлийг хурцатгаснаар тэгш байдлыг тогтоох өргөн олны хувьсгалт тэмцлийн түүхэн нөхцөл бүрдэнэ хэмээн үзсэн. Хэдийгээр түүний энэхүү үзэл санаа нь бодит байдал дээр биелээгүй ч ажилчинангийн эрх ашгийг анхаарах ёстойг сануулснаараа ач холбогдолтой. Түүний үзэл санаа нь орчин үеийн зөрчилдөөний болон шүүмжлэлт онол хөгжихэд түлхэц үзүүлсэн.



М.Вебер. “Анги, статус, нам” (1920) бүтээлдээ М.Вебер давхраажилтын асуудлыг хөндсөн. Тэрээр ангийн ялгааг авч үзэхдээ өмчөөс гадна орлого, эрхэлж буй ажил мэргэжил гэсэн эдийн засгийн бусад хүчин зүйлсийг чухалчилж үзжээ. Түүнчлэн тэрээр давхраажилтын судалгаанд статусын бүлэг, намын ялгарлын асуудлыг судалсан. Статусын бүлэг нь нийгмийн бүлгүүдийн нэр хүндийн ялгаралтай холбоотой. Их хэмжээний баялгийг шинээр олж авсан баяныг бус, харин ядуурч хоосорсон язгууртныг хүмүүс илүүтэй хүндэтгэдэг нь нийгэм бүрд ажиглагддаг. Тэгэхээр статусын бүлгийн гол онцлог нь нийгмийн бүлгүүдийн нэр хүндийн субъектив үнэлгээгээр тодорхойлогддогт оршино.

Нам нь ашиг сонирхлоороо ялгаатай бүлэг хүмүүс бөгөөд эрх мэдлийн ялгарлыг илтгэнэ. Тэрээр нийгмийн зөрчил нь зөвхөн ангийн ялгаанаас гадна шашин, үзэл суртал, итгэл үнэмшил зэргээс ч хамаардаг, төгсгөлгүй шинжтэй, зөвхөн хэлбэрт нь өөрчлөлт гардаг гэжээ. Түүний үзэл санаа нь давхраажилтын талаарх бүтэц чиг үүргийн онол, зөрчилдөөний онол зэрэг орчин үеийн онолын хандлага бүрэлдэн тогтоход ихээхэн үүрэг гүйцэтгэжээ.

ОРЧИН ҮЕД НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТЫГ ХЭРХЭН СУДАЛЖ БАЙНА ВЭ?

Зөрчилдөөний онол нь Марксын ангийн ялгаа нь ашиг сонирхлын ялгаа, улмаар зөрчилд хүргэдэг гэсэн санаанд тулгуурладаг ч ангийн ялгарлыг өмчийн гэхээсээ эрх мэдлийн ялгаатай түлхүү холбон үзсэн. Ашиг сонирхлын ялгаа нь зохион байгуулагдсан шинжтэй эрх мэдлийн (бюрократ байгууллага болон улс төрийн) бүтцэд тусгалаа олдог. Орчин үеийн нийгэмд бюрократ байгууллагад эрх мэдэл ажилтнуудад тэгш бусаар хуваарилагдсан байдаг нь ноёрхогч хийгээд дагач гэсэн хоёр ангид хуваагдахад хүргэдэг. Байгууллагад хувь хүмүүс материалыг урамшуулал авах, эрх чөлөөтэй байх, нэр хүндтэй байх, чөлөөт цаг ихтэй байх зэрэг олон янзын ашиг сонирхолтой байна. Харин тэрхүү ашиг сонирхлоо хэрэгжүүлж чадах эсэх нь эрх мэдэлд хүрч чадаж буй эсэхээс хамаардаг. Эрх мэдэл бүхий хэсэг өөрийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх давуу нөхцөлд байх бол бусад нь тэрхүү ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээр хүчин зүтгэх нөхцөлд байна.

Харин неомарксистууд буюу **шүүмжлэлт онолынхон** К.Марксын санааг М.Веберийн үзэл баримтлааар засах оролдлого хийдэг буюу өмчөөс гадна эрх мэдлийн ялгарлыг чухалчилдаг. Тэд төр нь ноёрхогчангийн эрх ашгийг хэрэгжүүлж байдаг гэж үздэг. Марксын үзэл санаанд тулгуурлан, М.Веберийн үзэл санааг харгалзан нийгмийн давхраажилтыг судалсан судлаач бол Е.О.Райт юм. Тэрээр К.Марксын үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцаа (өмч)-ны ялгарлыг чухалчилсан үзэл санааг үйлдвэрлэлийн харилцаан дахь М.Веберийн “хянах” эрх мэдлийн үзэл санаагаар баяжуулан судалсан юм. Судалгааны үр дүнд капиталист, менежер, ажилчин, жижиг хөрөнгөтөн гэсэн дөрвөн ангийг тодорхойлсон. Түүнийхээр капиталист нь үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөгч, бусдын хөдөлмөрийг хөлслөгч, бусдын хөдөлмөрийн үйл ажиллагааг хянач юм. Менежер нь өөрийн хөдөлмөрөө борлуулагч, капиталистуудын төлөө бусдын хөдөлмөрийн үйл ажиллагааг хянач. Ажилчин нь өөрийн хөдөлмөрөө капиталистад борлуулагч, хянах эрх мэдэл үгүй анги юм. Харин жижиг хөрөнгөтөн нь өөрийн үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөгч, цөөн ажилтан хөлслөх тохиолдолд тэдний хөдөлмөрийн үйл ажиллагаанд хяналт тавигч, эсвэл ажилтангүй тохиолдолд хяналт тавих эрх мэдэлгүй анги хэмээн үзсэн.

Бүтэц-чиг үүргийн онолын хандлагын төлөөлөгчид тухайлбал, Э.Дюркгейм нарын социологичид анхнаасаа нэр хүнд, ажил мэргэжлийн байр суурийн ялгарлыг нийгмийн давхраажилтын суурь шалтгаан гэж үздэг. Тэд хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүргэх үндсэн шалтгаан гэжээ.

Т.Парсонс тухайн нийгэмд зонхилж байгаа үнэлэмжийн дагуу хүмүүс бусад хүмүүсээрээ үнэлэгдэж, зэрэглэгдэж байдаг. Тэгэхээр бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршин байдаг. Нийгмийн институтууд нь нийгмийн оршин тогтолын төлөө ялгаатай чиг үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тухайн нийгмийн үнэлэмжийн дагуу тэдгээрийг үнэлдэг бөгөөд энэхүү үнэлгээний түвшнээрээ ялгагдана. Жишээ нь, ер бусын хүчинтэй харилцахыг онцгой чухал гэж үзэх нийгэмд шашны зүтгэлтэн, санваартан, бөө, шидтний байр суурь илүү өндөрөөр үнэлэгдэнэ. Бүтэц-чиг үүргийн онолд Дэвис ба Мур нарын онол чухал үүрэгтэй. Тэдний судалснаар нэг хэсэг байр суурь нь бусдаас илүү чухал бөгөөд илүү өндөр ур чадварыг шаарддаг, хүмүүсийн сонирхлыг татахын зэрэгцээ илүү хүндлэл хүлээж байдаг. Тухайн нийгэмд чухал

бөгөөд илүү нарийн ур чадвар шаардах хөдөлмөрийн нийлүүлэлт бага байх тохиолдолд хөдөлмөрийн зах зээлд илүү өндөрөөр үнэлэгддэг гэж үздэг.

Бүтэц-чиг үүргийн онолын үүднээс Янки хотын нийгмийн давхраажилтыг судалсан судлаач бол Л.Уорнер юм. Тэрээр хувь хүний ангийн харьяллыг нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хэмжих бус, харин бусад хүмүүсийн зүгээс үнэлэх нэр хүндийн субъектив үнэлгээ, хүндлэлээр хэмжих загварыг боловсруулсан юм. Тодруулбал, дэлгүүрийн эзэн, эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзнээс дээд ангид оруулж судална. Энэхүү аргачлалыг цөөн хүн амтай орон нутагт ашиглах болох ч томоохон хот сууринд ашиглахад хүндрэлтэй юм. Ажил мэргэжлийн нэр хүндийг тодорхойлоходоо объектив шалгуурыг ашиглах үүднээс Дункан нийгэм, эдийн засгийн индексийн аргачлалыг боловсруулсан. Энэхүү аргачлал нь ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.



Үйл ажиллагаа 1.4 Багийн ажил

Тус үйл ажиллагааг үргэлжлүүлэн судалгаа хийх тул багаар (6 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй) гүйцэтгээрэй.

- Хувь хүний нийгмийн давхраажилтын байр суурийг тодорхойлох талаар социологийн онолууд ямар санаа дэвшүүлсэн болохыг дүгнээрэй.

Сонгодог үеийн сэтгэгчид		Орчин үйин онолууд		
Төлөөлөгч	Гол санаа	Онолын хандлага	Төлөөлөгч	Гол санаа
К.Маркс		Функциональ зөрчилдөөний онол		
М.Вебер		Шүүмжлэлт онол		
Э.Дюркгейм		Бүтэц чиг үүргийн онол		

- Социологийн онолын тайлбаруудын уялдаа холбооны талаар бүдүүвч боловсруулаарай.



Гэртээ хийгээрэй. Давхраажилтыг судлах онолын хүрээг тодорхойлоороой

Өөрийн оршин суугаа баг/хорооны нийгмийн давхраажилтыг судлахын тулд аль онолын хандлага, хэний боловсруулсан аргачлалыг ашиглахаар сонгож байгаа үндэслэлээ тайлбарлан бичээрэй. Дараах дарааллын дагуу тухайн онолын хандлага, төлөөлөгчийн үзэл баримтлалд тулгуурлах ёстойг анхаараарай.

- Социологийн сонгодог үеийн төлөөлөгчийг сонгоё. Түүний тайлбараас үндэслэн бичээрэй.
- Социологийн орчин үеийн онол, түүний төлөөлөгчөөс сонгож, сонгосон үндэслэл, тайлбарыг бичээрэй.
- Өөрийн баг, хорооны давхраажилтыг тодорхойлох судалгааны асуултыг дэвшүүлээрэй.

ДАВХРААЖИЛТЫН ЯМАР ХЭВ МАЯГУУД БАЙДАГ ВЭ?

Социологийн бүхий л суралчилгээний бичигт боолчлол, каст, язгуур, анги гэсэн давхраажилтын дөрвөн хэв маягийг тайлбарласан байдаг. Нийгэм өөрчлөгдхөхтэй зэрэгцэн нийгмийн давхраажилт өөрчлөгддөг. Тухайлбал, түүхийн эртний үед боолчлол, дундад зууны үед язгуур, аж үйлдвэржилтийн үед ангийн давхраажилтын тогтолцоо оршин байжээ. Гэхдээ эдгээр нь тодорхой үндэстний түүхийн онцлогоос хамааран бүрэлдэн тогтох, өөрчлөгджэх ирсэн юм.

Боолчлол. Боолчлол нь иргэний эрхтэй эсэхээр ялгагддаг, нэг нь нөгөөгийнхөө өмч нь болж байдаг, албадлагын хөдөлмөрийн харилцаанд тулгуурласан, байр сууриа өөрчлөх боломжоор хомс давхраажилтын хэв маяг. Дайн байлдаан, өр төлөөс эсвэл тоталитар дэглэмийн нөлөөгөөр боолчлол үүсэж байсан. Боолчлол нь эртний Грек, Ром, 1850 он хүртэлх Америкийн өмнөд, ХХ зуунд Германы нацист, ЗХУ-ын коммунист хориц лагерьт байсан гэж судлаачид дүгнэдэг. Энэ бүгдэд хүний үндсэн болон иргэний эрхийг нь хязгаарлаж, албадлагын хөдөлмөрийн харилцаа оршин байсантай холбоотой. Өнөө үед боолчлолыг хууль ёсоор халсан ч, хүний наймаанд цөөн биш хүн өртөж байгааг боолчлол далд хэлбэрээр оршиж байна гэж дүгнэж болно.

Язгуур. Энэ нь улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээрээ ялгаатай, эрх зүйн хувьд баталгаажсан, хаалттай давхраажилтын хэв маяг. Энэ давхраажилтын тогтолцооны үед нийгэмд эзлэх байр суурь нь угсаа залгамжлах замаар олгогддог онцлогтой. Давхраа харгалзалгүйгээр гэрлэх нь харьцангуй нээлттэй, мөн онцгой гавьяяа байгуулах эсвэл хэргэм зэргийг худалдаж авах замаар байр сууриа өөрчлөх боломжтойгоороо онцлог. Язгуур нь дундад зууны үед оршин байсан бөгөөд улс орнуудад өөр өөрийн онцлогтойгоор оршиж байжээ.

Каст. Каст нь гол төлөв Азийн улс орнуудын давхраажилтын уламжлалт хэв маягийн нэг. Шашны номлол дахь хөдөлмөрийн хуваарийг тогтоосны дагуух, хувийн байр суурийг өөрчлөх боломжгүй хаалттай давхраажилтын хэв маяг бол каст юм. Мөн каст нь гэрлэх хосоо зөвхөн тухайн кастын хүрээнээс сонгодог эндогами гэрлэлтийн хэлбэртэй. Энэ нь Энэтхэг, Балба, Пакистан, Шри Ланк, Индонези зэрэг орны давхраажилтын тогтолцоонд илэрдэг байна.

Анги. Энэ нь эдийн баялгаар ялгаатай, хувийн байр сууриа өөрчлөх боломжтой нээлттэй давхраажилтын хэв маяг. Социологичид орчин үеийн нийгэмд эдийн засгийн баялаг, орлогын хэмжээ, ажил мэргэжлээр ялгагдах дээд, дунд, доод ангиас аливаа нийгэм тогтдог хэмээн тайлбарладаг. Эдийн засгийн баялгийн өсөлт нэмэгдэж, тэрхүү өсөлтийн хуваарилалт шударга явагддаг нийгэмд дундаж ангийнхны эзлэх хувийн жин нэмэгддэг байна. Баялгийн шударга бус хуваарилалт бүхий нийгэмд цөөнх хэсэг баялгийн ихэнхийг хүртэж, олонх хэсэг ядуу амьдардаг.



Үйл ажиллагаа 1.5 Мэдээллийг асуултын дагуу шинжилж, хэлэлцээрэй.

- Дээдийн дээд анги.** Тун бага хувийг эзэлдэг ч баялгийн дийлэнхийг эзэмшдэг. Энэ ангийн байр суурь нь үе залгамжилдаг.
- Дээдийн доод анги.** Тун цөөн хувийг эзэлнэ. Энэ ангийн байр суурь харьцаангуй нээлттэй байдгаараа ялгаатай.
- Дундын дээд анги.** Энэ нь өндөр боловсролтой, нарийн мэргэжсэн мэргэжилтнүүдийн анги. Их хэмжээний баялаг эзэмшихгүй ч, өндөр орлоготой, хянах, шийдвэрт оролцох эрх мэдэлтэй цагаан захтанууд энэ ангид багтдаг.
- Дундын дунд анги.** Энэ ангид мэргэжилтэн, жижиг бизнес эрхлэгч, инженер техникийн ажилтан зэрэг цагаан захтан, нарийн мэргэжсэн хөх захтан багтдаг.
- Ядуу ажилчин анги.** Маш бага орлоготой, мэргэжилгүй, энгийн ажил эрхэлдэг ажилчид энэ ангийг бүрдүүлдэг.
- Доод анги.** Энэ анги нь бага боловсролтой эсвэл боловсролгүй, хөдөлмөр эрхлэх чадвар муутай, өөртөө итгэх итгэлгүй, маш бага орлоготой эсвэл тогтмол орлогын эх үүсвэргүй хүмүүсээс бүрддэг. Тэд нийгмийн халамжаас хамааралтай амьдардаг.
- Ёроолын хэсэг.** Орон гэргүйчүүд, хар тамхи, архинд донтогсод зэрэг нийгмийн бүхий л үйлчилгээ, тусламжаас гадна амьдардаг, гадуурхагдсан, шоовдорлогдсон хүмүүс.

Асуулт:

- Тус мэдээлэл юуны тухай өгүүлж байна вэ?
- Эдгээр анги нь ямар, ямар шинжээр өөр хоорондоо ялгагдаж байна вэ?
- Эдгээр анги нь түүхэн үе бүрд байсан уу?
- Даёхраа бус анги гэсэн ойлголтыг хэрэглэсний учир юу вэ?



Тулгуур ойлголт

Анги гэдэг нь нэг талаас эдийн баялгаар ялгаатай, хувийн байр сууриа өөрчлөх боломжтой, нээлттэй давхраажилтын хэв маяг, нөгөө талаас орчин үеийн нийгмийн давхраажилтыг бүрдүүлэх эдийн баялаг, нэр хүнд, эрх мэдлээр ялгаатай давхраа юм.

Цагаан захтан анги гэдэг нь оюуны хөдөлмөр эрхлэгч анги бөгөөд үүнд удирдлага, менежер, мэргэжилтэн, туслах, гүйцэтгэх, техникийн түвшний оюуны хөдөлмөр эрхлэгчид бүгд багтана.

Хөх захтан анги гэдэг нь биеийн хөдөлмөр эрхлэгч анги бөгөөд нарийн ур чадвар шаардах биеийн хүчний ажилчдаас эхлээд тусгай бэлтгэл, ур чадвар үл шаардах энгийн ажил эрхлэгчид багтана.

НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ ДАХЬ БАЙР СУУРИЙГ ХЭРХЭН ТОДОРХОЙЛОХ ВЭ?

Орчин үеийн социологийн давхраажилтын судалгаанд давхраажилтыг эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэл гэсэн гурван хэмжигдэхүүнээр авч үздэг.



Бүдүүвч 1.1 Нийгмийн давхраажилтын хэмжигдэхүүн

Хувь хүн, өрхийн эдийн засгийн байр суурийг тодруулахад “юу өмчилдөг” болохыг тодруулах нь чухал. Үүнд баялагт хувьцаа, хадгаламж, газар, үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, орон байр гээд үл хөдлөх хөрөнгө зэрэг үнээр илэрхийлэгдэх бүх хөрөнгийн өмчлөл багтдаг байна. Мөн ашиг, орлогыг асуудаг. Байгууллагын хүрээний шийдвэрт хөрөнгө эзэмшигч оролцох, нөлөөлөх боломжтой бол жирийн ажилтан тэрхүү шийдвэрийг хэрэгжүүлэх үүргийг хүлээх замаар тэдгээрийн хооронд эрх мэдлийн ялгаа илэрнэ. Мөн хөрөнгөтэй хүн олны танил болж, бусад хүмүүсийн хүндлэлийг хүлээдэг.

Нэр хүнд нь нийгмийн бусад гишүүдийн зүгээс олж авсан хүндэтгэл, нэр төр, алдар хүнд, хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэргийг багтаадаг субъектив шинжтэй юм. Хэн нэгний нэр хүнд нь шууд мэдрэгдэхүйц зүйл биш боловч бусдын зүгээс хэрхэн тодорхойлж, үнэлж байна вэ гэдгээр тодорхойлогддог. Нэр хүндийн ялгаатай бүлгүүд нь материаллаг хэрэглээ, амьдралын хэв маягаар басхүү ялгаатай. Нэр хүнд нь тухайн хувь хүний эрхэлж буй ажил мэргэжил, авьяас чадвар, эрдэм боловсрол, гарал угсаа, уламжлал зэргээс хамаардаг. Зарим ажил мэргэжил нь өндөр боловсрол, нарийн ур чадварыг шаарддаг. Ийм төрлийн ажил эрхэлдэг хүнийг бусад нь илүүтэй хүндэтгэнэ. Нэр хүндтэй ажил эрхэлснээр орлого олох, баялаг эзэмших, эрх мэдэлд хүрэх боломж нээгддэг. Мөн хаан, язгууртан угсааны нэр хүнд нь бусдын хүндэтгэлийг хүлээж байдаг.

Эрх мэдэл нь улс төрийн шахалт, нөлөөлөл, хувийн болон албан ёсны алдар хүндийг багтаадаг ойлголт. Эрх мэдэл нь юуны түрүүнд тодорхой хувь хүн бусдаасаа илүү хүчтэй, давуу байхтай холбоотой. Мөн эрх мэдлийг тодорхой субъектэд тулган хүлээлгэсэн, хууль ёсоор олгосон, хүлээн зөвшөөрөгдсөн эрх хэмжээгээр тодорхойлно. Энэ нь хэн шийдвэр гаргах, хянах, нөлөөлөх эрхтэй байгаагаар илэрхийлэгдэнэ.

Эдийн засгийн давуу байдал нь эрх мэдэлтэй болоход нөлөөтэй. Тухайлбал бюрократ байгууллагад өмчлөгч нь шийдвэр гаргах, хяналт тавих эрх мэдэлтэй байдаг. Мөн нэр хүнд нь эрх мэдлийн өөр нэгэн эх сурвалж болно. Олон нийтэд алдартай хэн нэгэн өөрийн хүсэл зоригоо бусдаар гүйцэлдүүлж чаддаг. Ийнхүү эдийн засаг, нэр хүнд, эрх мэдэл гэсэн давхраажилтын үндсэн хэмжигдэхүүн нь өөр хоорондоо харилцан холбоотой.



Тулгуур ойлголт

Бюрократ байгууллага. Албан тушаалын шаталсан бүтэц бүхий, албан тушаалтны эрх, үргийг албан ёсны хэм хэмжээгээр тогтоосон байгууллага.

Эдийн засгийн баялаг, эрх мэдэл, нэр хүнд гэсэн давхраажилтын З хэмжигдэхүүнээр хүмүүсийн байр суурийг шууд тодорхойлоход нэн төвөгтэй. Иймд хувь хүний давхраажилт дахь байр суурийг тодорхойлохдоо объектив хийгээд субъектив хэмжүүр ашигладаг. Нийгэм, эдийн засгийн байр суурь бол нийгмийн тэгш бус байдлыг тогтоох объектив хэмжүүр юм. Нийгэм, эдийн засгийн байр суурийг боловсрол, орлого, ажил мэргэжлийн гэсэн З байр сууриар тодорхойлдог. Харин хүмүүсээс өөрийгөө ямар анги эсвэл давхраанд хамааруулдаг болохыг асуух нь давхраажилтыг тодорхойлох субъектив хэмжүүр юм.



Гэртээ хийгээрэй. Багаар гүйцэтгээрэй.

Нийгэм, эдийн засгийн байр суурь	Ойлголтын тодорхойлолт	Хэмжих үзүүлэлтүүд
Орлого		
Ажил эрхлэлт		
Боловсрол		

Сонгосон үзүүлэлтүүдийн дагуу хүмүүсээс асуух асуултыг бэлтгээрэй.

- Хувь хүний эдийн засгийн байр суурийг ямар үзүүлэлтээр хэмжих вэ?
- Хувь хүний эрх мэдлийг ямар үзүүлэлтээр, хэрхэн хэмжих вэ?
- Хувь хүний нэр хүндийг хэрхэн хэмжих вэ?
- Нийгэм, эдийн засгийн байр суурь гэж юу вэ?
- Ямар үзүүлэлтээр түүнийг хэмжих вэ?

Хүн өдөр тутамдаа хэмжилт хийж байдаг. Жишээ нь, уух цайныхаа хэмийг, идэх хоолныхоо амтыг хэмжиж байдаг. Аль ч шинжлэх ухааны судалгаанд “Хэмжилт” чухал үүрэгтэй. Сонирхож буй хувьсагчийн өөрчлөлтийг ажиглахын тулд хэмжих шаардлагатай болдог. Биеийн жинг кг-аар, өндрийг м, см-ээр хэмждэгийн адил нийгмийн шинжлэх ухаан судалж буй хувьсагчаа хэмжиж судалдаг. Нийгмийн ухаанд хэмжилт хийхийн тулд:

Нэгдүгээрт судалж буй хувьсагчаа нэг утгатайгаар тодорхойлох ёстой, **Хоёрдугаарт** тэрхүү хувьсагчийг хэмжих үзүүлэлт, шалгуурыг тогтоодог.

Гуравдугаарт, бодит нөхцөлд хэрхэн хэмжих арга, хэрэгслээ боловсруулдаг. Хэмжилт хийхдээ онол, өмнөх судлаачдын судалгаанд тулгуурлана.



Бүдүүвч 1.2 Хэмжилтийн жишээ

ТҮҮХЭН ҮЕУДЭД МОНГОЛЫН НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ ЯМАР БАЙСАН БЭ?



Үйл ажиллагаа 1.6 Монголын түүхэн үеуд дэх нийгмийн давхраажилтын талаар хэлэлцээрэй.

1. Түүхэн үе тус бүрд давхраа хоорондын гол ялгаа нь юу байсан бэ?
2. Түүхэн үе тус бүрд ямар хэв маягийн давхраажилт оршин байсан бэ?

... XII-XIV зуунд дээд давхраанд Чингис хааны алтан ураг, талын язгууртнууд багтаж байв. Чингис хааны ургийн бус язгууртнуудад мянгатын ноёд багтаж байжээ. Дээд давхрааны дотоодод бас нэгэн чухал байр суурийт эзэлж байсан хүмүүс бол тэргүүн бөө нар юм.

Чингисийн ургийнхан нь тус тусын хувь иргэний эзэн болохул харин талын язгууртнууд болох бусад нь мянгат, зуут, аравтад багтсан иргэнийг захиран баримталж байв. Жирийн иргэд нь “улсын иргэн”, “харьяатан иргэн” гэж хоёр булэгт хуваагджээ. Улсын иргэн нь олон мянгадад хуваагдсан хүмүүс бөгөөд цэрэгт мордох, өртөө хийх, их ав хомрогод оролцох зэргээр эзэн хааны гол алба, үүрэг гүйцэтгэдэг байжээ. Харьяатан иргэд нь тодорхой язгууртны харьяаны хүмүүс болно. Тэд ноёдын мал сүргийг хариулах, орд өргөөнд зарцлагдах, хөтөч дагуул болох зэргээр эзэндээ үйлчилдэг байжээ.

Юань улсаас хойш “харлигууд” буюу харьят ард иргэд дотооддоо, сайн, дунд, адаг хүн гэсэн гурван хэсэгт хуваагджээ. “Сайн”-д харц язгуурын түшмэд, дархад, тайж нарын хүргэн-тавнан, баян чинээлэг өрх багтдаг. “Дунд”-д чинээлэг хөрөнгөтэй, элч, хия зэргийн жижиг эрх мэдэлтнүүд, “адаг”-т хар хүн хэмээх жирийн харц иргэд багтаж байв.

Эх суреалж: Д.Гонгор (1978) Халх тоочоон II боть УБ., 203-218 дахь тал

... Манжийн эрхшээлийн үед Монголын нийгэм нь олон давхраанаас бүрдэж байв. Нийгмийн давхрааны дээд хэсэг нь хошууны ноёд, тайж, лам нар байв... Нийт монгол хошуудын засаг ноёд нь уг гарлаараа 5 янз байв. Тэднээс хамгийн олон нь алтан ургийн ноёд юм... жирийн малчин ард нийгмийн дунд давхрааг голлон бүрдүүлж байв. Тэд тухайн хошуу ноёд, тайж нар, хутагтад харьяалагдан, тэдэнд татвар нийлүүлэх, мал сургийг нь адгуулан үржүүлэх үүрэг хүлээж байв... доод давхраа нь гэрийн боолчууд байв.

Эх сурвалж: Очир А, Энхтувшин Б (ред). Монгол улсын түүх. IV боть. УБ хот. 2004.
177-182-р тал)

Судлаач Х.Гүндсамбуу социализмын үеийг малчдын, ажилчдын, сэхээтний, номенклатура (дарга) гэсэн ангийн бүтэцтэйгээр тодорхойлсон аж. Тэрээр малчин анги нь нэгдлийн харьялал, амины малын тоо, орлогын хэмжээгээр бага зэргийн ялгаатай бөгөөд тэдний амьжирааны түвшин ажилчид, тариаланчидтай харьцуулахад доогуур, ядуучуудын давхрааг бүрдүүлж байжээ. Мөн ажилчин анги нь биеийн хөдөлмөр эрхлэгчид бөгөөд дотоодоо аж үйлдвэрийн, тээврийн, барилгын, үйлчилгээний, хөдөө аж ахуйн гэсэн салбараар хэвтээ чиглэлд, мэргэшлийн зэргээрээ босоо чиглэлд ялгаатай байжээ. Сэхээтэн анги нь оюуны хөдөлмөр эрхлэгчдээс бүрдэх ба дотоодод нь оюуны хөдөлмөрийн түвшний: сэхээтэн ба албан хаагчид, эрх мэдлийн: удирдах ба гүйцэтгэх, өмчлөлийн хэлбэрийн: бүх нийтийн өмчлөлийн ба хоршооллын, байршилын: хотын ба хөдөөний гэсэн ялгаа ажиглагддаг. Номенклатурчдын буюу дарга анги нь дээрээс томилогддог нам, төрийн албан тушаалын жагсаалтын дагуу ялгардаг. Номенклатурчид нь намын босоо шатлалын дагуу эрх мэдэл, орлого, нэр хүндийн ялгарал бүхий, малчин, ажилчин, сэхээтнүүдээс хэд дахин илүү орлого, тусгай хангамж бүхий байсан анги юм.

1990 ОНООС ХОЙШ МОНГОЛЫН НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДСӨН БЭ?

1990 оноос эхэлсэн нийгмийн тогтолцооны өөрчлөлт нь социализмын үеийн давхраажилтын бүтцийг өөрчилсөн юм. Үүнд нэг нам ноёрхсон улс төрийн тогтолцооны өөрчлөлт, зах зээлийн эдийн засгийн харилцаа, өмч хувьчлал, чөлөөт худалдааны харилцаа зэрэг нь нөлөөлсөн байна.

1990 оноос хойших үеийн давхраажилтын талаар судалсан Х.Гүндсамбуу, О.Мөнхбат, Ц.Уртнасан, МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн, Удирдлагын академиас явуулсан судалгаа, Үндэсний статистикийн хорооны өрхийн нийгэм, эдийн засгийн байдлын судалгааны үр дүнд тулгуурлан өнөөгийн Монголын нийгмийн ангийн бүтцийг авч үзье.

Дээд анги. “Улс төр, эдийн засгийн олигархиуд” гэж нэрлэгддэг цөөнх энэ ангийг үндсэндээ бүрдүүлж байна, энэхүү ангид төрийн өндөр албан тушаалтнууд, томоохон компанийн ерөнхийлөгч, захирлууд багтаж байгаа тухай судлаач Х.Гүндсамбуу (2002), О.Мөнхбат (2000) нар тэмдэглэжээ. Судлаач Ц.Уртнасан (2008) энэ анги нийт хүн амын гурав орчим хувийг эзэлнэ хэмээгээд харьцангуй богино хугацаанд хөрөнгөжсөн, хэрэглээний өндөр хангамжтай, тансаг, хангалуун амьдралтай, гэрийн үйлчлэгч болон жолоочтой, тансаг тавилга бүхий орон сууц, зуслангийн байшинтай, үр хүүхдээ өндөр хөгжилтэй оронд сургадаг нийгмийн хэсгийнхэн багтана гэжээ. Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөөд 20 гаруй жил өнгөрч байгаа тул дээд ангийнхан

бусад ангиас хэрэглээ болон амьдралын хэв маягаар ялгаран, харьцангуй хаалттай, үе залгамжилсан дээдийн дээд анги бүрэлдэж эхэлж байна. АТГ-т гаргасан УИХ-ын гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлэг (2016)-ээс харахад нийт гишүүдийн 18.4 хувь нь тэрбуунаас дээш орлоготой буюу хадгаламжтай бол зөвхөн 2.6 хувь нь ямар нэг ААН-д хувьцаа эзэмшдэггүй байна. Эдийн засгийн тэгш бус байдал гүнзгийрэх тусам улс төрийн өндөр албан тушаал хөрөнгөлөг хэсгийнхнээр хязгаарлагдах болж, улс төр, эдийн засгийн цөөнх бүрэлдэж эхлээд байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (2016)-ны дүнгээс харахад хүн амын хамгийн чинээлэг 20 хувийн дундаж хэрэглээ хамгийн ядуу болох 20 хувийнхнаас 5 дахин, 10 хувийнхнаас 7 дахин өндөр байна. Тэр дундаа хэрэглээний тэгш бус байдал, зөрүү хөдөө гэхээсээ хотод илүүтэй ажиглагддаг байна.

Дунд анги. Дундын дээд давхраанд төр засгийн дунд тушаалын албан тушаалтан, хэрэгжүүлэгч агентлагийн удирдлага, банк, санхүү, томоохон аж ахуйн нэгжийн захираг, эзэд, соёл, урлаг, спортын элит бүлэг багтдаг болохыг судлаач О.Мөнхбат тэмдэглэжээ. Судлаач Ц.Уртнасангийн үзэж байгаагаар энэ ангийнхан нийт хүн амын 8-15 хувийг эзэлдэг байна.

Судлаач О.Мөнхбат дундын доод давхраанд жижиг, дунд аж ахуйн нэгжийн захираг, эзэд, томоохон компанийн болон үйлчилгээний байгууллагын салбарын менежер, их дээд сургуулийн багш, эрдэм шинжилгээний ажилтан, эмч зэрэг цагаан захтнууд, дунд гарын бизнесменүүд, төр засгийн доод шатны байгууллагын албан тушаалтууд, цэрэг, цагдаагийн дээд, дунд тушаалын офицерүүд, шүүх хяналтын байгууллагын албан хаагчид, чинээлэг малчид, өндөр мэргэжлийн ажилчдыг энэхүү ангид багтдаг хэмээн үзсэн байна. Судлаач Ц.Уртнасан энэ ангийнхан нийт хүн амын 30-35 хувийг эзэлж байгаа бөгөөд нийгмийн бүх булгээс төлөөлөлтэй гэжээ. Энэхүү таамаг нь доорх судлаачдын судалгааны үр дүнгээр батлагдаж байна. Энэ давхрааны дийлэнх хувийг нь ажил олгогчид биш, харин ажилтнууд эзэлж байна.

Судлаач Б.Энхцэцэг, Ц. Амартувшин, Д.Гансүх нар 2012 оны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” (2012 он)-ны мэдээллийг ашиглан, дунд ангийн төлөв байдлыг судалсан бөгөөд ингэхдээ 132,578-178,260 төгрөг нэг гишүүнд ногддог өрхийг дунд давхраанд хамааруулан судалжээ. Тэдний судалснаар дунд ангид нийт өрхийн 49.2 хувь нь багтаж, тэдгээр өрхийн сарын орлого улсын хэмжээнд дунджаар 753.555 төг байсан аж. Хэрэглээний түвшний хувьд ядуу өрхөөс 2 дахин их хэрэглээтэй ч нийт хэрэглээний 35.6 хувийг (2012 оны байдлаар) хоол хүнс эзэлж байна. Гэтэл дундаас дээш ангийн өрхийн хэрэглээний 24 хувийг хоол хүнсний хэрэглээ эзэлж байна.

Хүснэгт 1.1 Өрх, нийгэм, эдийн засгийн бүлгээр, суурьшилын бүсээр (хувиар)

Нийгэм, эдийн засгийн нийтлэг	Улаанбаатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Бүгд
Дундаас доогуур	25.2	39.2	34.3	51.0	35.0
Дунд анги	51.7	48.6	54.5	42.0	49.2
Дундаас дээгүүр	23.2	12.2	11.2	7.0	15.8
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх сурвалж: *Enkhsetseg B, Amartuvshin Ts, Gansukh D (2014) Middle class profile in Mongolia. ERI discussion papers series No 4.*

Гэхдээ дундангийн хамрах хүрээ, төлөв байдлыг ядуурлын түвшинг тодорхойлж буй аргачлалаар судлах нь учир дутагдалтай. Судлаач Ц.Пүрэв өөрийн судалгаандаа “дор хаяад тусгай дунд боловсролтой, оюуны хөдөлмөр эрхэлдэг, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажил эрхэлдэг, нийслэлд ажиллагсдын цалингаас багагүй байх” гэсэн шалгуурыг дундангийг тодорхойлоходо ашигласан байна. 2013 онд Нийслэлийн хэмжээнд хийсэн уг судалгаанд оролцогчдын 41.3 хувь нь 500-800 мянга, 26.7 хувь нь 800 мянгаас 1 сая төгрөгийг сарын орлоготой гэж хариулсан байна.

Доод анги. Энэхүү ангийг доодын дээд, доодын дунд, ёроол хэсэг гэсэн 3 давхраатайгаар авч үздэг. Энэ анги бүхэлдээ ядуусаас бүрдэж байна. Нийт хүн амын гурван хүн тутмын нэг нь буюу өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (2016)-гаар 29.6 хувь нь энэ ангид багтаж байна.

Доодын дээд давхрааг ядуу ажилчдын анги гэж нэрлэж болно. Учир нь тогтмол ажилтай ч, орлогын хэмжээ бага, цалин багатай мэргэжилтэй болон мэргэжилгүй энгийн ажил эрхэлдэг ажилчид энэ давхрааг бүрдүүлж байна. Харин үүнд нарийн мэргэжсэн ажилчид багтахгүй. Одоогоор ажилчдын нийт тоо, эзлэх хувийн жинг гаргах боломж бас хомс байна. Мэргэжилтэй ажилчдын хувийн жин тодорхойгүй байгаа бол харин 2010 оны хүн амын тооплогын дүнгээс хараход нийт ажил эрхэлдэг хүн амын 7.5 хувь, ойролцоогоор тооцоолбол нийт хүн амын 8.9 хувь нь энгийн ажилчид байна. Энгийн ажилчдын дийлэнх нь ядууралд өртсөн байна. Мэргэжлийн ур чадвараар хомс байдал нь тэдний эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Гэхдээ тэд нийгмийн халамжаас хамаарахгүйгээр ажил хөдөлмөр эрхэлдэг нь давуу тал юм.

Доодын дунд давхрааг гүнзгийрсэн ядууралтай, тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай хүмүүс бүрдүүлнэ. Судлаач Гилберт, Калл нарын үзэж байгаагаар энэ анги нь бага боловсролтой эсвэл боловсролгүй, хөдөлмөр эрхлэх чадвар муутай, өөртөө итгэх итгэлгүй, маш бага орлоготой эсвэл тогтмол орлогын эх үүсвэргүй хүмүүсээс бүрддэг гэж үзсэн. Тэд маш хүнд нөхцөлд амьдардаг ба нийгмийн халамж, тусламжаас хамааралтайгаар амьдардаг.

Ёроол хэсгийг орон гэргүйчүүд, тэнүүлчид, хар тамхи, архинд донтолч, биеэ үнэлэгчид бүрдүүлнэ. Тэдний амьдрах арга хэлбэр нь гүйлга гүйх, хог түүх, биеэ үнэлэх, тэнүүчлэх зэрэг юм. Нийгмийн бүхий л үйлчилгээ, тусламжаас гадна амьдардаг, гадуурхагдсан, шоовдорлогдсон хүмүүс ажээ. 2010 оны 11 дүгээр сарын 14-15-ны шилжих шөнө орон гэргүй, тэнэмэл амьдралтай хүмүүсийг хүн ам, орон сууцны тооллогод хамруулсан бөгөөд нийслэлд 770, Орхон аймагт 73, Дархан-Уул аймагт 45, Дорнод аймагт 40, улсын хэмжээнд 928 хүн тоологдсон байна.



Гэртээ хийгээрэй. Баг, хорооныхоо нийгмийн давхраажилтыг тодорхойлоорой.

1. Даалгавар 1.3-т гүйцэтгэсний дагуу асуулгын хуудсаа бэлтгэнэ үү.
2. Асуулгын хуудасны дагуу мэдээллээ цуглуулна уу.
3. Цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийнэ үү.
4. Дүн шинжилгээний үр дүнг тайлбарлана уу.

Судалгаа хийгээрэй.

Судалгааг гүйцэтгэх удирдамж

A. Асуулгын загвар

Удиртгал хэсэг. ...

Сургуулийн XI ангийн сурагчид баг/хорооны нийгмийн давхраажилтыг тодорхойлох үүднээс уг судалгааг явуулж байна. Бид таны хариултыг зөвхөн судалгааны зорилгоор ашиглана. Таныг бидний судалгаанд идэвхтэй оролцохыг урьж байна.

Судлаачийн тэмдэглэх хэсэг.

1. Орон нутгийн нэр
2. Огноо
3. Судлаачийн нэр

Ерөнхий мэдээллийн хэсэг.

1. Таны нас:
2. Таны хүйс:
3. Тухайн орон нутагт амьдарч буй жил
4. Танай ам бүл
5. Өөрийн хэв шинж (эмэгтэй эсвэл эрэгтэй тэргүүлсэн эсэх)
6. Өөрийн болон хадам эцэг, эхийн ажил эрхлэлт, боловсрол
7. Өөрийн болон эхнэр, нөхрийн ажил эрхлэлт, боловсрол

Үндсэн мэдээллийн хэсэг.

7. Таны болон танай эхнэр/нөхрийн боловсролын түвшин
8. Та болон танай эхнэр/нөхөр ямар ажил эрхэлдэг вэ?
9. Таны болон өрхийн бусад гишүүдийн сарын дундаж орлого гэх мэт хэмжилтийн хүрээнд боловсруулсан асуултаа оруулаарай.

Төгсгөл хэсэг. Судалгаанд оролцсонд баярлалаа. Холбоо барих утас:

Б. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа

Түүврийн төлөвлөлт

- Дүн шинжилгээний нэгжийг сонгох.
 - o Өрхийг эсвэл хувь хүнийг судлахаар сонгох уу? (Асуулгад өрхийг судлахаар сонгосон байна)
- Судалгааны хамрах хүрээг тогтоох.
 - o Судлах хороо/багийг сонгох
- Судалгаа явуулах талбарыг сонгох.
 - o Судалгааг явуулах баг, хорооны хэсгийг сонгох
- Судалгаанд хэдэн өрх/хувь хүнийг хамруулах вэ?
 - o Санамсаргүй түүврийн аргаар уу, зорилтот түүврийн аргаар уу?

Судалгааны мэдээлэл цуглуулахад баримтлах ёс зүйн дүрэм

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг боловсруулах

- Удирдамж. Мэдээллийг хэрхэн цуглуулах тухай зааврууд
- Төлөвлөгөө. Хэн, хэдий хугацаанд хэрхэн гүйцэтгэх талаар төлөвлөнө.

В. Мэдээллийг боловсруулах үйл ажиллагаа

- Цуглуулсан мэдээллийн чанарыг шалгасны дараагаар асуулга тус бүрд дугаар оноогоорой.
- Нээлттэйгээр асуусан хариултын хувилбарыг жагсаан, дахин бүлэглэж, бүлэглэлтийн дагуу код оноон, түүнийгээ асуулга дээрээ тэмдэглээрэй.
- Цуглуулсан мэдээллээ гараар, компьютер ашиглан боловсруулаахаа шийдээрэй. Компьютер ашиглах бол Microsoft-Excell программыг ашиглан боловсруулаарай.
- Баганын дагуу асуулт бүрийг оруулаарай.
- Мөрийн дагуу асуулга тус бүрийн мэдээллийг оруулаарай.

Г. Дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа

- Асуулт тус бүрийн хариултын давтамжийг (тоо, хувийн жин) тооцож тайлбарлаарай.
- Орлого зэрэг нээлтэй асуултын хариултыг өрхөөр нэгтгээрэй.
- Өрхөөр нэгтгэсэн орлогын дүнгээс дундаж, голч зэргийг тооцоорой.
- Нэгтгэсэн орлогын дунг дундаж, голчийн дүнгээс хамааруулан дундаас дээгүүр, дунд, дундаас доогуур гэсэн 3 бүлэгт хуваан, бүлэг тус бүрийн давтамжийг тооцож, үр дүнг тайлбарлаарай.
- 2 хувьсагч бүхий харьцуулсан хүснэгтээр (тухайлбал, өрхийн хэв шинжээр орлого, боловсрол зэргийг) шинжлээрэй.
- Үр дүнг туузан, секторан график, хүснэгтэд нэгтгэж, дүрслэн үзүүлж тайлбарлаарай.

Өрхийн хэв шинж	Өндөр орлоготой өрх	Дунд орлоготой өрх	Бага орлоготой өрх
Эмэгтэй тэргүүтэй өрх			
Эрэгтэй тэргүүтэй өрх			
Бүгд			

Д. Үр дүнг тайлбарлан бичих үйл ажиллагаа

- Даалгавар 1.1-д дэвшиүүлсэн асуултад хариулан бичээрэй.
- Сонирхсон хувьсагч бүрээр шинжилгээний үр дүнг хүснэгт, графикт харуулан, тайлбарлан бичээрэй.
- 2 хувьсагч бүхий харьцуулсан хүснэгтээр (тухайлбал, өрхийн хэв шинжээр орлого, боловсрол зэргийг) шинжилсэн үр дүнг хүснэгт, графикаар харуулан тайлбарлаарай.

Е. Илтгэл

Илтгэлийг дараах агуулгатайгаар бэлтгээрэй.

- Судалгааны зорилго
- Судалгаа тулгуурласан онолын хүрээ
- Судалгааны үйл явцын товч танилцуулга
- Судалгааны үр дүн
- Судалгааны дүгнэлт
- Олж авсан туршлага



Тулгуур ойлголт

Дүн шинжилгээний нэгж. Хувьсагчийг хэмжих, шинжлэх хувь хүн, бүлэг, байгууллага зэргийг хэлнэ.

Эх олонлог. Судалгаа чиглэж бүх нэгжүүдийг хэлнэ. Жишээ нь. Нийслэлийн өрхийг судлах бол УБ хотын бүх өрх судалгааны эх олонлог болно.

Нэлэнхүй судалгаа. Эх олонлогийг бүхэлд нь хамруулах судалгаа. Жишээ нь, хүн ам, орон сууцны тооплого.

Түүвэр судалгаа. Эх олонлогийг бүхэлд нь бус, дэд хэсгийг нь хамруулах судалгаа.

Түүвэр олонлог. Эх олонлогоос судалгаанд сонгон хамруулах олонлог.

Санамсаргүй (магадлалт) түүврийн арга. Эх олонлогийн бүх гишүүд судалгаанд хамрагдах адил магадлалтай байх түүврийн арга.

Зорилтот (магадлалт бус) түүврийн арга. Тодорхой онол, зорилго зэрэгт дулдуйдан судалгаанд оролцогчдыг сонгох түүврийн арга.



Тулгуур ойлголт

(Эдгээрийг хэрхэн тооцох талаар математикийн хичээлээсээ дэлгэрүүлэн судлаарай.).

Дунджийн үзүүлэлтүүд. Тухайн эх олонлог хийгээд түүвэр олонлог хэр зэрэг нэг төрлийн бүлгүүдээс бүрэлдэн тогтох байна вэ гэдгийг ерөнхийд нь харуулах үзүүлэлтүүд.

Моод. Хамгийн их давтамжтай шинж тэмдгийн утга. Жишээ нь, судалгааны оролцогчдоос хамгийн олон хүн 30 настай байсан тул насны мод нь 30 байна.

Голч. Эх олонлог болон түүвэр олонлогийг хоёр тэнцүү хэсэгт хувааж буй шинж тэмдгийн утга. Жишээ нь, насын голч 30 гарсан бол судалгаанд оролцогчид энэ насан дээр 2 тэнцүү бүлэгт хуваагдаж байгааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, 30-аас доош насыхан 50 хувь, 30-аас дээш насыхан мөн 50 хувийг эзэлж байна гэсэн уг юм.

Дундаж. Эх олонлог болон түүвэр олонлогийн төв, жин дарж буй хэсэг. Жишээ нь, судалгаанд оролцогчдын насыг, давтамжаар үргүүлэн, нийт оролцогчдын тоонд хуваах замаар тооцдог. Гэхдээ хэт бага нас, эсвэл хэт өндөр настай цөөн хүн орсон байсан ч, дунджид нөлөөлдөг онцлогтой.

Асуулгад өрхийн хэв шинжийн хариултыг дан, нийлмэл, өрх толгойлсон, ганц бие гэсэн дөрвөн хариулттайгаар мэдээлэл цуглуулсан бол “**Моод**”-ыг дунджийн үзүүлэлт болгон ашиглана.

Асуулгад боловсролын түвшнийг “боловсролгүй, бага, бүрэн бус дунд, бүрэн дунд, тусгай дунд, дээд” гэсэн хариулттайгаар хэмжсэн бол “**Моод болон голч**”-ийг дунджийн үзүүлэлт болгон ашиглана.

Асуулгад ам бүлийн тоо, орлого зэргийг тоогоор хэмжсэн бол “**Дундаж**”-ийг дунджийн үзүүлэлт болгон ашиглана.

НИЙГМИЙН НИЙТЛЭГ ХИЙГЭЭД ТЭГШ БУС БАЙДАЛД ХОЛБОГОДОХ ЯМАР АСУУДЛУУД БАЙДАГ ВЭ?



Үйл ажиллагаа 1.7 Дүн шинжилгээ хийгээрэй.

Ажил мэргэжлийн ангилаал	Хүс	2017	Ажил мэргэжлийн ангилаал		
Менежер	Бүгд	1,073.9	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	Бүгд	511.7
	Эрэгтэй	1,132.9		Эрэгтэй	498.0
	Эмэгтэй	1,009.9		Эмэгтэй	538.2
Мэргэжилтэн	Бүгд	1,053.7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Бүгд	928.3
	Эрэгтэй	1,276.2		Эрэгтэй	1,003.5
	Эмэгтэй	945.4		Эмэгтэй	758.4
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	Бүгд	1,083.1	Машин механизмын, төхөөрөмжийн операторч, угсралч	Бүгд	1,150.4
	Эрэгтэй	1,149.7		Эрэгтэй	1,142.1
	Эмэгтэй	998.9		Эмэгтэй	1,202.3
Контор, үйлчилгээний ажилтан	Бүгд	915.9	Энгийн ажил, мэргэжил	Бүгд	661.3
	Эрэгтэй	1,067.5		Эрэгтэй	706.2
	Эмэгтэй	830.1		Эмэгтэй	615.9
Худалдаа, үйлчилгээний ажилтан	Бүгд	671.8	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Бүгд	997.1
	Эрэгтэй	771.7		Эрэгтэй	1,002.7
	Эмэгтэй	599.		Эмэгтэй	980.2

Эх сурвалж: 1212.mn (Ажилтнуудын дундаж цалин, ажил мэргэжлийн бүлгээр, 2017 он)

Асуулт:

1. Ажил мэргэжлийн бүлэг тус бүрээр эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн цалингийн хэдэн хувьтай тэнцэх цалин хөлсийг авч байгааг тооцоолно уу.
2. Тооцооллын үр дүнгээр график байгуулна уу.
3. Тоон мэдээлэл нь ямар асуудлыг хөндөж байгааг тайлбарлана уу.

Нас, жендер, үндэс угсаа, арьс өнгөний байр суурь нь хүнд заяагдмал шинжтэй. Гэхдээ тэдний нийгэмд эзэлж буй байр суурийн ялгаа нь тэдний төрөлх шинжтэй нь бус, харин тэдэнд ялгаатай боломжийг олгож буй нийгмийн бүтцийн орчин нөхцөл, үнэлгээ, хандлагын ялгаанаас үүдэлтэй юм. Өөрөөр хэлбэл, нас, хүйс, үндэс угсаа, арьс өнгөний бүлгүүдийн нийгмийн байр суурийн ялгаа нийгмийн бүтэц, соёлоос хамаардаг.

**Тулгуур ойлголт**

Хүйс. Эрэгтэй, эмэгтэй хүний биологийн буюу бие махбодийн ялгаа. Энэ нь заяагдмал шинжтэй.

Жендер. Эрэгтэй, эмэгтэй хүний нийгмийн бүтэц, соёлоос хамааран тодорхойлогдох ялгаа. Энэ нь нийгмийн харилцааны явцад бүтээгддэг, хүнд төлөвшдөг шинжтэй.

Жендер. Эцгийн эрхт ёс бүхий нийгэмд эрэгтэйчүүдийн гарт баялаг, эрх мэдэл, нэр хүнд төвлөрч байгаа нь жендерийн тэгш бус байдал бодитоор оршин байгааг нотлон харуулдаг. Улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, шашин, гэр бүл гэх мэтчилэн нийгмийн бүхий л институтийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байна. Шийдвэр гаргахад оролцож байгаа эсэх нь эрх мэдлийн ялгааг харуулдаг.

Нийт хүн амын 50.5 хувь нь эмэгтэйчүүд атлаа 2016 оны байдлаар төрийн эрх барих дээд байгуулага болох УИХ-ын гишүүдийн 17.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Түүнчлэн 2017 оны байдлаар эмэгтэй ажиллагсад эрэгтэй ажиллагсдын дундаж цалингийн 83.5 хувьтай тэнцэхүйц цалинг дунджаар авч байна. Энэхүү цалингийн зөрөөтэй байдал нь эрэгтэй, эмэгтэйчүүд ялгаатай ажил эрхэлдэгтэй холбоотой. Цалин хөлс өндөртэй салбарт эрэгтэйчүүд давамгай ажиллаж байхад цалин хөлс багатай салбарт эмэгтэйчүүд зонхилон ажиллаж байна. Жишээ нь, багш, эмч нарын дийлэнх нь эмэгтэйчүүд байхад жолооч, инженер техникийн ажилтнуудын ихэнх нь эрэгтэйчүүд байдаг. Гэхдээ судалгаагаар ажил мэргэжлийн бүхий л төрөлд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс ямагт бага цалин авч байна. Энэ нь албан тушаалын жендерийн ялгаатай холбоотой юм. Тодруулбал, удирдах албан тушаалын ажлыг эрэгтэйчүүд, туслах, гүйцэтгэх ажлыг эмэгтэйчүүд голдуу эрхэлдэгтэй нь цалингийн ялгаа холбогдоно. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өссөн тохиолдолд ч цалингийн зөрөө илэрсээр байна. Ийнхүү эрх мэдэл болон эдийн засгийн байр суурьт жендерийн ялгаа ихээхэн нөлөөтэй байна.

Угсаатны нийтлэг. Олонх нийгэм угсаатны янз бүрийн нийтлэгээс бүрдэж байдаг. Угсаатан гэдэг нь үндэс угсаа, хэл, соёл, түүх, зан заншил, газар нутаг, шашин зэргээр ижил төстэй нийгмийн нийтлэг юм. Угсаатны бүлэг нь улс төрийн үйл явцын нэг хэсэг, түүний үр нөлөөгөөр бүрэлддэг. Манайд угсаатны бүлгүүд төвийг сахисан шинжтэй, энх тайванчаар амьдарч байгаа бол бусад нийгэмд угсаатнууд нь эрх мэдэл, баялгийн хувьд харилцан адилгүй нөхцөлд амьдрах ба улмаар тэдний хооронд зөрчил ил болон далд хэлбэрээр өрнөж байдаг. Ямар давхраанд багтах нь үндэс угсаа, арьс өнгөний шинжээс хамаардаг нийгмүүд ч цөөнгүй. Үндэс угсаа,

арыс өнгөний зарим шинж нь эрх мэдэл, эдийн баялаг, нэр хүндэд хүрэх саад тогтор болдог буюу алагчлагдаж, энэ нь тухайн нийгэмд тогтсон бурангуй, хэвшмэл үзэл хандлагаас хамаардаг.

Насны нийтлэг. Нас нь яах аргагүй хүний физиологийн хөгжлийн утгыг илрэхийлэхээс гадна нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхойлж байдаг. Ихэнх нийгэмд насны нийтлэгүүд нь үнэ цэнтэй бүхэнд хүрэх харилцан адилгүй боломж бүхий нөхцөлд амьдардаг. Иймээс давхраажилтыг судлахдаа насны хүчин зүйлтэй холбон судалдаг байна. Японд нас ахих тусам нийгмийн байр суурь нь өсдөг зүй тогтол ажиглагддаг. Харин манайд ийм хандлага илэрдэг ч зарим тохиолдолд 35-аас дээш насныханд шинээр ажилд орох боломж бусад насныхнаас харьцангуй бага болох нь ажлын байрны зараас харагдах жишээтэй. Нийгмийн нийтлэгийн хэлбэрүүд нь өөр хоорондоо холбоотой. Жишээ нь, нас болон хүйсийн ялгаа нь өөр хоорондоо нягт уялдаатай. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль болон “Нийгмийн даатгалын тухай хууль”-аар эмэгтэй хүн 4, түүнээс дээш хүүхэд төрүүлсэн бол 50 насандaa өндөр насны тэтгэвэрт гарч болно. Хэдийгээр хувь хүн өөрөө тэтгэвэрт гарахыг илүүд үзэж болох ч, энэ нь туршлагажиж, чадваржсан насандaa албан тушаал ахих, орлогоо нэмэгдүүлэх боломжийг хязгаарлах талтай юм.

Шашны нийтлэг. Зарим нийгэмд зонхилогч хийгээд цөөнхийн шашин хооронд зөрчил үүсдэг. Зонхилогч биш шашныхан алагчлалд өртөн, улмаар олонхтой харьцуулахад харьцангуй дорой нөхцөлд аж төрөх нь бий. Түүнчлэн шашны ялгаатай цөөнхийг хүй олноор нь устгасан тохиолдлууд дэлхийн түүхэнд нэлээд гарсан байдаг. Ийнхүү нийгмийн гарал, шашин шүтлэг, хэл, эд хөрөнгө, эрүүл мэндийн байдал, нутагшилт зэргийн ялгаа бүхий нийтлэгүүдэд адил бусаар хандах, алагчлах явдал нь тухайн нийгмийн давхраажилтын тогтолцоонд нөлөөлөхийн зэрэгцээ давхраажилтын тогтолцооны тусгал болж байдаг.

Бурангуй үзэл

Алагчлал
(ялгаварлан гадуурхалт)

Тэгш бус байдал

Бүдүүч 1.3 Тэгш бус байдал үүсэх нөхцөл

НАС, ХҮЙС, ҮНДЭС УГСАА, ШАШИН, АРЬС ӨНГӨНИЙ НИЙТЛЭГ ХООРОНДЫН ТЭГШ БУС БАЙДАЛ, ЗӨРЧИЛ ЮУНААС ХАМААРАН БИЙ БОЛДОГ ВЭ?

Энэхүү асуултад хариулахад бурангуй үзэл хийгээд алагчлал хоорондын зааг ялгааг тодруулах нь чухал юм. Бурангуй үзэл нь нэг бүлгийнхний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол, хандлага билээ. Харин алагчлал нь нэг бүлэгт давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хааж буй бодит үйлдэл аж. Жишээ нь, еврейчүүдийн талаарх нацист германчуудын бурангуй үзэл нь тэдгээрийг хавчин хөөх, улмаар устгах зорилго бүхий алагчилсан үйлдэлд хүргэсэн байна. Гэхдээ бурангуй үзэл нь өөрсдийгөө дорд үзэгдэж байна гэж хардах үзэлтэй цөөнхөд ч хамаатай ойлголт юм.

Алагчлал нь ил болон далд хэлбэрээр үйлдэгдэж байдаг. Шууд алагчлал гэдэг нь ижил буюу төстэй нөхцөлд нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг зэрэг шинжээр

ялгаатай байдалд хүргэсэн үйлдлийг хэлнэ. Эдгээр шинжүүдээр шууд ялгаагүй ч ямар нэг стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь ялгаатай байдалд хүргэхийг шууд бус алагчлал гэнэ. Бичигдмэл болон бичигдмэл бус хэм хэмжээнд суурьшсан, институт, байгууллагын хувьд ялгарах алагчлалын төрлийг институтийн алагчлал гэнэ. Бүхий л төрлийн алагчлал нь тэгш бус байдалд хүргэдэг.

НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ, БАЙР СУУРЬ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДДӨГ ВЭ?



Үйл ажиллагаа 1.8 Чанарын судалгааны дүн шинжилгээ хийнэ үү.

Зохиомж 1-4-ийг дахин сайтар уншаад, доорх хүснэгтийг бөглөөрэй.

<p>Нэг. А нь 1974 онд Налайх дүүрэгт уурхайчин А-ийн гэр бүлд төрсөн. 1990 онд 8-р анги төгссөн. 1992 онд мэргэжлийн сургууль төгссөн уурхайчин болсон. 1992 - 1995 онд Налайхын уурхайд уурхайчнаар ажилласан 1995 оноос хойш хувиараа нүүрс олборлож байна. Сарын орлого 600, 000 төгрөг. Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг.</p>	<p>Гурав. В нь 1974 онд Швейцари улсын Женев хотноо дипломатч В-ийн гэр бүлд төрсөн. 1992 онд бүрэн дунд боловсролыг эзэмшиж. 1996 онд Оксфордын их сургууль төгссөн. 1998 онд тус сургуульд магистрын зэрэг хамгаалсан. 1998 онд өөрийн компани байгуулсан. 2012 оноос хойш дэд сайдаар ажиллаж байна. Сарын орлого 30 сая төгрөг. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг.</p>
<p>Хоёр. Б 1974 онд Улаанбаатар хотод Б гэдэг эмэгтэйн гэр бүлд төрсөн. 1985 онд гэрээсээ дайжсан Мөн онд сургуулиас гарсан. Хулгайн гэмт хэрэг удаа дараа үйлдсэний учир 10 гаруй жилийг шоронд хоригдсон ба өөрийн гэсэн гэр оронгүй. Эхнэргүй, мөн хүүхэдгүй.</p>	<p>Дөрөв. Г нь 1974 онд Өвөрхангай аймгийн Хужирт суманд малчин Г-ийн гэр бүлд төрсөн. 1992 онд бүрэн дунд боловсрол эзэмшиж. 1996 онд их сургууль төгссөн. 1996-1998 онд банкны эдийн засагчаар ажилласан 1998-2002 онд салбарын захирал, 2002-2010 онд банкны дотоод аудитын газрын дарга, 2010 оноос хойш дэд захирлын албыг хашиж байна. Сарын орлого 10 сая төгрөг. Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг.</p>


Категори	A	Б	В	Г
Нас				
Хүйс				
Нийгмийн гарал				
Боловсрол				
Ажил эрхлэлт				
Орлогын хэмжээ				

Асуулт:

1. А, Б, В, Г нарын байр суурьд ямар өөрчлөлт гарсан бэ?
2. Тэрхүү байр суурийн өөрчлөлтөд ямар хучин зүйлс нөлөөлсөн бэ?
3. А, Б, В, Г нарын олдмол байр суурьт нийгмийн гарал, боловсрол ямар нөлөө үзүүлсэн байна вэ?
4. Төрөлхийн байр сууриа өөрчлөх боломж хүмүүст байхгүй тохиолдолд юу болох вэ?

Чанарын судалгааны мэдээллийн шинжилгээ

- Нээлттэй кодлолт.** Бичвэр мэдээлэл дэх бүх мэдээллийг кодолно. Жишээ нь 1974 онд төрсөн.
- Категоричлол.** Үүсгэсэн кодуудын давхцалаас шинэ код буюу категорийг үүсгэнэ. Жишээ нь, төрсөн оны тухай кодоос “Нас” гэсэн категорийг бүтээж болно.
- Харьцуулсан жишилт.** Тохиолдол дахь ижил нөхцөл нь ижил үр дагаварт хүргж буй холбоог хайх шинжилгээ. Жишээ нь, тохиолдоос боловсролын түвшний ижил нөхцөл нь орлогын төсөөтэй байдалд хүргэж байгааг шинжлэн илрүүлж болно.



Бүдүүвч 1.4 Байр суурийн шилжих хөдөлгөөний хэлбэрүүд

Хувь хүн, нийгмийн бүлгийн байр суурь өөрчлөгдхийг байр суурийн шилжих хөдөлгөөн гэдэг. Хэрэв нийгэм, эдийн засгийн байр суурь нь өөрчлөгдвэл босоо чиглэлийн, нийгэм, эдийн засгийн байр суурьт өөрчлөлт гараагүй бол хэвтээ чиглэлийн байр суурийн шилжих хөдөлгөөн гэнэ. Мөн байр суурийн шилжих хөдөлгөөнийг нийгмийн бүтцийн өөрчлөлтөөс хамаарч байна уу, хувийн хичээл зүтгэл, чармайлтаас шалтгаалж байна уу гэдгээс нь хамааруулан хувийн ба бүлгийн гэж ялган үзнэ. Тодорхой хувь хүнээс өөрөөс нь хамааран, түүний хичээл зүтгэл, авьяас чадвар, хөдөлмөрийн үр дүнд байр суурьд нь өөрчлөлт гарах нь хувийн хөдөлгөөн юм. Харин нийгмийн бүтцийн өөрчлөлттэй холбогдон нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийн байр суурьд өөрчлөлт гарахыг бүлгийн шилжих хөдөлгөөн гэнэ. Жишээ нь, 1990 онд Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжсэнээр төрийн татаасаар ажилладаг байсан боловсруулах үйлдвэрүүдийн ихэнх нь хаагдсан. Үүнтэй холбоотойгоор олон тооны нэхмэлчин, гуталчин, оёдолчин, ээрмэлчид ажилгүйчүүдийн эгнээнд орсон юм.

Байр суурийн шилжих хөдөлгөөн нь эцэг эхээс заяагдмал төрөлхийн байр сууриа өөрчилсөн эсэхээс хамааран үе хоорондын ба үе дотоодын шилжих хөдөлгөөн хэмээн ялгагддаг. Эцэг эх, гэр бүлээс залгамжилсан төрөлхийн байр суурьтай нь тодорхой хувь хүний олдмол байр суурийг харьцуулахад өөрчлөгдсөн бол үе хоорондын байр суурийн шилжих хөдөлгөөн гэнэ. Харин эцэг эх, гэр бүлийн төрөлхийн байр суурьтай нь харьцуулалгүйгээр хувь хүний байр суурь хэрхэн өөрчлөгдж байгаа нь үе дотоодын шилжих хөдөлгөөн юм.

Тухайн нийгэмд байр суурийн төлөөх шударга өрсөлдөөн хэр зэрэг илэрч байгааг нийгэм дэх байр суурийн босоо чиглэлийн болон үе хоорондын шилжих хөдөлгөөн харуулах юм. Америкийн социологич Л.Козер байр суурийн шилжих хөдөлгөөний асуудлыг судалсан. Тэрээр судалгааны үр дүндээ тулгуурлан хаалттай ба нээлттэй нийгэм хэмээн нийгмийн хоёр хэв маягийг тодруулсан байна. Босоо чиглэлийн, хувийн, үе хоорондын байр суурийн шилжих хөдөлгөөн хийх боломжтой нийгмийг нээлттэй нийгэм гэжээ. Байр суурийн шилжих хөдөлгөөний дурдсан төрлүүд хэрэгжих боломжгүй нийгэм нь хаалттай нийгэм юм.

Хувь хүн эцэс заяагдмал төрөлхийн байр сууриа өөрчлөхөөр бусадтайгаа зөрчилддөг. Энэхүү зөрчил нь нийгмийн хөшингө, царцангы байдлыг хална. Учир нь авьяас чадвараар дутмаг хэсэг дээд давхраанаас хасагдан, дунд болон доод давхрааны авьяас, чадвартай хэсэг дээд давхраанд шилжих замаар нийгэм өөрчлөгддөг. Нийгмийн өөрчлөлт нь нэг талаас байр суурийн хөдөлгөөн хэрхэн явагдаж байгаагаас ихээхэн хамаарлтай, нөгөө талаас нийгмийн өөрчлөлт нь хувь хүний байр суурийн хөдөлгөөнд нөлөөлдөг.

Орчин үеийн нийгэм харьцангуй нээлттэй болжээ. Хэн хичээн ажиллаж, чадваржина, тэр амжилтад хүрэн, дээд ангид очих боломж нээгдэж байна. Гэхдээ нийгмийн гишүүн бүрийн боломжид зэрэг, сөргөөр нөлөөлөгч олон хүчин зүйлс оршсоор байна. Хүмүүс олон янзын сувгаар байр сууриа өөрчилдөг. Уламжлалт нийгэмд цэрэг арми болон шашин, сүм хийд нь хүмүүсийн байр суурийн хөдөлгөөн хийхэд голлох ач холбогдолтой суваг байсан бол орчин үеийн нийгэмд энэ чанар нь алдагдаж, харин бүх нийтийн боловсрол онцгой үүрэг гүйцэтгэх болжээ. Орчин үеийн нийгэмд боловсролоор дамжуулан хувь хүн мэдлэг, чадвар эзэмшин, эцэг эхээс зяасан төрөлхийн байр сууриа өөрчлөх замаар давхраажилтын бүтцийг илүү нээлттэй болгож байна. Гэтэл хувь хүний боловсрол эзэмших боломж нь ямар ангид харьялагдаж байгаагаас хамаарч байгаа тул тэгш бус байдлыг бууруулахад сайнаар нөлөөлж чадахгүй байгаа тал бий. Учир нь дээд ангиас гаралтай хүүхдэд чанартай боловсрол эзэмших боломж нээлттэй байдаг бол үүний эсрэгээр доод ангийнханд боловсролын хүртээмж, чанар сайн биш хэвээр байгаатай холбоотой.



Гэртээ хийгээрэй. Дүн шинжилгээ хийгээрэй.

- Даалгавар 1.3-ын хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлаа үргэлжлүүлэн, судалгаанд оролцогчдын орлого, ажил мэргэжил, боловсролын байр суурийн хөдөлгөөнд нь нөлөөлсөн зэрэг хийгээд сөрөг хүчин зүйлсийг тодорхойлоорой.
- Байр суурийн хөдөлгөөний төрлүүдийг (эцэг эхийн ажил эрхлэлт, боловсролын байр суурийн мэдээллийг ашиглан) тодорхойлон, үр дүнг тайлбарлаарай.
- Тайлбар, үр дүнг илтгэлээр хэлэлцүүлээрэй.



Нэмж судлаарай

- А.Гидденс. Социологи. Уб., 2006..
- Удирдлагын академи. Нийгмийн дунд давхрааны төлөв байдал: Улаанбаатар хотын өрхийн судалгаа. Уб., 2017

СЭДЭВ 1.2 НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бид энэхүү бүлгийн хүрээнд хувь хүний үйлдэл, нийгмийн бүтэц, нийгэм хэрхэн өөрчлөгддөг, нийгмийн өөрчлөлт хувь хүний амьдрал, үйлдэлд хэрхэн нөлөөлдгийг судална.

НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Тодорхой цаг хугацааны хүрээнд нийгмийн бүтэц, соёл, нийгмийн институт, хүмүүсийн зан үйл шинэчлэгдэхийг нийгмийн өөрчлөлт гэдэг. Хүн төрөлхтний нийгэм хэрхэн өөрчлөгджэй ирснийг олон эрдэмтэн судлаачид тайлбарлаж, нийгмийн тодорхой хэв маягуудыг тодорхойлсон байдаг. Марксистууд нийгмийн өөрчлөлтийг эдийн засгийн нөөцийг хэн эзэмшиж, ашиглаж байгаад ямар өөрчлөлт гарч байгаатай холбон үзсэн бөгөөд бооплын, феодалын, капиталист, коммунист нийгмийг дамжин хөгждөг гэсэн. К.Маркс Азийн нийгмийг өрнөдийн нийгмийн туулж өнгөрүүлсэн нийгмийн хэв маягаас ялгаатай гэж үзжээ.

Бүтэц чиг үүргийн онолын төлөөлөгчид болох Г.Ленский, Ж.Ленский нар нийгмийн оршин тогтоно арга хэрэгслээ хэрхэн олж авч буй үндсэн шинж нь хувьсан өөрчлөгддөг гэж үзсэн ба дараах нийгмийн хэв маягийг илрүүлсэн юм.

Ан агуурын нийгэм. Хүнсэндээ ургамал, жимс түүж, ан агнаж, нүүдэллэн амьдардаг нийгэм. Чулуун сүх, жад, хутга зэрэг энгийн зэвсэг ашигладаг, улс төрийн бүтэц үүгүй, овгийн байгуулал бүхий нийгэм юм. Өнөө хэр Зүүн өмнөд Африкийн бушмен, Австралийн угуул иргэд ийм төрлийн нийгмийн байгуулал бүхий байсаар байна.

Цэцэрлэг аж ахуйн нийгэм. Энгийн хөдөлмөрийн багаж зэвсэг ашиглан тариалангийн аж ахуй эрхэлдэг ч, нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй, ураг төрлийн холбоонд суурилсан, олон төрлийн овгуудаас тогтох нийгэм. НТӨ 4000 оны тэртээ үүсэж, Ази, Европ даяар тархсан ба өнөө үед Африкт уламжлагдан хадгалагдаж буй нийгмийн байгуулал юм.

Газар тариалангийн нийгэм. Анх эртний Египетэд үүссэн бөгөөд түүхэнд хамгийн өргөн тархсан нийгмийн байгуулал юм. Энэ үед газар тариаланд анжис ашиглан, мал амьтныг ажиллах хүч болгон хэрэглэдэг тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр худалдаа арилжаа үүсэж, улмаар хотыг үүсгэхэд нөлөөлжээ. Ураг төрлийн холбоонд тулгуурлахаа больж, төр үүсэж, бичиг үсэг хэрэглэх болж, мөнгөн гүйлгээ ашиглах болжээ. Гэхдээ өрх гэр бүлд суурилсан эдийн засгийн харилцаа оршин байжээ.

Аж үйлдвэржсэн нийгэм. Их Британи дахь аж үйлдвэржилтийн нөлөөгөөр XVIII зууны сүүлчээр үүссэн бөгөөд өнөө цагт хамгийн өргөн тархсан нийгмийн байгуулал юм. Үйлдвэрлэлийн технологи, шинжлэх ухааны мэдлэгт суурilan, хүн, амьтны булчингийн хүчийг халж, дулаан, цахилгаан, атомын эрчим хүчийг үйлдвэрлэлд ашигласнаар аж үйлдвэрийн нийгэм бүрэлдэн тогтож, хөгжихд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг асар их хэмжээгээр үйлдвэрлэж, төвлөрөн суурьшсан хотын маш олон хүн амын хэрэгцээг хангах болсон. Төрийн удирдлага нь бюрократ байгууллагын тогтолцоо, зэвсэгт хүчинд суурилсан байдаг бөгөөд гэр бүл, шашны институтийн үүрэг супарсан нийгмийн байгуулал юм.

XVIII зууны сүүл үеийн социологичид, философичдын анхаарал газар тариалангийн нийгмээс аж үйлдвэржсэн нийгэмд шилжих үеийн асуудал, ялгааг тодруулахад чиглэж байсан юм. Тухайлбал, Германы социологич Ф.Тённис аж үйлдвэржилтийн нийгмийн өмнөх үеийн нийгмээс ялгарах ялгааг тодруулсан юм. Тэрээр Гемайншафт (хөдөөний буюу уламжлалт), Гезеллшафт (хотын буюу орчин үеийн) гэсэн ойлголт ашиглан тайлбарласан. Гемайншафтын үед уламжлал ёс зан заншил, шашин, сүсэг бишрэл онцгой үүрэгтэй байх тул хүн хувийн хүсэл зоригт гэхээсээ нийгэм-хамт олны зарчимд нийцэн амьдрахыг тэтгэдэг. Харин гезеллшафтын үед шашин, сүсэг бишрэл, зан заншлын үүрэг нөлөө буурсны нөлөөгөөр хувийн сонирхлыг зохистой хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг. Гемайншафтын үед хөдөлмөрийн хуваарь энгийн байх бөгөөд үйлдвэрлэл өрх, гэр бүлийн хүрээнд явагддаг бол гезеллшафтын үед хөдөлмөрийн хуваарь нарийч, үйлдвэрлэл, хөдөлмөрийн үйл ажиллагаа өрх, гэр бүлийн хүрээнээс тусдаа болсон онцлогтой.



Үйл ажиллагаа 1.9 Хүснэгтийг бөглөөрэй. Дараах сэтгэгчид нийгмийг хэв маягчлахдаа ямар шалгуурт тулгуурласан бэ?

	Хэв маягчлалын шалгуур
К.Маркс	
Г.Ленский, Ж.Ленский	
Ф.Тённис	

Г.Ленский, Ж.Ленский, Ф.Тённисийн үзэл баримтлал нийгмийг ангилах дараа, дараагийн социологичдын үзэл баримтлалын үндэс болсон юм. Өнөө цагийн олон социологичдын бүтээлд нийгмийг дараах хэдэн хэв маягт хуваасан байдаг. Тухайлбал, Т.Билтон нарын судлаачид:

1. Уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх нийгэм

- Газар тариалангийн аж ахуй болон түүнээс өмнөх хэлбэрийн аж ахуйтай.
- Шашны эсвэл домгийн итгэл үнэмшлийн тогтолцоотой
- Уламжлалт төрийн бүтэцтэй. Тодруулбал, угсаа залгамжлах ёс бүхий хаант засаглал эсвэл төрийн бүтэцгүй нийгэм
- Хувийн хүсэл зориг гэхээсээ нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэн хувь хүн амьдардаг.
- Хүний амьдралын үйл ажиллагааны гол талбар нь өрх, гэр бүлийн хүрээ байна.

2. Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм

- Аж үйлдвэр эдийн засгийн гол талбар байна.
- Шинжлэх ухааны итгэл үнэмшлийн тогтолцоо тэргүүлэх үүрэгтэй.
- Орчин үеийн төрийн бүтэцтэй буюу үндэсний төрийн бүгд найрамдах засаглал бүхий төртэй байна.
- Нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэх гэхээсээ хувийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг.
- Хүний амьдралын үйл ажиллагаа өрх, гэр бүлийн хүрээнээс гадна олон нийтийн, байгууллагын хүрээнд олон янзын үүрэг хүлээж, олон талт харилцаа бүхий байна.

Уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэм болон өөрчлөгдхийг шинэчлэл (modernization) гэдэг. Энэ нь нэг талаас нийгэм дэвшин өөрчлөгджэх байгаатай холбогдож байгаа ч нөгөө талаас доройтохой басхүү холбогдоно. Жишээ нь, шинэчлэлийн үр дүнд нийгмийн доод ангийнхны амьдралын чанарт дэвшил гарсан байж болох ч, байгаль орчин, ёс суртахуун, ёс зүй ухарч, доройтсон тал ажиглагддаг. Аж үйлдвэржилт өрнө дахинд анхлан дэлгэрсэнтэй холбоотойгоор бусад нийгэм дэх шинэчлэлийн үйл явц өрнөжих үйл явцтай зарим талаар холбогддог. Жишээ нь, ихэнх хосууд хуриглахдаа монгол зан үйлээ дагаж байгаа ч, өрнөдийн гэрлэх зан үйл аль хэдийн нэвтэрч, гэрлэх ёслолыг өөрчилж байна.

Нолан, Ленский нарын үзсэнээр шинэчлэлийн үйл явцад дараах шинж нийтлэг ажиглагддаг.

- Хүмүүс илүү том нийгэм-хамт олны дунд амьдарч, тэдний хоорондын ялгаа ихэсдэг бөгөөд нийгэм-хамт олон, бусдын өмнө хүлээх үүрэг гэхээсээ хувийн ашиг сонирхол, хэрэгцээг илүүд үздэг. Том нийгэм-хамт олны дунд хүн амьдрах болсноор хүмүүс хоорондын хувийн биш холбоо тархаж, эрх зүйн зохицуулалтын үүрэг өсөн нэмэгддэг.
- Танин мэдэх, бодож сэтгэх уламжлалт арга зам үнэ цэнээ алдаж гээгддэг. Хүмүүс танин мэдэх үйл ажиллагаанд төдийгүй өөр хоорондоо харилцахдаа уламжлалт заншлыг мөрдөхөөс татгалзах болдог. Жишээ нь, цаг агаарыг монголчууд ан амьтад, ургамал, нар, сар, од, гарагс, салхины байдлыг ажиглан мэддэг байсан бол өнөөдрийн малчид бараг бүгдээр радио, ТВ, гар утсаар цацагдах цаг уурын үндэсний хүрээлэнгийн мэдээллийг ашиглан, аж ахуйгаа хөтлөн явуулж байна.
- Шинэчлэлийн үйл явц нь хувийн эрх чөлөө, бие даасан байдлыг нэмэгдүүлсэн. Томоохон нийгэм-хамт олны дунд хүн амьдрах болсноор нийгмийн гишүүд хоорондын харилцаа илүү хувийн шинжтэй биш болж, нийгэм-хамт олны гэх мэдрэмж, уламжлалаа гээж, өөрийн эрх чөлөөг илүүтэй чухалчилж, өөрийнхөөрөө байхыг илүүд үздэг. Иймээс орчин үеийн нийгэмд өмнө нь хүлээн зөвшөөрөгдөггүй, хүлээн авамгүй үйлдэлд хүндэтгэлтэй хандаж, тэвчсэнээр хувь хүний эрх чөлөө хангагдаж, ухаалаг, баригдмал бус бүтээлч үйлийг дэмжиж өгдөг сайн талтай.
- М.Вебер шинэчлэл нь хүн хувийн амьдралын хүрээнээс гадна бюрократи байгууллагын хүрээнд ажиллах болж, рациональ хандлагыг чухалчилснаар илүү үр ашигтай байх болсон гэж үзсэн. Энэ нь уламжлал гээгдэж, хувийн гэх холбоо буурахад хүргэж байна гэжээ.

Шинэчлэлийн нэлөөгөөр бүтээлч байдал, эрх чөлөө гэх мэт олон давуу талыг бий болгосон ч, бохирдсон орчин, нөөцийн хомсдол, хэтийдсэн тэгш бус байдал, хүмүүсийг сая, саяар нь хөнөөсөн дайн байлдаан, цөмийн зэвсэг, дайсагнал, терроризм гээд урьд урьдынхаасаа илүү түгшүүртэй, найдваргүй, эргэлзээтэй орчинд амьдрах болсон. Иймээс нийгмийн шинэчлэлийг зөвхөн дэвшил болох талаас бус, зарим зүйлийн хувьд ухралт байдаг гэж үзэж болно.

3. Орчин үеийн дараах буюу аж үйлдвэржилтийн дараах нийгэм

Бауман, Лиотард нар 1970-аад оноос хойших нийгмийн харилцаанд гарч буй өөрчлөлт, тэр дундаа даяаршлын төлөв байдлыг орчин үеийн дараах нийгэм хэмээх ойлголтоор илэрхийлсэн.

Тэдний үзэж байгаагаар:

- Аж үйлдвэр эдийн засгийн гол салбар хэвээр хэдий ч нэг ижил бүтээгдэхүүнийг олноор үйлдвэрлэх гэхээсээ хүмүүсийн амьдралын хэв маягаас хамаарсан олон төрөл, хэв маягийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх болсон. Түүнчлэн, эдийн засгийн амьдралд үндэстний төрийн зохицуулалтаас гадна үндэстэн дамнасан корпорациудын оролцоо өссөнөөр үндэстэн хоорондын, бус нутгийн олон улсын зохицуулалт ихэссэн. Хөгжингүй оронд томоохон хот, жижиг суурин хоорондын ялгаа багасаж, үйлчилгээний салбарт илүүтэй хөдөлмөр эрхлэх болсон бол хөгжик буй оронд хотжилт эрчимжиж, хөгжингүй орнуудын аж үйлдвэрлэлийн салбарыг эрхлэх болсноор тус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн оролцоо өссөн.
- Шинжлэх ухааныг туйлчлан дээдлэх хандлага эрчээ алдаж, нэг арга зам, хандлагаар мэдлэг бүтээх гэхээсээ ялгаатай хандлага, арга зүйг хүлээн зөвшөөрөх болсон.
- Үндэстэн дамнасан эдийн засаг, соёл, улс төрийн үйл ажиллагаа нь үндэстний төрийн үйл ажиллагаанд нөлөөлөх болсон ба улс төрийн хувьд нийгмийн асуудал руу анхаарах болж, илүү зүүний чиглэлийн бодлогыг Засгийн газрууд хэрэгжүүлэх болсон.
- Гэр бүл, гэрлэлтийн харилцаа өөрчлөгдөж, гэрлэлтийн нас хойшилж, ганц биеэр амьдрах, ижил хүйстэнтэй гэрлэх зэрэг олон янзын төрөл, хувилбарууд хүлээн зөвшөөрөгдөх болсон бөгөөд гэрийн бүлийн нийтлэг үнэт зүйлс, нийтлэг зарчим гэхээс хувь хүний сонирхлыг тэргүүнд тавих хандлага өсөж байна.



Үйл ажиллагаа 1.10. Асуултын хүрээнд ярилцаарай.

Дээрх мэдээллийг сайтар уншаад дараах хуудсыг бөглөнө үү.

1. Уламжлалт, орчин үеийн, орчин үеийн дараах нийгмийн аж ахуй, эдийн засаг, итгэл үнэмшилийн тогтолцоо, улс төрийн бүтэц, хувийн хүсэл зориг, хүний амьдралын үйл ажиллагаа зэрэгт илрэх гол ялгаа юу вэ?
2. Г.Ленский, Ж.Ленский нарын нийгмийн хэв маягуудаас аль нь уламжлалт нийгэмд хамаарах вэ?

	Уламжлалт нийгэм	Орчин үеийн нийгэм	Орчин үеийн дараах нийгэм
Аж ахуй, эдийн засаг			
Итгэл үнэмшилийн тогтолцоо			
Улс төрийн бүтэц			
Хувийн хүсэл зориг			
Хүний амьдралын үйл ажиллагаа			

НИЙГЭМ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДДӨГ ВЭ?

Хүний нийгэм энгийнээс нарийн төвөгтэй байдал руу шилжиж өөрчлөгддөг. Г.Ленский, Ж.Ленский нарынхаар ан агууруын нийгмээс цэцэрлэгжүүлэх улмаар хөдөө аж ахуйн, түүнээс орчин үеийн нийгэм рүү хувьсан өөрчлөгджээ. Тодруулбал, бүтэц чиг үүргийн онолчид энгийн бүтэцтэй байгаагаас нарийн төвөгтэй, олон талт бүтэц руу хувьсан шилжих замаар өөрчлөгддөг гэж үздэг. Байгаль дахь хувьслын үйл явцад энгийнээс нарийн руу шилжих үйл явц нь гадаад орчиндоо дасан зохицох үйл явцаар тодорхойлогддог. Түүний нэгэн адилгаар нийгэм нь орчиндоо дасан зохицох замаар хувьсдаг. Байгальд амьдралын төлөөх тэмцэл дасан зохицлыг тодорхойлдгийн адил нийгэмд ч амьдралын төлөөх тэмцэл тодорхойлно. Т.Парсонс нийгмийн хувьсал бол нийгмийн институтуудын ялгарлын өсөн нэмэгдэлт гэж үзсэн. Шинэ хэрэгцээ бий болох буюу гадаад орчны шаардлагад зохицож байгаа нь тэрхүү хэрэгцээг хангах шинэ институт бий болох замаар нийгэм өөрчлөгднөг гэж үздэг.

Марксизмын хувьд хүрээлэн буй орчинд дасан зохицох бус, харин түүнийг өөрчилдөг гэдэгт анхаарлаа хандуулдаг. Эдийн засгийн амьдрал бол нийгмийн өөрчлөлтийн суурь, түүнийг дагаж давхаргын шинжтэй улс төр, шашин зэрэгт өөрчлөлт гардаг хэмээдэг. Нэг үйлдвэрлэлийн аргыг нөгөөх нь солих замаар нийгэм өөрчлөгддөг. Үйлдвэрлэлийн арга нь үйлдвэрлэх хүч ба үйлдвэрлэлийн харилцаанаас тогтоно. Үйлдвэрлэх хүч ба үйлдвэрлэлийн харилцааны зөрчил нь нийгмийг өөрчлөх гол түлхэц хүчин зүйл болдог хэмээн үздэг. Нийгмийн бүтэц энгийнээс нарийн руу хувьсан шилжих замаар өөрчлөгдөх бус дотоод дахь зөрчил нь нийгмийг эрс өөрчлөх хувьсгалд хүргэдэг гэдэгт түлхүү анхаарна. Мөн бүтэц чиг үүргийн онолчид нийгэмд гарах гэнэтийн өөрчлөлтийг хүсмээр зүйл биш хэмээн үзэх бол марксистууд гэнэтийн өөрчлөлт нь тэгш бус байдлыг өөрчиж, шударга ёсыг тогтооход чухал үүрэгтэй гэж үздэг.

М.Вебер нь марксизмыг шүүмжлэхэд гол анхаарлаа хандуулсан. Мөн тэрээр хувьслын онолыг ч бас шүүмжилсэн. Тэрээр нийгмийн өөрчлөлтийг нэг л хүчин зүйлээр тайлбарлах нь учир дутагдалтай, учир нь нийгэм өөрчлөгдөхөд эдийн засгийн адил төр, арми, шашин чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн өөрчлөлтийн судалгаанд тогтвортой, их нөлөө бүхий хүчин зүйлсийг тодорхойлох, нийгмийн тодорхой үеийг, харилцааг тайлбарлах л онолыг бүтээж чадна гэж тэрээр үзсэн байдаг. Өнөө үед түүний энэхүү үзэл санааг ихээхэн дэмжиж байгаа юм. Тэрээр эдийн засагт гарсан өөрчлөлт нь шашны өөрчлөлтийг дагуулдаг гэхээсээ шашинд гарсан өөрчлөлт нь эдийн засаг, аж ахуй өөрчлөгдөхөд хүргэдэг гэж үздэг.



Үйл ажиллагаа 1.11. Нийгмийн өөрчлөлтийг тайлбарласан онолуудыг харьцуулан дүгнэнэ үү.

Онол	Нийгэм өөрчлөгдөх үндсэн шалтгаан юу вэ?	Нийгэм хэрхэн өөрчлөгддөг вэ?
Марксизм		
Бүтэц чиг үүргийн онол		
М.Веберийн онол		

Нийгэм өөрчлөгдхөд түлхүү нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг бол **хүн амын өсөлт** юм. Нөгөө талаас нийгмийн шинэчлэлийн нөлөөгөөр хүн амын өсөлт эрчимжсэн. ХХ зуунд дэлхийн хүн ам 1.65 тэрбумаас 6 тэрбум болтлоо, Монгол улсын хүн ам 647.5 мянгаас 2373.5 мянга болж буюу бараг 4 дахин өссөн. Хүн амын өсөлт нь ажиллах хүчний өсөлтийг дагуулж, эдийн засагт өсөлт авчрахад чухал үүрэгтэйн хамт сургууль, цэцэрлэгийн эрэлт өсөж, төсвийн зардлыг нэмэгдүүлж, тэдний хэрэгцээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэхийг шаарддаг зэргээр нийгмийг өөрчилдөг.

Соёл, технологи нь нийгмийн өөрчлөлтийн дараагийн эх сурвалж юм. Соёлын хүчин зүйлс дотроос шашин чухал нөлөөтэй. Мөн бичиг үсэг, шинжлэх ухаан, технологи ч хүн төрөлхтний түүхэн өөрчлөлтийг дагуулжээ. Үзэл суртал, итгэл үнэмшлийн тогтолцоонд гарах өөрчлөлт ихээхэн нөлөөтэй. Үүний жишээ бол социалист орнуудын түүх юм. Соёлын өөрчлөлт нь технологийн дэвшлийг дагуулдгийн адиллаар технологийн дэвшил нь соёлыг өөрчлөхөд хүргэдэг. Дулаан, цахилгааны эрчим хүчийг ашиглах технологи нэвтэрсэн нь аж үйлдвэржилтийг эрчимжүүлсэн. Сүүлийн хориод жилийн хугацаанд мэдээллийн технологийн хурдацтай өөрчлөлт нь хүмүүсийн амьдрал дахь орон зайн хүчин зүйлсийн нөлөөг бууруулж байна.



Нийгэм өөрчлөгдхөд **хүрээлэн буй орчны хүчин зүйлс** тодруулбал, байгалийн гамшиг зэрэг нь нөлөөлдөг. Жишээ нь, 1990, 2000-аад онуудад болсон зуднаар малаа алдсан малчид амьжиригаагаа залгуулах, ажилтай болох үүднээс томоохон суурин руу шилжин суурьшиж амьдрах болсон. Үүний нөлөөгөөр Улаанбаатар хотын хүн ам эрс ихсэж, ус болон дулааны нэгдсэн хангамжгүйгээс шилжин ирсэн өрхийн дийлэнх нь түүхий нүүрсийг ашиглаж байгаа нь агаарын бохирдол нэмэгдэхэд хүргэсэн юм. Мөн дэлхий дахины уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр цөлжилт ихэссэн нь өрхийн аж ахуй эрхэлж буй малчдыг хорших, нэгдэх, бэлчээрээ хамтын оролцоонд тулгуурлан гаргасан хуваарь, төлөвлөлт, зохицуулалттайгаар ашиглахад хүргэж байна.

Дайн, улс төрийн мөргөлдөөн. Хүн төрөлхтний түүхийн туршид цэргийн хүчин баялгийг олж авах хүчин зүйл болж байсны хувьд эдийн засгийн өөрчлөлтөд ихээхэн нөлөөлжээ. Жишээ нь, дэлхийн 1 дүгээр дайны дараагаар өрөнд орсон Герман улс эдийн засгийн гүнзгий хямралд өртөж, энэхүү нөхцөл байдал нь хэсэг хугацааны дараагаар Гитлерийн нацист үзэл суртал түгэн дэлгэрэхэд хүргэсэн. Тухайн нэг улсын дотоодын самуун, иргэний дайн нь хүн амын дүрвэх хөдөлгөөн, цагаачлалд хүргэж, улс орны нийгмийн амьдралыг орвонгоор нь өөрчилсөн түүх цөөнгүй бий.



Дайнаас өмнөх Сир



Талибын дэглэмээс өмнөх Афганистан



Дайны дараах Сири



Талибын дэглэмээс хойших Афганистан

Нийгмийн хөдөлгөөн (*social movement*) нь нэг талаас нийгмийн өөрчлөлтийн эх сурвалжийн нэг, нөгөө талаас орчин үеийн нийгмийн салшгүй шинжүүдийн нэг юм. Нийгмийн хөдөлгөөн нь гол төлөв оршин буй нийгмийн ёс журамд дургүйцсэнтэй холбогдон үүсдэг бөгөөд нийтлэг ашиг сонирхлыг тогтсон ёс журам, хэм хэмжээний хүрээнээс гадуур хэрэгжүүлэх гэсэн хамтын үйлдлийн тусламжтайгаар хэрэгжүүлж буй нийтийн оролдлого юм. Өөрчлөлтийг хийх шаардлагатай болохыг харуулсан нийгмийн бодит нөхцөл хийгээд түүнийг ямар байх ёстойн талаарх хүлээлт, стандарт хоорондын зөрөөнөөс олон нийтийн дургүйцэл бий болдог. Жишээ нь, нэг талаас инфляци өссөн, цалин нэмэгдээгүй тул орлого нь хаанаа ч хүрэхгүй байгаа ажилчдын бодит нөхцөл байдал, нөгөө талаас баялгийг бүтээхэд шийдвэрлэх үүрэгтэй ажиллаж байгаа атлаа баялаг хуваарилалтад ажилчдын дуу хоолой, санаа бодлыг сонсохгүй байгааг шударга бус гэж ажилчид ухамсарласнаар ажил хаях, жагсаал, цуглаан зохион байгуулах зэргээр нийгмийн хөдөлгөөн гардаг.

Цалин нэмэх, баялгийн хуваарилалтад ажилчдын эрх ашгийг тусгах ёстой гэж үзсэн нийгэм хамт олны дундаас нийгмийн хөдөлгөөн үүсэхээс биш, шударга бус гэж үзэхгүй байгаа тохиолдолд нийгмийн хөдөлгөөн бий болохгүй. Мөн цалингаа нэмүүлэх, баялгийг хуваарилахдаа ажилчдад ч гэсэн хувь хүртээх ёстой гэсэн саналыг хүлээн авч, ярилцдаг институтчилэгдсэн буюу хүлээн зөвшөөрөгдсөн, хэм хэмжээгээр зохицуулагдсан арга зам байгаа тохиолдолд нийгмийн хөдөлгөөн гарахгүй юм. Тодруулбал, ажилчдын ҮЭ ажил олгогчтой байгуулах хамтын гэрээндээ цалин нэмүүлэх, ажилчдад ашиг олгох тухай асуудлыг тусгаж, шийдүүлж байгаа тохиолдолд ажил хаялт гарахгүй.

Нийгмийн хөдөлгөөн нь маш олон янз. Тухайлбал, марк цуглуулагчдын бүлгээс эхлээд нийгмийг бүхэлд нь өөрчлөхөөр зорьсон эсэргүүцлийн хөдөлгөөн, хувьсгал ч үүнд багтдаг. Хүн төрөлхтний түүхэнд нийгэмд хувьсгалт өөрчлөлтүүдийг авчирсан нийгмийн хөдөлгөөн асар олон.

Нийгмийн өөрчлөлт дэх нийгмийн хөдөлгөөний үүргийн талаар зайлшгүй авч үзэх нэг ойлголт бол **хувьсгал** юм. Английн социологич Э.Гидденс хувьсгалыг дараах үндсэн шинжтэй гэжээ. Эдгээр шалгуур нь төрийн эргэлт, зэвсэгт бослого зэргээс хувьсгалыг ялгаж өгдөг. Үүнд:

- Олон нийтийн хөдөлгөөнд тулгуурласан байна.
- Өргөн хүрээтэй шинэчлэл буюу засаглалын бүтцийг, дэглэмийг өөрчлөхөд хүргэдэг.
- Хүч хэрэглэх эсвэл хүч хэрэглэхээр сүрдүүлсэн үйлдэл.



Үйл ажиллагаа 1.12. Аль нь хувьсгалын жишээ болох вэ?

Түүхийн хичээлээр судалсан мэдлэгтээ тулгуурлан 1911, 1921, 1990-ээд оны Монголын түүхэн өөрчлөлтийн жишээг сонгон, дараах асуултад хариулаарай.

1. Аль нь хувьсгал вэ? Аль нь биш вэ? Яагаад?
2. Дэлхийн түүхийн мэдлэгтээ тулгуурлан түүхэн хувьсгалуудыг нэрлэж, яагаад хувьсгал болохыг үндэслэн тайлбарлаарай.



Гэртээ хийгээрэй. “Нийгмийн өөрчлөлтийн хувь хүний амьдрал дахь нөлөө” сэдвээр судалгаа хийгээрэй.

Ингэхдээ дараах насны бүлгүүдийн (70-аас дээш, 65-69, 60-64, 59-55, 50-54, 45-49, 40-44) ажил мэргэжлийн болон нутагшилтын байр суурь хэрхэн өөрчлөгджэй ирсэнд гол анхаарлаа хандуулаарай. Дараах үе шаттайгаар судалгааг явуулна уу.

- Судалгаа явуулах төлөөвлөгөөг гаргах
- Мэдээлэл цуглуулах аргаа тоогтоож, хэрэв асуулгаар мэдээлэл цуглуулах бол асуулгаа болоевсруулах.
- Мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх
- Үр дүнг нэгтгэж илтгэл бичих



Нэмж судлаарай

- А.Гидденс. Социологи. Уб., 2006
- Н.Смелзер. Социологи. Уб., 2018

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

“Нийгэм, нийгмийн харилцаа” бүлгийн хүрээнд нийгмийн давхраажилт, нийгмийн өөрчлөлтийн талаар судаллаа. Сурагч та бүхнийг тус сэдвүүдийг судлахаа Х ангидаа судалсан мэдлэг, чадвараа гүнзгийрүүлэн, тодорхой сэдвээр судалгаа явуулах үйл ажиллагааг төлөвлөх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үр дүнг нэгтгэх, тайлбарлах, илтгэл бичих зэрэг даалгавар гүйцэтгэж сурахад тухайлан анхаараа.

Бид 10 дугаар ангидаа нийгмийн гишүүд нь харилцан адилгүй байр суурь эзлэн, үүргээ хэрэгжүүлэх замаар амьдардаг нь харилцан бие биенийхээ хэрэгцээг хангаж, эмх цэгц, зохион байгуулалттайгаар амьдрах нөхцөлийг бүрдүүлдэг тухай судалсан. Нийгмийн гишүүд ялгаатай байр суурь эзэлж, үүрэг гүйцэтгэх нь гарцаагүйн адил байр суурийн ялгаа нь тэгш бус байдалд хүргэдэг. Ямар байр суурьт хүрэх вэ гэдгийг тухайн хүн спорт, урлаг, оюуны авьяастай төрж, түүнийгээ хичээл зүтгэл, хөдөлмөрөөрөө тэтгэсний үр дунд амжилтад хүрэх зэрэг хувийн хүчин зүйлс тодорхойлж байгаа ч гэр бүлээс улбаатай хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь төрөөс үзүүлж буй үйлчилгээ тусалж чадахгүй байх зэргээр хувь хүнээс өөрөөс нь үл шалтгаалсан институтийн (нийгмийн) хүчин зүйлс нөлөөлдөг. Ийнхүү нийгмийн давхраажилт нь хувь хүний амьдрал, үйл ажиллагааны сонголт, хүрээг тодорхойлж байдаг юм.

Нийгэм байнгын хөдөлгөөнтэй буюу өөрчлөгддөг мөн чанартай. Нийгэмд шинэ төрлийн хэрэгцээ бий болж, түүнийг хангахаар шинэ байр суурь, шинэ дүр үүрэг үүсэх эсвэл байр суурийн дүр үүрэг өөрчлөгддөг. Эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологи, шашин зэрэгт гарсан өөрчлөлт нь нийгэм өөрчлөгдөхөд хүргэж байдаг. Мөн улс төрийн нөхцөл байдал, зөрчил мөргөлдөөн, нийгмийн хөдөлгөөн, эсэргүүцэл, дайн нь нийгэмд эрс өөрчлөлт авчрах нь бий. Нийгэм өөрчлөгдөх нь хувь хүний амьдрал, үйл ажиллагааны шинж, сонголт, хүрээг басхүү өөрчилж байдаг. Нөгөө талаас хувь хүний үйл ажиллагаа, сонголт нь нийгмийг өөрчилдөг

Дүгнэлт хичээлээр та бүхэн бүлгийн агуулгатай холбогдох дараах даалгаврыг гүйцэтгээрэй.



I. ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭЭРЭЙ

1. Нөхөж бичээрэй: Бүтэц чиг үүргийн онолын төлөөлөгчид нэр хүнд хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлсон бэ?

Т.Парсонс	Девис ба Мур	Уорнер	Дункан

2. Хүснэгтийг ашиглан асуултад хариулаарай.

Д/д	Сонгосон үзүүлэлтээр	1990	2000	2004	2008	2012
1.	Парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь	24.9	11.8	6.6	3.9	14.47
2.	Парламентад нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн хувь	7.7(1992)	10.9	13.7	18.5	32.0

Эх сурвалж: ЖҮХ, НҮБХХ, Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо ба төлөөлөл, 2012

1. Монгол улсад хэдэн оноос эхлэн эмэгтэйчүүд сонгуульд оролцох эрхтэй болсон бэ?
2. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо ямар түвшинд байна вэ? Хэрхэн өөрчлөгджэй байна вэ?
3. Нэр дэвшилэн эмэгтэйчүүдийн хувийн жин, сонгогдсон эмэгтэйчүүдийн хувийн жин хооронд холбоо хамаарал байна уу.
4. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн хувийн жинд юу, юу нөлөөлж байгаа вэ?

3. Дараах эхийг харьцуулаад асуултад хариулаарай.

Д нь 1915 онд төрсөн бөгөөд 16 насандaa нөхөрт гарсан. Түүний эцэг эх нь нөхрийн талаас бэр гүйсныг зөвшөөрсөн тул анх удаа харсан нөхөртэйгээ гэрлэсэн байна. Таван хүүхэд төрүүлсэн ч 3 нь эндсэн. Тэрбээр гертээ амарждаг байжээ.	Д нь 1937 онд төрсөн бөгөөд бага сургуулиа төгсөөд, үргэлжлүүлэн сурхыг хүссэн ч эцэг эх нь зөвшөөрөөгүй байна. 17 насандaa хайр сэтгэлтэй хүнтэйгээ учирч гэрлэсэн байна. Тэрбээр 9 хүүхэд төрүүлсэн бөгөөд ууган хүүхдээ гэртээ, бусдыг нь эмнэлэгт төрүүлсэн байна.	Д нь 1970 онд төрсөн бөгөөд цэцэрлэг, сургууль дамжсаар 1993 онд их сургуулиа дүүргэсэн байна. Ажил хөдөлмөр эрхэлсээр 30 орчим насандaa хайр сэтгэлтэй хүнтэйгээ гэрлэж, 2 хүүхэд төрүүлжээ. Бага хүүхдээ төрүүлсний дараагаар жирэмсэлтээс сэргийлэх арга хэрэглэх болсон байна.
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

1. Эх дэх нийтлэг болон ялгаатай талуудыг тодорхойлно уу.
2. Түүхэн цаг хугацаанд эмэгтэйчүүдийн гэрлэлтэд ямар өөрчлөлт гарсан бэ?
3. Түүхэн цаг хугацаанд төрөлттэй холбоотой ямар өөрчлөлт гарсан байна вэ?
4. Гэр бүл, эрүүл мэндийн институтэд гарсан өөрчлөлтийн талаар дүгнэлт хийнэ үү.

Эсээ бичих болон бие даах ажлын үлгэрчилсэн сэдвүүд

1. Монголын нийгэм бол орчин үеийн нийгэм мөн
2. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаанд биологийн ялгаа чухал нөлөөтэй.
3. Нийгмийн давхраажилтын боловсрол дахь үр нөлөө
4. Нийгмийн хalamжийн туслалцаа, дэмжлэгийн хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэхийн үр ашиг
5. Нийгмийн давхраажилт дахь нийгмийн гарлын нөлөө
6. Материаллаг орчны өөрчлөлт нь нийгмийн өөрчлөлтийн үндсэн шалтгаан.
7. Үзэл суртал, итгэл үнэмшлийн тогтолцоонд гарах өөрчлөлт нь нийгмийн өөрчлөлтийн үндсэн шалтгаан
8. Ядуурал нь нийгмийн хөдөлгөөн үсэх гол нөхцөл мөн



II. ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

1. Дараах бодомжуудын аль нь зөв бэ?
 - а. Хувийн өмчийг устгаснаар нийгэмд тэгш байдлыг тогтоож чадна.
 - б. Хувийн өмчийн ялгааг арилгах боломжгүй бөгөөд өмчийн ялгаа тэгш бус

- байдалтай холбоогүй.
- в. Эдийн засгийн ялгаанаас үүдэлтэй тэгш бус байдлыг арилгаж чадах ч мэргэжлийн нэр хүндээс үүдэлтэй тэгш бус байдал арилах боломжгүй байна.
- г. Тэгш бус байдлын үндсэн шалтгаан бол эрх мэдлийн ялгаа гэдэг нь харагдаж байна.
- д. Нийгмийн бүх гишүүд хүсэж чадах аваас нийгэмд тэгш байдлыг тогтоож чадна.
2. К.Марксын үзсэнээр капиталистууд ажилчин ангийг хэрхэн мөлждөг вэ?
- а. Өөрийн ажилчдад цалин өгөлгүйгээр
 - б. Нэмүү өртгийг ажилчдаар бүтээлгэн, өөрсдөө авч
 - в. Ажилчдыг шалтгаангүйгээр ажиллуулан
 - г. Ашгийг ажилчдад хуваарилж
3. Язгуурын давхраажилтын хэв маяг дараах нийгмүүдийн алинд нь зонхилдог вэ?
- а. Орчин үеийн нийгэм
 - б. Газар тариалангийн нийгэм
 - в. Аж үйлдвэржсэн нийгэм
 - г. Мэдээллийн нийгэм
 - д. Ан агууруын нийгэм
4. Монгол улсын эдийн засаг 2011 онд 17.5, 2012 онд 12.3 хувиар эрчимтэй өсөж байна. Харин ядуурлын хамрах хүрээ 2011 онд 9.4, 2012 онд 2.4 хувиар буурчээ. Тухайн жилүүдэд эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоогоор эрчимтэй өсөж байсан ч өсөлтийн үр ашиг ядуурлыг дорвitoйгоор буурахад нөлөө багатай байсны учир шалтгааныг аль дүгнэлт хамгийн оновчтой тайлбарласан байна вэ?
- а. Эдийн засгийн өсөлтийг дагаж, ядуурал буурсантай холбоотой.
 - б. Эдийн засаг өссөн ч, тэгш бус байдал өссөнтэй холбоотой.
 - в. Эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулаагүй байна.
 - г. Эдийн засгийн өсөлттэй ядуурлын бууралт холбогдох албагүй.
5. Девис ба Мур нар дараах дүгнэлтүүдийн алийг нь хүлээн зөвшөөрсөн бэ?
- а. Нийгмийн гарлаас хамаараад авьяасаа нээн илрүүлэх боломж янз бүр
 - б. Хөдөлмөрийн зах зээл дэх өрсөлдөөн нь ажлын орчин, нэр хүндийн ялгаанд нөлөөтэй.
 - в. Хөдөлмөрийн зах зээлийн орчин нь баялгийн ялгаанд гарцаагүй хүргэдэг.
 - г. Хөдөлмөрийн нийлүүлэлт бага байх нь цалин хөлс их байхын гол шалтгаан биш.
6. Гадаад орчны зүгээс ирэх шаардлагад нийцэх, дасан зохицох замаар нийгэм өөрчлөгддөг гэж үзсэн онол аль нь вэ?
- а. Марксизм
 - б. Функционализм
 - в. Зэрчилдөөний онол
 - г. Бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онол



Суралцахуйн зорилт

Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагууд

- Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүрэг, харилцан хамаарлын талаар судалж мэдэх
- Соёлын үйлдвэрлэлийн ДНБ-д оруулж буй хувь нэмрийг тооцоолох, цаашид хөгжүүлэх санал, хувилбарыг дэвшүүлэх
- Хүрээлэн буй орчноос соёлд хамаарах асуудлыг тодорхойлох, уг асуудлыг шийдэх хувилбаруудыг бүтээх, үнэлэлт өгөх, өөрийн хувь нэмрийг оруулах

Тулгуур ойлголт

- Соёл
- Соёлын үйлдвэрлэл
- Соёлын аялал жуулчлал
- Соёлын даяаршил
- Соёлын адилсал
- Соёлын дархлаа
- Соёлын орон зай
- Соёлын цочирдол
- Соёлын эрх чөлөө

Соёлын өөрчлөлт

- Жишээ, тохиолдлыг судлах замаар соёлын өөрчлөлт, харилцан хамаарал, хожимдлын талаар тайлбарлах
- Хүмүүсийн харилцаа, хандлага хэрхэн өөрчлөгддөгийг түүхэн харьцуулалт, тоон болон чанарын судалгааны аргаар судлан тодорхойлох
- Орчин үеийн соёлын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг жишээ баримтаар нотлон тайлбарлах

Монголчуудын соёл ба соёлын даяаршил

- Мэдээлэл, баримт, эх сурвалжийг ашиглан Монголчуудын соёл ба соёлын даяаршил, соёлын эрх чөлөөг тайлбарлах
- Эх орон, эх дэлхийг хайрлан хамгаалах, бусдын соёлыг хүндэтгэх, амьдралын зохистой зан үйлд суралцах талаар санаа дэвшүүлэх

СЭДЭВ 2.1 СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Бид өмнөх ангидаа бэлгэ тэмдэг, хэл, мэдлэг, итгэл үнэмшил гэх мэт соёлыг бүрдүүлэгч элементүүдийн утга холбогдлыг мэдэж, соёлын түгээмэл шинж, олон янз байдлын учир шалтгааныг тайлбарлах, соёлын хэрэглээ, чиг үүргийг тодруулах зэрэг чадварт суралцсан билээ. Эдгээр мэдлэг, чадвараа ашиглаад 11 дүгээр ангидаа соёлын бодлого, үйлдвэрлэл, даяаршил, эрх чөлөө зэрэг орчин үеийн соёлын асуудлыг судалж, утга учрыг ойлгох, улмаар үндэсний хийгээд олон соёлын орчинд амьдрах чадвар эзэмших, амьдралын зохистой зан үйлд суралцах талаар санаагаа дэвшүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх болно.



Үйл ажиллагаа 2.1. Дараах мэдээллийг уншаад асуултад хариулаарай.

Монгол улс Үндэсний их баяр наадмаас гадна Даншиг наадам, Морин хуур наадам, Тэмээний баяр, Мөсний баяр гэх мэт олон наадмыг уламжлал болгон зохион байгуулж байна. 2014 оноос эхлэн өвлийн наадмыг зохион байгуулдаг болсноор манай орныг зорих жуулчдын тоо нэмэгджээ. Улаанбаатарын өвлийн наадмын мөсөн шагай болон месөн сурын харвааны тэмцээн, тэшүүрийн болон уран гулгалтын үзүүлбэр, өвлийн дугуйн аялал, нохойтой чарганы тэмцээн зэрэг нь жуулчдын ихэд сонирхдог арга хэмжээний нэг болов.

Хөвсгөл нуурын “Хөх сувд-2018” мөсний баярт дотоодын 15 мянга гаруй, гадаадын 130 орчим жуулчин оролцсон бол Хар ус нуурын “Мөнгөн шагшуурга” мөсний баярт дотоод, гадаадын жуулчин нийлсэн 12 мянга гаруй хүн оролцжээ. Олон нийтийг ийнхүү татаж буй эдгээр наадам нь соёлын үйлдвэрлэлийн хэлбэрүүд юм.

Наадмыг зохион байгуулахад боловсрол, соёл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагууд, бус нутгийн төрийн захиргааны байгууллагууд, хэвлэл мэдээлэл, олон нийтийн радио, телевиз, тохижилт, засвар үйлчилгээний байгууллага, хэв журам сахиулах байгууллага гэх мэт маш олон байгууллага оролцдог байна.

Дэлхий даяар зөвхөн зун болдог хөгжмийн наадам мянга гаруй байдаг аж. Хэдэн өдрөөр үргэлжлэн олон мянган хүнийг нэг дор цуглуулж чаддаг хөгжмийн наадмуудад тайз, дэлгэц, хөгжмийн тоног төхөөрөмжөөс гадна үйлчилгээний асар, VIP тусгай өрөө зэрэг хүрэлцэн ирсэн дуучид, хөгжимчид, зочид, үзэгчдэд тав тух, таашаалыг дээд зэргээр мэдрүүлэх зорилго бүхий орчинг бүрдүүлдэг байна.

Монгол улсад зохиогддог янз бүрийн наадам нь нүүдэлчин монголчуудын соёлыг олон улсад таниулах, үндэстний соёлын салбарын хөгжлийг илтгэх, соёлын харилцааг дэмжих, бэхжүүлэх, харилцааны шинэ хэлбэрийг нээх гэх мэт чухал ач холбогдолтой.

Асуулт:

1. Соёлын ямар чиг үүргүүд илэрч байна вэ?
3. Соёлын үйлдвэрлэл гэж юу болох талаар бичээрэй.
4. Соёлын үйлдвэрлэлээр ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг вэ?

1980-аад оны үед техник, технологийн эрс дэвшил гарч, кино урлаг, дуу хөгжим, шоу бизнес эрчимтэй хөгжсөнтэй холбоотой олон улсын түвшинд соёлын үйлдвэрлэл хэмээх ойлголт анх гарчээ. Олон улсын туршлагаас харахад соёлын үйлдвэрлэлийг “бүтээлч эдийн засаг”, “шинэ эдийн засаг”, “утаагүй үйлдвэрлэл”, “бүтээлч үйлдвэрлэл”, “соёлд суурилсан бүтээлч үйлдвэрлэл”, “чөлөөт цагт зориулсан үйлдвэрлэл” зэргээр нэрлэж байна. Улс орнуудын үндэстний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогоо агуулсан үйлдвэрлэл, үйлчилгээг бүтээж, олон улсын болон үндэсний зах зээлд гарган таниулах үйл ажиллагаа улам өргөжиж байна. Бас соёлын үйлдвэрлэлийг өргөжүүлэн, түүний эдийн засаг, нийгэмд оруулах бодит үр өгөөжийг нь хүлээн зөвшөөрч, улам бүр дэмжин хөгжүүлэх зорилт тавин хэрэгжүүлж байна.



Тулгуур ойлголт

Соёлын үйлдвэрлэл. Хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгээс эх сурвалжтай, оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа, бүтээл үйлдвэрлэх, тэдгээрийн хуваарилалт, нийлүүлэлтийн тогтолцоог хангасан үйлдвэрлэлийн салбарыг хэлнэ.

Соёлын үйлдвэрлэлд оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой бүтээл туурвил, үйлчилгээ багтана. Жишээ нь, археологи, архитектур, гар урлал, үндэсний тоглоом, хувцас загвар, дизайн, музей, галерей, угсаатны зан үйл, тайзны урлаг, дуурь, дуу бүжиг, хөгжим, театр, цирк, ардын урлаг, баримал, уран зохиол, номын сан, хэвлэл, телевиз, радио, орчин үеийн модерн урлагийн урсгалууд, кино, видео, гэрэл зураг, дүрслэх урлаг, цахим хэвлэл, зар сурталчилгаа, компьютерийн тоглоом зэргийг нэрлэж болно.

Соёлын үйлдвэрлэл ямар ач холбогдолтой вэ?

- ажлын байр нэмэгдүүлдэг.
- иргэдийн авьяасыг нээх, хөгжүүлэх боломжийг бий болгоно.
- уралдаан, тэмцээн, нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулах хэлбэрээр соёлын ажилтан, уран бүтээлчдийн бүтээн туурвих, мэргэших, соёлын солилцооны шилжилт хөдөлгөөнд орох, тогтмол орлоготой байх, төсөл, хөтөлбөрт хамрагдах боломжийг бүрдүүлнэ.
- эрх чөлөө, ардчилал, хүлээцтэй байдал, харилцан хүндлэл, нийгмийн шударга ёсны зарчим, үнэ цэнийг дэлгэрүүлж, бэхжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- соёлын үйлдвэрлэл дэх иргэдийн оролцоо нь нийгмийг нягтуулж, нийгмийн бүлгийг хүчирхэг болгодог.
- улс орнуудыг соёл, ёс заншилаар нь ялган таниулах гол арга зам болдог.
- тухайн соёлын бусдаас ялгарах, дахин давтагдашгүй өвермөц шинжийг нээн илрүүлдэг.
- дэлхий нийтэд өөрсдийн брэндийг бий болгож, соёлын салбарын шударга өрсөлдөөнийг дэмжих, соёлын өвөө эргэлтэд оруулах замаар эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулдаг.
- ДНБ-ний хэмжээг нэмэгдүүлэн ард түмний амьжиргааны түвшнийг дээшлүүлдэг.

Соёлын төрөл бүрийн үйлчилгээ бий болгох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг үндэсний соёлын бодлогод тусган хэрэгжүүлдэг. Монгол улс “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг 2015 онд батлан хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хөтөлбөрт:

- соёлын үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх

- соёлын салбарт хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх
- улс, үндэстнийхээ арвин баялаг өв уламжлал, ёс заншил, байгалийн өвөрмөц дүр төрх, соёлын нөлөөг сэргээх, хайллан хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах, дэлхий нийтэд таниулах, сурталчлах арга хэмжээ авч, өөрийн орны нөөц, бололцоонд тулгуурлан соёлын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх зорилгыг дэвшүүлжээ.

“Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж, нийгэм, эдийн застийн үр ашгийг харгалзан үзэж дараах хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд:

- кино урлаг (бүх төрөл)
- дизайн, дурслэх урлаг (хувцас загвар, дизайн, гар урлал, уран зураг)
- тайзны уран бүтээл (урлагийн бүх төрлийн тогтолт, үзүүлбэр)
- соёлын өв, уламжлал, зан заншил, соёлын аялал жуулчлал



Үйл ажиллагаа 2.2. Асуултад хариулаарай.

1. Соёлын үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн соёл гэсэн ойлголтууд ямар ялгаатай вэ?
2. Таны хамгийн их сонирхдог, эсвэл хамгийн сайн мэддэг соёлын үйлдвэрлэлийн төрөл юу вэ?
3. Соёлын үйлдвэрлэлийн онцлог, соёлын шалгуур нь юу вэ?
4. Энэхүү үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлагын талаар та ямар бодолтой байна вэ?

СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Хүснэгт 2.1. 2018 оны 1 сарын жуулчдын мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан мэдээ

Монгол улсад ирсэн гадаадын иргэд	2017 оны 1 сар	2018 оны 1 сар	Зөрүү /тоо/	Зөрүү /хувь/
Нийт: Зорчигч	22516	27209	4 693	17.25%
Үүнээс: жуулчин	19548	22233	2 685	12.08%
1.Ази, номхон далай	11059	12090	1 031	8.53%
2.Европ	7748	9286	1 538	16.56%
3.Америк	693	777	84	10.81%
4.Африк	34	43	9	20.93%
5.Ойрх дорнод	14	37	23	62.16%

Эх сурвалж: Хил хамгаалах ерөнхий газар

Өмнөговь, Хөвсгөл аймагт голчлон очдог. Ирж буй жуулчид манай орны унаган байгаль, нүүдэлчдийн зан заншил, Чингис хааны тухай илүү их сонирхдог. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээлж байгаагаар сүүлийн 5 жилд зөвхөн Улаанбаатар хотод аялал жуулчлалын салбарт ажиллагчдын тоо жилд дунджаар 1114 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

Соёлын үйлдвэрлэлийн салбарт аялал жуулчлал онцгой байр суурь эзэлдэг. Жишээ нь, энэхүү мэдээ, судалгаа янз бүрийн угсаатны төлөөллийн манай соёлын орон зайд амьдарч үзэх, бидний амьдралын хэв маягтай танилцах хүсэл сонирхол нэмэгдсээр байгааг харуулж байна.

Манай улсыг зорин ирсэн жуулчид Төв, Өвөрхангай,

**Үйл ажиллагаа 2.3 Эх сурвалжтай ажиллаарай.****Хүснэгт 2.1. ДНБ ба Аялал жуулчлалын салбарын нийт орлого**

Үзүүлэлт	Огноо	2012	2013	2014	2015	2016
Аялал жуулчлалын салбарын нийт орлого, сая ам.долл		286.5	263.2	253.8	277.0	312.8
ДНБ-д эзлэх хувь хэмжээ, %		2.3	2.1	2.11	5.3	5.6

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, 2016, YCX

Асуулт:

1. Аялал жуулчлалын салбарын орлого 1%- аар өсөхөд түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээ хэдэн хувиар өсөж байна вэ?
2. Аялал жуулчлалын салбарын орлого болон түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээг графикаар илэрхийлж тэдгээрийн хоорондын хамаарлын чиглэлийг тогтооно уу
3. Графикаас ямар асуудал ажиллагдаж байна вэ?
4. Тус асуудалд хүргэсэн шалтгааны талаар юу гэж бодож байна вэ?

Соёлын аялал жуулчлал ямар ач холбогдолтой вэ?

- эдийн засгийн өсөлт, нийгмийн тэгш байдлыг хангаж, бие хүний хөгжлийг дэмжинэ.
- олон улсын харилцаа, харилцан хүндэтгэл, ойлголцол, энх тайвнаар зэрэгцэн орших зорилгод эерэгээр нөлөөлнэ.
- түүх, соёлын үнэт зүйлсийг нийтийн хүртээл болгодог.
- өөрийн соёлын өвөрмөц хэв маягийг тодруулах, бэхжүүлэхэд тусалдаг.
- үндэсний бахархлыг сэргээх, соёлын дархлааг идэвхжүүлдэг.
- бусдын соёлд хүндэтгэлтэй хандах, хүн төрөлхтний оюун ухааны ололт амжилттай танилцах, танин мэдэх арга хэрэгсэл болдог.
- соёлын олон янз байдал, баялаг шинжийг зөв ойлгох, хүлээн авах, хүндэтгэх боломжийг бүрдүүлдэг.
- хүн төрөлхтнийг оюун санааны болон ёс суртахууны нэгдмэл байдалд уриалан дуудах хүчин зүйлийн нэг болдог.
- хөдөө орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлснээр хот руу чиглэх хүн амын урсгалыг багасгадаг зэрэг ач холбогдолтой юм.

Хүмүүс соёлын хэрэгцээгээ хангахын тулд шинэ мэдлэг, туршлага хуримтлуулах, одоо ба өнгөрсөн үеийн түүхийг төлөөлж байгаа газар нутаг, үйл ажиллагааг сонирхох, судлах зорилгоор өөр газар оронд аялдаг. Ийнхүү биеэр очиж үзэх, судлах, аялан жуулчлах гол шалтгаан нь соёлын олон янз байдал юм. Соёлын агуулгагүй аялал жуулчлалын төрөл гэж үгүй. Учир нь хүмүүс очиж буй улс орныхоо үндэсний хэлээр ярихгүй ч гэсэн сонсон мэдрэх, соёлын тэмдэг дохиог нүдээр үзэх, телевиз, театр урлагийн тогтолц үзэх, үндэсний хоол ундаар дайлуулах, орон гэр, тээвэр холбоогоор үйлчлүүлэх, түүх, соёлтой нь танилцах гэх зэрэгээр соёлын орчинд нь ордог. Энэ утгаар нь судлаачид соёлыг аялал жуулчлалын хамгийн анхдагч орчин гэж үздэг.



Тулгуур ойлголт

Соёлын аялал жуулчлал. Түүх, соёл, урлаг, амьдралын хэв маяг, үнэт зүйл, үнэлэмж, уламжлал зэрэг соёл хоорондын харилцааны олон хэлбэрийг багтаасан өөр соёлын орчинтой биечлэн танилцах аяллыг хэлнэ.

Соёлын аялал жуулчлал хэмээх ойлголт 1970-аад оноос нийтийн хэрэглээнд нэвтэрчээ.

Соёлын аялал жуулчлал нь бусдын соёлыг өөрийн бие, сэтгэлээр мэдэрч судлах, хэрэглэх, хүлээн авах үйл ажиллагаа юм. Бас тухайн ард түмний соёл, ёс заншил, үнэлэмж, үнэт зүйлс аялал жуулчлалын эргэлтэд орж байгаагийн илрэл юм.

Соёл нь жуулчдын сонирхлыг татдаг нэг үндсэн хүчин зүйл бөгөөд энэ чиглэлийн үйлдвэрлэл бол соёлын аялал жуулчлал мөн. Энэ үйлдвэрлэл нэг талаас, улс үндэстний соёлын өвөрмөц байдал, түүх, соёлын өвд түшиглэх, негөө талаас, жуулчдын эрэлт хэрэгцээнд түшиглэн хөгжиж байна.



Бүдүүч 2.1. Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд баримтлах зарчмуудаас

Соёлын аялал жуулчлалыг байгалийн болон соёлын нөөц баялгийг зөвхөн үзэж сонирхох төдийхнөөр хязгаарлаж болохгүй юм. Манай судлаачид соёлын өвийн хадгалалт, хамгаалалт муудаж байгаа, хадгалан тээгчид нь жилээс жилд цөөрч байгаа, язгуур соёлын нөөц хомсдож байгаа талаар олонтоо тэмдэглэдэг. Соёл, ёс заншилаа хадгалж хамгаалах, түүнийг тээж яваа хүмүүстэй нь уулзах, дотносих хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Энэ утгаараа соёлын аялал жуулчлал нь өрсөлдөх чадвар сайтай салбар юм.

Энэ салбар уламжлалт эдийн засгийн салбар биш боловч орчин үед улс орнуудын хөдөө аж ахуй, уул уурхай болон аж үйлдвэрийн салбартай өрсөлдөхүйц салбар болон хөгжиж байна.

Соёлын аялал жуулчлал

Дотоодын аялал жуулчлал

Олон улсын аялал жуулчлал

Бүдүүч 2.2. Соёлын аялал жуулчлалын төрөл

Нөгөө талаас, үйлдвэрлэлийн нэг төрөл төдийгүй, амьдралын шинэ хэв маяг, ертөнцийг үзэхүйн шинэ хандлага болон хөгжиж байна.

Судлаачид манай улсад соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэн түрүүнд тулгамдаж буй асуудлыг жуулчдын саналд үндэслэн гаргажээ. Үүнд:

- бүс нутгийн онцлог бүхий брэнд бүтээгдэхүүнтэй болох
- байгалийн гамшиг, утаа, халдварт өвчин, улс төр, эдийн засгийн тогтвортгүй байдал, тээврийн хэрэгсэл зэргээс шалтгаалан жуулчдын аюулгүй байдлыг хангах
- эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах
- түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах
- байгаль орчноо хайрлан хамгаалах
- зочид буудлын үйлчилгээг сайжруулах
- уламжлалт ёс заншлаа сайн судалж, илүү тод таниулах боломжийг бүрдүүлэх
- соёлын аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх
- хөдөө орон нутагт дэд бүтэц, замын сүлжээг сайжруулах
- шинжлэх ухаан, техникийн дэвшлээр улс орнуудын бүтээгдэхүүн, хэрэглээ ихээхэн ижилсэж байгаа өнөөгийн нөхцөлд нүүдлийн соёлын өвөрмөц төрх, давуу талыг тодруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- угсаатны аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх
- зөв оновчтой бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангах
- жуулчдын тоо өсөн нэмэгдэх хэрээр байгаль, орчин соёлын өв газруудад үзүүлэх сөрөг нөлөөллийг судлах зэрэг орж байна.



Үйл ажиллагаа 2.4. Мэдээллийг уншаад асуултын дагуу ажиллаарай.

- a. Хүн бүхэн эрхээ мэддэг байх, амьдралын өөр хэв маягийг ойлгодог, хүлээнтэй байх хэрэгтэй болов.
- b. Улс үндэстнүүдийн харилцаанд хүндэтгэлтэй хандсан, хүнлэг, шударга хамтын ажиллагааг эрхэмлэх хэрэгтэй болов.
- c. Монгол гэрээ барьж чаддаг өрхийн тэргүүн, хоймортоо сууж үлгэрээ ярьж туулиа хайлдаг өвгөд, дээс томж, утас ээрэх эмгэд, адгуугаа манаж, морьдоо сойж, айргаа исгэдэг өрчүүд, саалиа авч, цагаан идээгээ боловсруулдаг эзэгтэй нар, шилбүүр унан наадаж, эцэг эхээсээ монгол ухаанаа өвлөх багачууд бүгд оршин байх хэрэгтэй болов.

Асуулт:

Мэдээллүүд соёлын аялал жуулчлалын хөгжилд ямар ач холбогдолтой вэ? Мэдээлэл тус бүрд тайлбар хийж, ярилцаарай.



Гэртээ хийгээрэй.

Танай орон нутагт соёлын үйлдвэрлэл явуулж буй ямар байгууллага, хувь хүмүүс байна вэ? Тэдгээрийн үйл ажиллагааны онцлог, орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг судлан, дүгнэлт хийж танилцуулаарай.



Нэмж судлаарай

- “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр 2015 он
- “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, 2012 он
- Аялал жуулчлалын статистик. АЖГ., 2014-2016.
- Долгорсүрэн.Ж “Соёлын аялал жуулчлал” судалгааны тайлан. УБ., 2005.
- Статистикийн эмхэтгэл, 2016. YCX
- Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын вэб хуудас:

www.unwto.org/www.1212.mn

<http://www.unesco.ee/bct>

СЭДЭВ 2.2 СОЁЛЫН ДАЯАРШИЛ



Үйл ажиллагаа 2.5. Дараах мэдээллийг уншаад асуултын дагуу багаар ажиллаарай.

Бид өндөр хөгжилтэй орнуудын хэрэглээнд байгаа бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэж, материаллаг тав тух бүхий орчин бүрдүүлж чадаж байна. Хот, хөдөө гэлтгүй манай иргэд гар утсыг албан болон албан бус харилцаанд олон зориулалтаар ашиглаж байна. Олон хүн гадаадад сурч, амьдарч байна. Цахим технологийн үр шимээр ном зохиолыг төрөлх хэл дээр нь унших, судлах, нэр томъёоны цахим лавлагааг ашиглах боломж бүрдэж байна. Бас сонирхсон асуудлын дагуу судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд үр дүнг өөрийн нэрээр дэлхий нийтэд таниулах боломжтой болов.

Хүмүүс гэрээсээ, өөр улсаас эсвэл өөрийн боломжит цагтаа хийдэг хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрүүд ч бий болов. Энэ бүхэн бол шинжлэх ухаан, технологи нь олон салбарт гайхамшигийг бүтээж байгаагийн илрэл юм.

Орчин үед бидний хүүхдүүд юу чухал болох, ямар үр дагавартай болохыг мэдэхгүйгээр олон цагийг цахим орчинд өнгөрөөх болов. Тэд доромжил, хэрүүл, хүчирхийлэл, гэмт хэрэг гэх мэт хүсээгүй, шаардлагагүй зүйлсийн талаар уншиж байна. Нийгэмд эдийг шүтэх хандлага, зохисгүй хэрэглээ, буруу хэвшил, авлига, хулгай дээрэм дэлгэрэх зэрэг гаж үзэгдлүүд ихсэж байна. Ийм сөрөг үзэгдлүүд манай улсын хөгжилд чөдөр тушаа болж байна. Энэ бүхэн бол зөвхөн материаллаг зүйлсийн хөгжлийн хойноос хөөцөлдөж, оюун санааны үнэт зүйлсийн төлөвшлийг орхигдуулж байгаатай холбоотой.

ХХ зууны сүүлээр ардчилал, зах зээлийн харилцаа өргөжин тэлж, улс орон, ард түмний соёлын харилцаа эрс өслөө. Соёлын нийгмийн үүрэг улам тодорч, эдийн засаг, улс төр ч соёлын онцлогоор тодорхойлогдох болов. Өөрөөр хэлбэл, соёлын онцлог нь эдийн засаг, улс төрийн бодлогыг тодорхойлж байна гэсэн үг. Энэ бүгд нь соёл судлалын үүрэг, ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Өнөөдөр соёл судлалд угсаатны соёл судлал, соёлын философи, соёлын эдийн засаг, соёлын газар зүй, соёлын социологи, соёлын сэтгэл зүй, соёлын экологи, соёлын үйлдвэрлэл, тэрчлэн музей судлал, номын сан судлал гэх мэт олон салбар бий болов. Энэ бүхэн нь соёл нийгэмд асар их үүрэгтэйг харуулж байгаа юм.

Асуулт:

- Мэдээлэл тус бүрийн гол утга санаа юу вэ?
- Мэдээллүүд хоорондоо ямар хамааралтай вэ?
- Мэдээллүүдийг нэгтгэж, гол утга санаагаар нь эргэцүүлэмж бичээрэй. Үгийн тоо 60-80.
- Эргэцүүлэмжийнхээ утга санааг илэрхийлсэн оновчтой гарчиг өгч, үндэслэлээ тайлбарлан ярилцаарай.

Орчин үед дэлхийн улс орнууд эдийн засаг, санхүү, улс төр, хэл, соёл, техник, технологийн салбарт нэгдэн нягтрах үйл явц эрчимтэй явагдаж байна. Улс орнуудын санхүү, хөрөнгийн зах зээл харилцан хамааралтай болж, нэг орны эдийн засгийн хямрал бүс нутагт, бүс нутгийн хямрал нь дэлхийд нөлөөлөх болов. Соёлын солилцоо эрчимжиж, хүмүүс хормын дотор өөр тивд байгаа наиз нөхөдтэйгээ холбогдох, дэлхийн өнцөг булан бүрд түргэн шуурхай зорчих, мэдээллийг нэгэн зэрэг хүлээн авах боломжтой болж байна. Энэ бүхний нөлөөгөөр амьдралын уламжлалт хэв маяг, уламжлалт сэтгэлгээ өөрчлөгдэж, амьдралын шинэ хэв маяг бий болж байна. Соёлуудын нэгдэн нягтрах үйл явц ийнхүү бидний амьдрал, нийгмийг бүхэлд нь хамрах болов. Энэ үзэгдлийг бүхэлд нь соёлын даяаршил гэсэн ойлголтоор илэрхийлдэг. Соёлын даяаршил хэмээх ойлголт соёл судлалд 1980-аад оны төгсгөлөөс бий болжээ.



Тулгуур ойлголт

Соёлын даяаршил. Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг хэлнэ.

Янз бүрийн улс орны ард түмэн ялгаатай байдлаа үл харгалзан харилцан ойлголцож, нэгдсэн даяар соёл руу тэмүүлэх болсон нь өдгөө хөгжлийн хүлээн зөвшөөрөгдсөн хандлага боллоо.

Соёлын даяаршил нь эрдэм соёлын чуулган, кино наадам, урлаг, спортын

өдөр, үзэсгэлэнг нөгөө орондоо зохион байгуулах, урлаг, спортын одуудын солилцоо, уран зохиол, орчуулгын зохиол бүтээлийн солилцоо, багш, оюутан солилцоо, хамтын судалгаа, төсөл, хөтөлбөр, соёлын стратеги түншлэлийн харилцаа, хэвлэл мэдээллийн солилцоо, биет ба биет бус соёлын туршлага солилцоо, хоёр улсын хамтарсан кино, урлагийн тогтолц, аялал жуулчлал гэх мэт олон арга хэлбэрээр хэрэгжиж байна. Эндээс харахад соёлын даяаршил нь олон талын боломжийг олгодог. Үүнд:

- мэдээлэл, бараа бүтээгдэхүүн, хүн хүчээ ч дэлхий даяар солилцох, хамтран ажиллаж, хамтдаа хөгжих боломж
- ямар ч төрлийн мэдээллийг хоромхон зуурт авах, өгөх боломж
- чөлөөт худалдаа, олон улсын худалдаа, бизнесийн үйл ажиллагаа тэлэн хөгжих, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд борлуулах боломж
- олон ургалч соёл дэлгэрч, янз бүрийн соёлыг мэдрэх боломж
- олон улсын аялал жуулчлал хүрээгээ тэлж, гадаадын бүтээгдэхүүн, соёлыг хэрэглэж, шинэ арга технологид суралцах боломж
- соёл, урлаг, спортын тэмцээний цар хүрээ, хэлбэр улам бүр өргөжих боломж
- өндөр хөгжилтэй орнуудад суралцах боломж
- үндэсний соёлын үйлдвэрлэлээр олон улсад өрсөлдөх чадварт эзэрэгээр нөлөөлөх боломж
- соёл, боловсрол хариуцсан олон нийтийн байгууллагын үүрэг өсөн нэмэгдэх боломж
- муу муухай үзэгдэл, түрэмгийлэл, хүний эрхийн зөрчилтэй тэмцэх хамтын ажиллагаа сайжрах боломж
- түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засах, хадгалан хамгаалах, материаллаг баазыг нь бэхжүүлэхэд хамтран ажиллах гэх мэт олон боломжийг өргөжүүлж байна.



Үйл ажиллагаа 2.6. Соёл хэмээх ойлголтын утга агуулгад хэл, ёс заншил, мэдлэг, боловсрол, шашин шүтлэг чухал байр суурьтай гэдгийг та бүхэн мэднэ. Дараах бүдүүвчийг нөхөн гүйцээж манай улсад соёлын даяаршил хэрхэн илэрч байгааг харуулаарай

Хэл: Бүх шатны сургуульд англи хэлийг зааж байна. Англи, хятад, орос, япон, солонгос хэлний сургалтын төв, сургуулиуд олширч байна. Бизнесийн байгууллагуудын ажлын байрны тодорхойлолтыг үзэхэд гадаад хэлний боловсрол хамгийн чухалд тооцогдож байна гэх мэт

Ёс заншил, итгэл
үнэмшил:

Мэдлэг, боловсрол:
.....

СОЁЛЫН ДАЯАРШИЛ

Урлаг:

Шашин шүтлэг:
.....

Соёлын даяаршлыг соёлын олон янз байдал, оршин тогтнолд аюул дагуулдаг хэмээн үзэх нь бий. Нөгөө талаас, орчин цагт олон янзын үзэл, өөр чиг хандлага бий болж, зэрэгцэн оршиж байна, хүн бүх талаар хөгжих боломж нэмэгдэж байна. Иймд даяаршил бүгдийг адилхан болгодог үйл явц биш юм гэсэн хандлага ч бас байдаг. Бодит байдал дээр эерэг, сөрөг үр дагаврын аль аль нь байна. Соёл нь даяаршлын өмнө тэгш байж чадахгүй учир тэсэж үлдэхийн төлөө тэмцэл хийж буй соёлын өөрийгөө илэрхийлэх хэлбэрийг хадгалан үлдэхийн тулд бүх талын боломжит хүчин чармайлт гаргах учиртай хэмээн ЮНЕСКО-гийн Дэлхий дахины тайлан илтгэл ("Соёлын төрөл зүйл, соёл хоорондын харилцааг тэтгэхүй" Люксембург., 2009., 28 дахь тал)-д дурдджээ. Тиймээс соёлын олон төрөл зүйлээс юуны түрүүнд үндэсний соёлын өвөрмөц шинжээ хадгалах, үндэсний онцлогийг даяаршлын сул талд алдахгүй байх нь чухал юм.



Үйл ажиллагаа 2.7. Мэдээллийг уншиж, асуултын дагуу ажиллаарай.

Одоогийн залуус хүмүүжилгүй, хувшия хичээсэн, эх оронч бус байна гэсэн зэмлэл байдаг. Телевизийн сувгууд олон түмнийг залж, цахим орчин зарим талаар хөнөөн сүйтгэгч боллоо гэсэн харамсал байдаг. Бас юуг шүтэхээ мэдэхгүй, юуг шүтэж байгаагаа ч ойлгодоггүй өнөө үеийнхэн айх болгоомжлох зүйлгүйгээр хайран сайхан байгалаа сүйтгэж дуусаж байна гэдэг. Соёлын амьдралд шоу урлаг, үзвэр цэнгүүний бизнес давамгайлж, урлаг, соёлын цэнгүүлэх, зугаацуулах чиглэл нь үлээмж газар авах болов гэсэн шүүмжлэл бас бий.

Асуулт:

1. Та энэхүү шүүмжлэлт байр суурьтай санал нийлж байна уу?
2. Эдгээр саналд ямар нийтлэг асуудал байна вэ?
3. Асуудлыг шийдвэрлэхийн тулд яах ёстой вэ?
4. Соёлын даяаршил бол хөгжингүй улс орнуудын дарангуйлал мөн гэдэгтэй та санал нийлэх үү? Яагаад?

Даяаршил нь зөрчилгүй үйл явц биш ажээ. Даяаршил өөртөө шинэ боломжуудыг тээж, бас шинэ эрсдэлийг дагуулж байна. Эрсдэлтэй тал нь өөрийн соёлын зарим үнэт зүйл, амьдралын уламжлалт хэв маягаас татгалзах хандлагыг бий болгож байгаад оршино. Даяаршлын үр дагаврын асуудалд нийгмүүд өөр өөрийн байр сууринаас ханддаг. Гэхдээ ихэнх улсуудад бусад соёлын үнэлэмж нэвтрэхээс зайлсхийх, соёлын ойртон нягтрах үйл явцыг шүүмжлэх байр суурь давамгайлж байгааг судлаачид тэмдэглэдэг. Үүний илрэл нь орчин үеийн шашны мөргөлдөөн, үндэсний үзэл, бүс нутгийн шинжтэй тэмцэл, хөдөлгөөнүүд юм. Ийм үзэгдэл, ялангуяа, Ази, Африк, Латин Америкийн улс орнуудад зонхилох шинжтэй байна.

Амьдралын нийтлэг хэв маяг дэлхий нийтэд түгэн тархаж, энэ үйл явцтай зэрэгцэн ард түмнүүд өөрийн соёлын өвөрмөц онцлогийг мэдэрч эхлэв.



Бүдүүвч 2.3. Соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрүүд

тулган хүлээлгэх гэсэн хэлбэрүүд юм.

Тус илтгэлд соёлыг хуулбарлан дуурайх гэдгийг “нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан, өмнөх соёлын дадал хэвшлээсээ хавьгүй илүүд үзэж хүлээн зөвшөөрсөн сэтгэлгээний үр дүн юм” гэжээ. Ийм байдал орчин үеийн соёлын зарим төрөл, тухайлбал, урлагийн төрлүүдэд хүчтэй нөлөөлж үр дүн авчирдаг ч үндэсний соёлд сэргөөр нөлөөлдөг сэтгэлгээ ажээ. Харин соёлын тулгалт бол ихэвчлэн тухайн цаг үеийн хүчирхэг гүрнүүдийн зүгээс бага буурай улс оронд хандсан үйлдэл юм. Соёлын тулгалт нь бүтээсэн бүхнийг устгаж, хүнийг тэр зүйлээ дахин бүтээхгүй болтол нь айлган сүрдүүлэх үйл явц мөн. Жишээлбэл, 1930, 1940-өөд оны үед манай улс уламжлалт шашин, соёл, үндэсний бичиг үсэг зэргээ орхиход хүрсэн нь ийм тулгалтын хэлбэр байсан гэж зарим судлаачид тэмдэглэжээ. Харин соёлын солилцоо нь илүү ерөнхий ойлголт бөгөөд улс үндэстэн, угсаатны соёл харилцан үйлчлэлцэх хэлбэрүүд юм.

Даяаршлын үеийн үндсэн бодлого юу вэ? Дэлхий нийтийн хэмжээнд даяаршлын үед барих үндсэн бодлогыг тогтвортой хөгжлийн үзэл баримтлал юм гэж хүлээн зөвшөөрч байна. Тогтвортой хөгжлийн үндэс нь байгаль, нийгмийн хөгжлийн зүй тогтлыг алдагдуулахгүй байх, ёс суртахууныг дээдлэх, тухайлбал, нийгмийн хариуцлагаа биелүүлэх, сахилгыг өндөржүүлэх явдал юм. Үр хүүхэд болон хойч үеэ ирээдүйд сайн сайхан амьдраасай хэмээх хүсэл эрмэлзэлтэй тогтвортой хөгжлийн үзэл санаа бүрэн нийцдэг. Улс орон бүхэн байгаль орчноо хайрлан хамгаалж, нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын оновчтой бодлого хэрэгжүүлж, үндэсний дархлаагаа хадгалж гэмээнэ тогтвортой оршин тогтонох, хөгжих юм.

ЮНЕСКО-гийн ”Соёлын төрөл зүйл, соёл хоорондын харилцааг тэтгэхүй“ сэдэвт дэлхий дахинь тайлан илтгэлд хүн төрөлхтний олон талт өвийн үндэс болсон соёлын харилцан үйлчлэлийн гурван үндсэн хэлбэр байдаг гэжээ. Энэ нь соёлыг хуулбарлан дуурайх, соёлын солилцоо, соёлыг

Экосистем нь хүнгүйгээр оршин тогтнож чадна. Харин хүн экосистемгүйгээр, экосистемийн үйлчилгээг авахгүйгээр оршин тогтнох чадваргүй юм. Экосистем нь соёл иргэншлээ агуулдаг гэдэг утгаар нь өнөөгийн соёл иргэншил ба байгаль орчныг бүхэлд нь ногоон соёл иргэншил гэж нэрлэж байна. Монгол улс 2005 онд дэлхийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт нэгдэн орсон билээ. Энэхүү хөтөлбөрт харилцан шүтэлцээтэй эх дэлхийн зүй тогтолд хүндэтгэлтэй хандах, байгалиа нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг хамгаалах явдлыг манай эрин үеийн эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн шалгуур, улс үндэстэн, гэр бүл, хувь хүний эрхэмлэх зүйл мөн гэдгийг тодорхой зааж өгсөн байдал.

Уг хөтөлбөрт хувь хүний чадварыг дээшлүүлэхийг онцлон тэмдэглэжээ. Үүнд:

- өнөөдрийн аж төрөх ёс ирээдүйд нөлөөлдөг гэдгийг ухаарах
- нийгмийн, биологийн, соёлын олон янз байдал ба нэгдэлд хүндэтгэлтэй хандах
- нийгмийн шударга ёс, тэгш эрхийн зарчмыг хүндэтгэх
- аливаа асуудлын шийдлийг нийгэм, соёл, эдийн засаг, байгалийн харилцан шүтэлцээнд авч үзэх
- амьдралынчанарыг дээшлүүлэхэд хувийн болон хамтын шийдвэр гаргахуйц мэдлэг, чадвартай байх



Бүдүүч 2.4. Тогтвортой хөгжлийн гол утга санаа



Гэртээ хийгээрэй.

1. Дараах хүснэгтийн дагуу ажиллаарай

Даяаршил хэмээх ойлголтын гол шинж юу вэ?	Танай орон нутагт соёлын даяаршил ямар ээрэг үр дүн өгч байгаа вэ?	Танай орон нутагт соёлын даяаршлаас үүдсэн ямар сөрөг үзэгдэл байна вэ?	Сөрөг нөлөөг даван туулах ямар арга зам байна вэ?	Танай орон нутгийн тогтвортой хөгжилд ямар хүчин зүйлс нөлөөлөх вэ?

2. Асуултад хариулж бичээрэй

1. Соёлыг хуулбарлан дуурайх үзэгдэл яагаад гардаг вэ? Үүнд ямар хүчин зүйлс нөлөөлдөг вэ?
2. Соёлыг хуулбарлан дуурайх үзэгдэл таны бодлоор ямар үр дагавартай вэ?
3. Соёлыг хуулбарлан дуурайх үзэгдэл манай нийгэмд байгаа эсэхийг жишээ, баримтад тулгуурлан тайлбарлана уу.

СОЁЛЫН ОРОН ЗАЙ ГЭЖ ЮУ ВЭ?



Үйл ажиллагаа 2.8. Эх сурвалжийг уншаад асуултад хариулаарай.

Дарангуйллын дэглэмтэй улс оронд мэдээллийн тоог нэмэгдүүлнэ гэдэг нь, нэг талаас шууд хувьсгалд хүргэнэ гэсэн уг. Нөгөө талаас, мэдээллийн илүүдэл нь сайн үр дүнд хүргэхгүй. Хэтэрхий их байна гэдэг бол ерөөсөө тэг буюу хоосон гэсэнтэй адилхан. Өнөөдөр цахим орчноос ганцхан асуултад арван мянган нэр төрлийн ном бүхий хариу хүлээн авч болно. Тэдгээрт яаж хандах вэ? Ийм тохиолдолд тэр арван мянган ном ердөө л тэгтэй тэнцэнэ.

Ном хэвлэлийн “төгсгөл” ирж буй тухай ярих нь илүүц биз ээ. ... ном хүмүүсийн амьдралд цаашид ч үргэлжилж, баяр баясгаланг бэлэглэсээр байх болно. Өнөөдөр бид бүхний дасал болсон “уншигч” хэмээх ойлголтын оронд мэдээллийн программуудыг “хэрэглэгч” хэмээх ойлголт нэвтэрсэн. Цахим орчинд “бүх юм” бий. Шинэхэн сонин сайхан мэдээ, дуулиан шуугиан, нийслэл, том хотуудын болон хөдөө орон нутгийн сонин сэтгүүл, дэлхий дахинь хөрөнгийн биржүүд дээрх янз бүрийн хувьцааны ханшийн мэдээ, зээллэгийн хувь хэмжээ, тухайн долоо хоногийн буюу тухайн өдрийн валютын ханш, олон улсын нислэгийн хуваарь гэх мэт. Компьютерээсээ холдолгүйгээр Ерөнхийлөгчтэй уулзаж, түүнд асуулт тавин хариулт авч болно.

Эх сурвалж: В.П.Большакова. Кибер орон зай бол бодит байдлын шинэ хэв шинж мөн. Орч. С.Энхбаяр. МУБИС. НХУС-ийн ЭШБ №6

Хүмүүсийн ном уншихад зарцуулдаг цаг бараг үгүй болсон гэхэд болно. “NOP World” компанийн гаргасан судалгаагаар дэлхийн хамгийн их ном уншдаг орноор Энэтхэгийн иргэд шалгарчээ. Тэд уншлагад долоо хоногт 10.7 цагийг зарцуулдаг аж. Энэ жагсаалтыг Хятад, Тайланд, Филиппин, Египет зэрэг орнууд үргэлжлүүлж байгаа бол АНУ уг жагсаалтын 23-рт бичигджээ. Энэ нь тус орны иргэд ном уншихад долоо хоногт 5.7 цаг зарцуулдаг гэсэн уг юм. Манайд 1989 оны байдлаар 418 номын сан байсан бол, 2007 оны байдлаар 278 болж 33.5 хувиар буурсан үзүүлэлт гарчээ. Номын сангийн уншигчдын тоо 1989 онд 6431 байсан бол, 2012 оны байдлаар 2233 болж 65.3 хувиар буурчээ. Үүнийг мэдээллийн олон шинэ сувгууд гарч ирсэн, чөлөөт цагаа өнгөрүүлэх бусад боломж нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байгаа ажээ.

Эх сурвалж: Г.Амарсанаа.
Даяаршил ба монголчууд. 2012

Асуулт:

1. Эх сурвалжуудад өгөгдсөн мэдээлэлд ямар ялгаатай болон нийтлэг талууд байна вэ?
2. Цахим орчны хэрэглээний ээрэг, сөрөг үр дагаврын талаар өөрийн санаагаа илэрхийлнэ үү
3. Өнөө үед номын сан, ном уншигчдын тоо цөөрч байгаа нь хэвийн үзэгдэл мөн эсэх талаар санаагаа илэрхийлнэ үү.

Соёл нь амьдралын орчин, нутаг орны байдалтай холбоотой. Хүн төрөлхтний түүхэнд далайн, уулын, голын, тал нутгийн, ойн гэх мэт янз бүрийн соёл дурдагдаж байдгийг та бүхэн мэднэ. Эдгээр нь байгалийн хүчин зүйлс боловч тэднээс амьдралын хэв маяг, аж ахуй, оромж сууцны шинж чанар, харилцааны хэв маяг, хоол ундны төрөл, итгэл үнэмшил, үнэлэмж гэх мэт олон зүйл шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл, тухайн улс үндэстний соёлын хэлбэр төрх нь өөрийн гэсэн оюун санааны өвөрмөц орон зайг бий болгодог. Энэ нь соёл бүтээгчийнхээ оршин амьдрах эрмэлзлийг илэрхийлсэн утгат чанар байдагтай холбоотой. Тухайлбал, угсаатан бүхэн хэл, бичиг, итгэл үнэмшил, урлаг, утга зохиол, өв, зохицол, эмх цэгц, үндэсний мэдрэмж зэрэг өөрийн гэсэн үнэт зүйлстэй. Эдгээр нь нийлж тухайн үндэстэн, угсаатны хувьд онцгой утга холбогдол бүхий оюун санааны орон зайг бий болгодог.

Энэхүү орон зай эргээд хүмүүсийг оюун санааны хувьд тэжээн тэтгэж, төлөвшил олгож, соёлын үнэт зүйлсээ хайлрлах, хадгалах сэдэл, мэдрэмжийг өгч байдаг. Жишээ нь, үндэснийхээ барилга, ном, зураг, хөгжим зэрэг соёлын биет болон биет бус зүйлсээс хүн ухаан бодол, таашаал, сургамжийг хүртэж болно. Монгол гэр л гэхэд зүгээр нэг орон гэр төдий биш, харин манай ард түмний олон янзын бэлгэдэл, итгэл үнэмшилийг тээгч юм. Жишээ нь, гэрийн тоонон дээгүүр алхах, гишгэхийг цээрлэдэг нь угтаа тооныг гэрийн толгой, тэргүүн буюу хүний тэргүүнээр төсөөлөн бэлгэддэгтэй нь холбоотой.



Тулгуур ойлголт

Соёлын орон зай. Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг орчныг хэлнэ. Соёлын орон зай нь төрсөн нутаг биш, соёлын дурсгалт зүйлс биш, харин улс үндэстэн, хүмүүсийн хамтын мэдрэмж юм.

Кибер орон зай. Компьютер, технологи, цахим сүлжээнд суурилсан соёлын харилцаа, нөлөөллөөр бий болж буй хамтын мэдрэмжийг кибер орон зай гэдэг.

шинэ барааны сурталчилгаа, хотын өнгө үзээмжийн өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлс соёлын орон зайн дүр төрхийг өөрчилсөөр иржээ. Орчин үед электрон технологи, мэдээлэл харилцааны хөгжил нь орчин үеийн соёлын орон зайд дахь шинэ өнгө төрх, голлох шинж тэмдэг болж байна. “Цахим оршихий” хэмээх шинэ ойлголт бий болов. Энэ ойлголтыг дэлхийн соёлын орон зайд соёл хоорондын харилцан ойлголцлыг нэвтрүүлэх арга зам гэсэн утгаар ойлгож болно.



Үйл ажиллагаа 2.9. Асуултад хариулаарай.

1. Соёлын орон зайд бол улс үндэстэн, хүмүүсийн хамтын мэдрэмж, үнэлэмж юм. Монголчууд бидний хамтын мэдрэмж, үнэлэмжийг тодорхойлогч тэдгээр хүчин зүйлсэд юу юу багтаж вэ?
2. Соёлын орон зайд, кибер орон зайд гэсэн ойлголтуудын аль нь багтаамжаараа их вэ? Яагаад?

Орчин үед цахим орчны хэрэглээний үр дүнд мэдээллийн чөлөөтэй урсгал бий болж, хүмүүсийн сэтгэлгээ болон зан төлөвийн ижил дүрэм журмыг дэлгэрүүлэгч соёлын онцгой харилцаа, шинэ орон зайд бий болж байна. Мэдээллийн технологиор тодорхойлогдож буй харилцааны энэхүү шинэ хэв маягийг кибер орон зайд гэсэн нэр томьёогоор илэрхийлдэг. Жишээ нь, цахим орчны нөлөөн дор хувь хүний үнэт зүйл, хүсэл сонирхол, үнэлэмжийн чиг баримжаа, амьдралын байр суурь, сэтгэл санааны байдал болон үзэл бодол тэргүүтэн өөрчлөгдөн хувьсаж байна. Харилцааны хэлнүүд түгэн дэлгэрч байна.

Цахим сүлжээг ашиглаж соёлын өв уламжлалыг түгээх, дамжуулах болов. Цахим орчин, компьтерийн технологи нь оюун санааны болон сэтгэл хөдлөлийн нөөц, чадвар чадамжийг баяжуулж, танин мэдэхүйн болон харилцаа холбооны бололцоог нь тасралтгүй өсгөн нэмэгдүүлж байна. Кибер орон зайн онцлогийг дараах байдлаар тодруулж болох юм. Үүнд:

- Хүний танин мэдэхүйн, бүтээхүйн болон харилцааны бололцоог бүх талаар өргөжүүлэн тэлж байна.
- Дэлхийн соёлд цэрэг арми, эдийн засаг, улс төрийн хориг, гааль, татвар, хяналт шалгалтаас үл хамааран чөлөөт бүсийг бий болгож байна.
- Шаардлагатай мэдээллээ хайх, шинжлэх ухааны нээлттэй танилцах, архив, сан хөмрөг дэх баримт материалыг үзэж сонирхох, олон улс үндэстний музей, үзвэрийн газрууд дахь үзмэр, танилцуулга, цуглуулга зэргийг үзэж харах, сонирхох, тэдгээрийг хэсэгчлэн судлах, хувь хүний танилтын хүрээг өргөжүүлэн тэлж байна.
- Асар богино хугацаанд янз бүрийн хүрээнд олон янз нөхцөл байдлын хөгжлийн хувилбаруудыг загварчлах, турших, оновчтой шийдвэр гаргах бололцоог бий болгож байна.
- Мэдээллийн эх сурвалжийн төлөөх тэмцэл, мэдээлэл дамжуулах хурд, түүнийг хүлээн авах явдал нь эдийн засаг болон улс төрийн шийдэл гаргах үндэс суурь, голлох өрсөлдөөн болж байна.
- Хүний өдөр тутмын амьдрал, ажил хөдөлмөр, амралт, зугаалгын дасал болсон хэмнэлийг өөрчилж байна.

Мэдээллийн өргөн солилцоо нь хүний хөгжих бололцоог өргөтгөж байгаа хэдий ч олон сөрөг үзэгдлийг дагуулж байна. Тухайлбал, бусдын нэр төрд халдах, оюун санааны дарамт учруулах, цахимд донтох, ажил амралтын дэглэм алдагдах, цахим карттай холбоотой хэрэг үйлдэх, хуурамч мэдээлэл тараах, оюуны өмч болох ном, дуу цомог зэргийн зохиогчийн эрхийг зөрчих, садар самоууныг сурталчлах зэрэг үзэгдлүүд эдүгээ дэлхий нийтэд өргөнөөр хэлэлцэж байна. Ялангуяа, гар утасны өндөр давтамжит цахилгаан соронзон туяа нь хүний эрүүл мэндэд хортой юм. Хүүхдийн эсийн хөгжилд сөрөг нөхөөтэй учир 12 нас хүртэлх хүүхдэд аюул ослоос бусад үед гар утас хэрэглүүлэхгүй байхыг олон улсын эрдэмтэн судлаачид зөвлөсөөр байна. Эдгээр сөрөг үр дагаврыг бий болгож байгаа нь төрөөс зайлшгүй бодлогын зохицуулалтыг шаарддаг аж.


Дэлхийн зарим оронд цахим орчин ашиглалтын хатуу дүрэм журам үйлчилдэг. Жишээ нь, Монгол улсын Засгийн газрын ээлжит хуралдаанаар /2018.09.05/ “Сургалтын орчинд авах арга хэмжээний тухай” тогтоол гарч сургууль цэцэрлэгийн сургалтын орчинд ухаалаг гар утас хэрэглэхийг 2018 оны 10 дугаар сарын нэгний өдрөөс хязгаарлахаар заажээ. Энэ нь хүүхдүүдийг цахим халдлага, донтолт, гадуурхлаас сэргийлэх, эрүүл мэнд, амь насыг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, сурах идэвхийг нэмэгдүүлэх, хүүхдүүдийн чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх, нийгмийн бодит харилцаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилготой авч буй арга хэмжээ юм.



Үйл ажиллагаа 2.10. Мэдээллийг уншаад асуултад хариулаарай.

Ийгл төлөвизийн мэдээгээр (2018. 09.07) дараах мэдээллийг өгөв.

Монголчуудын нүүр номын хэрэглээ



Улсын хэмжээнд хүн амд ногдох нүүр номын /фэйсбүүк/ хуудас хэрэглэгчийн тоогоор Монгол улс дэлхийн дунджаас 2.1 дахин, Ази тивийн улс орнуудаас 3.6 дахин их байна.

Цахим донтолт

/СЭМТ-д хэвтэн эмчлүүлсэн хүүхэд/
2017 онд 55 хүүхэд
2018 оны эхний 9 сард 23 хүүхэд

2018 оны эхний 9 сарын байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд цахим дарамтад өртсөн 125, цахим донтолтын 35 дуудлага бүртгэгдэж, хүүхдүүд хамгааллын үйлчилгээ авчээ.

Асуулт:

1. Монголчуудын фэйсбүүк хэрэглээний өнөөгийн байдал, эерэг, сөрөг талыг дүгнэн ярилцаарай
2. Та бүхэн цахим орчинд ихэвчлэн ямар зорилгоор аялдаг вэ?
3. Гар утасны хэрэглээ нь та бүхэнд ямар эерэг, сөрөг үр дагаврыг бий болгож байна вэ?
4. Цахим дарамт, цахим донтолт гэж юу вэ? Үүнээс хэрхэн сэргийлж болох вэ?



Гэртээ хийгээрэй.

1. “Цахим хэрэглээний сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх арга зам” сэдвийн дагуу өсвөр насыханд зориулсан 5-7 заалт бүхий зөвлөмж боловсруулаарай
2. Зөвлөмжөө харилцан танилцуулж, хамгийн чухал гэсэн 5 заалт бүхий нэгдсэн зөвлөмж боловсруулж, ангidaa байрлуулан, нэг сарын дараа үр дүнг хэлэлцэн дүгнээрэй



Нэмж судлаарай

- Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013. 93-147 дахь тал
- Монгол улсын хүний хөгжлийн илтгэл. 2016
- Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010
- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- В.П.Большакова. Кибер орон зайд бол бодит байдлын шинэ хэв шинж мөн.

МУБИС. НХУС-ийн ЭШБ №6

СЭДЭВ 2.3 СОЁЛЫН АДИЛСАЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Үйл ажиллагаа 2.11. Эхийг уншаад асуултад хариулаарай.

“Хүн төрөлхтөнд өөрөө нөхөн үйлдвэрлэгдэх, өөрөө эмхэрч цэгцрэх шаардлага байдгийн нэг адил аливаа соёлын зүй тогтол нь соёлынхоо үнэлэмжийг хадгалах, дамжуулах явдал байсаар ирсэн. Энэ үйл явц яんз бүрийн үеийг холбоо замаар угсаатны дотор явагдаж иржээ. Ийм зүйл байгаагүй бол хүн төрөлхтөн хөгжихгүй байх байсан”

/Основы межкультурной коммуникации. Под ред. А.П. Садохина. - М.: ЮНИТИ-ДАНА, 2003. – 42-43 с./

Асуулт:

1. Соёлын үнэлэмжүүдэд юу юу багтах вэ?
2. Эдгээр үнэлэмжийг “хадгалах, дамжуулах явдал байхгүй байсан бол хүн төрөлхтөн хөгжихгүй байх байсан” гэсэн эшлэлийн утгыг тайлбарлаарай.

Соёл нь хүний үйл ажиллагааны үр дүн гэдэг утгаараа тухайн соёлыг тээгч, бас бүтээгчээсээ ангид байх боломжгүй юм. Даяаршлын үед оршин тогтоно чадварын хувьд хамгийн тогтвортой, хамгийн найдвартай тээгчид бол угсаатан гэдгийг судлаачид тэмдэглэдэг.

Угсаатан бүхэнд соёл нь тэдний эрх чөлөөт байдлын баталгаа болдог. Энэхүү баталгаанд жишээ нь, тэдний түүх, зан заншил, сэтгэлгээний онцлог, үнэлэмжийн баримжаалал, хэл, бичиг үсэг, урлаг, утга зохиол, шашин багтана. Энэ бүгд нийлээд тухайн угсаатны бүлгийн гишүүдийг нэгтгэж, тэр хэмжээгээрээ бусад угсаатны бүлгээс ялгарах үндэс суурь болдог.

Бусдын соёл хүмүүст харилцан адилгүй төсөөлөгдөх боломжтой. Тухайлбал, үнэхээр татагдам, гайхалтай, хүчирхэг эсвэл, ойлгоход төвөгтэй, хачин жигтэй, эсвэл, дургүй хүрмээр, амьдралд аюултай гэх мэтээр төсөөлөгддөг. Эдгээр төсөөллийн үр дүнд өөрийн соёлыг улам бүр эрхэмлэх, аль эсвэл бусдын соёлд автагдах буюу мухар сохроор даган дуурайх үзэгдэл бий болно. Иймд угсаатан өөрийгөө “угсаатан” гэдэг утгаар нь хадгална гэдэг нь угсаатан бүрийн эрхэм дээд чиг үүрэг аж. Ийнхүү хадгалж бэхжүүлэх нь тухайн угсаатны нэгдмэл байдал, идэвх зүтгэлээс хамаарна.

Угсаатны соёл гэдэг нь түүнд харьялагдах хүмүүсийн соёлын жирийн нэгэн цуглуулга биш, харин тухайн угсаатны итгэл үнэмшил, зан байдлын хэв маяг, үнэлэмж байдаг тухай бид өмнөх ангидаа судалж байсан. Угсаатныхаа онцлогийг хадгалах мэдрэмж, хүсэл эрмэлзэл нь дэлхийн бусад ард түмэнтэй харилцан хамааралтай болох үед улам бүр идэвхждэг байна.

Даяаршил нь төрт улсын тусгаар тогтнолыг хадгалагч арга хэрэгслийн хүрээг өргөжүүлэхэд хүргэдэг нь даяаршлын сөрөг хандлага мөн гэдгийг судлаачид тэмдэглэдэг. Энэ тохиолдолд уламжлалт соёл, байгалийн нөөц, баялаг бүхий буурай хөгжилтэй улс орнууд дэлхийн түүхий эдийг бэлтгэгч орон төдийгүй, үндэсний эдийн засаг, орчин үеийн технологигүй үлдэж болох юм. Соёлын харилцаа өргөжиж хүрээгээ тэлэхийн хэрээр тусгаар үндэс, соёл, ёс заншил, уламжлал, шашнаа хэвээр нь авч үлдэх гэсэн жам ёсны эрмэлзэл дэлхийн өнцөг булан бүрд бий болж байгааг судлаачид тэмдэглэж байна.

Юуны түрүүнд, хүн өсөж торnisон соёлынхоо тээгч байдаг. Тэрбээр эхлээд өөрийн соёлыг өөрт нь өгөгдсөн зүйл мэтээр ойлгодог, гагцхүү өөр соёлын төлөөлөлтэй уулзах үед, соёлын харилцааны үр дүнд, харьцуулалтын үр дүнд өөрийн соёлын онцлогийг мэдэрч, бас өөрсдийнхөөс нь өөр амьдралын хэв маяг, үзэл төсөөлөл, үнэлэмж, зан төлөвийн хэм хэмжээ байдаг гэдгийг ойлгодог. Энэ байдлыг соёл судлалд соёлын адилсал гэсэн ойлголтоор илэрхийлдэг. 1970-аад оны II хагасаас адилслын тухай ойлголт нийгэм, хүмүүнлэгийн ухаанд хэрэглэгдэж эхэлжээ. Соёлын адилсал хэмээх ойлголтыг манай судлаачид “соёлын ижилсэл”, “соёлын өөрийншил”, “соёлын өвөр төрх” гэх зэргээр нэрлэх нь бий.

Олон соёлын эрчимтэй харилцаа холбоо нь хүмүүст амьдарч аж төрж буй орчноо ойлгомжгүй, тогтвортгүй гэсэн мэдрэмжийг бий болгодог байна. Ийм үед тулгарч болох бэрхшээлээс хамгаалах, бүрэн бүтэн, аюулгүй байх, эмх цэгцийг хангахад чухам юу тус болох вэ гэдгийг хайж эхэлдэг. Өөрөөр хэлбэл, өөрийн угсаатны хүрээнд цаг үеийн шалгуурыг давсан, эдүгээ ч үнэ цэнтэй, найдвартай, ойлгомжтой байгаа үнэт зүйлсээсээ дэмжлэг хайж эхэлдэг байна. Ийм эрэл хайгуулын үр дүнд угсаатны дотоод нэгдлийн мэдрэмж сэргэдэг.

Улмаар үнэлэмж, баримжаа олгогч нийтлэгийн нэг хэсэг гэдгээ мэдэрч нийгмийн хамгаалалтгүй байдлаас гарах гарцыг хайх эрмэлзэл бий болдог байна.

Соёлын адилсал гэдэг нь ард түмэн өөрийн соёлын дахин үл давтагдах хосгүй шинж онцлогийг ойлгож, түүний төлөөлөл байхын утга учрыг мэдэж, өөрийгээ илэрхийлэх, хөгжүүлэх өргөн боломжийг олж харна гэсэн үг.

 **Тулгуур ойлголт**

Соёлын адилсал. Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, тэрхүү соёлын байр сууринаас өөрийгөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухаарах байдлыг соёлын адилсал гэнэ.

Янз бүрийн улс орны соёлын солилцоо, харилцан үйлчлэл нэг ёсны соёлын адилслын солилцоо юм. Энэ нь бусдын соёлыг хүндэтгэн зэрэгцэн орших уу, эсвэл хүлээн зөвшөөрч уусан автагдах уу гэсэн асуудалд аяндаа хүргэдэг байна.



Үйл ажиллагаа 2.12. Дараах эргэцүүллээс аль нь соёлын адилсал хэмээх ойлголтын утгыг илэрхийлж байна вэ? Яагаад?

- Амьдралдаа бид маш олон сонголтыг хийдэг. Үүнээс үүдэн бид нэг нэгнээсээ ямагт ялгарч байдаг. Ямар нэг хүнийг надтай адилхан байсангүй, адилхан зүйлгүй байна гэж үзвэл би өөрийн оршихуйг үгүйсгэж байгаагаас өөрцгүй юм.
- Нийгэмд ёс суртахууныг үл ойшоосноор бохир мөнгө угаах, хар тамхи, зэвсэг, хүн наймаалах, бие үнэлэх, байгаль орчныг сүйрүүлэх зэрэг хөгжил, дэвшилд серөг нөлөө үзүүлэх муу муухай үзэгдлүүд гарах болов.
- Манай өсвөр үеийнхэн үндэсний соёлоо ойлгож мэдээгүйгээс болж гаднын соёлыг гайхан бишрээд байх шиг. Уг нь монгол ёс заншил, түүх, соёл бол агуу юм. Эдгээрийг сурталчлах, өвлөхөд бид их анхаарах учиртай юм.

СОЁЛЫН ДАРХЛАА ГЭЖ ЮУ ВЭ?



Үйл ажиллагаа 2.13. Эх сурвалжийг уншаад асуултад хариулаарай.

- Судалгаагаар тогтоосон, төр засагт, эсвэл шинжлэх ухааны байгууллагуудад хандаж асуудал дэвшүүлэх, иргэдэд сэргэмжлүүлэх ямар зүйлүүд байдаг вэ?

... Манай малчид уламжлалт эд өлгийн зүйлс хэрэглэхээ больж байна. Жишээ нь айргаа хөхүүрэндээ өсгэхээ больж хятадын цэнхэр саванд эсгэдэг боллоо. Гэрийн бүслүүрээ малынхаа үс хялгасаар биш, хятадын дээсээр хийдэг боллоо, морио унахаа больж мотоцикл хэрэглэдэг боллоо. Монгол гэрээр жишээ авч үзэхэд, өнөөдөр гэрт малчин айл амьдардаг гэж ойлгодог болчихож, эсвэл гэр хорооллын ядуу айлууд амьдардаг гэж ойлгодог болчихож. ... Хөдөө орон нутагт угсаатны зүйн эд өлгийн зүйлүүдийг цуглуулдаг ченжүүд ихээхэн явдаг боллоо. Айлуудаар явж араг савраас эхлээд аяга, домбо, эмээл, хазаар, хуучны гэсэн болгоныг хуу хамаад явж байна.

Нөгөө талаар нүүдлийн өв соёлыг тээгчид бол малчид. Нүүдэл гэж юу вэ гэвэл, тэр бол цэвэр бэлчээр ашиглалт. Нүүнэ гэдэг нь бэлчээрээ ашиглаж байгаа нэг хэлбэр. Эрт дээр үеэс газар нутгаа хамгийн зөв зохицой ашиглаж, бэлчээрээ хуваарилдаг байсан. Гэтэл өдгөө зарим сумын нутагт маш том чулуун хашаа барьсан байгаа юм. Мал оруулдаггүй. Тэгээд намар нь сумын төвийнхөн тэнд очиж хадлангаа хаддаг. Түүний дараагаас тэр хашаан дотор айлууд орж намарждаг.

Өнөөдөр удам дагасан малчид цөөрч байна. Малчин айлын хүүхдүүд их, дээд сургуульд сурдаг. Сургуулиа төгсөөд буцаж малmallадаггүй. Өнөөдөр 5 хүүтэй айлын 5 хүүхэд бүгд төв газар амьдарч, тэдний малыг зарын дагуу очсон туслах малчин маллаж байна. Мал, малчин хоёр байх боловч, мал дагасан соёл, удам дагасан малчин хоёр ховордох гээд байна. ...

Энэ бүхэн юу хэлээд байна вэ гэхээр Монголчууд бидний өв соёлын дархлаа ямар түвшинд байна вэ гэдгийг ойлгож болохоор байна. ... Хүнээр бол монгол соёлд маань дархлаа хэрэгтэй байна.

Б.Баатархүү “Түүх, соёл бол үндэсний аюулгүй байдлын дархлаа мөн” ярилцлагаас хэсэгчлэн авав.

Асуулт:

1. Монголыг “монгол” болгож байдаг соёлын гол хүчин зүйлсэд юу юу багтах вэ?
2. Нүүдлийн соёлын гол шалгуур үнэт зүйлс юу болох талаар саналаа солилцоорой
3. Судлаач ямар асуудлыг дэвшүүлж байна вэ?

Соёлын эрх чөлөөг хүснэгжлэх нь соёлын дархлааны асуудалд хургэнэ. Соёлын дархлаа хэмээх ойлголтын гол утга санаа нь бусдын соёлд үл автагдах, үнэт зүйлсээ хадгалж үлдэх асуудал мөн. Соёлын дархлааг тухайн үндэстэн, угсаатны амьдралын итгэл үнэмшил болсон үзэл санаа, үнэлгээний тодорхойлдог.

Янз бүрийн үнэлгээнийг эсрэгцүүлж харьцуулсны үндсэн дээр тухайн хүнд өөрийгөө соёлын төлөөлөл болохын хувьд мэдрэх, үнэт зүйлсээ хадгалах, хамгаалах, эрхэмлэх үүргийн талаар мэдрэмж, төсөөлөл, мэдлэг ухаан төлөвшдэг аж. Энэ байдлыг соёлын дархлаа гэсэн ойлголтоор илэрхийлдэг. Аливаа бие махбод оршин тогтоноход дархлаа шийдвэрлэх үүрэгтэйн адил соёлд бас хамгаалалт хэрэгтэй. Соёл бүрд өөрийн гэсэн үнэт зүйл /хэл, зан үйл, ёс заншил гэх мэт/ байдаг гэж үзвэл энэхүү үнэт чанараа хадгалах чадвар нь соёлын дархлаа юм.

Соёлын дархлаа хүчтэй байгаа бол соёлын адилсал, үнэт зүйлс нь баталгаажна, харин дархлаа нь сул байгаа тохиолдолд сүйрэлд хүрэх аюултай. Жишээ нь, өнөөгийн манай нийгэмд хотжилт, үнэт зүйлсийн чиг баримжааны өөрчлөлттэй холбоотой элдэв сөрөг үзэгдэл ихсэх болов. Энэ нь бидэнд монгол соёлын дархлаа супарч, алдагдахад хүрч болзошгүй гэдгийг ухаарах, соёлын өв уламжлал, үнэт зүйлс рүүгээ хандах, тэдгээрийг хамгаалах асуудлыг нэн чухал болгож байна.

Аливаа соёл бол түүхэн үзэгдэл байдаг. Хүн төрөлхтний соёлыг ерөнхийд нь нүүдлийн, суурьшмал гэж хувааж болно. Монголчууд бид соёлын нүүдэлчин шинжийг төлөөлж, өнөөг хүртэл сонгодог утгаар нь хадгалсаар яваа билээ. Хүмүүс хоорондын харилцаа, нүүдлийн аргаар орших нутаг усны хамтын эзэмшлийн соёл, мал маллах арга ухаан, хүн байгаль хоёрын зохицол, мэндлэх, хүндлэх, талархах ёсон, хүнс хоолоо бэлтгэх арга технологи, үр хүүхдээ сургах туршлага, сургамж, шашин шүтлэгийн онцлог, сэтгэл зүй энэ бүхэн нь монгол соёлын онцлог, дархлааг илтгэх хүчин зүйлс билээ.

Соёлын дархлаа ихээр алдагддаг хүрээнд судлаачид залуусын соёлын хүрээ, телевизийн нэвтрүүлэг, цахим сүлжээ буюу цахим орчны хэрэглээ, хэлний соёлын хүрээг онцолж байна.

Улс үндэстэн бүр өөрийн соёлыг эрхэмлэдгийн учир юунд орших вэ?

- үндэстнийг бусдаас ялгах гол шинж учраас
- ард түмний бахархал, омогших хүч учраас
- үндэстний эв нэгдлийн үндэс учраас
- үндэстний тусгаар тогтолын баталгаа учраас

Улс үндэстэн бүр өөрийн соёлыг хадгалж үлдэхийн тулд яах ёстой вэ?

- эрин цагийнхaa түүхэн хандлага, өөрчлөгдэж байгаа гадаад орчиндоо зохицож, зохих хэмжээ, хязгаарын дотор шинэчлэгдэж байх
- өөрийг нь бусад соёлоос ялгаж буй язгуур ба уламжлалт чанараа хадгалж, хамгаалах

Соёлын дархлаа супардаг гол шалтгаан юу вэ?

- бусдын соёлыг хуулбарлан дуурайх
- өөр соёлын зүгээс соёлын тулгалт хийх

Бүдүүвч 2.5. Соёлын дархлааны утга учир



Гэртээ хийгээрэй. Дараах мэдээллийг уншаад асуултын дагуу ажиллаарай

Телевизийн сувгууд олон түмнийг залж, өөртөө татахын тулд тархийг нь угаан сэтгэхүйг нь дундажчилж байна. Өнөөгийн олон түмний тархи сэтгэхүй нь залхууралд орж, хов жив, сураг ажиг төдийхнөөс давахаа болилоо. Энд цахим орчин ч зарим талаар гавшгайлсан довтлогч, хөнөөн сүйтгэгч боллоо. Хэрэв хүнийг өдөр бүр телевизийн дэлгэц болон дэлхийн цахим сүлжээний шүүлтүүр муутай мэдээллээр угжаад байвал хүний, түүний эргэн тойрныхын соёлын дархлаа супарч, бүр алдагдах нь илэрхий.



Тулгуур ойлголт

Соёлын дархлаа. Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадварыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, соёлынх нь өвөрмөц байдал болон бусдаас ялгаран онцгойрох хэв маягт гаднын нөлөө орж өөрчлөгдөх, эсвэл соёлын тулгалтаар устгах оролдлого гарах тохиолдол бурд хариу үзүүлэх чадвар юм.

Телевизийн олон суваг олон нийтийн ухамсарт таалагдаж, тэднийг байлдан дагуулахын тупд америкчлал, европчлол, өрнөдийн элдэв уриа лоозон дэвшүүлэн, халамжлагч ивээгчийн дүрээр халхавчлан зүсэн зүйлээр довтолж байна.

Эх сурвалж: Ж.Отгонбаяр. Соёлын дархлаа:асуудал, шийдэл. Философи, эрх зүйн боловсрол. УБ. 2011. №11. 31 дэх тал

Асуулт:

1. Судлаач ямар асуудлыг дэвшүүлсэн бэ?
2. Та энэхүү асуудлыг үүсэхэд нэлээлж буй хүчин зүйлсийн талаарх судлаачийн байр суурьтай санал нийлэх үү? Хариултаа бодит жишээ, баримтаар нотлоорой.



Нэмж судлаарай

- Соёлын адилсал ба ялгарал. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. Философи, эрх зүйн боловсрол. УБ. 2011. №11. 3-81 дэх тал
- Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013. 93-147 дахь тал
- Монгол улсын хүний хөгжлийн илтгэл. 2016
- Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010
- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- www.unwto.org <http://mongolcom.mn>

СЭДЭВ 2.4 СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ




Үйл ажиллагаа 2.14. Мэдээллийг уншаад асуултын дагуу ажиллаарай.

1. Жон Локк /1632-1704/. Хэнд ч байгалиас заясан засаглах эрх, өөрөөр хэлбэл, хэнд ч бусдыгаа захирах төрөлх эрх гэж байхгүй. Эрх бол хүн бүрд хамаарах ёстой. Хүнд төрөлхөөс заясан гурван эрх байна. Энэ нь амьдрах эрх, эрх чөлөөтэй байх эрх, өмчлөх эрх юм. Хуулийн зорилго нь хүний эрхийг устгах буюу хавчин хясах явдал биш, харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал мөн.	2. Дж.Кэмпбелл /1904-1987/. Эрх чөлөө бол хүний амьдралын эрхэм зорилго, хувь хүний өөрийгөө нээх, хувь чанараа хөгжүүлэх боломж мөн. Бид хараат байдлаас гарч, эрх чөлөөг оллоо гэхэд юу хийхээ мэддэг байх нь хамгийн чухал, эрх чөлөөтэй байх эсэх нь хувь хүнээс өөрөөс нь шалтгаална. Жишээ нь, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хэрэгжилт нь бид өөрийн гэсэн үзэл бодолтой байх тохиолдолд, чөлөөт сонголт хийх эрх нь бид чухам юу хүсэж, юуг эрхэмлэж, амьдралдаа ямар зорилго тавьсан бэ гэдгээ мэддэг тохиолдолд л тус тус хэрэгжих боломжтой юм.	3. Э.Фромм /1900-1980/. Хүн бурийн өвөрмөц боломжийг хүлээн зөвшөөрч, тэр бурийг хөгжүүлэхээр тэмцэнэ гэдэг хүмүүний соёлын хөгжлийн үнэт ололт яах аргагүй мөн. Гэтэл одоо энэ ололтод аюул занал нөмрөөд байна. Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй, айж хургасан нэгэн болгодог. Ялангуяа, кибернетикийн хувьсгал, цөмийн зэвсэглэл гэх мэт хүний оюун ухаан, техникийн өндөр чадвар, соёлын жишиг нь нийгмийн зан чанарыг хүнлэг бус болгож байна.
-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Асуулт:

1. Гурван сээтгэгчийн үзлийг уншаад харьцуулалт хийж, нийтлэг болон ялгаатай талыг тодруулаарай. Бүдүүчийг ашиглаарай.
2. Харьцуулалтдаа тулгуурлан эрх, эрх чөлөө гэсэн ойлголтыг ашиглан үзэл тус бүрийн агуулгыг илрүүлэх Засуулт зохиогоорой
3. Хүний эрх, эрх чөлөө гэсэн 2 ойлголт ямар ялгаатай вэ? Аль нь анхдагч вэ? Яагаад?



Эрх чөлөө гэж юу вэ?, Эрх чөлөөтэй байх эрмэлзэл хүний төрөлх мөн чанараас гаралтай юу? Аль эсвэл нийгмийн тодорхой хүмүүс буюу хэсэг бүлэгт олгосон тусгай эрх дарх юм уу? Эрх чөлөөнд хүмүүсийн амьдралын нөхцөл, нийгэм, соёлын хөгжлийн түвшин нөлөөлөх үү? Гаднын шахалт дарамтгүй байх нь эрх чөлөө мөн үү? Эрх чөлөө нь хэн нэгний хувьд зовлон, шаналал болж хувирах учир бий юу гэх мэт олон арван асуулт судлаачдын дунд байдаг. Бид үзэн ядах, шударга бус хандах, үл тоох, нийгмийн хүрээнээс шахах, зайлцуулах зэрэг үйлдлийн улмаас хүнийг боолчлох, худалдах, анти давхаргад хуваах, ялгаварлах үзэгдлийн талаар зөвхөн хичээл төдийгүй, ном зохиол, кино зэргээс мэдэх билээ. Үндэс угсааг “цэвэрлэх” нэрийн дор үй олноор хомроглон устгах, эсвэл нэг бүлэг, үндэстэн, улс бусдаас ангид, тэргүүнд байх ёстой гэж үзэх гэх мэт бусармаг хандлага, үзэгдлийг хүн төрөлхтний түүхээс ч мэдэх билээ.

**Тулгуур ойлголт**

Хүний эрх: Хүн бүрт олгогдсон адил тэгш боломжийг хэлнэ. Энэхүү боломжийг төрөөс, эсвэл хэн нэгэн хүнээс авч болдоггүй учраас хүний эрх жам ёсны шинжтэй юм.

Эрх чөлөө. Хүн бүр бусдын эрхийг хүндлэн өөрийн үйлдлээ сонголтын үндсэн дээр хийх боломж, түүний баталгааг хэлнэ.

Төрөлх хэлээрээ ярих, өөрийн үндэстэн, угсаатны уламжлалаар бахархах, ёс заншлаа дээдлэх, нийгмийн амьдралд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх хэрэгцээ хүн бүхэнд байна. Хүний эрх гэдэг нь хүн бүрд угаас олгогдож заяасан адил, тэгш боломж юм. Өөрөөр хэлбэл, хүн бүрд хүний ёсоор амьдрахад шаардагдах наад захын баталгаа мөн. Энэ утгаараа хүний эрх жам ёсны шинжтэй, түүнийг аль нэг төр, хэн нэгэн хүн өгдөггүй. Ийм ч учраас хүн бүрийн амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх гэх мэт эрхийг Үндсэн хууль, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжуудаар баталгаажуулдаг гэдгийг та бүхэн эрх зүйн хичээлээс мэдэх билээ.

Хүний сонголт бүрийг хариуцлага дагадаг, өөрөөр хэлбэл, өөрийн үйл хэргээ хэрэгжүүлэхдээ бусдын үйл хэргийг үгүйсгэхгүй, түүнд саад тогтор учруулахгүй байх явдал нь эрх чөлөөтэй байх гол шалгуур юм. Хүн эрхийнхээ хүрээнд амьдрахдаа бусдын эрхийг хүндэтгэх ёстой, ийм тохиолдолд хэн ч түүний эрхийг хязгаарлах ёсгүй учраас эрх чөлөө нь ёс суртахууны дээд үнэт зүйл мөн.

**Үйл ажиллагаа 2.15. Асуултын дагуу эргэцүүлээрэй.**

Э гэдэг хүний эрх Б-гийн эрхийг зөрчих аваас Э-гийн эрх ерөөсөө эрх биш. Үүнтэй адил Б-гийн эрх бусад хүний эрхийг зөрчвөл мөн л эрх биш.

Асуулт:

1. Надад ямар эрх байхгүй вэ?
2. Надад байхгүй энэ эрх бусдад байгаа юу?

Эрх чөлөө бол бусадтай хамт амьдрах, бусдын санал бодлыг зөвшөөрөх, өөрийн байр суурийг илэрхийлэх, хэн нэгний эрх, эрх чөлөөнд халдалгүйгээр эрхээ эдлэх ур чадвар юм. Тэгвэл соёлын эрх чөлөө гэж юу вэ гэдгийг мэдэхийн тулд дараах даалгаврыг ажиллацаа.



Үйл ажиллагаа 2.16. Тохиолдол шинжлээрэй.

- Германд ажилд саад учруулахгүй хэмээн албан байгууллагын хаалгыг ямагт хаасан байдаг. Харин АНУ-д ажлын газрын хаалга ихэвчлэн нээлттэй байдаг. Хаалттай хаалга нь хүмүүст найрсаг бус харилцааны мэдрэмжийг үүсгэж байна гэж Германд ажиллаж буй америкчууд гомдоллох тохиолдол гардаг гэнэ.
- Казах оюутан Б монголоор сайн ярьж чаддаггүй. Хэлний бэрхшээлээс болж ангийнхандаа шоолуулж, буруу зөрүү хэлж ярьсан зүйлээсээ болж янз бүрийн хоч авдаг. Хичээлээ сайн хийдэг ч буруу ойлгосноос болж зарим үед сүл дүн авна. Энэ байдлаасаа болж өөртөө гомдох, шантрах тохиолдол гардаг гэнэ.

Асуулт:

- Тохиолдол тус бүрд гомдоллоход хүргэсэн гол асуудал нь юу байв? Ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ?
- Уг асуудлыг шийдвэрлэж болох ямар, ямар арга зам байж болох вэ? Эдгээрээс хамгийн гол арга замыг тодорхойлно уу

Соёлын олон янз байдлаас хэн ч ангид байх боломжгүй. Нэгдмэл дэлхий өртөнцөд энэхүү олон янз байдалд хүндэтгэлтэй хандах нь өөрөө нэгдмэл байдлын үндэс болдог. Шинэ зууны хүн төрөлхтний соёлын зорилго, хөгжлийн хандлага нь сонголтын эрх, хүний хөгжилд чиглэх ёстой гэдгийг дэлхий нийтээр зөвшөөрч байна. Хувь хүнийг хүмүүнлэг, бүтээлч болгон хөгжүүлэх нь аль ч соёлын гол зорилго мөн. Хүний хөгжил бол хүн өөрөө, түүний амьдарч байгаа гэр бүл, хамт олон, улс, нийгэм хөгжин дэвших эх сурвалж юм. Ийм ч учраас НҮБ хүний хөгжлийн үзэл баримтлалыг дэвшүүлж, улс орон болгон хүний хөгжлийн тухай илтгэл бичдэг байна.



Тулгуур ойлголт

Соёлын эрх чөлөө:

- бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөрийн соёлыг бүтээн түүрвих бололцоог эдлэх эрх,
- хүмүүс өөрсдийгөө илэрхийлэх, өөрийн хувь чанараа хөгжүүлэх, хэн байх, хэрхэн аж төрөх вэ? гэдгээ сонгох чадвар,
- баталгаат боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, бусад олон төрлийн нийгмийн баталгаагаар хангагдаж байх эрх

Эх сурвалж: НҮБ-ын Хүний хөгжлийн илтгэл. 2004

Соёл бүхэн өөр өөрийн өвөрмөц өнгө төрхийг хадгалснаар харилцан тэгш хөгжиж, хүн төрөлхтний соёлын агуулгыг улам баяжуулж зэрэгцэн орших учиртай байдаг. Өөрсдийн соёлыг тээж явах эрх нь бусдын соёлд хүлээлтэй хандсан, эрхэмлэн нандигнасан дэмжлэг бүхий харилцан хүндэтгэлийн тайван орчинд хэрэгждэг. Соёлын энэ шинж, онцлогийг соёлын эрх чөлөө хэмээх ойлголтоор илэрхийлэг.

Хүн сэтгэл хангалуун амьдрахын тулд өөрийгөө олох, тодорхойлох, өөрөөр хэлбэл, “Та хэн бэ? гэсэн асуултад хариулттай байх хэрэгцээ бий болдог. Энэ хэрэгцээг хангач амин чухал зүйл бол соёлын эрх чөлөө юм. НҮБ-ын хүний


хөгжлийн 2004 оны илтгэл “Соёлын эрх чөлөө” сэдэвтэй байв. Тус илтгэлд үндэсний соёлын өвөрмөц язгуур чанарыг харгалзан хүн өөрөөрөө байх чөлөөт сонголтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүн төрөлхтний соёлын нийтлэг ололт болон үйлчилгээгээр хангагдаж байхын чухлыг тэмдэглэжээ.

Соёлын эрх чөлөөний асуудалд, жишээ нь, соёлын, угсаатны, арьсны, бэлгийн чиг баримжааны, шашны, оюун санааны ялгаатай байдлыг үнэлэх, эдгээрээс үл хамааран хоорондоо харилцах, уг харилцаагаа улам тэлэх, нийгмийн бүлгүүдийн харилцан адилгүй санаа бодлыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах, хувийн онцлогоос хамааран нээлттэй байж чадахгүй байгаа хүмүүст манлайлах боломжийг олгох, дэмжих, амьдрах хэв маягийг тулгахгүй байх гэх мэтээр бусдыг хүлээн зөвшөөрөх зэрэг олон асуудал багтана.

Соёлын эрх чөлөө нь тухайн хүний харьяалж буй улсаас их шалтгаална. Жишээ нь, нийгмийн хангамж үйлчилгээг хүртэх, эмнэлгийн тусlamж авах, тэтгэвэр, тэтгэмж авах, сурч боловсрох, бүтээл туурвих, түүнийхээ эрхийг хамгаалуулах, өөрийн хэл, соёлоор бахархах, эх хэлээрээ сурч боловсрох эрх гэх мэт. Манай улсын хувьд 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш нийгмийн оюун санааны амьдралд олон өөрчлөлт гарсан билээ. Тухайлбал,

- уг хэлэх, чөлөөтэй ярих, бичих, хэвлэн нийтлэх эрх чөлөө,
- үндэсний чөлөөт хэвлэл бүрэлдэн бий болох эрх чөлөө,
- авьяас билгээ дайчлах, бүтээн туурвих эрх чөлөө,
- үндэсний үзэл санаа, соёл, уламжлалаа сэргээн мандуулах эрх чөлөө,
- сүм хийд нээх, шүтэн бишрэх эрх чөлөө,
- бусад улс оронд суралцах, аялан жуулчлах, ажиллаж амьдрах
- хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл, аливаа шударга бус үйлдэлтэй тэмцэх боломж бүрдсэн гэх мэт олон эрх чөлөө нээлттэй болов.

Одоо та бүхэн соёлын эрх чөлөөний суурь зарчим хийгээд хөгжлийн түвшнээс үл хамааран бараг бүх нийгэмд соёлын эрх чөлөө зөрчигддөг хандлагатай танилцана уу.



Бүдүүеч 2.6. Соёл эрх чөлөөтэй байх зарчим, түүнийг зөрчих хандлагаас

Хүмүүс хоорондын харилцаа, үнэт зүйл, үзэл санаа, амьдралын хэв маягийн солилцооны хүрээ тэлсээр байна. Энэ байдлыг зарим хүн амьдрах боломж, эрх

өргөжиж байна гэж эерэгээр үнэлдэг. Харин зарим хүмүүст энэ нь айdas түгшүүр, эргэлзээг төрүүлж, даяаршил амьдралын уламжлалт хэв маяг, үнэт зүйлсийг үгүй хийж байна гэж эмзэглэж, шүүмжлэлтэй хандахад хүргэдэг. Соёлын эрх чөлөөг үгүйсгэх нь хүмүүсийн бололцоог хязгаарлах, амьдралыг явцууруулж, соёлын харилцаанаас хөндийрүүлж болно. Хүний хөгжлийн үзэл баримтлалд соёлын эрх чөлөөний асуудал чухал байр суурь эзэлдэг. Хүний хөгжлийг соёлын хэмжүүрээр тодорхойлох гол шалтгааныг дурдаж болно. Үүнд:

- Соёлын эрх чөлөөг эдлэх буюу хүн өөрт байгаа бололцоог ашиглах нь тухайн хүний амьдралд гол үүрэгтэй юм.
- Хүний хөгжлийн үзэл баримтлал нь уламжлалт соёлоор үл хязгаарлагдан соёлын янз бүрийн салбарт хүний эрх чөлөөний үүргийг тодруулахад хувь нэмрээ оруулдаг.
- Соёлын эрх чөлөө нь зөвхөн соёлын салбарт төдийгүй, нийгэм, улс төр, эдийн засгийн салбарын амжилт болон бүтэлгүйтэлд нөлөөлдөг. Жишээ нь, ядуурал нь эдийн засгийн гол асуудал боловч соёлын эрх чөлөөний асуудлаас гадуур шийдвэрлэгдэх боломжгүй.



Гэртээ хийгээрэй.

Хүснэгтийг гүйцээж бичээрэй.

Ойлголт	Гол шинж	Жишээ, баримт
эрх		
эрх чөлөө	Хүн бүр бусдын эрхийг хүндлэн өөрийн үйлдлээ сонголтын үндсэн дээр хийх боломж	
соёлын эрх чөлөө		

2. Дараах эргэцүүлэл эрх, эрх чөлөө, соёлын эрх чөлөө гэсэн ойлголтуудын алинд нь хамаарах вэ? Яагаад?

Өргөн уудам нутагт тархан суух нүүдэлчид эргэх дервэн улиралд зөвхөн байгальтайгаа харилцаж, дураар амьдардаг байсан нь тэдний аливаа дэг журамд орох дургүй, өөрийгөө хүндэтгэдэг, биеэ тоосон, цагийн мэдрэмж муутай зан төрхийг бүрдүүлжээ. Байгалийн эрс тэс уур амьсгалд янз бүрийн нөхцөлтэй газраар байнга сэлгэн амьдардаг нь нүүдэлчдийг ямар ч шинэ нөхцөлд амархан дасан зохицдог занд сургажээ.

СОЁЛЫН ЦОЧИРДОЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Үйл ажиллагаа 2.17. Тохиолдлыг шинжлээд асуултад хариулаарай.

Би америк оронд сургууль төгсөж тэндээ олон жил амьдарсан. Эхэн үедээ надад хоол унданаас эхлээд бүх юм таалагдахгүй, заримдаа бүр хэл сурахаас хүртэл татгалзмаар мэдрэмж төрөх үе байсан. Харин саяхан эх нутагтаа ирээд сайхан амьдаръя гэтэл бүх зүйл бас л өөрчлөгдж буцах сэтгэл төрөх болов. Ийм байдал ганц надад ч байгаа биш бололтой. Охин маань бас тийм бодолтой байгаа нь анзаарагдсан юм. Би Монголдоо идээшихгүй байна гэвэл хэн ч үнэмшихгүй байх.

Асуулт:

- Тохиолдоос ямар асуудлыг дэвшүүлж болох вэ?
- Тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санаагаа илэрхийлээрэй.

Соёл судлалын ухаанд соёлын шок гэсэн ойлголт байдаг. Энэ ойлголтыг анх 1954 онд америкийн сэтгэл судлаач К.Оберг хэрэглэжээ. “Соёлын шок” гэдэг нэр томьёог монголоор соёлын цочирдол гэж орчуулан хэрэглэж байна. Хүн бүр суралцах, амьдарч ажиллах, аялж зугаалах гэх мэт янз бүрийн зорилгоор гадаад орныг зорих явдал олонтоо гардаг. Хүн өөрт дасал болоогүй харийн соёлд орох үед олон таагүй сөрөг мэдрэмжүүд үүсэж болох бөгөөд тэдгээрийн нэгдлийг соёлын цочирдол гэсэн ойлголтоор илэрхийлдэг.

Хэдийгээр сайхан бүхнийг төсөөлөн очдог ч харь оронд мэдэхгүй хэлээр, дасал болоогүй хүмүүстэй харилцаж аж төрнө гэдэг тийм ч амар зүйл биш ажээ. “Усыг нь уувал ёсыг нь дага” гэдэг үг байдаг. Харь орны соёл, зан үйлийн онцлогт дасан зохицох явцад гардаг хүндрэл бэрхшээлийн нэг нь соёлын цочирдол юм.



Тулгуур ойлголт

Соёлын цочирдол. Өөр соёлын орчин нөхцөл тухайн хүний хүссэнээс огт өөр байх, бүтэлгүйтэх, сэтгэл ханамж мэдрэгдэхгүй байх үед үүсэх бухимдал, гутрал, түгшүүр гэх мэт сөрөг мэдрэмж үүсэх үеийн сэтгэл зүйн байдлыг хэлнэ.

Харийн оронд очсон анхны өдруудэд ихэнх хүмүүс сэтгэлээр унаж, сэтгэл санааны хувьд таагүй болж, өөрийн соёл, ёс заншлаа үгүйлдэг. Эх орон ба зорчсон орны соёлын ялгаа нь их байх тусам соёлын цочирдлыг ихээр мэдэрнэ. Энэ бүхнийг гэрээ санагалзах, цаг агаар таарахгүй байх, ганцаардах зэрэг шалтгаантай ихэвчлэн холбон үзэж, шантрах үе гардаг. Иймд энэ байдлын учир шалтгааныг ойлгож, ийм байдалд орохгүй байх бэлтгэлтэй байх хэрэгтэй юм. Тухайлбал, хувь хүнээс хамаарах хүчин зүйлс байна. Жишээ нь, олон талын мэдлэгтэй, зорчих орныхоо түүх, соёлыг сайн судалсан, харилцааны чадвар сайтай, бусадтай ойлголцож чаддаг, хүлээцтэй, тэвчээртэй хүмүүс аливаа шинэ соёлд амархан дасан зохицож чаддаг байна. Бас эх орон ба зорчих орны соёлын ялгаа, тэдгээрийн хооронд харилцаа таатай эсэх болон нийгмийн шинжтэй хүчин зүйлс нөлөөлнө. Жишээ нь, төрөлх соёлд хатуу чанга дэг ёс байх нь харийн соёлд дасан зохицох үйл явцыг удаашруулна.

Соёлын цочирдлын илрэлд бухимдал, шинэ орчин нөхцөл, хоол хүнс, болон хүмүүсийг хэт шүүмжлэх, гомдоллох, өөртөө итгэл алдрах, нойргүйдэх, уурлах, түрэмгий авир гаргах гэх мэт шинж тэмдгүүд багтдаг байна. Эдгээр нь хэдийгээр түр зуурын шинжтэй мэт боловч хуримтлагдах аваас сүүлдээ ямар нэг өвчний эх үүсвэр болох магадлалтай.

Соёлын цочирдлыг даван туулах үйл явц нь тодорхой үе шатыг дамждаг ба тэдгээр үе шатыг аливаа соёлд дасан зохицох зам гэж нэрлэдэг. Дасан зохицох хугацаа янз бүрийн хүчин зүйлсээс шалтгаалж харилцан адилгүй байна. Зарим судлаачдын үзэж байгаагаар харийн соёлд дасан зохицох 7 үе шат байдаг ажээ. Үүнийг дараах графикаар үзүүльье.




График 2.1. Харь соёлд дасан зохицох ўе шам

F - найз, нөхөдгүй, нийгмээс тусгаарлагдсан мэдрэмж төрнө.

G - эргэн тойрныхоо хүмүүсийг ойлгож эхэлж, хүмүүстэй харилцаа тогтоож, аливаад уян хатан хандана.

Соёлын цочирдол нь нэг удаа биш, хэд хэдэн удаа давтагдаж болно. Ийм байдлыг даван туулж, гадаад орныг зорьсон зорилгынхоо төлөө шантрахгүй явах боломж бий. Аль болох бага цочирдол мэдрэхийн тулд яах ёстой вэ? Юуны түрүүнд шинэ соёл, үндэстэн, угсаатны онцлогийн талаарх мэдлэг хуримтлуулах, мэдээлэл цуглуулах, хүмүүсийн харилцааны онцлогийг судлах, холбогдох ном, сэтгүүл авч явах гэх зэрэгээр бэлтгэл хангах нь зүйтэй. Бас гадаад оронд очоод шүүмжлэхийг л урьтал болгох биш, харин шинэ орчин нөхцөл, амьдралын хэв маяг, тус соёлын үнэ цэн, үзэл санаатай аль болох түргэн танилцах, суралцах, бусадтай нөхөрсөг харилцаа тогтоож, сэтгэлээ хуваалцаж, ярилцаж байх хэрэгтэй. Соёлын ялгаатай байдлыг ойлгох, хүлцэн тэвчиж, хүндэтгэн хүний ёсоор хамтран амьдрах, харилцан ойлголцохыг эрмэлзэх нь соёлын эрх чөлөөний суурь зарчим мөн.

Зарим судлаачид соёлын цочирдлыг зөвхөн харь соёлд биш, бас байгалийн гэнэтийн гамшигт үзэгдэл (хар салхи, цунами, газар хөдлөх гэх мэт), терроризм, улс орнуудын хоорондох зэвсэгт мөргөлдөөн зэргийн нөлөөллөөр үүсэж болно гэж үзсэн байdag. Тухайлбал, байгалийн гамшигт үзэгдэлд хүмүүс үй олноороо нэрвэгдэж, хүчин мөхөсдөх, гарах арга замаа олохгүй байх, эд материал, санхүүгийн болоод эрүүл мэнд, сэтгэл санааны их хэмжээний хохирлыг амсах үед цочирдолд орж болно. Бас нийгмийн дотоодод амьдралын нөхцөл шинээр солигдох үед цочролд орж болно. Жишээ нь, нэг сургуулиас нөгөөд шилжиж байгаа хүүхдэд, өөр албан тушаалд томилогдож, өөр хотод, хотоос хөдөөд шилжин суурьших үед ч төрж болох аж.



Үйл ажиллагаа 2.18. Асуултын дагуу ажиллаарай.

1. Энэхүү сэдвээр та бүхэн юу мэдэж авсан бэ?
2. Сэдвийн гол ойлголтын утга санааг илэрхийлэх ямар жишээ байж болох вэ?
3. Багаар ажиллаж, санал болгосон жишээнүүдийн аль нь тухайн ойлголтын утга холбогдлыг илэрхийлсэн жишээ мөн, аль нь биш болохыг тогтоон, үндэслэлээ гаргаарай

**Гэртээ хийгээрэй.****1. Хүснэгтийн дагуу ажиллаарай**

Бидний ямар үйлдлүүд соёлын эрх чөлөөнд үл нийцэх вэ?

Энэ үйлдлийг зогсоохын тулд бид юу хийх ёстой вэ?

2. Манай орны хот, хөдөөгийн ялгаа нь соёлын цочирдолд хүргэх шалтгаан мөн эсэх талаар санаагаа илэрхийлээрэй. Үгийн тоо 150-200

**Нэмж судлаарай**

- Эрих Фромм. Эрх чөлөөнөөс дайжихуй. УБ. 2010
- Б.Батчулуун. Эрх чөлөөний дайсан. УБ., 2010.
- Б.Баабар “Монголчууд : нүүдэл суудал” I дэвтэр УБ. 2009
- А. Гидденс Социологи. УБ., 2006. I бүлэг
- П.С.Гуревич. Соёл судлал. I, II дэвтэр. УБ. 2012
- Монгол улсын хүний хөгжлийн илтгэл. 2016
- Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010
- ЮНЕСКО-гийн Дэлхий дахинь тайлан илтгэл “Соёлын төрөл зүйл, соёл хоорондын харилцааг тэтгэхүй” Люксембург., 2009., 28 дахь тал www.unwto.org/

**БҮЛГИЙН ДҮГНЭЛТ**

“Соёл” хэмээх бүлэг сэдвээр бид Х ангийн “Соёл” бүлгийн агуулгыг үргэлжлүүлэн, соёлын үйлдвэрлэл, соёлын даяаршил, соёлын орон зай, соёлын эрх чөлөө, соёлын адилсал, соёлын дархлаа, соёлын цочирдол зэрэг ойлголтуудын утга холбогдлыг мэдэж, орчин үеийн соёлын нэн тулгамдсан асуудлуудыг судаллаа.

Соёл нь тогтвортой, нэгэн жигд байдаг үзэгдэл биш. Тэр үүсэж, хөгжиж, нэг ард түмэн, улс орноос нөгөөд түгэн дэлгэрч, өнгөрсөн үеийнхнээс хойч үеийнхэнд уламжлагдаж, бас өөрчлөгдөж байдаг.

Хүн төрөлхтний соёлын зорилго, хөгжлийн хандлага нь сонголтын эрх, хүний хөгжилд чиглэж байна. Хувь хүнийг хүмүүнлэг, бүтээлч болгон хөгжүүлэх нь аль ч соёлын гол зорилго юм. Соёл нь өнөөдөр битүү хаалттай орон зай байхаа больж, улс үндэстэн хоорондын харилцаа, мэдээлэл технологийн харилцаанд түшиглэн даяаршиж байна. Нөгөө талаас, өнөөгийн соёл нь дэлхий нийтийн тогтвортой хөгжил, улс үндэстний соёлын эрх чөлөө, бие даасан байдал, хувь хүний амьдралын хэв маяг, итгэл үнэмшил зэрэг олон асуудлыг дэвшүүлэн тавих боллоо. Эдгээр асуудлыг гүнзгийрүүлэн судлах, цаашдын чиг хандлага, шийдлийн талаар байр сууриа илэрхийлэх боломж сургач та бүхэнд нээлттэй байгаа билээ.

Дүгнэлт хичээллээр та бүхэн бүлгийн агуулгад нийцсэн даалгавруудыг хийж гүйцэтгэх болно. Энэ нь мэдлэг, чадвараа бататгах, гол асуудлыг эргэцүүлэн гүнзгийрүүлэх, амьдрал ахуйдаа хэрэглээ болгох арга, хандлагаа дээшлүүлэхэд тус дэхөм болно гэдэгт найдаж байна.

I. ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭЭРЭЙ.



1. Тохиолдол шинжлээд асуултад хариулаарай.

1989 онд Мери Месенжер Девиэс “Зурагт хүүхдэд сайн зүйл үү?” гэдэг номдоо зурагтаар үзүүлдэг балмад явдлууд хүүхдүүдэд ямар нөлөө үзүүлдгийг анхааран судалжээ. Энд цочирдох, цагаатгах, мэдрэмжгүй болох гэсэн дэлгэцийн балмад явдлын гурван төрлийн нөлөөг авч үзжээ.

Цочирдол гэдэг бол хүмүүс илүү мэдрэмтгий болох үйл явц юм. 1960-аад оны сүүлч, 70-аад оны эхээр америк хүмүүс бараг орой болгон зурагтын мэдээгээр биет аллагын үйлдлийг үзэх болжээ. Тэдэнд Вьетнамын дайныг өмнөх ямар ч дайныг үзүүлээгүй аргаар харуулжээ. Америкчууд иргэд ба цэргүүдийн зовлонг үзээд мэдрэмтгий болж энэ цочирдол, жигшил зэвүүцэл нь америкийн цэргийг татаж авахад хүргэсэн нийтийн эсэргүүцэл өрнөхөд тусалжээ.

Цагаатгал гэдэг бол бид сэтгэл хөдлөлөө сулруулах, арилгах үйл явц юм. Дэлгэцээр балмад явдал үзэх нь бид балмад сэтгэл хөдлөлөө гэм хоргүйгээр бууруулах юм уу, арилгахад тус болдог учраас сайн зүйл гэж хэлдэг хүмүүс бий. Бид тэдгээрийг уран сэтгэмждээ эдэлж өнгөрдөг гэнэ.

Мэдрэмжгүй болох гэдэг бол нэгэн цагт бид хүний зовлонд мэдрэмжгүй болох үйл явцыг хэлнэ. Балмад хөтөлбөрүүдийг үзэх нь бидэнд ийм нөлөө үзүүлж болно. Бид хүний зовлонг мэдрэх чадвараа алдаж, балмад явдал нь бидний хийдэг хэвийн зүйл мэт итгэдэг болчиж магадгүй юм. “BOZO тоглоом” гэдэг алдарт туршилт мэдрэмжгүй болох энэ нөлөөг нотолжээ. Бага насны хүүхдүүдэд том тоглоом руу хүүхдүүд алх барин эвдэлж байгааг харуулсан кино үзүүлжээ. Дараа нь яг кинонд үзүүлсэнтэй адил тоглоом бүхий өрөөнд хүүхдүүд юу хийхийг ажигласанд олон хүүхэд дэлгэцээр үзсэнтэйгээ адил балмад авирласан байна.

Асуулт:

1. Багаар хуваагдан зурагтаар үзүүлдэг балмад явдлаас болж цочирдол, цагаатгал, мэдрэмжгүй болж байгаа нэг тохиолдол, жишээг сонгож ярилцаарай
2. Та нарын сонгосон тохиолдол, жишээ аль нөлөөлөлд хамаарах вэ? Яагаад?
3. “Телевиз бол соёлын үйлдвэрлэл мөн” сэдэвт нотолгоо гаргаж, харилцан ярилцаарай



2. Асуултад хариулаарай.

1. Иргэдийн эрх чөлөөний тухайд төр ямар үүрэг хүлээдэг вэ?
2. Соёлын эрх чөлөө хүний ямар эрхийг баталгаажуулдаг вэ?
3. Соёлын орон зай нь физик газар зүйн орон зайнаас ямар ялгаатай вэ?
4. Танай орон нутгийн өвөрмөц брэнд бүтээгдэхүүн юу вэ?
5. Даяаршлын үеийн гол бодлогыг Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал гэжээ. Яагаад?



3. Дараах бүдүүвчийн дагуу соёлын үйлдвэрлэлийн төрлүүдээс бичиж, чиг үүргийн талаар дэлгэрүүлэн ярилцаарай





4. Эх сурвалжтай ажиллаарай

Хятадын баруун хойд хэсэг дэх Хөх нуур, Төвөдийн өндөрлөгт 32800-гаад Дээд монгол аж төрдөг. Тэд монголоор ярьдаггүй, зөвхөн Төвөдөөр ярьдаг. Дээд монголчууд хэдий шүтлэгтэй байсан ч өөрсдийгөө Төвөдүүдээс сүсэг багатай гэнэ. ... Нэг ч Дээд монгол ингэж сунаж мөргөхгүй гэж тэд итгэлтэй хэлнэ. Энэ талаар өөрсдийгөө Төвөдүүдээс ялгаж, бид Төвөдүүдтэй адилгүй, "Монгол" хэмээн мэтгэдэг.

Төвөдүүд монголчууд шиг мөн л нүүдлийн мал ахуй эрхэлнэ. Аж ахуйн энэ хэвшил нь Дээд монголчуудыг өөрсдийгөө тэднээс ялгахад улам амаргүй болгодог.

Хөх нуурт 1984-1985 оноос бэлчээр хуваан хувьчилснаар малчид бэлчээрийг урт хугацаа гар түрээсэлдэг болжээ. Хувьчлагдсан бэлчээрээ тойруулан хашаа татах ажил дууссан. ... хашаалсан үеийн нүүдэллэх хөдөлгөөн ямар нэг хэмжээгээр хязгаарлагдах нь тодорхой юм.

Хөдөлгөөний хязгаарлал айлуудыг суурьших, байшин барих нөхцөлтэй болгоно. Нэгэнтээ нэг л буурь дээр тогтсон газар л өвөлжиж, хаваржиж, зусаж, намаржиж байгаа тул тэндээ суурин орон гэр байгуулах нөхцөл бий болно. Улмаар монгол гэрийн хэрэглээ шахагдан цөөрч улмаар үгүй болох анхны алхмууд болж байгаа хэрэг юм. Мал чаяндаа суурьшмал нөхцөлдөө дасаж нүүдлийн хөл даахгүй болно. Өвөлжөөнд байшинаас гадна малын саравч барих болсон. Үүнийг "саравч" гэхийн оронд "малын байшин" гэж хэлж болно.

Эх сурвалж: Д.Бум-Очир. "Монголын хомдол ба монгол бусын илүүдэл: Төвөдийн шашин, хятадын даяаршил дахь Дээд монголчууд" өгүүллэгээс хэсэгчлэн авав.

Элион компанийн санаачилсан цөлийн өвермөц үйлдвэржилт нь өнгөрсөн 20 жилийн хугацаанд Хятадын шинжлэх ухааны салбарт ихээхэн амжилт авч ирэв. Газрыг хэсэгчлэн хашаалах, бэлчээрт ашиглахгүй байх, хашаалж ургамалжуулах, байгалийн ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх, холимог тарималжуулалтыг хийх, эмийн ургамал тариалах зэрэг арга хэмжээ нь өргөн уудам цөлжсөн газрыг баян бүрд болгоход нөлөөлсөн. Орон нутгийн иргэд, малчид, тариаланчид ажиллах урам зоригтой болсон. Ойролцоогоор 10000 малчин, тариаланч жил бүрийн экологийн арга хэмжээнд оролцдог ба бараг 60 сая юанын шууд орлого олдог байна. 2006 онд Элион компани нь цөлийн хамгийн гүн, хүнд хэсэгт үе дамжин амьдарч ирсэн малчдад зориулсан орчин үеийн тосгон барихад сая сая хөрөнгө оруулалт хийсэн. Ус, цахилгаан, харилцаа холбоо, замын сүлжээнд бүрэн холбогдсон, байшинд амьдрах болсноор хөдөөгийн малчдын амьдрал дээшилж, "үйлдвэрлэл, менежмент, хөгжил"-тэй хөл зэрэгцэн өсөн дэвжих боломжтой болсон.

Элион компанийн арга нь Хятад төдийгүй дэлхийд тэргүүлсэн дэвшилтээт арга болоод байна.

Эх сурвалж: Цөлжилт, газрын доройтолтой тэмцэх Ази, Номхон далайн орнуудын туршилагаас. 41-46 дахь тал.

Асуулт:

1. Таны бодлоор эдгээр эх сурвалжид зохиогчийн илэрхийлэх гэсэн гол санаа юу байв?
2. Эх сурвалж тус бүрээс хамгийн чухал гэсэн нэг асуудал дэвшүүлээрэй
3. Эдгээр асуудал хоорондоо хамааралтай юу? Яагаад?
4. Эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох талаар саналлаа солилцоорой
5. Дараах өгүүлбэрийг гүйцээж бичээрэй
 - Миний бодлоор, элсэн цөлийг "ногоон бүс" болгож байгаа нь юм, учир нь ...
 - Миний бодлоор, малчид бэлчээрээ хашаалж, байшинд амьдрах болж байгаа нь юм, яагаад гэвэл
 - Дээд монголчууд өөрсдийгөө Төвөдөөс ялгах гэж зүтгэж байгаа нь юм, яагаад гэвэл

II. ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

1. Соёлын орон зай гэж юу вэ?
 - а. Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг оюун санааны орчин
 - б. Соёлын харилцаа бүх талаар өргөжин тэлэх үйл явц
 - в. Янз бүрийн ард түмний эрх чөлөөний талаарх мэдрэмж
 - г. Өөр соёлын орчинд орох үед бий болж байдаг оюун санааны орчин
2. Монгол улс хэдэн онд дэлхийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт нэгдэн орсон бэ?

а. 1995	б. 1998	в. 2005	г. 2008
---------	---------	---------	---------
3. Зөв харгалзуулсарай

1. Хүмүүс эх хэлээрээ ярьж, хувь чанараа хөгжүүлэх, нийгмийн баталгаагаар хангагдах, өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх эрх	а. Соёлын адилсал
2. Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадвар	б. Соёлын эрх чөлөө
3. Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, өөрийгөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухаарах байдал	в. Соёлын дархлаа
4. Улс бүхэнд байдаг хүндэтгэл, идээ ундаа, дуу хөгжим, үндэсний спорт, хэл, бичиг үсэг, түүх, шашин, урлал, зан үйл, хөдөлмөрийн соёл зэргийг багтаамждаа агуулсан ойлголт аль нь вэ?

а. Сонгодог соёл	б. Нүүдлийн соёл	в. Үндэсний соёл	г. Суурьшмал соёл
------------------	------------------	------------------	-------------------
5. Соёлын орон зай, кибер орон зай гэсэн ойлголтуудын хамаарлыг аль нь зөв илэрхийлсэн бэ?
 - а. Энэ хоёр ойлголт ижил утгатай
 - б. Соёлын орон зайн нэг хэлбэр нь кибер орон зай юм.
 - в. Кибер орон зайн нэг хэлбэр нь соёлын орон зай юм.
 - г. Энэ хоёр ойлголт хоорондоо ямар ч хамаагүй
6. Цэгийн оронд тохирох үгийг бичээрэй
Үндэсний соёлын өвөрмөц өв санг дэлхий нийтэд үзүүлэн таниулах хэрэгцээ улам нэмэгдэж байгаа өнөө үеийн соёлын солилцооны гол хөтлөх хүч нь дотоодын болон олон улсын мөн.
7. Эргэцүүллийг уншаад өөрийн байр суурийг илэрхийлээрэй
Дэлхийн өнцөг булан бүрд хүмүүс пицца, гамбургер, кари, шарсан төмс идэж, кока-кола, пепси ууж, дэлхий нийтээрээ телевизийн нэг үзмэр /шоу/ үзэж, адилхан хэв маягаар хувцаслаж, нэг төрлийн хөгжим сонсож, чадсан чадаагүй нэг хэл /англи/-ээр ярьж байна. Төрөлх монгол хэлээрээ зөв ярьж, алдаагүй бичиж сурахыг эхэнд тавьж чухалчлахын оронд англи хэл рүү дэндүү шуурч байна.
8. Дараах эргэцүүллүүд соёлын ямар ойлголтыг илэрхийлж байна вэ? Яагаад гэдэг асуултын дагуу үндэслэлээ гаргаарай
 - а. Дэлхийн хүн ам ессеөр, бидний нөөц баялаг хурдацтай багассаар байна. Жишээ нь, ой модыг үй олноор устгаж байгаа нь цаг агаарт, хөрс шороонд, цаашлаад байгаль экологид асар их хор нөлөө үзүүлдэг тухай ярьж болно.
 - б. Монголын туульсын зохиолуудад харийн хаад, мангас махчны дүрүүд байдаг бол үлгэрт дарлагч ноёд, баяд, харийн дайсан, мөн мангас байдаг. Үлгэрт гарч байгаа өнчин хүү, туульд гарч байгаа баатар эр нь элдэв бэрхшээл, зовлон үзэж явсаар эцэст нь амар жаргалтай амьдралыг олж авч байгаагаар дүрслэгддэг.
 - в. Зарим улс оронд цагаач иргэдийг өөрийн соёлын дэг жаяг, зан үйл, төрөлх хэлнээс татгалзахыг шаарддаг байна. Бас нийгмийн амьдрал дахь оролцоог хязгаарладаг байна.
 - г. “Жар хоног жаргаж
Ная хоног найрлаж

Дээр ноёнгүй
Дэргэд дайсангүй
Амсан сайхан жарган суух нь энэ”
(Хан Харангуй, 2016: 88-89).



Суралцахуйн зорилт	Тулгуур ойлголт
<p>Хүний эрх ба үндсэн хууль</p> <p>а. Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизмыг судлан, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, эрх зөрчигдсөн тохиолдолд өөртөө болон бусдад хэрхэн туслах тухай арга хэлбэрүүдийг тодорхойлох</p> <p>б. Үндсэн хуульт ёс болон эрх зүйд захирагдах ёсны харилцан хамаарлын талаар судалж мэдэх, өөрийн байр суурийг илэрхийлэх</p>	<ul style="list-style-type: none"> Хүний эрх Үндсэн хууль Үндсэн хуульт ёс Эрх зүйд захирагдах ёс Өмч, оюуны өмч Гэмт хэрэг, гэм хор Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа Хүний эрхийг хамгаалах тогтолцоо
<p>Иргэний эрх зүйн харилцаа</p> <p>а. Тохиолдол шинжлэх замаар эдийн ба эдийн бус баялагийн эрх болон үүргийн ялгааг тайлбарлах</p> <p>б. Өмчлөх бүрэн эрхийн агуулгыг тохиолдол шинжлэн тодорхойлох</p> <p>в. Оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтыг танин мэдэж, бусдын оюуны өмчид хүндэтгэлтэй хандахын ач холбогдлыг тодорхойлох</p> <p>г. Иргэний эрх зүйн ойлголт гэм хор болон эрүүгийн эрх зүйн ойлголт гэмт хэргийн ялгааг тохиолдол шинжлэн тайлбарлах</p>	
<p>Иргэн ба төрийн харилцаа</p> <p>а. Эрх зөрчигдсөн тохиолдолд хууль, шүүхийн байгууллагад өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргахад суралцах</p> <p>б. Тохиолдол шинжлэн судлах замаар иргэний, захирагааны, эрүүгийн хэрэг маргааны ялгааг тодорхойлж, эрх зөрчигдсөн тохиолдолд эрхээ хамгаалан эрх зүйн харилцаанд оролцох</p>	

СЭДЭВ 3.1 ХҮНИЙ ЭРХ БА ҮНДСЭН ХУУЛЬ

Та бүхэн өмнөх ангидaa хүний эрх, хүний эрхэм чанар, үндсэн хуулийн суурь зарчим, иргэн, захиргаа, хөдөлмөр, нийгэм хамгааллын эрх зүйн харилцааны талаар судалж, жишээ тохиолдлыг шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх чадварт суралцсан билээ. Харин энэхүү бүлэг сэдвийн хүрээнд хүний эрх, эрх зүйд захирагдах ёс, үндсэн хуулт ёсны онолын зарчим, уялдаа холбоог судалж, мөн чанарыг тайлбарлах, салбар эрх зүйн харилцаанд бие даан оролцох, өөрийн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үндэсний болон олон улсын хэмжээнд хамгаалах чадварт суралцах болно.



Үйл ажиллагаа 3.1. Эх сурвалжид тулгуурлан хүснэгтийг ажиллаарай.



Нийгмиин гишүүн бүрийн амь бие, эд хөрөнгийг нийтийн хүчээр сахин хамгаалах чадвартай нийгмиин холбооны хэлбэрийг олох хэрэгтэй бөгөөд гишүүн бүр энэ нээдэлд нэгдэх ёстай. Ингэснээр гагцхүү өөрөө өөрийгөө захирч урьдын адил бусдаас хамааралгүй эрх чөлөөтэй улдэнэ.

Жан Жак Руссо




Хүмүүс байгалиас заясан эрх чөлөөтэй. Гэтэл яагаад төр засагт захируулж, эрх чөлөөгөө хязгаарлуулдаг юм вэ? Хариулт маш тодорхой юм. Байгалиас заясан эрх чөлөөгөө эдлэх нь таатай гэсэн уг биш. Хүмүүс бусдын халдлагад хэзээ ч өртөх боломжтой байдаг. Ийм учраас тэд өөртэй нь ижил аюулгүй байдлаа хангах хэрэгцээтэй байгаа хүмүүсийг олж нэгддэг.

Жон Локк




Т.Гоббс,
Төр бол
“левиафан”




Ф.Бастиа,
Төр бол
“татвараар
сорон мөлжигч”



Р.Нозик,
Төр бол “хүний
эрхийн гол
дайсан”



Ж.С.Милль, Төр
бол “зайлишгүй
байх ёстай муу
зүйл”



Л.Актон, “Аливаа эрх
мэдэл хүнийг эвддэг
бол хязгааргүй эрх
мэдэл хязгааргүй
эвддэг.”

№	Асуулт	Ж.Ж.Руссо	Ж.Локк	Бусад
1	Сэтгэгчид юуны тухай өгүүлсэн бэ?			
2	Сэтгэгчид ямар байр суурийг илэрхийлсэн бэ?			
3	Сэтгэгчдийн байр суурь ялгаатай байгаагийн шалтгаан юу вэ?			

Төр нь хүний эрхийг хамгаалдаг талаар бид өмнөх ангид судалсан. Төр хүний эрхийг хамгаалах үндсэн үүрэгтэй. Гэвч төр эсрэгээрээ хүний эрхийг зөрчих, иргэдийг хохироо тохиолдол цөөнгүй гарах болсон. Үүнийг бид бүхэн хүн төрөлхтний түүхээс мэдэх билээ.

Хүн төрөлхтөн НТӨ V зууны үеэс хүний байгалиас заясан жам ёсны эрхийн талаар ярьж, сургаж, түүний төлөө тэмцэж ирсэн хэдий ч хүний эрхийн хамгаалалт хангалттай үр дүнтэй байгаагүй. Учир нь хүний төрөлх эрхийг зөвхөн зарлан

тунхаглах нь хангалтгүй, харин түүнийг хамгаалах тогтолцоог бий болгох нь хамгийн чухал юм. Хүмүүс өмчөө хамгаалуулах, амар тайван, аюулгүй амьдрах, эрх чөлөөтэй байх эрхээ баталгаажуулахын тулд төрийг бий болгосон. Гэтэл хэмжээгүй эрхт засаг, төрийн дур зорго, үйлдэл, үйл ажиллагаа нь иргэдийн эрхийг үл тоомсорлох, зөрчих явдал түгээмэл байсан нь түүнд өгсөн эрх мэдлийг хязгаарлаагүй нөхцөлд дарангуйлал үгүй болохгүй гэдгийг харуулав.

Ийнхүү хүн төрөлхтөн засаг, төрийн мөн чанарыг мэдсэн цагаас эхлэн түүнийг хязгаарлах оролдлогуудыг хийж эхэлсэн байна. Ингэхдээ өрнө дахинд хууль болон ард түмний төлөөлөгчдийн дуу хоолойгоор дorno дахинд төрийн түшээ хүний ёс суртахуунаар хязгаарлах тухай ерөнхий санааг дэвшиүүлж байжээ. Гэвч эдгээр нь засаг, төрийн эрх мэдэл, дур зоргыг хязгаарлах тийм ч сонгодог шийдэл байж чадаагүй аж. Харин хүний эрх, эрх чөлөөг төрийн хүчинээс хамгаалах талаар хийсэн дорвитой ололтуудын нэг бол засаглалын эрх мэдэл хуваарилах тухай санаа байв.

Ш.Монтеське “Хуулийн амин сүнс” бүтээлдээ засаглалын эрх мэдлийг хуваарилах онолоо боловсруулж, ач холбогдолтыг тодорхойлжээ. Тэрбээр засаглалын эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 төрөлд хувааж, эдгээр эрх мэдэл харилцан хяналт, тэнцвэртэй байгаа нөхцөлд хүний эрх жинхэнэ ёсоор хамгаалагдана гэсэн санааг дэвшүүлжээ. Энэ үзэл баримтлал нь хүний эрхийн олон зарчимтай нийцдэг.

Засаглалын эрх мэдэл хуваарилах нь хүний эрхийг засаг, төрийн дур зорго, дарангуйллаас хамгаалах арга хэрэгсэл бөгөөд энэ зарчмыг бүх улс орнууд төрийн гол хууль тогтоомж болох Үндсэн хуулиар баталгаажуулж, хэрэгжүүлэх болсон. Энэ утгаараа Үндсэн хуулийн хамгийн гол зорилго бол засаглалын эрх мэдлийг хуваарилахад оршдог. Францын 1789 оны Хүний болон иргэний эрхийн тунхаг бичгийн 16 дугаар зүйлд “Иргэд нь эрхээр хангагдаагүй, засаглалын эрх мэдлийг хуваарилаагүй нийгэмд Үндсэн хууль байдаггүй” гэж заасан байдаг.



Тулгуур ойлголт

Үндсэн хууль нь засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй хамгийн дээд хүчин чадалтай засаг, төрийн гол хууль юм.

Эрх зүйд захирагдах ёс, үндсэн хуулт ёс хэмээх суурь ойлголтуудын ялгаа, онцлогийг мэдэх нь эрх зүй, үндсэн хууль, хуулийн мөн чанарыг ойлгоход ач холбогдолтой юм.

Эрх зүйд захирагдах ёс

Аливаа хууль, дүрэм, журам бол түүнийг тогтоож байгаа байгууллага, албан тушаалтны хүсэл зоригийн илэрхийлэл мөн. Эдгээр баримт бичгүүдийг Үндсэн хууль болон бусад хуулиар эрх олгосон аль нэг байгууллагаас гаргадаг. Ийнхүү гаргахдаа шууд удирдлага болгох эрх зүйн үндсэн зарчмуудад тулгуурладаг. Тухайлбал, шударга, тэгш, хүнлэг, энэрэнгүй байх, хүүхдийн эрх ашгийг зөрчихгүй байх мэт. Дээрх зарчмыг баримжаалсан хууль тогтоомж, дүрэм, журам эрх зүйд захирагдах ёсыг удирдлага болгосон гэсэн үг юм. Үүнийг бид хууль, дүрэм, журамд тавигдах шаардлага гэж хэлж болно.

Үндсэн хуулт ёс

Эрх зүйд захирагдах ёсны дагуу орчин цагийн үндсэн хуульд дараах зарчмыг удирдлага болгодог. Үүнд, Үндсэн хуулиар:

- Засаг, төрийн эрх мэдлийг хуваарилах
 - Хүний эрхийг баталгаажуулах
 - Ардчилсан дэглэм, бүгд найрамдах засаглалыг хүлээн зөвшөөрөх
 - Эрх зүйт төрийн үндсийг бэхжүүлэх
 - Хүнлэг энэрэнгүй байдлыг бий болгох. Иргэний нийгмийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх
 - Төрийн байгууламжийг тодорхой тусгасан байх
 - Үндсэн хуулийг хянах тогтолцоог бүрдүүлэх
- Дээрх зарчмуудыг цогцоор нь удирдлага болгох нь үндсэн хуульт ёсны гол үзэл баримтлал мён.



Үйл ажиллагаа 3.2. Дараах Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт болон хуулийн зохицуулалтад үндэслэл бүхий тайлбар хийнэ үү.

2010 оны 03 сарын 24-ны өдөр Монгол улсын Үндсэн хуулийн цэц иргэн Х-гийн өргөдлийн дагуу Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн заалт буюу “60-аас дээш настай хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно” гэсэн нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэжээ. Цэцээс Гэр бүлийн тухай хуулийн дээрх заалт Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн байна.

Эх сурвалж: Үндсэн хуулийн цэцийн шийдвэр
2010 он дугаар 01

Батын аав ямар нэг ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй. Тэр хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр авдаг.

Дулмаагийн аав гутлын үйлдвэрт 33 жил ажилласан. Тэр хуульд заасны дагуу нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авдаг.

Асуулт:

1. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт болон тохиолдлуудад үндсэн хуульт ёсны болон эрх зүйд захирагдах ёсны ямар зарчмыг баримжаалсан бэ?
2. Цэцийн дүгнэлт болон хуулийн зохицуулалтын уялдаа холбоо, зөрчилт талыг тайлбарлан ярилцаана уу.

ҮНДСЭН ХУУЛИЙГ ХЭН ХАМГААЛДАГ ВЭ?



Үйл ажиллагаа 3.3. Дараах асуултад хариулж, ярилцаарай.

Асуулт:

1. “Монгол улсын өрөнхий сайдын гаргасан шийдвэр нь Үндсэн хууль зөрчсөн” гэх бодомж зөв үү? Яагаад?
2. “Иргэн Үндсэн хууль зөрчсөн үйлдэл гаргажээ” гэх бодомж зөв үү? Яагаад?
3. Үндсэн хууль зөрчвөл ямар шийтгэл оногдуулдаг вэ?
4. Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг ямар байгууллага шийдвэрлэдэг вэ?

Өмнө бид хүний эрхийг зөвхөн тунхаглан зарлах бус хамгаалах тогтолцоог бүрдүүлэх нь хамгийн чухал болох талаар авч үзсэн. Энэ тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг нь хүний эрхийг баталгаажуулсан суурь хууль болох Үндсэн хуулийг хамгаалдаг, түүний биелэлтэд хяналт тавьдаг бие даасан, хараат бус байгууллагыг бий болгох юм. Үндсэн хуульт ёсонд тулгуурласан ардчилсан, эрх зүйт төрийн гол зорилго нь засаглалын эрх мэдлийг хууль дээдлэх зарчимд захируулж, түүний шийдвэр, үйл ажиллагааг Үндсэн хуулийг хамгаалах байгууллагын хяналтад оруулах замаар хүний эрхийг хамгаалахад чиглэдэг. Манай улсын хувьд Үндсэн хуулиар эрх, үүргээ тодорхойлуулсан төрийн дээд байгууллагуудын үйл ажиллагааг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүрэг бүхий “Үндсэн хуулийн цэц” хэмээх

байгууллага ажилладаг. Дэлхийн улс орнуудад энэ байгууллагыг Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн зөвлөл гэх зэрэг олон янзаар нэрлэдэг.

Үндсэн хуулийн цэц нь зөвхөн Үндсэн хууль зөрчсөн талаар маргааныг шийдвэрлэж, засаг, хуульд заасан тодорхой байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг. Иймээс Үндсэн хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй субъект л зөвхөн тус хуулийг зөрчих боломжтой гэсэн үг юм. Өмнө дурдсанчлан, Үндсэн хуулиар эрх, үүргээ тодорхойлуулсан засаг, төрийн эрх барьж буй байгууллага албан тушаалтан өөрийн шийдвэр үйл ажиллагаагаар Үндсэн хуулийг зөрчдөг. Харин энгийн иргэд, байгууллага, доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтан зөрчихгүй юм. Жишээлбэл, Улсын Их Хурал хууль батлахдаа, Засгийн газар шийдвэр гаргахдаа хүний үндсэн эрхийг зөрчсөн, Үндсэн хуульд заасан эрх хэмжээгээ хэтрүүлэх зэрэг үйлдэл гаргах тохиолдол байдаг. Бид Улсын Их Хурлын гишүүн, ерөнхий сайд Үндсэн хууль зөрчсөн гэж сонсож байснаас иргэн А Үндсэн хууль зөрчсөн гэж дуулаагүй нь лавтай. Үндсэн хуулийн цэц нь засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа дээд байгууллага, албан тушаалтны тус хуулийг зөрчсөн эсэх асуудлыг шалган тогтоож, хуульд заасан арга хэмжээ авдаг. Иймээс Үндсэн хуулийн цэцийг Үндсэн хуулийн хамгаалагч гэж нэрлэдэг.

Үндсэн хуулийн цэц нь дараах эрх зүйн актууд Үндсэн хуульд нийцэж буй эсэх, мөн тодорхой албан тушаалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянадаг. Хэрэв зөрчил гарсан тохиолдолд эрх зүйн актуудыг болон түүний холбогдох заалтыг хүчингүй болгох, Үндсэн хууль зөрчсөн албан тушаалтныг эгүүлэн татах, огцуулах үндэслэл байгаа эсэхэд дүгнэлт хийж шийдвэр гаргана. Үүнд:

Эрх зүйн актууд

Албан тушаалтны үндсэн хууль зөрчсөн эсэх

Албан тушаалтныг огцуулах эгүүлэн татах

- Хууль, УИХ-ын шийдвэр
- Ерөнхийлөгчийн зарлиг, шийдвэр
- Засгийн газрын шийдвэр
- Олон улсын гэрээ
- Ард нийтийн санал асуулга
- УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар Сонгуулийн төв хорооны шийдвэр

- Монгол улсын Ерөнхийлөгч
- Улсын Их Хурлын дарга
- Улсын Их Хурлын гишүүн
- Ерөнхий сайд
- Засгийн газрын гишүүн
- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч
- Улсын ерөнхий прокурор

- Монгол улсын Ерөнхийлөгч
- Улсын Их Хурлын дарга
- Ерөнхий сайд
- Улсын Их Хурлын гишүүн

Бүдүүвч 3.1. Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлээс



Гэртээ хийгээрэй.

1. “Үндсэн хуулийн манаач” гэх нэр томьёог тайлбарлана уу.
2. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьдаг байгууллагыг яагаад “Үндсэн хуулийн цэц” гэж нэрлэх болсон учир шалтгааныг тайлбарлана уу.
3. Сум, Дүүргийн Засаг дарга Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэж болох уу?



Нэмж судлаарай

- Монгол улсын Үндсэн хууль 1992 он
- Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль 1992 он
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль 1997 он
<http://www.legalinfo.mn/law/>
- Жан Жак Руссо, “Нийгмийн гэрээ”, Уб, 2016, Монсудар хэвлэх үйлдвэр

СЭДЭВ 3.2 ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ХУУЛИАР ХАМГААЛАХ НЬ



Үйл ажиллагаа 3.4. Эх сурвалжийг уншаад, асуултын дагуу хамтран ярилцаарай.

Америкийн эдийн засагч Мюррей Н.Ротбард “Эрх мэдэл ба зах зээл” хэмээх бүтээлдээ өмчлөх эрхийн мөн чанарыг дараах байдлаар өгүүлжээ.




Ул үндэстэй авч үзэх юм бол эрх гэж байхгүй зөвхөн “өмчлөх эрх” л байдаг аж. Үүнийг үнэн болохыг баталсан хэд хэдэн утга буй. **Нэгдүгээрт**, хувь хүн өөрөө өөрийнхөө зээн, өөрийгөө мэддэг гэсэн жам ёсны баримт байна. Хүний эрх дан ганц зах зээлийн нийгэмд хамгаалагддаг. Үнэндээ хүний өмчлөх эрх гэдэг бол өөрийнх нь оршихуйд байдаг, энэ л өмчлөх эрхээс өөрийн бүтээсэн баялгаа өмчлөх боломж бүрдэнэ.

Хоёрдугаарт, хүний алываа эрх өмчлөх эрх дээр хураангуйлагддаг. Жишээ нь, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг өөрийн дуртай зүйлээ чөлөөтэй хэлэх гэж ойлгож болно. Нээх их нухацтай биш ч гэсэн хүн хаана ийм эрхтэй байдаг юм бэ? гэсэн асуулт гарна. Лав л бусдын гэр оронд зөвшөөрөлгүй ороод би ийм эрхтэй гэж хэлэх боломжгүй. Товчоор хэлэхэд, хүн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ өөрийн хууль ёсоор эзэмшиж, өмчилж байгаа газартаа л эдэлнэ. Тэгэхээр бодит байдалд өмчлөх эрхээс тусдаа “санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх” гэсэн зүйл байдаггүй гэсэн уг.

Эх сурвалж: *Боаз Д. Либертарианизм эхлэн суралцах бичиг*
(Хууль хүний эрх чөлөөний философи), Уб., 2005, 97 дахь тал

Асуулт:

1. Өмчлөх эрхийг яагаад төрөлхөөс занасан жам ёсны эрх гэж онцлон тэмдэглэсэн бэ?
2. Өөр ямар эрх өмчлөх эрхгүйгээр хэрэгжих боломжгүй вэ? Жишээ гарган ярилцана уу.
3. Ж.Локк яагаад хувийн өмчийг “эцсийн зорилго бус эрх чөлөөг олж авах хэрэгсэл” гэж үзсэн бэ?
4. Өмчтэй хүнд байх давуу талуудыг нэргэнэ үү.



Өмнөх сэдэвт хүмүүс өөрийгөө хамгаалуулах, аюулгүй, амар тайван амьдралын тулд төрийг бий болгож, энэ зорилгын доор төрд нэгдсэн талаар тэмдэглэсэн. Засаг, төр нь иргэдийн өмчийн аюулгүй, баталгаатай байдлыг хангах үүрэг хулээдэг. Тухайлбал, газар, байшин өмчлөх эрхийг нэгдсэн бүртгэлд оруулж, өмчлөх эрхийн гэрчилгээ олгох, таны өмч хөрөнгөд халдсан тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авах гэх мэт.



Тулгуур ойлголт

Өмчлөх эрх гэдэг нь эдийн болон эдийн бус баялгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах боломжийг хэлнэ. Өмчлөх эрхийн агуулгад хамаарах **ашиглах эрх** бол тухайн баялгийн үр шимийг хүртэх, **эзэмших эрх** нь бүрэн хараа хяналтдаа байлгах, **захиран зарцуулах эрх** нь тус баялгийг худалдах, бэлэглэх, арилжих, зээлэх зэргийг шийдвэрлэх боломж юм.

Монгол улсын Үндсэн хуулийн 16.3 дугаар зүйлд “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжуулах” эрхийг баталгаажуулж, Иргэний хуулиар өмчийн харилцааг нарийвчлан зохицуулсан. Монгол улсын Иргэний хууль нь 2002 онд батлагдсан. Тус хуулийн зорилго нь хүмүүсийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Эдийн баялаг гэдэгт хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг ойлгодог бол эдийн бус баялагт оюуны өмч, зохиогчийн эрх, патент, нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд зэрэг хамаарах юм. Эдгээр баялгийг Иргэний хуулиар хамгаалж байдаг. Оюуны өмчийн эрхийг хамгаалах гол эрх зүйн хэм хэмжээ нь Зохиогчийн болон түүнд хамаарах эрхийн тухай болон Патентийн тухай хууль юм.

ӨМЧЛӨХ ЭРХ ХЭРХЭН ҮҮСЭХ ВЭ?



Үйл ажиллагаа 3.5. <http://www.legalinfo.mn/law/details/299> линкээр зочилж, Иргэний хуулийн 115-118 дугаар зүйлийг уншиж, дараах тохиолдлуудыг шинжлэн судлаад хууль зүйн үндэслэл бүхий тайлбар хийнэ үү.

№	Эд хөрөнгийг өмчлөх эрхтэй юу?	Тийм	Үгүй	Тайлбар
1	Иргэн “Д” автобусанд явж байхдаа 1.5 сая төгрөгийн үнэтэй гар компьютер олсон байна.			
2	Иргэн “Ч” Зөвлөлтийн цэргийн анги Монголоос гарах үедээ орхисон гахайн байрыг сумын захирагаанд мэдэгдэж, засаж, сэлбэж 7 жил тасралтгүй эзэмшсэн.			
3	Иргэн “Э” Онгийн хийдийн тууринд дарагдмал үнэт эд зүйл байдгийг бусдаас сонсож өөрөөсөө хөрөнгө хүч гарган хайгуул хийж, эрсэн зүйлээ олоход түүний дотор түүхийн дурсгалт зүйл ч байсан байна.			
4	Малчин “А” шуурганд туугдаж яваа 300 хонь олоод орон нутгийн захирагаанд мэдэгдэж, 1.6 жил маллав. Гэтэл алдуул хонинь эзэн “Б” ирж бүх малаа төлийн хамт авна гэхэд А малын төл бол миний өмч гэв.			
5	Иргэн А-г гудамжинд явж байхад үл таних Б хөөрөг худалдаж авахыг санал болгожээ. А хөөргийг үзээд худалдаж авсан. Уг хөөргийг Б нь Д-ээс хулгайлсан бөгөөд энэ талаар А огт мэдээгүй.			

Бид эзэнгүй, гээгдэл, дарагдмал эд хөрөнгө олж авсан тохиолдолд Монгол улсын хуульд заасан ямар зохицуулалт байдаг талаар мэдэж авлаа. Монгол улсын нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүн бүр хууль болон гэрээнд заасны дагуу баялгийг өмчлөх эрхтэй болдог. Үүнээс бусад аргаар өмч, хөрөнгөтэй болсон тохиолдолд хууль бус бөгөөд түүнийг үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж үздэг. Өмчлөх эрх үүсэх үндэслэлийг дараах бүдүүвчээс харж болно.



Бүдүүвч 3.2 Монгол улсын Иргэний хуулиас

Өмчийн харилцаанд зайлшгүй анхаарвал зохих асуудлууд байдаг. Үүнд:

- Өмчийг заавал хууль болон гэрээнд заасны дагуу олж авах эс тэгвэл эрх зүйн зөрчил болно.
- Хөдлөх эд хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлж авсан үеэс өмчлөх эрх үүснэ. Өөрөөр хэлбэл, ном худалдаж авбал номыг өөрийн мэдэлд оруулсан үеэс өмчлөгч болно.
- Үл хөдлөх эд хөрөнгийн хувьд худалдах, бэлэглэх, зээлэх, арилжих аль ч тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ авснаар өмчлөх эрх үүснэ.
- Хууль болон гэрээнд заасан үндэслэлээр нэг талд өмчлөх эрх үүсэхэд нөгөө талын өмчлөх эрх дуусгавар болж байдаг.

ӨМЧЛӨХ ЭРХЭЭ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ, ХАМГААЛАХ ВЭ?



Үйл ажиллагаа 3.6. Тохиолдол шинжлээрэй.

Нэг. Иргэн А малаа бэлчээрт гаргахдаа хөрш Б-гийн өмчлөлийн газраар дайрч өнгөрдөг. Үүнээс өөр гарц байхгүй. Гэтэл хөрш Б хүнсний ногоо тарихаар шийдэж, А-г ногооны талбайд мал оруулахыг хориглосон.

Асуулт:

- А нь эрхээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Хоёр. Иргэн Д Говь-Алтай аймагт оршин суудаг. Тэр “Нарантуул” захаас 70 000 төгрөгөөр өвлийн гутал худалдан авч 3 өдөр өмссөн байна. Гэтэл гутлын ар талын хатуулгыг буруу нааснаас болж урагдсан. Иргэн Д худалдагчтай уулзаж энэ талаар хэлэхэд, “энэ гутлыг би үйлдвэрлээгүй, надаас шинэ гутал авсан, одоо өмсчихсөн тул буцаах, солих боломжгүй” гэв. Худалдагч Баянзүрх дүүрэгт оршин суудаг.

Асуулт:

1. Худалдагчийн тайлбар үндэслэлтэй юу?
2. Иргэн Д-ийн ямар эрх зөрчигдсөн бэ?
3. Иргэн Д эрхээ хэрхэн хамгаалах вэ?
4. Хэрэв та А болон Д байсан бол асуудлыг шийдвэрлэхийн тулд юу хийх вэ?

Өмчтэй холбоотой харилцаа нь ихэнх тохиолдолд талуудын тохиролцоо буюу гэрээний үндсэн дээр үүсдэг. Эд хөрөнгийг худалдах, худалдан авах, бэлэглэх, хөлслэх, түрээслэх гээд олон төрлийн харилцаанд талууд гэрээ байгуулж оролцно. Гэрээг заавал бичгээр байгуулахыг шаардахгүй, амаар тохиролцох, автомат машинаас худалдаа хийх гээд бодит үйлдлээр ч байгуулж болно. Жишээ, нь иргэн



А нь малаа бэлчээрт гаргахын тулд Б-тэй зөвшилцөн түүний газрыг хязгаартай ашиглах гэрээ байгуулж болно. Үүнийг иргээний хуулийн 151 дүгээр зүйлээр зохицуулсан. Харин А нь Б-ын хэсэг газарт нарийн зам гаргаж, хашаа татаж, малаа бэлчээрт гаргаад хариуд нь Б-д мөнгөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэж болох юм.

Өмчлөх эрх зөрчигдсөн тохиолдол нь гэмт хэргийн шинжгүй эсвэл захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаатай холбоогүй бол иргээний эрх зүйн зөрчил болно.



Тулгуур ойлголт

Нэхэмжлэл гэдэг нь иргээний хэргийн шүүхэд хандаж эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой маргаж байгаа буюу зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалахын тулд анхан шатны шүүхээр дамжуулан эрх зөрчигчид тавьж буй шаардлага юм.

Иргэн, хуулийн этгээд гэрээний үүргээ биелүүлээгүй, үйл ажиллагаандаа хариуцлагагүй хандсан зэрэг өмч хөрөнгөд хор хохирол учрах, ашиг орлогоо алдах гэх мэт тохиолдолд Иргээний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж өөрийн эрхийг хамгаалдаг.

Нэхэмжлэлийг буруутай гэж үзэж байгаа хүнийхээ оршин суугаа газрын Иргээний хэргийн анхан шатны шүүхэд гаргана. Нэхэмжлэл гаргахдаа хуульд заасан бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай болдог. Үүнийг нэхэмжлэлийн бүрдүүлбэр гэж нэрлэнэ. Энэхүү бүрдүүлбэр хангаагүй бол нэхэмжлэлийг шүүх хүлээн авахгүй.

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХДАА ЮУ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

- Нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа;
- Нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, утасны дугаар, хуулийн этгээд бол оршин байгаа газар;
- Эрх зөрчигчийн буюу хэргийн хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг;
- Нэхэмжлэгийн үнэ буюу хэдэн төгрөг нэхэмжилж байгаа талаар бичих, хэрэв эд хөрөнгө гаргуулах нэхэмжлэл бол тухайн эд зүйлийн зах зээлийн үнэ бичих;
- Улсын тэмдэгтийн хураамж буюу шүүхээс үйлчилгээ үзүүлсний хөлсийг хуульд заасан хэмжээгээр төлсөн баримт;

Иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагааны хамгийн гол онцлог бол маргалдагч талууд маргааны үйл, баримтыг өөрөө нотлох үүрэг хүлээдэг. Иймээс аливаа төрлийн өмчийн харилцаанд оролцохдоо гэрээ хийх, дансаар мөнгө шилжүүлэх, гэрчлэх хүнтэй байх зэрэг ямар нэг байдлаар үйлдлээ нотлох баримт үлдээж байхыг харилцаанд оролцогчид анхаарах хэрэгтэй болдог.



Үйл ажиллагаа 3.7. Загварын дагуу Нарантуул захаас гутал худалдан авсан иргэн Д-гийн өмнөөс нэхэмжлэл бичээрэй.

Нэхэмжлэл бичих загвар

..... Иргэний хэргийн анхан шатны шүүхэд
нэхэмжлэл гаргах нь
.....онысарынөдөр хот, аймаг, сум\

Худалдах, худалдан авах гэрээнээс үйлдэлтэй
хохирол гаргуулах тухай

Нэхэмжлэгч: _____

Хариуцагч _____

Нэхэмжлэлийн утга

Нэхэмжлэлийн шаардлага:

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр:

1. Нэхэмжлэл 2 хувь
2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
3. Мөнгө шилжүүлсэн баримт
4.



Нэхэмжлэл гаргасан

\Гарын үсэг\

Монгол улсын 2015 онд батлагдсан шинэ Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн 12 төрлийн нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн ял, шийтгэл оногдуулахаар тусгажээ. Үүнд:

Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших

Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үүрэгдүүлэх

Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах



Хөрөнгө завших



Хулгайлах

Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах

Эд хөрөнгө устгах, гэмтээх

Мал хулгайлах

Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих



Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх

Дээрэмдэх



Залилах

Бусдын болон өөрийн өмчлөх эрхэд халдсан энэ төрлийн үйлдлийг шүүхэд бус цагдаагийн байгууллагад хандаж гомдол гаргах, мэдээлэл өгөх замаар өмчлөх эрхийг хамгаална.



Гэртээ хийгээрэй.

1. <http://www.legalinfo.mn/law/details/551> линкээр зочилж, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг уншиж судлаад “Хэрэглэгчийн эрхийн хэрэгжилт” сэдвээр эссе бичээрэй.
2. <http://www.legalinfo.mn/law/details/299> Иргэний хуулийн 243 дугаар зүйл буюу худалдах, худалдан авах гэрээний зохицуулалтыг судалж, худалдан авагч ямар эрх, үүрэгтэй талаар тайлбар хийгээрэй.
3. <http://www.legalinfo.mn/law/details/11634> линкээр зочилж, Эрүүгийн хуулийн 17.5-д заасан “Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших” гэмт хэрэгт ямар хариуцлага хүлээлгэдэг талаар судлаарай.

СЭДЭВ 3.3 ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Шударга шийтгэл бол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шилдэг арга мөн.
Иммануил Кант



Үйл ажиллагаа 3.8. Тохиолдол шинжлээрэй.

Иргэн Ж-г ажилдаа явсан хойгуур түүний байшингийн цонхоор Б хоёр удаа орж эд зүйлийг нь хулгайлж авсан байна. Б-гийн үйлдлийг хамар хашааны иргэн О харсан боловч энэ талаар хэнд ч хэлээгүй. Дараагийн өдөр нь Ж ажлаасаа чөлөө авч гэртээ Б-г хүлээв. Б дахин ирж цонхоор орох үед Ж түүнийг цохиж биед нь хүндэвтэр гэмтэл учруулжээ.

Асуулт:

1. Хэнд хохирол учирсан бэ?
2. Хэнд гэм хор учирсан бэ?
3. Хэн гэмт хэрэг үйлдсэн бэ?
4. Хэрэв та Ж байсан бол ямар үйлдэл хийх вэ?
5. Хэрэв та О байсан бол ямар үйлдэл хийх вэ?
6. Ж өөрийн өмчлөх эрхээ хуулийн дагуу хамгаалж чадсан уу?
7. Ж буруутай юу?




Францын философийч, социологич Э.Дюркгейм (1858-1917) “Аливаа нийгэмд гэмт хэрэг, зөрчил байнга оршсоор ирсэн. Олон зууны турш хүн төрөлхтөн үүнийг үгүй болгохыг хичээсэн ч соёл иргэншилд төвлөрсөн амьдрал буюу хот суурин бий болохын хэрээр улам нэмэгдсээр байна” гэж дүгнэжээ.

Өргөн уудам тал нутагт гэрээ барьж, аж төрж буй хоёр айлын хувьд хэрэг, зөрчил гарах нь тийм ч элбэг биш байдаг. Харин хүн амын хэт төвлөрөл, суурин соёл иргэншил бүхий бидний амьдарч буй нийгэмд энэ үзэгдэл бага бус байсаар ирсэн. Тиймээс бид бүхэнд гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч, оролцогч болох тохиолдол гарахыг үгүйсгэхгүй. Энэ тохиолдолд буруу алхам хийхгүй, өөрийн эрхийг хамгаалах чадварт суралцах нь энэ цаг үеийн зайлшгүй хэрэгцээ, шаардлага болоод байна.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ ЯМАР ЯЛГААТАЙ ВЭ?

Эрх зүйн зөрчил гэж хууль, дүрэм, журмыг зөрчсөн нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ. Эрх зүйн зөрчлийг гэмт хэргийн, гэмт хэргийн бус зөрчил гэж ангилна. Гэмт хэргийн зөрчлийг зөвхөн эрүүгийн хуульд тусгаж, хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг. Гэмт хэргийн бус зөрчилд захиргааны, эд хөрөнгийн, сахилгын зөрчил хамаарна.




Бүдүүч 3.3. Гэмт хэргэг, гэмт хэргийн бус зөрчил

Тайлбар: Эс үйлдэл гэдэг нь хуульд заасан үүргийг гүйцэтгэхгүй байхыг хэлдэг. Жишээ нь, гэмт хэргийн талаар мэдсэн хэрнээ цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөхгүй байх нь эс үйлдлээр эрх зүйн зөрчил гаргаж, гэмт хэрэг үйлдсэнд тооцогдоно.

Үйл ажиллагаа 3.9. Эх сурвалжтай ажиллаад даалгаврыг гүйцэтгээрэй.	
Эрүүгийн хууль 2015 он	Зөрчлийн тухай хууль 2017 он
Хулгайлах Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар өөрийн мэдэлд шилжүүлэн авсан бол хупгайн гэмт хэрэг болдог. Энэ хэрэгт нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.	Хулгайлах Бусдын эд хөрөнгийг хулгайлсан үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинж агуулгаагүй хор хохирол багатай бол захиргааны зөрчилд тооцно. Энэ зөрчил гаргасан хүнийг албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулдаг.

Зохиогчийн эрхийг зөрчих	Зохиогчийн болон түүнд хамаарах эрхийн тухай хууль зөрчих
Зохиогчийн эрхийг зөрчиж бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, улсын хилээр нэвтрүүлсний улмаас зохиогч, эрх эзэмшигчид их хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг болно. Энэ үйлдэлд дөрвөн зуун тавин нэгжээс 450.000-5.400.000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэдэг.	Хэрэв зохиогчийн эрх зөрчсөн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинж агуулаагүй бол зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг. Тухайлбал, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, үйл ажиллагааг нь зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 500.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5.000.000 төгрөгөөр торгоно.
Хүүхэдтэй хэрцгий харилцах	Хүүхдийн эрхийг зөрчих
<p>Хүүхдийн эрхийг зөрчсөн ноцтой үйлдэл гаргасан багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн үйлдсэн бол 400.000-700.000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зурган сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p>	

1. Гэмт хэрэг болон гэмт хэргийн бус зөрчлийн ялгаатай ба нийтлэг талыг диаграммаар илэрхийлнэ үү.



ГЭМ ХОР ГЭЖ ЮУ ВЭ?

Эрх зүйд гэм хор, хохирол, хор уршиг хэмээх ойлголтууд нь хоорондоо ойролцоо боловч өөр өөр утга илэрхийлдэг. Эдгээр нь эрх зүйн зөрчил бий болсон, түүний шууд үр дагавраас үйлдэлтэй бий болно.



Бүдүүвч 3.4. Гэм хорын ангиалал

Гэм хорыг эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус гэж ангилдаг. Эрх зүйн зөрчлийн улмаас гэм хор учирсан этгээд дараах шаардлагуудыг гаргах эрхтэй юм.

Тулгуур ойлголт

Гэм хор нь хохирол, хор уршиг гэсэн ойлголтыг өөртөө багтаанаа.

Хохирол. Гэмт хэрэг үйлдсэн, нэр төрд халдсан, гэрээний үүргээ гүйцэтгээгүй гэх зэрэг эрх зүйн зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, аюулгүй байдалд шууд учирсан үр дагавар юм.

Хор уршиг нь хохирлын улмаас үүссэн үр дагаврыг хэлнэ.



Эд хөрөнгөд

- 🕒 Гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээж өгөхийг шаардах
- 🕒 Ижил нэр, төрөл, чанаарын эд хөрөнгөөр сольж өгөхийг шаардах
- 🕒 Гэмтсэн эд хөрөнгийг засаж өгөхийг шаардах
- 🕒 Мөнгөөр нөхөн төлөхийг шаардах эрхтэй



Сэтгэл санаанд

- 🕒 Сэтгэл санаанд учирсан хохирлоо мөнгөөр үнэлж нэхэмжлэх
- 🕒 Нэр төрд нь халдсан бол учлалт гүйхыг шаардах
- 🕒 Хохирлоос шалтгаалан орлого, ашиг алдсан бол гаргуулах



Эрүүл мэндэд

- 🕒 Хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоо нэхэмжлэх
- 🕒 Эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан асарч сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувиллын газар сувилуулах зэрэг бий болсон хохирлыг гаргуулах



Амь насанд

- 🕒 Оршуулгын зардал төлүүлэх
- 🕒 Нас барсан хохирогчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй хүн, хүүхэд, хохирогчийг нас барсны дараа төрсөн хүүхэд, нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байгаа байнгын цалин хөлс орлогогүй эзэг, эх, нөхөр /эхнэр/-ийг тэжээн тэтгүүлэх

Бүдүүвч 3.5. Гэм хорыг арилгах арга зам. Монгол улсын Иргэний хуулиас

Хэрэв гэмт хэргийн талаар мэдсэн, хохирсон, ямар нэг байдлаар холбогдсон бол нэн тэргүүнд цагдаагийн байгууллагад мэдэгдэх ёстой. Гэмт хэргийг таслан зогсоох гэж өөрөө ямар нэг арга хэмжээ авах, дур мэдэн үйлдэл хийх нь аюултай бөгөөд хохирогч, холбогдогч болохыг үүгүйсэхгүй. Мөн хохирогч, гэрч, сэжигтэн аль нь ч байсан өөрөө бие даан тухайн харилцаанд оролцох нь эрсдэлтэй юм. Ийм нөхцөл байдалд хуульч, өмгөөлөгчөөс заавар зөвлөгөө авах нь өөрийн эрхээ хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга юм.

Хууль зүйн туслалцаа авах, өөрийгөө өмгөөлүүлэх нь Үндсэн хуульд заасан эрх юм. Аль ч хууль хяналтын байгууллага бидэнд ийм боломж, бололцоо бий болгоход анхаарч ажиллах үүрэгтэй. Бид гэрээ, хэлцэл хийх, нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах гээд олон үйл ажиллагаанд өмгөөлөгчөөс зөвлөгөө авдаг. Энэ нь биднийг аливаа эрсдэлээс хамгаалах, хор хохирлоос урьдчилан сэргийлэх арга зам мөн.

Өмгөөлөгчийн туслалцаа төлбөртэй байна. Төлбөрийг тухайн хэрэг маргааны нэхцэл байдал, гүйцэтгэх ажлын цар хүрээ, зарцуулах цаг хугацаа, өмгөөлөгчийн ажлын дадлага, туршлага зэргийг харгалзан үзэж талууд харилцан тохиролцож тогтооно. Хууль зүйн туслалцаа авах хүсэлтэй байгаа хүн өмгөөлөгчтэй бичгээр гэрээ байгуулж, үйлчилгээний хэлс, талуудын эрх, үүрэг, хариуцлагын талаар тусгана. Мөн өмгөөлөгч таны нууцыг хуулийн дагуу хадгалж, эрх ашгийг туштай хамгаалах үүрэгтэй. Өмгөөлөгч өөрийн чиг үүргийг хангалттай хэмжээнд гүйцэтгээгүй, алдаа дутагдал гаргасан бол түүний үйлдлийн талаар Монголын хуульчдын холбоонд хандаж гомдол, мэдээлэл өгч болно. Энэ тохиолдолд тус холбооноос өмгөөлөгчид сануулах, үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах хүртэл арга хэмжээ авдаг.

Монголын хуульчдын холбоо, Улсын дээд шүүхэд Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх өмгөөлөгчдийн нэгдсэн буртгэл мэдээлэл хадгалагдсан байдаг. 2018 оны 7 дугаар сарын байдлаар албан ёсны зөвшөөрөлтэй 2738 өмгөөлөгч үйл ажиллагаагаа явуулж байна. Бид өмгөөлөгч сонгон авах шаардлагатай өмгөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг Монголын хуульчдын холбооны <https://www.mglbar.mn/?action=reference> линк, Улсын дээд шүүхийн <http://www.supremecourt.mn/utguulugch/index> линкээр зочилж, бүх өмгөөлөгчдийн мэдээлэл, мэргэшсэн чиглэл, ажлын туршлагын талаар мэдэж болно.

Манай Улс 2013 онд “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хууль баталсан. Энэ хуулиар гэмт хэрэгт яллагдаж байгаа хүнд, төлбөрийн чадваргүй этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хуульчийг төрөөс “улсын өмгөөлөгч” хэмээх нэрээр томилж ажиллуулахаар заажээ. Одоогоор улсын хэмжээнд 32 салбарт 58 улсын өмгөөлөгч ажиллаж байна. Гэхдээ төлбөрийн чадваргүй гээд л шууд улсын өмгөөлөгч авах боломжгүй юм. Шүүх, Цагдаагийн байгууллагад төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргаж, тэдгээр байгууллагаас улсын өмгөөлөгчөөс туслалцаа авах боломжийг бүрдүүлж өгдөг.



Гэртээ хийгээрэй.

Тохиолдлыг шинжлээрэй.

Иргэн А нь Б-ийн машинд мөргүүлсний улмаас биед нь хүнд гэмтэл учирч, 3 сарын турш эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

1. Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорыг хэрхэн тодорхойлох вэ?
2. Иргэн А нь өөрт учирсан хохирлоо арилгуулахын тулд юу юу шаардаж болох вэ?
3. Иргэн А-д та ямар зөвлөгөө өгөх вэ?

СЭДЭВ 3.4

ЗАХИРГАА, ИРГЭДИЙН ХООРОНДЫН МАРГААНЫГ
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НЬ

Хүүхдүүд ээ та бүхэн 10-р ангид Захиргааны байгууллагаас захиргааны акт гаргадаг тухай судалсан. Захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл тухайн захиргааны актыг гаргасан захиргааны байгууллагын дээд шатны захиргаа болон албан тушаалтанд хандан иргэн, хуулийн этгээд гомдол гарган шийдвэрлүүлдэг.

**Үйл ажиллагаа 3.10. Тохиолдол шинжлээрэй.**

Баянгол дүүргийн Засаг дарга 2017 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 59 дүгээр захирамжаар иргэн Б-д, мөн оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 274 дүгээр захирамжаар иргэн Г-д газар олгоходо иргэн Б-ийн нэр дээр байдаг “Очир” дэлгүүрийн газартай давхцал бүхий хэсгийг давхардуулан олгосон байна.

Асуулт:

1. Засаг даргын гаргасан захирамж нь захиргааны акт мөн үү?
2. Дээрх тохиолдолд хэний эрх ашиг зөрчигдсөн бэ?
3. Зөрчигдсөн эрхээ хамгаалахын тулд иргэн хаана хандаж гомдол гаргах эрхтэй вэ?
4. Гомдолыг ямар хугацаанд, хэрхэн шийдвэрлэх вэ?

Захиргааны байгууллагын үйл ажиллагааны гол шинж нь өдөр тутмын тасралтгүй байдагт оршино. Захиргаа нь захиргааны актыг дангаар батлан гаргах давуу эрхтэй байдаг тул түүний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт маш чухал байдал. Энэ хяналтыг Захиргааны хэргийн шүүх хэрэгжүүлдэг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэх захиргааны акттай холбоотой гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаа үндсэн 2 төрөлд хуваагддаг. Үүнд:

1. Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУ ВЭ?

Монгол улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 16 дугаар зүйлийн 12-т “Монгол улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдолыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэсэн заалтын дагуу Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг шүүх бус дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан явуулдаг. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь:

1. Нийтийн захиргааны байгууллагад өөрийн хяналтыг хэрэгжүүлэх боломж олгодог.

- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад хамгаалахад чиглэсэн байдаг.

Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг гомдол гэх бөгөөд захиргааны байгууллагын гадагш чиглэсэн үйлдэлд дээд шатны захиргааны байгууллагын зүгээс тавих хяналтын ажиллагаа иргэн, хуулийн этгээд гомдол гаргаснаар эхэлнэ.

- Захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах
- Гомдол гаргагчид тухайн актыг шийдвэрлэх хугацаа, газрыг мэдэгдэж, түүнийг байлцуулах

Гомдлыг хүлээж авсан байгууллага, албан тушаалтан маргаантай захиргааны актын биелэлтийг гомдол бүхий хэргийг хянан шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлж болно. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь гомдлыг дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан хүлээн авснаар эхэлж, эцсийн шийдвэр гаргаснаар дуусна.



Тулгуур ойлголт

“Шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан” гэдэг нь тухайн захиргааны байгууллагыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, албан тушаалтныг сонгох, томилох, тэдний гаргасан захиргааны актыг өөрчлөх буюу хүчингүй болгох эрх бүхий шууд удирдах захиргааны байгууллага, захиргааны албан тушаалтан юм. Жишээ нь: Дүүргийн Засаг даргыг шууд харьяалах дээд шатны захиргааны албан тушаалтан нь нийслэлийн Засаг дарга байна.

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ГОМДОЛ ГАРГАХ ХУГАЦАА ЯМАР БАЙДАГ ВЭ?

Иргэн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагад гомдол гаргах хугацааг 30 хоногийн дотор байхаар тогтоож өгсөн. Тухайн гомдол гаргагч холбогдох захиргааны актыг “хүлээн авсан, эсхүл мэдсэн” үеэс эхлэн хугацааг тоолно. Өөрөөр хэлбэл, холбогдох актыг өгөөгүй, мэдэгдээгүй бол хугацаа тоологдохгүй гэсэн үг. Гомдол гаргагч 30 хоногийн хугацаандaa хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гомдлоо гаргаагүй бол холбогдох захиргааны актад гомдол гаргах эрхээ алдана. Тэгэхээр хугацаа хэтэрсэн гэсэн үндэслэлээр шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг буцаавал иргэн, хуулийн этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй болно. Зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаа хэтэрсэн тохиолдолд гомдол хүлээн авсан захиргааны байгууллага, албан тушаалтан хугацаа хэтэрснээс хойш 3 сарын дотор уг хугацааг нөхөн сэргээж болохоор Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зохицуулсан.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ГЭЖ ХЭН БЭ?

- Хэргийн оролцогч - Гомдол гаргаж буй иргэн, хуулийн этгээд, хариуцагч болох захиргааны байгууллага, албан тушаалтан, гуравдагч этгээдийг хэлнэ.
- Бусад оролцогч - Захиргааны байгууллага, хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд туслах чиг үүрэгтэй оролцож буй этгээд. Жишээ нь, гэрч, өмгөөлөгч, хэлмэргч, шинжээч, орчуулагч гэх мэт

Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хариуцагч нь тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа захиргааны байгууллага, албан тушаалтны шууд харьяалах доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байна. Жишээ нь, Нийслэлийн засаг даргад урьдчилан шийдвэрлэх журмаар хандаж байгаа хэргийн хариуцагч нь дүүргийн Засаг дарга байна.

Гомдол гаргагчийн гомдлыг түүнд мэдэгдсээр байхад ирээгүй тохиолдолд тэдгээрийг оролцуулахгүйгээр шийдвэрлэж болохоор хуульчилсан байдаг. Дээд шатны байгууллага, албан тушаалтан шийдвэрээ өөрийн эрх хэмжээний хүрээнд, шууд харьяалах доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас хараат бус, бие даан гаргана. Захиргааны байгууллага, албан тушаалтан 30 хоногийн дотор гомдлыг хянаад дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

1. Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх
2. Захиргааны актыг бүхэлд нь эсвэл холбогдох хэсгийг хүчингүй болгох
3. Дахин захиргааны акт гаргахыг даалгах

Шийдвэрлэсэн хариуг захиргааны байгууллага, албан тушаалтан гомдол гаргагчид заавал мэдэгдэх үүрэгтэй. Захиргааны хэргийн шүүхэд хандахаас өмнө иргэн, хуулийн этгээд (нэхэмжлэгч)-эд тавигдаг хамгийн гол шаардлага бол гомдлоо захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлсэн байх явдал юм. Тухайн хууль бус шийдвэр, үйл ажиллагааг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтныг шууд харьяалдаг дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандаж Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан гомдол гаргах ёстой. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтныг тодорхойлоход хүндрэлтэй байвал тухайн албан тушаалтныг томилж, чөлөөлдөг, эсхүл шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй байх шинжийг голлон анхаардаг. Хэрэв шууд харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй тохиолдолд “гомдлоо захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх” шаардлага тавигдахгүй, шууд захиргааны хэргийн шүүхэд хандах эрхтэй.



Үйл ажиллагаа 3.11. Тохиолдлыг шинжлээрэй.

Иргэн Б, Т нар захиргааны хэргийн шүүхэд хандан гаргасан нэхэмжлэлдээ, Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Гандантэгчинлэн хийдийн урд гудамжинд 2015 оноос хойш ТҮЦ ажиллуулж өөрсдийн амьдрал ахуйгаа залгуулж ирсэн. 2017 онд ТҮЦ байсан газар дээрээ 18 м.кв талбайд палкан байшин барьсан бөгөөд байшингийн голоор хаалт хийн 2 хаалга гаргаж тус тусдаа үйл ажиллагаа явуулах болсон. Уг байшингийн суурийн хэмжээний газар Б-ийн нэр дээр Баянгол дүүргийн Газрын албанад бүртгэлтэй бөгөөд газар ашиглах гэрээ байгуулж жил бүр 82080 төгрөгийг газар ашигласны хураамжид төлж хуулийн дагуу ашиглаж ирсэн. Гэтэл бидний байшингийн урд талын залгаа байшингийн эзэн Г нь байшингийн чинь тал миний газар дээр байна. Газар чөлөөлж өг хэмээн шаардах болсон. Энэ асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү гэжээ.

Асуулт:

1. Захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авах уу? Яагаад?
2. Захиргааны хэргийн оролцогчдыг тодорхойлно уу
3. Нэхэмжлэлийг ямар хугацаанд, хэрхэн шийдвэрлэх вэ?

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУ ВЭ?

Захиргааны байгууллагын хууль бус актын улмаас эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд нь дээд шатны захиргааны байгууллага, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн бол шийдвэрийг мэдэгдсэнээс хойш захиргааны хэргийн шүүхэд 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргана:

Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах бөгөөд түүнд нэхэмжлэгч, эсхүл түүний төлөөлөгч гарын үсэг зурсан байна. Нэхэмжлэлд дараах зүйлийг тусгана:

1. Нэхэмжлэлийг захиргааны хэргийн аль шүүхэд гаргаж байгаа;
2. Нэхэмжлэгчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, байгууллага бол нэр, оршин байгаа газрын хаяг;
3. Хариуцагчийн нэр, оршин байгаа газрын хаяг;
4. Нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл;
5. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл чөлөөлөгдөх хүсэлт, түүнийг нотлох баримт;
6. Хавсаргасан баримт бичгийн жагсаалт;
7. Холбоо барих утас, факс, цахим хаяг.



Тулгуур ойлголт

Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэл

Иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актад холбогдуулан өөрийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалулахаар захиргааны хэргийн шүүхэд хандан гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шаардлага.

Гуравдагч этгээд

Тухайн захиргааны актын талаар бие даасан шаардлага гаргасан, эсхүл уг актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн буюу хөндөгдөж болзошгүй байгаа бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зүйтэй гэж захиргааны хэргийн шүүх шийдвэрлэсэн иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

Захиргааны хэрэгт өнгөц харвал иргэн, захиргааны байгууллага гэсэн хоёр маргагч талууд байдаг боловч ихэнх хэрэгт “гуравдагч этгээд” оролцдог. Шүүхээс хоёр талын маргааныг хянаад гаргах шийдвэр нь өөр бусад (гуравдагч) этгээдийн эрх ашигийг хөндөж болзошгүй тохиолдолд шүүх санаачилгаараа эсвэл тухайн этгээдийн хүсэлтээр хэргийг шийдвэрлэх ажиллагаанд “гуравдагч этгээд” -ээр татан оролцуулдаг. Ингэснээр “гуравдагч этгээд” нь тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нотлох баримт гаргах гэх мэт эрхийг эдлэх боломжтой хэргийн оролцогч болдог. Захиргааны хууль бус актын улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд шүүхэд хандан гаргаж байгаа нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл нь дараах агуулгатай байдаг. Үүнд:

- захиргааны акт, захиргааны гэрээг хүчингүй болгуулах, илт хууль бус болохыг тогтоолгох, эсхүл эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, захиргааны акт гаргуулахыг даалгах, нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болохыг;
- хохирол гаргуулах нэхэмжлэлийн хувьд захиргааны байгууллага ямар үүргээ биелүүлээгүйгээс, эсхүл захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх талаар;

- нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгосноор нэхэмжлэгчид ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол үүсэхийг;
- захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэлийн хувьд ямар хууль зөрчигдсөн, эсхүл нийтийн эрх зүйн ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн;
- нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдэж болзошгүй;
- захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд иргэн, хуулийн этгээдийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдэж болзошгүй болон ямар хуулттай зөрчилдсөн.

Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө. Нэхэмжлэлийг тухайн захиргааны хэргийн шүүх хүлээн авч, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минут, нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудасны тоог тэмдэглэн нэхэмжлэл бүртгэх дэвтэрт бүртгэж баримтжуулна. Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авсан, өдрөөс хойш долоо хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана. Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш нийслэлд долоо, орон нутагт 14 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулна. Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэх талаар бичгээр хариу тайлбар гаргах бөгөөд тайлбартай үндэслэлийг зааж, нотлох баримтаа хамтад нь гаргаж ирүүлнэ.



Тулгуур ойлголт

Нотлох баримт

Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг хэлнэ.

Нотлох баримтыг гаргах, цуглуулах

Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ. Захиргааны хэргийн шүүх нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох этгээд шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Нотлох баримт нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл, цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дурсний, дуу-дурсний бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, танъж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.

Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ. Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох этгээд шаардлагыг биелүүлэх үүрэгтэй байдаг.

Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана:

- Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангах;
- Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох;
- Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;
- Захиргааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох;
- Захиргааны акт илт хууль бус болохыг тогтоох;
- Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг захиргааны байгууллагаас гаргуулах;
- Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн захиргааны актыг хүчингүй болгох.

Захиргааны хэргийн оролцогчид анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл 14 хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан гомдол гаргах эрхтэй. Давж заалдах гомдлыг шийдвэр гаргасан шүүхээр дамжуулан гаргана. Давж заалдах гомдлын үндэслэлд анхан шатны шүүхээр хэлэлцээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй байдаг. Давж заалдах гомдол гарсан хэргийг давж заалдах шатны шүүх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдлын хүрээнд хянах ба хэргийн хоёр, түүнээс дээш оролцогч гомдол гаргасан, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гомдол гаргасан тохиолдолд хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг тусгасан магадлал гаргана. Хэргийн оролцогчид магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор хяналтын журмаар гомдол гаргаж болно.

Хяналтын журмаар гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээж авна. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гомдлын талаар тайлбараа гаргах эрхтэй байдаг. Гомдол хүлээж авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган гомдлыг хүлээж авсан өдрөөс хойш Нийслэлд гурав хоногийн дотор, орон нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

Улсын дээд шүүх хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Улсын дээд шүүх хяналтын журмаар хэргийг дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:

- шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;
- шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулах;
- магадлалыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл өөрчлөх;
- шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг болон нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг хангах;
- шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаах.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн тогтоол нь эцсийн шийдвэр байна.

**Гэртээ хийгээрэй.**

1. Захиргаа, иргэдийн хооронд үүсдэг маргааны төрлүүдийг судлан дүн шинжилгээ хийгээрэй.
2. Захиргааны байгууллагаас гаргасан актын улмаас эрх ашиг нь зөрчигдсэн бодит тохиолдлыг олж, зөрчигдсэн эрхээ хэрхэн хамгаалах талаар гэр бүл, найз нөхдөдөө зөвлөгөө өгөөрэй.

**Нэмж судлаарай**

- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
- Захиргааны ерөнхий хууль, 2015 он

СЭДЭВ 3.5**ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ БОЛОН
ОЛОН УЛСЫН МЕХАНИЗМ****Үйл ажиллагаа 3.12.** Эх сурвалжтай ажиллаарай.

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 277 буюу 52.3 хувь нь ямар нэг байдлаар мориноосоо унаж байсан бөгөөд унах болсон шалтгаан нь 121 буюу 43.6 хувь нь замын халтиргаанаас, 83 буюу 29.9 хувь нь үлийн нүхэнд морь нь бүдэрсэн, 53 буюу 19.1 хувь нь морины болон тоос шороо их учир замаараа яваагүйгээс, 29 буюу 10.4 хувь нь олом жирэм, хазаар жолоо тасарсан гасэн байна. Эдгээр мориноосоо унасан гасэн хариулт өгсөн хүүхдүүдийн 196 буюу 70.7 хувь нь ямар нэг байдлаар бэртэж гэмтсэн гэсэн хариултыг өгснөөс 51 буюу 26 хувь нь толгой өвдөх, тархи доргих, 55 буюу 28 хувь нь биенеийн аль нэг хэсэг хөхрөх, шалбарч шархлах, 50 буюу 25.5 хувь нь хөл гарсаа гэмтээх, хугалах, 34 буюу 17.3 хувь нь хөл, гар нүүр хацраа хөлдөөх, 9 буюу 4.5 хувь нь нуруу, нугасаа гэмтээх гэсэн хариултыг тус тус өгсөн байх бөгөөд мориноос унах, бэртэж гэмтэх үедээ хамгаалалтын хувцсаа бүгдийг өмссөн байсан гэж 145 буюу 52.3 хувь, заримыг өмссөн байсан гэж 80 буюу 28.8 хувь, огт өмсөөгүй байсан гэж 52 буюу 18.7 хувь нь хариулсан байна.

.....Хавар, өвлийн хурдан морины уралдаанд хүүхдийг хичээл, сургуулиас нь чөлөө авах, таслуулах зэргээр хөндийрүүлж, хоцрогдуулах, сурлагын түвшинг бууруулах, цаашилбал хичээл сургуульд дургуй болж сургуулиас гарах, завсардах зэрэг сөрөг асуудлуудыг дагуулсаар байна.

Эх сурвалж: "Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх" ХЭҮК, ОУ-ын Хөдөлмөрийн байгууллага, УБ 2015 он

Асуулт:

1. Эх сурвалжид хүний ямар, ямар эрх зөрчигдэж байна вэ?
2. Хүний эрхийг төр хэрхэн хамгаалах үүрэгтэй вэ?
3. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоонд ямар байгууллагууд ордог вэ? Хүний эрхийг хамгаалах үүргийнхээ дагуу ямар үйл ажиллагааг явуулдаг вэ?
4. Хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар дүгнэн ярилцаарай.

Хүний эрх нь бүх хүний нэр төр, алдар хүндтэй хамт угаас заяагдсан төрөлх чанартай агаад нас, хүйс, арьсны өнгө, хэл, үндэс угсаа, язгуур, шашин, улс төрийн үзэл бодол үл харгалзан эрхээ бүгд тэгш эдлэх үндсэн зарчимд тулгуурладаг. Монгол улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан байдаг. Аливаа төрийн үүрэг нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хангах явдал юм. Төрийн үүрэг нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой. Нэгэнт хүнээс салгаж болшгүй ойлголт тул хүний эрхийг огт үгүйсгэлгүй, зөвхөн тусгайлан заасан нөхцөлд хязгаарлах боломжийг орчин үеийн төрд олгосон юм. Иймээс төр нь эн тэргүүнд өөрийн улсын нутаг дэвсгэр дээрх хүмүүсийн эрхийг:

- **Хүндэтгэх:** Тухайн эрхийг эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байхыг ойлгодог. Төрийн зүгээс хүмүүсийн эрхээ эдлэх гэсэн үйлдлийг хязгаарлах, хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж болохгүй (жишээлбэл, эрүүдэн шүүх, хууль бусаар баривчлах, хүчээр нүүлгэх гэх мэт).
- **Хамгаалах:** Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох боловсронгуй хууль тогтоомж батлахыг ойлгодог.
- **Хангах:** Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох (үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох, эмээг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэх) арга хэмжээг авна гэсэн үүргүүд хүлээдэг.

Эдийн засаг, нийгэм, хууль зүйн хувьд хүний эрхийн талаар төр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл үүргээ биелүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авч, үр дүнд хүрээгүй тохиолдолд хүний эрхийн зөрчил үүснэ. Хүний эрхийн зөрчил нь Монгол улсын Үндсэн хууль, хууль, нэгдэн орсон олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн эс хэрэгжилтээр тодорхойлогдоно.

Тухайлбал, төр, төрийн байгууллага, албан тушаалтнаас хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүргээ биелүүлж чадахгүй байгаагаас үүдэн гарч бий зөрчлийг хүний эрхийн зөрчил хэмээн ойлгоно. Түүнчлэн төр хүний эрхийн хамгаалалтыг сулруулах, түүнээс татгалзах нь хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогддог. Иймээс төр нь дотооддоо хүний эрхийг хангахдаа өөрийн тогтолцоог сайтар ажиллуулах үүрэг хүлээдэг. Эдгээр тогтолцоог нийтэд нь хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо хэмээнэ.

Төрийн хүний эрхийг хамгаалах чиг үүрэг

Чиг үүрэг	Хууль тогтоох	Гүйцэтгэх эрх мэдэл	Шүүх эрх мэдэл
Байгууллага	Улсын Их Хурал	Засгийн Газар	Шүүх
Үйл ажиллагаа	Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, ЗГ-ын үйл ажиллагаанд хяналт тавих	Хүний эрхийн талаарж хууль тогтоомж, олон улсын гэрээний биелэлтийг хангах, үр дүнг УИХ, НҮБ-д тогтмол тайлagnaх	Хүний эрх зөрчсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх

Монгол улсад хүний эрхийн асуудлыг хариуцсан, үүрэг хүлээсэн албан бутэц, механизм нь УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, Хүний эрхийн үндэсний комис, шүүх, иргэний нийгмийн байгууллагууд, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хороо, түүний ажлын алба болон аймаг, нийслэл дэх салбар хороодоос бүрдэнэ.



Тулгуур ойлголт

Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо:

МУ-ЫН Үндсэн хуульд зааснаар төр нь хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд тодорхой байгууллага, тогтолцоог бүрдүүлэн ажилладаг.

Хүний эрхийн зөрчил:

Үндэсний хууль тогтоомж, олон улсын болон бус нутгийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийг төр өөрийнхөө ямар нэгэн үйлдлээр зөрчсөн, эсхүл төрөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үүргэг биелэгдээгүй байхыг хэлнэ.

Монгол улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Хүний эрхийн дэд хороо нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын асуудлаар шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэд, байгууллагаас тайлбар авах, өөрийн байгуулсан дагнасан буюу хамтарсан ажлын хэсгээр хяналт шалгалт хийлгэх эрхтэй байдаг. Мөн эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж харьялах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэйгээс гадна өөрийн харьялагдах Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж бодлогын баримт бичиг, асуудал боловсруулах буюу санал, дүгнэлт гаргаж,

түүнийгээ харьялагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх эрх хэмжээтэй билээ.

Улсын Их Хурлын түвшинд хүний эрх, эрх чөлөөний баталгааг ханган шалгах, хянах эрхийг Хүний эрхийн дэд хороо хэрэгжүүлэх үүрэгтэй. Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмын нэг бүрэлдэхүүн хэсэг нь хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд /ИНБ/ юм. Иргэний нийгмийн байгууллагууд нь хүний эрхийн чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулдаг. Үүнд:

- Олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, Засгийн газраас хэрэгжүүлэхийг шаардах
- Хүний эрхийн асуудлаар судалгаа явуулах, мэдээллээр хангах
- Хүний эрхийн боловсрол олгох

- Хүний эрхийн талаар зөвлөгөө өгөх, зөвлөмж гаргах
- Эрх нь зөрчигдсөн хүмүүсийг хамгаалах үйлчилгээ үзүүлэх

Хүний эрхийг хамгаалах тогтолцоо нь түүнийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчихтэй тэмцэх, зөрчсөн тохиолдолд эрхийг нь сэргээх, хохирлыг арилгахад чиглэдэг. Хүний эрхийг хамгаалах төрийн механизмыг үр дүнтэй ажиллахыг шаардах, хяналт тавих, хөндлөнгөөс нөлөөлөх үүргийг хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд хүлээж байдаг.



Үйл ажиллагаа 3.13. Тохиолдол шинжлээрэй.

“Монгол улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 63 дугаар тогтоолыг хууль бус байсан болохыг тогтоолгох, уг тогтоолын дагуу 2017 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Төв аймгийн Аргалант суманд зохион байгуулагдсан Дүнжингарав уралдаан хууль бус байсан болохыг тогтоох, Засгийн газарт жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэл улс, аймаг, сумын хэмжээний хурдан морины уралдаан бэлтгэл шат болон уралдааны явцад хүүхдээр морь унуулах, аливаа хэлбэрийн морин уралдаан зохион байгуулахыг хориглосон улс даяар дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт гаргахыг даалгах” нэхэмжлэлийг хүний эрхийг хамгаалах иргэний нийгмийн байгууллагууд хамтран захиргааны хэргийн шүүхэд гаргасан байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн шийдвэрээрээ “Монгол улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 63 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хууль бус байсан болох”-ыг тогтоож нэхэмжлэлийн бусад шаардлагыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж гагцхүү “Монгол улсын Засгийн газарт жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэл улс, аймаг, сумын хэмжээний хурдан морины уралдаан бэлтгэл шат болон уралдааны явцад хүүхдээр морь унуулах, аливаа хэлбэрийн морин уралдаан зохион байгуулахыг хориглосон улс даяар дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт гаргахыг даалгах” нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж захиргааны хэргийн шүүхийн харьялан шийдэх маргаан биш байна гэж дүгнэсэн.

Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх тогтоолыг гаргасан байна.


Асуулт:

1. Тохиолдоос захиргааны хэргийн оролцогчдыг тодорхойлно уу.
2. Тохиолдлыг шийдвэрлэсэн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг харьцуулан ярилцана уу.
3. Тохиолдоос харахад хяналтын шатны шүүхийн тогтоол хэргийн оролцогчдын алиных нь талд гарсан бэ?
4. Шүүхийн эцсийн шат болох хяналтын шатны шүүхийн тогтоолыг хүлээн зөвшөөрөхгүй, эрх нь зөрчигдсөөр байгаа гэж үзвэл хэргийн оролцогчид хаана хандаж гомдол гаргах вэ?

Шүүх хүний эрхийг хэрхэн хамгаалдаг вэ?

Шүүх нь “Үндсэн хуульт ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа” тул хүний эрхийг хамгаалах бүтэц, механизмын чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Өөрөөр хэлбэл, шүүх нь үндсэн хуульт ёс алдагдаж, хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн

тохиолдолд иргэнийг хамгаалж, хохирлыг барагдуулан шударга ёсыг сэргээх үүрэг хүлээдэг. Иргэд эрх чөлөө нь зөрчигдсөн бол түүнийгээ хамгаалулахаар шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах замаар зөрчигдсөн эрхээ сэргээн эдлэх, хохирлоо төлүүлэх эрхтэй байдаг. Иймээс хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны чухал бүрэлдхүүн хэсэг нь шүүх байдаг. Шүүх нь иргэд, байгууллагын эрх ашиг, сонирхлыг хамгаалах төрийн үйлчилгээг үзүүлдэг. МУ-ын Үндсэн хуулийн 47-р зүйлд “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно” гэж заасан байдаг.



Бүдүүвч 3.6. МУ-ын шүүхийн тогтолцоо

Шүүхийн тогтолцоо нь иргэн, захиргаа, эрүүгийн хэрэг маргааныг шударгаар хянан шийдвэрлэх замаар хүний эрхийг ханган ажиллана. Бүх шатны шүүх нь ерөнхий шүүгч болон шүүгчдээс бүрдэнэ. Шүүгч нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хуулийн хүрээнд шударгаар шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангаж ажиллах нь шүүхийн байгууллагын гол зорилт байдаг. Шударга шүүхээр шүүлгэх эрх нь дараах агуулгатай байдаг. Үүнд:

1. Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрх: Алагчлалгүй, тэгш хүртээмжтэй байх /ХЭТТ-ийн 7, 10-р зүйл, ИУТЭП-ийн 14-р зүйл/
2. Хуулийн дагуу байгуулагдсан бүрэн эрх бүхий шүүхээр шүүлгэх эрх: Эрх мэдэл бүхий, бие даасан, хараат бус, хуулийн дагуу байгуулагдсан /ХЭТТ-ийн 10-р зүйл, ИУТЭП-ийн 14-р зүйл /
3. Шударга шүүх хуралдаан хийлгэх эрх: Талуудын тэгш байдал хангагдсан байх, шүүх хуралдаан нээлттэй явагдах /ХЭТТ-ийн 10-р зүйл, ИУТЭП-ийн 14-р зүйл/
4. Гэм буруугүйд тооцогдох эрх: Гэм буруугүй болохоо нотлох, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх /ХЭТТ-ийн 11-р зүйл, ИУТЭП-ийн 14-ийн 2-р зүйл/
5. Анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрх: Гэрч дуудаж оролцуулах, орчууллагч, хэлмэрч, өмгөөлөгч авах эрх /ИУТЭП-ийн 14-р зүйл/
6. Шүүхийн шийдвэртэй холбогдох эрх: Олон нийтийн өмнө шүүхийн шийдвэрийг уншиж танилцуулах, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэж авах, шүүхийн шийдвэрт гомдол гаргах хугацаатай байх /ИУТЭП-ийн 14-р зүйл/



Үйл ажиллагаа 3.14. Эх сурвалжтай ажиллаарай.

Морь унаач хүүхдүүд нар, салхи, бороо, шуурга, цастайг үл анхааран унсан морины наснаас шалтгаалан 10-30 километр газар туулдаг. Өвлийн улиралд хацар, чих, гар хөл нь хайрагдах, бүр хөлдөх ч тохиолдол бий гэнэ. Нэрээ нууцлахыг хүссэн хүү захидалдаа “Манай сургуульд 500 хүүхэд явдаг. Ихэнх хүүхэд морь унадаг учраас хичээлгийн хоцрогдол ихтэй. Энэ сургуулийн 60-70 хүүхэд морь унадаг. Бидний хийдэг ажил:

- Өглөө 8 цагт очоод морь услах, тэжээл өгөх гэх мэт маш их ажил хийдэг.
- 11 цагт өдөр бүр уралдаантай байдаг учир хүүхэд бүр морь унадаг.
- Орой морь услад, тэжээл өгөөд 19 цагт гэртээ харьдаг.
- Бид морь унаж ирээд халуун хоол цай иддэггүй. Өөрсдөө хоол хийж иддэг.
- Өвөл, хаврын цагт чих, гар, хацар, хөл хайрах, хагарах, хөлдөх асуудал нь хэвийн зүйл болтлоо давтагддаг.
- Мориндоо өшиглүүлэх, унах тохиолдол их байдаг.
- Цалин гэж сард 150.000 төгрөг авдаг.
- Унаач хүүхдүүд хичээлээс их хоцорч, тасалдаг учир сурлагаар хоцрогддог.

Эх сурвалж: <http://time.mn/n/6NE>

Асуулт:

1. Эхийг уншаад морь унаач хүүхдийн ямар, ямар эрх зөрчигдөж байгааг харилцан ярилцаарай.
2. Зөрчигдсөн эрхийг хэрхэн хамгаалах боломжтой вэ?
3. Зөрчигдсөн эрхээ хамгаалулахаар шүүхээр явсан боловч гомдолтой байгаа иргэн, хуулийн этгээд Хүний эрхийн Үндэсний Комисст хандаж гомдол гаргаж болох уу?
4. Хүний эрхийн Үндэсний Комисст хандан гомдол гаргахад ямар шаардлага тавигддаг вэ?
5. Хүний эрхийн Үндэсний Комисс гомдлыг ямар хузацаанд хэрхэн шийдвэрлэдэг вэ?

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА ХҮНИЙ ЭРХИЙГ ХЭРХЭН ХАМГААЛАДАГ ВЭ?

Хүний эрхийн үндэсний комисс нь хүний эрхийн бие даасан, хараат бус үндэсний байгууллага юм. Хүний эрхийн үндэсний байгууллага нь хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалах, дэмжих, мөн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй ажилладаг. Монгол улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Монгол улсын иргэн дангаар буюу хамтарч Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах эрхтэй. Монгол улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол улсын иргэний адил Комисст гомдол гаргах эрх эдэлнэ. Хүний эрхийн Үндэсний Комисссын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Комиссны гишүүн нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэрэг, маргааны талаарх гомдлыг хүлээн авахгүй” гэж заасан байдаг. Тиймээс иргэний хэрэг, захиргааны хэрэг, эрүүгийн хэргийг Комисс хүлээн авч шийдвэрлэхгүй. Харин иргэнээс төрийн захиргааны, хууль сахиулах болон шүүхийн байгууллагад хандаж байгаа үйл явцад, эсхүл тэдгээр байгууллагаас чиг үүргээ хэрэгжүүлэх үйл явцад


хуулиар баталгаажуулсан хүний эрх зөрчигдсөн тохиолдолд хүний эрхийн зөрчил гэж үзэж гомдлыг хүлээн авч болно.

Иргэний эрхийн бүрэн чадамжгүй, зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүнийг түүний хууль ёсны төлөөлөгч-эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь, түүнчлэн сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүнийг хуульд заасан төлөөлөгч нь төлөөлж, гомдол гаргаж болно. Гомдол гаргагч эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн өдрөөс, эсхүл зөрчигдсөн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор, монгол хэл дээр, амаар болон бичгээр гаргана. Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан гомдол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Гомдоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх /гомдол гаргагч Комисст гомдол гаргахын өмнө тус асуудлаар өөрийг нь хохироосон байгууллага, албан тушаалтны холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдоо танилцуулж албан ёсны хариуг авсан байна./
- Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжид заасан ямар эрх зөрчигдсөн болохыг тодорхой заах;
- Өөрийн нэр, оршин суугаа газрын болон шуудангийн хаяг, утасны дугаараа бичиж, гарын үсгээ зурсан байх;
- Гомдолд холбогдож буй аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар холбогдох бусад баримтыг хавсаргах.

ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ ХЭРХЭН ЯВАГДДАГ ВЭ?

Хүний эрхийн Үндэсний Комисс гомдлыг албан ёсоор хүлээн авсны дараа гомдлыг шалгах ажиллагаа эхэлдэг. Хуулийн дагуу 30 хоногт багтаан шийдвэрлэх үндсэн дээр шалгах ажиллагааг төлөвлөж явуулах ёстой. Нэмэлт судалгаа, шалгалт хийх шаардлагатай бол хугацааг Комиссын дарга 60 хүртэл хоногоор сунгаж болно. Өргөдөл, гомдол хариуцсан ажилтан нь хуульд заасан дээрх хугацаанд гомдлыг шийдвэрлэхийн тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Комисс гомдлыг дараах дарааллын дагуу шийдвэрлэнэ.



Бүдүүч 3.7 Гомдол шийдвэрлэх үйл явц



Үйл ажиллагаа 3.15. Баримтыг шинжлээрэй.

Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл Хүний эрхийн Үндэсний Комисст хандан, хурдан морь унаач хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор дараах шаардлагыг хүргүүлэн хамтран ажиллахаар болжээ.

- Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс дараа жилийн 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хүүхдээр хурдан морь унуулахгүй байх;
- Жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрөөс 11 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл 12-оос дээш насны хүүхдээр унуулахыг зөвшөөрөх.

Өмнөх шаардлагын дагуу Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасан эрх, эрх чөлөөг төрийн зүгээс баталгаатай эдлүүлэх үүргийн дагуу Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5, 6, 7, 12, 13, 14 дүгээр зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахаар болсон.

Энэ ажлын хүрээнд Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүйтний улиралд хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх, хүйтний улиралд хүүхдээр хурдан морь унуулахгүй байх талаар Монгол улсын Засгийн газарт 2018 оны 1-р сард зөвлөмж хүргүүлжээ. Комисс жил бүр хүйтний улиралд хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх, хүйтний улиралд хүүхдээр хурдан морь унуулахгүй байх талаар Монгол улсын Засгийн газарт удаа дараа зөвлөмж хүргүүлж байсан бөгөөд хурдан морь унаач хүүхдийн эрхийн асуудлаар Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэлдээ тусгаж байсан. Гэвч өмнөх Засгийн газрууд хүйтний улиралд буюу газар, зам харгүй хөлдүү, цас мөс, халтиргаа гулгаатай жил бүрийн 11 дүгээр сараас 5 дугаар сарыг хүртэлх хугацаа буюу өвөл, хаврын хүйтний улиралд хурдан морины уралдааныг зохион байгуулах шийдвэрийг удаа дараа гаргаж байсан. Үүнээс болж тус уралдааны үеэр болон хурдан морины үсэргээ, сунгааны үеэр хүүхэд мориноос унаж бэртэл, гэмтэл авах, гар, хөл, хацраа хөлдөөх, амь насaa алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох зэргээр унаач хүүхдүүд сэтгэл санаа, бие махбод, эрүүл мэндийн хувьд ноцтой хохирол амссан тохиолдууд ихээр гарсан байна.

Комисс улс, бүс, аймаг, сумын наадам болон хүйтний улиралд хурдан морь унаач хүүхдийн амь нас хохирсон, олон арван хүүхэд гэмтэж бэртэн хөгжлийн бэрхшээлтэй болсон эмгэнэлтэй явдал дахин давтагдаар байгааг тухай бүр анхааруулж ирсэн төдийгүй энэ асуудлаар НҮБ-ын Хүүхдийн сангаас албан ёсоор мэдэгдэл гаргасан билээ. Иймд Нэгдсэн Үндэстний Байгууллага 1989 онд баталж, манай улс 1990 онд соёрхон баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд харгалзаж ажиллахыг зөвлөсөн байна.

Асуулт:

1. 2014 оноос жил бүр Хүний эрхийн үндэсний комиссоос Засгийн газарт зөвлөмж удаа дараа хүргүүлсэн болооч биелүүлээгүй нь хүний эрхийг хамгаалах төрийн ямар үүрэг хэрэгжихгүй байгааг харуулж байна вэ?
2. Төр хэрвээ хүний эрхийг хамгаалах үүрээ биелүүлээгүй тохиолдолд иргэний нийгмийн байгууллагууд морь унаач хүүхдийн эрхийг хамгаалахаар хүний эрхийг хамгаалах опон улсын байгууллагад хандаж болох уу?
3. НҮБ-ын Хүний эрхийн хороонд гомдол гаргахад ямар шаардлага тавигддаг вэ?
4. Гомдлыг хүний эрхийн хороо хүлээн авсан тохиолдолд ямар хугацаанд, хэрхэн шийдвэрлэдээ вэ?
5. НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд хандан хүүхэд өөрөө гомдол гаргаж болох уу?
6. Засгийн газар Хүний эрхийн үндэсний комиссын зөвлөмжийн дагуу морь унаач хүүхдийн эрхийг хамгаалсан шийдвэр гаргавал хүүхдийн ямар эрх хэрэгжин хангагдах вэ?

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ТОГТОЛЦОО ГЭЖ ИЮУ ВЭ?

Хүний эрхийн үзэл баримтлал дараах гурван шинжийг агуулдаг гэж үздэг. Нэгдүгээрт, хүн бүрд аливаа эрх мэдлийн зүгээс нөлөөлөх ёсгүй. Өөрийн автономи эрх байдаг. Хоёрдугаарт аливаа эрх мэдэлд хязгаар бий. Гуравдугаарт, хүн бүр эрхээ

хамгаалаулахаар төр, засагт гомдол, шаардлага гаргах эрхтэй. Тодруулбал, хүний эрхийн зөрчилд хариуцагч этгээд нь төр байдаг. Эдэлбэл зохих эрхээ шаардах чадвар хүний эрхийн хамгийн чухал асуудлын нэг юм. Эрхээ эдлэхийг болон түүнийг хамгаалахыг шаардах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гомдол гаргах нь нэг талаас эрх мэдлийн тэнцвэргүй байдлаас бий болдог бол нөгөө талаас энэ нь тухайн хүн эрх чөлөөтэй субъект гэдэгтэй холбоотой. Энэхүү эрхээ шаардах чадвар нь хүний өөрийгөө хүндэтгэн үзэхтэй нягт холбоотой бөгөөд бас энэ утгаараа хүний эрхийн гол чиг үүргийн нэг болдог.

Хүний эрхийг зөрчдөг гол субъект нь төр бөгөөд эргээд төрөөс эрхээ шаардахад нэг талаас иргэн, нөгөө талаас төр хоорондоо сөргөлдөн тэгш бус байдал үүсдэг. Нэгэнт тэгш бус байдал үүссэн тул төр өөрийн хүссэнээр хүсэл зорилгоо хэрэгжүүлж иргэдийхээ эрх ашгийн эсрэг зогсох боломжтой болдог байна. Ийм тохиолдолд хүн эрхээ хамгаалахын тулд НҮБ-ын хүний эрхийг хамгаалах байгууллагуудад хандан дараах шаардлагыг гаргадаг. Үүнд:

- Төр нь хүний тодорхой эрхийг хүлээн зөвшөөрөгүй бол түүнийг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тэмцэх;
- Тухайн эрхийг хүлээн зөвшөөрсөн боловч хүндэлж үздэггүй бол түүний хэрэгжилтийг баталгаажуулахын төлөө тэмцэл өрнүүлэх;



Тулгуур ойлголт

Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо

НҮБ-ын Хүний эрхийн байгууллагуудыг дүрмийн үндсэн дээр байгуулагдсан, хүний эрхийг хамгаалах гэрээнд үндэслэн байгуулагдсан байгууллагууд гэсэн үндсэн хоёр төрөлд хуваан хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо гэж нэрийддэг.

Эмэгтэйчүүдийн байдлын тухай НҮБ-ын комисс

Хүний эрхийг хамгаалах НҮБ-ын дүрэмд үндэслэгдсэн байгууллагууд:

НҮБ-ын дүрэмд шууд ба шууд бусаар хүний эрхийг тогтоож, хэрэгжүүлэх үүрэг бүхий хэд хэдэн байгууллага байгуулдаг.

Үүнд: Ерөнхий Ассамблей, Аюулгүйн зөвлөл, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Хүний эрхийн комисс,

Хүний эрхийг хамгаалах гэрээнд үндэслэгдсэн байгууллагууд: Хүний эрхийн гэрээнд гарын үсэг зурсан орнууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ сахин биелүүлсэн байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэгч засгийн газар хоорондын байгууллагуудын тогтолцоо. Үүнд: НҮБ-ын олон улсын шүүх, хүний эрхийн хороо, хүүхдийн эрхийн хороо, арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах хороо, эрүүдэн шүүх үйл ажиллагааны эсрэг хороо ордог.

НҮБ нь хүний эрхийг хангах, хамгаалах олон улсын тогтолцоо бүрдүүлэн ажиллах чиг үүргийг гүйцэтгэж ирсэн. Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо нь дэлхийн улс орнууд хүний эрхийг хэрхэн ханган, хамгаалж буйд хяналт тавьж, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэдэг. НҮБ нь дэлхийн олонх улс орнуудыг эгнээндээ нэгтгэсэн зөвшилцлийн байгууллага болохын хувьд олон улсын хүний эрхийн баримт бичгүүдийг батлан гаргадаг. Хүний эрхийн олон улсын гэрээ нь улс орнууд

хэлэлцэн баталсан албан ёсны баримт бичиг бөгөөд хүлээн зөвшөөрсөн бүх оронд (хэлэлцээрт нэгдэн орох замаар) хүний эрхийг хамгаалж, эрх чөлөөг нь дэмжих нэг ёсны баталгаа болдог. Олон улсын хүний эрхийн гэрээ нь пакт, протокол, конвенц зэрэг хэлбэртэй байдаг. Хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэгч механизмыг тогтоосон олон улсын хүний эрхийн дараах 4 баримт бичгийг хүний эрхийн билл гэнэ. Үүнд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 он;
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1996 он;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол 1966 он;

Эдгээрээс гадна үндэсний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалсан болон эрүүдэн шүүхийн эсрэг, алагчлахын эсрэг хүний эрхийн олон гэрээ, конвенцууд батлагдан хэрэгжиж байна. Хүний эрхийн гэрээнүүд нь хяналт тавих, тайлагнах журмыг өөртөө агуулдаг. Үүний дагуу улс орнууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах эрх бүхий хороод НҮБ-ын бүтцэд ажилладаг. Хороод нь улс орны Засгийн газрын тайлан мэдээг өөрийн хяналт шалгалтын дүнтэй нэгтгэн албан ёсны зөвлөмж гарган хэрэгжүүлдэг. Тухайлбал, хүүхдүүд та бүхний эрхийг хамгаалсан Хүүхдийн эрхийн конвенц хэрхэн хэрэгжиж байгаад олон улсын хүүхдийн эрхийн хороо хяналт тавьж, гишүүн улсууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ ямар хэмжээнд биелүүлж байгаа талаар 4 жилд нэг удаа тайлан илтгэлээ гаргаж хэлэлцүүлдэг.

Аливаа улс орнуудын Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүний эрхийг зөрчиж байгаа тохиолдолд олон улсын түвшинд гомдол гарган шийдвэрлүүлэх механизм байдаг.



Бүдүүвч 3.8 Олон улсын гэрээний хэлбэр

ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХОРООНД ГОМДОЛ ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

Олон улсын гэрээний хүрээнд гомдол гаргахын тулд тухайн улс нь дараах хоёр нөхцөлийг хангасан байх шаардлагатай.

- Тухайн улс холбогдох олон улсын гэрээний гишүүн буюу соёрхон баталсан эсхүл гарын үсэг зурсан байх ёстой.

- Хувь хүмүүсийн гомдлыг хүлээн авч хэлэлцэхийн тулд холбогдох олон улсын гэрээний дагуу байгуулагдсан Хороонд бүрэн эрхийг нь олгосон байх ёстой.

Гомдлыг бичгээр гаргаж холбогдох нотлох баримтуудыг хавсаргана. Олон улсын хүний эрхийн хороо нь гомдлыг хүлээн авч хэлэлцэхээс өмнө дараах шаардлагуудыг хангасан эсэхийг шалгадаг. Үүнд:

- Хэрэв та хэн нэгний өмнөөс гомдол гаргаж байгаа бол шаардлагатай зөвшөөрөл авсан эсэх
- Та (эсхүл таны өмнөөс нь явж байгаа тэр хүн) санаатай зөрчлийн хохирогч уу? Та өөрөө таны эрхийг зөрчсөн болон зөрчиж байгаа гэж гомдол гаргаж буй оролцогч улсын хууль, бодлого, хэрэгжүүлэлт, арга хэмжээ, үйл ажиллагааны нөлөөлөлд шууд өртсөн гэдгээ нотлон харуулах ёстой.
- Таны гомдол нь холбогдох олон улсын гэрээний үзэл баримтлалтай нийцэж байгаа юу? Таны гомдол хангалттай нотолгоотой юу?
- Таны гомдол танай улсад гомдол шийдвэрлэх механизм ажиллаж эхлэхээс өмнө болсон үйл явдалд холбогдох уу?
- Дотооддоо байж болох бүх арга хэмжээг авсан уу?
- Таны гомдлыг өөр ямар нэгэн олон улсын гэрээ, хэлэлцээрт хамаарах механизмаар хүлээн авч хэлэлцэж байгаа юу?

Олон улсын хүний эрхийн хороо хэрэг бүрийг хаалттай хуралдаанаар хэлэлцдэг бөгөөд шийдвэрлэсэн тохиолдолд шийдвэрээ танд болон оролцогч улсад зэрэг хүргэнэ. Олон улсын хүний эрхийн хороо нь гомдлыг хянан үзээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

- Хороо таныг оролцогч улс олон улсын гэрээнд заасан хүний эрхийн зөрчлийн хохирогч мөн гэж шийдвэрлэвэл оролцогч улсыг гурван сарын хугацаанд ийм үр дүнд хүргэсэн арга хэмжээний талаарх мэдээллээр хангахыг шаардана.
- Хороо таны хэрэгт олон улсын гэрээний зөрчил байхгүй эсхүл хүлээн зөвшөөрөгдөхгүй гэж шийдвэрийг оролцогч улс болон танд хүргэнсээр гомдол гаргах үйл явц дуусгавар болно.
- Гомдлыг шийдвэрлэхэд нэмэлт материал, тайлбар шаардлагатай гэж үзвэл оролцогч улсыг тодорхой хугацааны дотор тодорхой нөхцөл байдлын хүрээнд тайлбар хийхийг шаардана.

Хүүхдийн эрхийн конвенцийн III нэмэлт протокол “Мэдээлэл хүргүүлэх журмын тухай” 2015 онд батлагдан гарснаар хүүхдийн эрхийн хороонд хүүхэд өөрийнхөө болон бусад хүүхдүүдийн эрхийг зөрчсөн хүний эрхийн зөрчлийн талаар гомдол гаргах механизм бий болсон.



Гэртээ хийгээрэй.

- Хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын тогтолцооны ач холбогдлыг тодорхойлно уу.
- Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны өнөөгийн байдалд ХЭҮК-оос жил бүр гаргадаг хүний эрхийн тайлан илтгэлд тулгуурлан дүн шинжилгээ хийнэ үү.



Нэмж судлаарай

- Монгол улсын Үндсэн хууль 1992 он
- Монгол улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр
- Хүний эрхийн тоөч тайлбар, ХЭҮК, Улаанбаатар хот, 2012 он
- Хүний эрхэд сууринсан хандлага, ХЭҮК, 2016 он

БҮЛГИЙН ДУГНЭЛТ

“Эрх зүй” бүлэг сэдвийн хүрээнд Үндсэн хуулийн зорилго, ач холбогдол, үндсэн хуульт ёс болон эрх зүйд захирагдах ёсны харилцаан хамаарал, өмчлөх эрхийн мөн чанар, гэмт хэрэг, гэм хор, түүний ялгаа, онцлог, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрхийг хамгаалах арга замын талаар судаллаа.

Бид бүхэн өглөө гэрээсээ гараад автобусанд суух, сургуулийн өлгүүрт хувцсаа өгөх, хичээл, сургалтад хамрагдах, дэлгүүр, цайны газраар үйлчлүүлэх гээд алхам тутамдаа эрх зүйн харилцааны оролцогч байсаар ирсэн. Энэ бүх үйл ажиллагаанд эрхээ хамгаалах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлоо арилгах, нийгмийн харилцаанд зүй зохистой оролцох хэрэгцээ, шаардлага бий болдог. Иймээс улс орон бүр иргэддээ эрх зүйн боловсрол олгох асуудалд өндөр ач холбогдол өгдөг. Та бүхнийг ч гэсэн цаашид эрх зүйн мэдлэг, боловсролоо улам гүнгийрүүлэхэд анхаарч, хичээн суралцана гэдэгт найдаж байна.

Энэхүү бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгах, хэрэглээ болгохын тулд дараах дасгал, даалгаврыг хийж гүйцэтгээрэй.

I. ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭЭРЭЙ.



- Түүхийн хичээлийн мэдлэгээ ашиглан төр хүний эрхийг зөрчиж байсан бодит баримтын жишээ гаргаарай.

Эртний үе	Дундад зууны үе	Сэргэн мандалтын үе	Орчин үе

Асуулт:

- Тухайн баримтат үйл явдлын гол шалтгаан юу байв?
- Тухайн цаг үед Үндсэн хуульт ёс болон эрх зүйд захирагдах зарчим хэрэгжиж байсан бол нөхцөл байдал ямар болох вэ?
- Засаглалын эрхийг хязгаарлах болсон гол үндэслэлүүдийг нэрлэнэ үү.
- Ж.С.Милль, Төр бол “зайлишгүй байх ёстой мую зүйл” гэж хэлсний утга учрыг тайлбарлана уу.
- Төрийн зайлшгүй байх шаардлагыг тодорхойлно уу.



2. Эх сурвалжтай ажиллаарай.

Хамгийн эртний хууль боловсруулагчдын нэг Ромын эзэн хаан Юстинан шударга ёс гэдэг бол “хүн бүрд зохих хувийг нь өгөх” хэмээн тодорхойлжээ.

*Эх сурвалж: Др.Найжель Ашфорд,
“Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд”*

63 дахь тал

- Дээрх тодорхойлолтыг эрх зүйд захирагдах ёсны үүднээс тайлбарлана уу.
- Өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрөөгүй нийгэмд эрх зүйт ёс оршин тогтох боломжтой юу?
- Яагаад өмчлөх эрхийг бүх эрхийн үндэс гэж үзсэн бэ?
- Нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх нь шударга ёс болон эрх зүйт ёсны зарчимд харшлах уу?
- Үндсэн хуульт ёсны үүднээс халамжийн бодлогын талаар эерэг тайлбар хийх боломжтой юу?

3. Тохиолдол шинжлээрэй. <http://www.legalinfo.mn/law/details/283> линкээр зочилж Зохиогчийн болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг уншиж судлаад дараах тохиолдолуу хууль зөрчсөн эсэхэд дүн шинжилгээ хийгээрэй.

- Сурагч А зохиогч Б-ийн “Монголчуудын түүх, соёл” номоос 25 хуудас хувилан авч хичээлд ашигласан байна.
- Сурагч Д зохиогч Ц-ийн номоос эшлэл авалгүй 5 өгүүлбэр хуулж, эсээндээ бичсэн.
- Иргэн Т нь Хууль зүйн яамнаас зөвшөөрөл авалгүй эрүүгийн хуулийг 300 хувь хэвлээд худалдан борлуулсан байна.

II. ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ.



1. Өөрийгөө сориорой

№		Зөв	Буруу	Тайлбар
1	Үндсэн хуулийн бүх заалтыг Монгол улсын иргэд дагаж мөрдөх үүрэгтэй.			
2	Шударга ёсны зарчмыг бүх хуульд тусгах ёстой			
3	Засаглалын эрх мэдлийг хуваарилах нь сайн үр дүнд хүрч чадаагүй			
4	Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалын хамгийн гол нь үндсэн хуулийг хянах тогтолцоог бүрдүүлэх юм.			
5	Үндсэн хуулийн цэц иргэдийн эрх зөрчсөн маргааныг шийдвэрлэдэг.			
6	Би сургуулийн гадаа талбайд хаясан номыг олж авсан. Энэ бол миний ном.			
7	Зөрчилтэй асуудлыг заавал шүүх, цагдаа биш талууд зөвшилцэж шийдвэрлэж болно.			
8	Бид гэмт хэргийн талаар мэдээллийг цагдаагийн байгууллагад өгөх үүрэгтэй.			
9	Гэмт хэргийн хохирогч заавал өмгөөлөгчөөс зөвлөгөө авах шаардлага байхгүй.			
10	Гэмт хэрэг, зөрчил хоёр ялгаатай.			



2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиас захиргааны хэргийн оролцогчид болон бусад оролцогчдын эрх, үүргийг харьцуулан бичээрэй.

№		Эрх	Үүрэг
1	Нэхэмжлэгч		
2	Хариуцагч		
3	Гуравдагч этгээд		
4	Өмгөөлөгч		
5	Төлөөлөгч		
6	Гэрч		
7	Шинжээч		
8	Орчуулагч		
9	Иргэдийн төлөөлөгч		



3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийг уншиж судлаад дараах харьцуулалтыг хийгээрэй

№	Захиргааны хэрэг	Иргэний хэрэг
1	Нэхэмжлэгч	
2	Хариуцагч	
3	Нотлох баримт цуглуулах	
4	Нэхэмжлэл гаргах	
5	Хэргийг шийдвэрлэх хугацаа	
6	Анхан шатны шүүхээс гарах шийдвэр	



4. Зөв хариулалтыг сонгоно уу

1. Засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй хамгийн дээд хүчин чадалтай засаг, төрийн гол хууль аль нь вэ?

- a. Зөрчлийн тухай хууль
- b. Үндсэн хууль
- v. Иргэний хууль
- g. Эрүүгийн хууль

2. “Ул үндэстэй авч үзэх юм бол эрх гэж байхгүй өмчлөх гэж л байдаг”хэмээх бичсэн Америкийн эдийн засагч Мюррей Ротбардын бүтээл аль нь вэ?

- a. Нийгмийн гэрээ
- b. Хуулийн амин сүнс
- v. Эрх мэдэл ба зах зээл
- g. Европын доройтол

3. “Аливаа нийгэмд гэмт хэрэг, зөрчил байнга оршсоор ирсэн.Олон зууны турш хүн төрөлхтөн үүнийг үгүй болгохыг хичээсэн ч хот суурин бий болохын хэрээр нэмэгдсээр байна” хэмээн дүгнэсэн Францын философич, социологич хэн бэ?

- a. Э.Дюркгейм
- b. Н.Ротбард
- v. Ж.Локк
- g. И.Кант

4. Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой маргаж байгаа буюу зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалахын тулд шүүхээр дамжуулан эрх зөрчигчдөд тавьж буй шаардлагыг эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ?

- a. Өргөдөл
- b. Нэхэмжлэл
- v. Гомдол
- g. Хүсэлт



Суралцахуйн зорилт	Тулгуур ойлголт
<p>Төрийн эдийн засгийн бодлого</p> <p>а. Эх сурвалжийг судлан, төрөөс эдийн засгийг зохицуулах арга механизм, ач холбогдлыг тоочин бичих</p> <p>б. Төрийн эдийн засгийн бодлогын баримт мэдээлэлд үндэслэн, үндэсний эдийн засгаа хөгжүүлэх хувилбарыг дэвшүүлэх</p> <p>в. Төрийн эдийн засгийн ач холбогдлыг тодорхойлж, үр ашгийг нэмэгдүүлэх саналын үндэслэлийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> • Төрийн сангийн бодлого • Төрийн мөнгө, зээлийн бодлого • Татвар • Төсөв • Гадаад худалдаа • Экспорт • Импорт • Гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого • Гадаадын хөрөнгө оруулалт • Эдийн засгийн хөгжил
<p>Төрийн эдийн засгийн гадаад бодлого</p> <p>а. Эх сурвалжийг судлан, төрийн эдийн засгийн гадаад бодлогыг тодорхойлох</p> <p>б. Гадаад худалдааны төрөл, онцлог, ач холбогдлын талаар өгөгдөл, баримтыг шинжлэн байр сууриа илэрхийлэх</p> <p>в. Эх сурвалжийг ашиглан, үндэсний эдийн засгийн хөгжил дэх өөрийн хандлагаа эсээгээр илэрхийлэх</p>	

СЭДЭВ 4.1 ТӨР ЭДИЙН ЗАСГИЙГ ЯМАР БОДЛОГООР ЗОХИЦУУЛДАГ ВЭ?

Бид өмнөх ангид эдийн засгийг улс орны хэмжээнд хэмжих үзүүлэлтүүд, макро эдийн засгийн асуудал болох ажилгүйдэл, инфляци, тэдгээрийн шалтгаан, үр дагаврыг мэдэж ажилгүйдэл, инфляцитай холбоотой хувь хүнд учирч болох эрсдэлээс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар ойлголттой болсон. Мөн статистик үзүүлэлтүүдэд зарим тоон шинжилгээ хийх чадварт суралцсан. Харин XI ангидаа та бүхэн төрийн макро эдийн засгийн бодлого, түүний мөн чанарыг ойлгож судалгааны энгийн аргуудыг ашиглан бодит үйл явцыг үнэлэх, үндэсний эдийн засгaa хөгжүүлэх санал, хувилбаруудыг бие даан боловсруулах чадварт суралцана.

Эдийн засгийн уналт болон инфляци нь хувь хүн болон нийт нийгэмд хүндээр тусдаг учраас эдгээр үзэгдэлд эсрэг нөлөөлөл үзүүлэхийн тулд төр макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлдэг. Түүний зорилго нь эдийн засгийн уналтыг зогсоох, инфляцийг сааруулах, эдгээрийн эдийн засаг болон нийгэмд бүхэлд нь учруулах хор нөлөөг багасгах, арилгахад оршино. Төр макро эдийн засгийн сангийн ба мөнгөний гэсэн үндсэн хоёр арга хэрэгслийг ашигладаг.

ТӨРИЙН САНГИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО ЮУ ВЭ?



Үйл ажиллагаа 4.1. Асуултад хариулаарай.

- Та бүхэн өмнөх ангидаа ажилгүйдэл, инфляцийн талаар судалсан зүйлээ сэргээн санаж дараах асуултад хариулаарай. Үүнд:
 - Эдийн засгийн уналтын үед бидний орчинд ямар, ямар сөрөг үзэгдэл ажиглагддаг вэ?
 - Эдийн засгийн уналт, ажилгүйдэл, инфляцитай холбоотой асуудлыг зохицуулахад төр яагаад оролцох ёстой вэ?
 - Ажилгүйдэл, инфляцитай холбоотой хувь хүнд учирч болох эрсдэлээс өөрийгөө хэрхэн хамгаалж болох вэ?
- Нийт эрэлт гэдэгт юуг ойлгох вэ?
 - Та бүхэн өмнөх ангидаа судалсан зүйлээ сэргээн санаж зах зээлийн эрэлтийн гол утга санааг тайлбарлана уу.
 - Бид өмнөх ангидаа ДНБ-ийг зардлын аргаар тооцоходоо 4 бүлэг хэрэглэгчийн зардлын нийлбэрээр тодорхойлж байсан. Энэ нь нийт эрэлтийн бүрэлдэхүүн хэсэг юм. Тэгээл, нийт эрэлтийн бүрэлдэхүүн хэсгийг хүснэгтэд гүйцээн бичиж тайлбар хийнэ үү.

д/д	Тэмдэглэгээ	Хэрэглэгчийн зардлын бүрэлдэхүүн	Тайлбар
1	C	Өрхийн хэрэглээний зардал	
2	I	?	
3	G	?	
4	X	?	
Нийт эрэлт = C+I+G+X			

- Нийт эрэлт (нийт хэрэглэгчийн орлого) болон эдийн засгийн өсөлт хоорондоо ямар хамааралтай болохыг тайлбарлана уу.

Эдийн засаг унаж ажилгүйдэл өсөх нь нийт эрэлт хангалтгүй байгаатай холбоотой гэж эдийн засагчид үздэг. Тэгвэл, нийт эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд тэр ямар бодлого боловсруулж хэрэгжүүлдэг вэ? Үүнийг тайлбарлахын тулд улсын төсвийн талаар ойлголттой байх хэрэгтэй.



Тулгуур ойлголт

Татвар нь хуулийн дагуу, тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж юм.

Татвар ба улсын төсөв. Өөрийн бүхий л үүргийг гүйцэтгэхийн тулд төрд мөнгө хэрэгтэй. Төрийн мөнгөн хөрөнгийн гол эх үүсвэр нь бүх төрлийн татвар юм.

Зах зээлийн онолыг үндэслэгч Адам Смит татвар хураалтын үндсэн зарчмуудыг тодорхойлсон. Түүнээс заримыг дурдвал, татвар нь:

1. Шударга байх. Энэ нь татварыг бүх нийтээр төлдөг байх, татвар нь хүмүүсийн орлоготой шууд хамааралтай байх гэсэн зарчим юм.
2. Ил тод байх. Энэ нь татвар төлөгчдөд татварын хэмжээ, татвар хураах арга, хугацааг урьдчилан мэдэгдсэн байх ёстой гэсэн агуулгатай юм.



Үйл ажиллагаа 4.2. Асуултад хариулна уу. Орчин үеийн Америкийн эдийн засагч Артур Лаффер татварын орлого болох хураасан татварын нийт хэмжээ, татварын хувь хэмжээнээс хөрхэн хамаарч байдгийг графикаар илэрхийлжээ.

- a. Татварын хувь хэмжээ нэмэгдэхэд татварын орлого өсөж байгааг муруйн аль хэсэгт илэрхийлсэн бэ?
- b. Татвар хураалтын хэт хатуу зарчим ямар хор уршигтай байдгийг муруйн аль хэсэгт илэрхийлсэн бэ?
- c. Графикийн 0,M болон 0-C хүртэлх шулуунаар юуг илэрхийлсэн бэ?
- d. Графикийн t болон C цэгийн утга санааг тайлбарлана уу?
- e. Далд эдийн засаг үүсэх нөхцөлийг графикийн аль хэсэгт дүрсэлсэн бэ?
- f. Төрийн татварын орлого хэдийд 0 тэй тэнцэх вэ?




График 4.1. Лаффериийн муруй

Татварын орлого



Төрийн зардал

4.1 дүгээр зураг. Улсын төсвийг усан сан гэж үзвэл татвар нь түүнийг дүүргэж байдаг хоолой, төрийн зардал нь түүнээс хөрөнгийг урсган гаргаж байдаг хоолой болно.

Төсвийн орлого, зарлагыг тэнцүүлж байх нь ихээхэн хүндрэлтэй асуудал юм. Төсвийн дефицит буюу төсвийн хомсдол гэж нэрлэдэг орлогоос зарлага давах тохиолдол байнга л үүсэж байдаг. Харин орлого нь зарлагаасаа давснаас бий болсон зөрүүг төсвийн илүүдэл буюу профицит гэнэ.

Улсын зардлыг нэмэгдүүлэх нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

1. Төр өөрийн хөрөнгөөр нийтийн шинжтэй ажил зохион байгуулж болно. Жишээ нь, зам гүүр барих, нийгэмд хэрэгцээтэй бусад объектуудыг байгуулж болно. Ингэснээр ажилгүй олон хүмүүс ажилтай болж тэдний орлого нэмэгдсэнээр өрхийн хэрэглээнийн зардал буюу эрэлтийг нэмэгдүүлнэ.
2. Төрөөс “Засгийн газрын хөтөлбөр, төсөл” боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд зориулж зардлаа ихэсгэж болно. Жишээ нь, төмөр зам барихад мөнгө хуваарилж болно. Төрийн энэхүү томоохон захиалгыг төмөр замын эд анги, тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг компани, байгууллагууд хүлээн авч үйлдвэрлэл явуулсны эцэст төр, тэдгээрийг захиалгын дагуу худалдан авна. Захиалга авсан компани ажилчид нэмж авахын зэрэгцээ бусад холбоотой ажилладаг байгууллагудад мөн захиалга өгч болно. Ингэж ажил эрхлэлт болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж нийт эрэлт өснө.

Засгийн газар төсвийн зарлагыг нэмэгдүүлэх зорилгоор дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд маш их мөнгө хэрэгтэй. Тэгвэл энэ мөнгийг төрөөс Засгийн газрын бонд гаргах замаар санхүүжүүлж болно.

Татварын дарамтыг багасгах нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

Төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг (70.0-80.0%) хувь хүн болон ААН-ээс авах татварын хэмжээг бууруулснаар хэрэглэгчийн орлого, ААН-ийн орлого өснө. Ингэж хэрэглээнийн зардал болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж нийт эрэлт өснө. Гэхдээ татварын хувь хэмжээг бууруулах нь эргээд төрийн орлого буурах нэг шалтгаан болно.

Улсын төсөв нь орлого болон зарлага гэсэн хэсгээс бүрддэг тул төрийн сангийн бодлого мөн энэ хоёр хэсэгт хуваагддаг.



Тулгуур ойлголт

Бонд нь тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэй эргүүлэн төлөхийн баталгаа болох үнэт цаас юм.



Тулгуур ойлголт

Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг төрийн сангийн буюу **төсвийн бодлого** гэнэ.

**Гэртээ хийгээрэй.**

1. Эдийн засгийн уналтын үед улсын орлого болон зарлагыг өөрчлөхөд ямар арга замыг ашиглаж байна вэ? Хүснэгтэд тэдгээрийг нэрлэж үр дагаврыг тодорхойлоорой.

Төсвийн зарлагыг өөрчлөх бодлого		Төсвийн орлогыг өөрчлөх бодлого	
Арга зам	Үр дагавар	Арга зам	Үр дагавар

Дээрх хүснэгтийг бөглөсөн мэдээлэлд анализ хийж, асуултад хариулна уу.

- a. Өнөөдөр манай улсын Засгийн газраас ямар бондуудыг ямар нэрээр гаргаж байна вэ? Тэдгээрийн эх үүсвэр, зорилго, зориулалт нь юу вэ?
- b. Өнөөдөр манай оронд хэрэгжүүлж байгаа “Засгийн газрын төсөл, хөтөлбөрүүд”-ийн зорилго нь юу вэ? Энэ хүрээнд өнөөдөр та бүхэнд ажиглагдахаар, үр дүнгээ өгсөн бүтээн байгуулалтын ямар, ямар ажил хийгдсэн байгааг нэрлэнэ үү. Цаашид ямар, ямар ажлыг хийхээр төлөвлөж байна вэ?
- v. Эдийн засгийн огцом уналтаас гарахын тулд Засгийн газар татварын бодлоготой хамтруулан төрийн зардлыг огцом нэмэгдүүлэхийг хичээдэг. Ийм бодлогын давуу ба сул тал нь юу байж болох вэ?
- g. Төрийн зардал, орлогоосоо давбал алдагдлыг бууруулахад чиглэсэн дараах шийдвэрээс хамгийн чухал гэж үзэж байгаа 2 арга замыг сонгож үндэслэлээ хамгаална уу.
1. Төсвийн зардлыг хэмнэх
 2. Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх
 3. Төрийн өмчийн хөрөнгийг арилжих
 4. Мөнгө шинээр хэвлэж гүйлгээнд гаргах

СЭДЭВ 4.2 ТӨРИЙН МӨНГӨ, ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО ЮУ ВЭ?

НИЙТ ЭРЭЛТИЙГ ХЭРХЭН НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ТӨРИЙН МӨНГӨ, ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН АРГА МЕХАНИЗМ НЬ ЮУ ВЭ?



Тулгуур ойлголт

Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг **төрийн мөнгө, зээлийн бодлого** гэнэ.

Төр нийт эрэлтийг (нийт худалдан авалт) нэмэгдүүлж эдийн засгийн уналтыг сааруулахын тулд зээлийн хүүг бууруулах, эсвэл гүйлгээнд байх ёстой мөнгөний тоо хэмжээг өсгөх механизмыг хэрэглэж болно.

Зээлийн хүүг бууруулах нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

Банкны зээлийн хүү буурахад иргэд болон ААН-үүдээс хэрэглээ болон хөрөнгө оруулалтдаа зориулж авах зээлийн хэмжээ нэмэгдэж гүйлгээнд мөнгөний тоо хэмжээ өссөнөөр хүмүүс мөнгөтэй болж нийт эрэлт нэмэгдэнэ.

Гүйлгээнд байх мөнгөний хэмжээг өсгөх нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

Мөнгөний талыг баримтлагчид хэрэв эдийн засагт мөнгөний хэмжээг түүний хэрэгцээнээс хамааруулан өсгөөд байвал хүмүүсийн хувьд мөнгөний үнэ цэн буурч тэд мөнгийг мөнгө байдлаар хадгалахын оронд түүнийг бараагаар солихыг илүү үзнэ. Товчоор хэлбэл, энэ бодлогын гол санаа нь аль болох бага хуримтлуулж илүү ихийг худалдан авснаар нийт эрэлтийг нэмэгдүүлнэ гэж үздэгт оршино.

Зээлийн хүүний тусламжтайгаар гүйлгээнд мөнгөний нийлүүлэлтийг зохицуулна. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлогыг “Мөнгөний хумих бодлого”, харин гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг “Мөнгөний тэлэх бодлого” гэнэ.

Засгийн Газар бонд гаргах нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

Засгийн Газар үнэт цаас буюу бонд гаргаж худалдах, түүнийгээ эргүүлэн худалдан авах замаар мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлж болно.

- Хэрэв Засгийн газар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн хүүгийн хэмжээг бууруулах гэж байгаа бол зах зээлээс өөрийн бондыг эргүүлэн худалдан авч оронд нь мөнгө төлнө. Эдгээр мөнгө банкуудад очсоноор зээлийн хэмжээ нэмэгдэж гүйлгээнд байх мөнгөний хэмжээ өснө. Энэ нь нийт эрэлтийг нэмэгдүүлэх нөхцөл болно.
- Хэрэв Засгийн газар инфляцитай тэмцэж байгаа бол үүний эсрэгээр бонд гаргаж худалдана. Худалдан авагчид түүнийг олж авахын тулд банканд байгаа мөнгөө зарцуулна. Ингэснээр банкны зээлэнд зориулсан мөнгөний нөөц буурч гүйлгээнд байх мөнгөний хэмжээ багассанаар инфляци буурах боловч нийт эрэлтийг бууруулах нөхцөл болно.

Мөнгөний бодлогыг эдийн засгийн уналт болон инфляцийн аль алинтай нь тэмцэж чадах хоёр талаас нь хурцалсан зэвсэгтэй зүйрлэж болно. Сангийн бодлого нь эдийн засгийн өсөлтийг урамшуулдаг байж болох ч инфляцийн эсрэг хүчин мөхөсддөг бол мөнгөний бодлого нь инфляцид хүчтэй нөлөөлж чаддаг аргад тооцогдоно. Мөнгөний бодлогын үндсэн арга хэмжээнүүдийг Төв банк бүрэн эрхийнхээ хурээнд дангаар, бие даан хэрэгжүүлдэг бол төсвийн орлого, зарлагын аливаа нэгэн өөрчлөлтийг УИХ дээр хэлэлцэж байж шийдвэр гаргадаг учраас мөнгөний бодлого нь сангийн бодлогыг бодвол илүү уян хатан чанартай байна.



Үйл ажиллагаа 4.3. Эх болон графикийг харьцуулан судалж асуултад хариулаарай.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 оны 4 дүгээр сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч жилийн 19.1 хувьд хүрэв. Харин хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар буурсан буюу 4 дүгээр сарын байдлаар 12.8 хувь байна. Зээл, хадгаламжийн хүүний зөрүү 6.3 хувьтай тэнцэж байна.

Эх сурвалж: 2018 он МҮ-ын тогтвортой байдлын тайлан



- Арилжааны банкууд хэрхэн ашиг олдог вэ? Түүнд хадгаламжийн болон зээлийн хуугийн аль нь хүчтэй нөлөө үзүүлж байна вэ?
- Гүйлгээн дэх мөнгөний хэмжээ аль оны, ямар улиралд мэдээдэхүүц өсөж вэ?
- 2017 оны 3-р улирлаас 2018 оны 2-р улирал хүртэлх хугацаанд гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээг 2016 оны 1-р улирлаас 2017 оны 3-р улирал хүртэлх хугацаатай харьцуулахад өссөн үү? эсвэл буурсан уу?
- Нийт зээлийг салбарын ангиллаар авч үзвэл олгосон зээлийн хэмжээ 2018 оны эхний улиралд өмнөх оны дунтэй харьцуулахад үйлдвэрлэлийн аль салбарт буурсан, аль салбарт өссөн бэ? Энэ нь ямар шалтгаантай байж болох вэ?



Үйл ажиллагаа 4.4. Асуултад хариулаарай.

- Ажлын байрыг шинээр бий болгоход чиглэсэн төрийн зардал нь дараах үр дагаварт хүргэдгийн шалтгаан юу вэ?
 - Татварыг нэмэгдүүлэх;
 - Улсын төсвийг хомсдолд оруулах;
 - Инфляцийг хөөрөгдөх;
- Дор дурсан шийдвэрүүдээс аль нь инфляцийн эсрэг бодлогод хамаарах вэ? Яагаад
 - Банкны зээлийн хүүг нэмэгдүүлэх;
 - Банканд байгаа хувийн хадгаламжуудыг индексжүүлэх (хадгаламжийн өсөлтийн хурдыг инфляцийн хурдтай тэнцүү байхаар тооцох);
 - Засгийн газраас үнэт цаас гаргаж худалдах;

Орчин үеийн зах зээлийн эдийн засгийг төрийн макро эдийн засгийн бодлогогүйгээр төсөөлөхийн аргагүй. Гэхдээ түүний ач холбогдлыг хэт үнэлж болохгүй, түүнийг “Цагаа олоогүй” шийдвэр, төрийн бодлогын уян хатан бус байдал, шаардлагатай мэдээлэл байхгүй зэрэг асуудлууд хязгаарлаж байдаг. Төрийн эдийн засгийн бодлогын арга хэмжээ нь ямагт нийгмийн нэг хэсгийн сонирхолд нийцэж, нөгөө хэсгийн сонирхолтой зөрчилдөж байдаг.



Үйл ажиллагаа 4.5. Эдийн засгийн ухааны нэрт эрдэмтдийн эдийн засгийн ухаанд оруулсан хувь нэмрийн талаар төвч дурбсан эхийг уншиж асуултад хариулна уу.

1. Эдгээр эрдэмтэд энд ямар асуудлыг хөндсөн бэ?
2. Төрийн эдийн засаг дахь оролцоог зайлшгүй болохыг нотолсон, няцаасан үндэслэлийг олж жишээгээр тайлбарлана уу.

Фридрик фон Хайек (1899-1992).



Хайекын сонирхдог эдийн засгийн асуудлуудын хүрээ маш өргөн бөгөөд түүн боловсруулсан эдийн засгийн онолууд нь нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл бодолтой байнга зөрчилддөг. Тухайлбал, Хайек гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй гэдгийг баталсны зэрэгцээ зах зээлийн эдийн засаг дахь териин идэвхтэй оролцоо нь түүнд зөвхөн хор учруулна гэж үздэг. Хайек эдийн засгийн амьдрал, логик, ёс зүй болон социализмын шинжлэх ухааны үндэслэлийг бүх талаас нь судалж үзээд социализмыг аль талаас нь авч үзсэн ч маш алдаатай байсан гэдгийг нотолж байжээ. Эдийн засгийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн 1974 онд түүнд Нобелийн шагнал олгожээ.

Джон Мейнард Кейнс (1883-1945).




Кейнсийг эдийн засгийн шинжлэх ухаанд хувьсгал хийсэн хүн гэж үздэг. Тэрээр сонгодог уран зохиол, хөгжим, спортоор хичээллэхийн зэрэгцээ хөрөнгийн бирж дээр тоглож асар их амжилт олж байжээ. Кейнс зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч чадахгүй гэдгийг баталж териин оролцоотой нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар энэ зорилтыг шийдэх ёстай гэж үзжээ. 1930 аад оны эхээр барууны орнуудыг хамарсан хүчтэй бөгөөд сунжирсан эдийн засгийн уналт нь Кейнсийн дүгнэлтийг нэг ёsonдоо баталжээ. Кейнсийн онол нь макроэдийн засгийн онолын цаашдын хөгжил болон барууны орнуудын төрийн эдийн засгийн бодлогод маш их нөлөө үзүүлжээ. Түүнчлэн Кейнс мөнгө болон банкны талаарх агуу онолч төдийгүй онолыг хэрэгжүүлэгч юм. Түүний зөвлөгөөгөөр Англи болон бусад орнуудад банкны шинэчлэлүүд хийгджээ. Эх орныхоо өмнө байгуулсан гавьяаг нь үнэлэн түүнд “Лорд” зэрэг олгожээ.



Үйл ажиллагаа 4.6. Бүдүүчийг бөглөж ярилцаарай.

1. Төрийн сангийн болон мөнгө, зээлийн бодлогын арга хэрэгсэл, хүрэх үр дүнг бүдүүчээр илэрхийлээрэй.
2. Эдийн засгийн уналт болон инфляцитай тэмцэхэд хэрэглэдэг дараах аргууд нь төрийн эдийн засгийн ямар бодлогод хамаарах вэ?
 - Төрөөс хувь хүн болон ААН-ийн орлогын татварын хэмжээг бууруулах;
 - Төрийн зардлыг өөрчлөхгүй, харин зээлийн хүүг нэмэгдүүлэх;
 - Төрийн зардлыг ихэсгэж, татвар болон зээлийн хүүг өөрчлөлтгүй хэвээр үлдээх.





3. Зургийг ажиглан асуултад хариулаарай.

- Энэ зураг юуны тухай өгүүлж байна вэ?
- Эдгээр гурван байгууллага ямар асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар үүрэгтэй оролцох ёстой вэ?



Гэртээ хийгээрэй.

Эдийн засгийн хүрээний асуудлыг судлах олон арга, аргачлал байдаг бөгөөд эдгээрээс та бүхэн динамик хандлагын судалгаа, бүтцийн өөрчлөлтийн судалгаа, график дүрслэлийн аргутдыг өмнөх аngиудад судалж эзэмшсэн. Эдгээр нь тоон шинжилгээний аргууд болно. Энэ удаа тоогоор үл илрэх нийгэм, эдийн үзэгдлийг судлах нэгэн аргачлалыг эзэмшиж хот, дүүрэг болон орон нутагтаа судалгаа явуулж манай орны эдийн засгийн өнөөгийн байдал, ойрын ирээдүйг үнэлж цаашид эдийн засгийн өсөлтийг дэмжих, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд төрийн ямар бодлого чухал болох талаар судалгааны тайлан бичиж хамгаалаарай.

Судалгааны асуултууд:

- Сүүлийн 6 сарын турш танай өрхийн материаллаг аж байдалд ямар өөрчлөлт гарсан бэ? Хариулт нь сайжирсан, дордсон, өөрчлөгдөөгүй гэсэн хувилбартай байна.
- Ирэх 6 сард өрхийн материаллаг аж байдалд ямар өөрчлөлт гарна гэж үзэж байна вэ? Хариулт нь сайжирна, дордоно, өөрчлөгдөхгүй гэсэн хувилбартай байна.
- Дараагийн 12 сард улс орны эдийн засгийн байдлын талаарх таны бодол юу вэ? Хариулт нь сайжирна, дордоно, өөрчлөгдөхгүй гэсэн хувилбартай байна.
- Дараагийн 5 жил улс орны эдийн засгийн байдлын талаарх таны бодол юу вэ? Хариулт нь сайжирна, дордоно, өөрчлөгдөхгүй гэсэн хувилбартай байна.
- Таны хувьд гэртээ томоохон худалдан авалт хийхэд өнөөдөр “Сайн цаг” уу, эсвэл “Muu цаг” уу?

Мэдээлэлд боловсруулалт хийх арга зүй:

- Асуулт бүр дээр хэсгийн индексийг дараах байдлаар тооцно. Ээрэг хариултын хувийн жингээс, сөрөг хариултын хувийн жинг хасаж энэ зөрүүн дээр 100-г нэмнэ. Энэ нь сөрөг тэмдэг авахуулахгүй байх зорилготой.
- Бүх асуултуудыг нэгтгэсэн нийлмэл индексийг хэсгийн индексүүдийн арифметикийн дунджаар тодорхойлно.

Гарах үр дүнг тайлбарлах арга зүй:

Индекс нь 0-200 хүртэл өөрчлөгдж болно. Хэрэв, судалгаанд хамрагдсан хүмүүс,

- Бүгд эдийн засгийн байдлыг эерэг талаас нь үнэлж байвал, индекс 200-тай тэнцэнэ. ($100-0=100+100=200$)
- Эерэг ба сөрөг үнэлгээ тэнцүү байвал, индекс 100 тай тэнцэнэ. ($50-50=0+100=100$)
Бүгд сөрөг талаас нь үнэлж байвал 0 тэй тэнцэнэ. ($0-100=(-100)+(+100)=0$)

Жишээ нь, судалгаанд хамрагдсан хүмүүсийн 60% нь эерэг, үлдсэн 40% нь сөрөг хариулт өгсөн гэвэл, $60\%-40\%=20+100=120\%$ болно. Энэ нь хүмүүс асуудалд эерэгээр хандаж байгаа ч хангалттай хэмжээнд үнэлэхгүй байгааг илэрхийлнэ.

СЭДЭВ 4.3 ГАДААД ХУДАЛДАА, ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО

ГАДААД ХУДАЛДАА ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Нэг хүн өөртөө зориулж бүхнийг үйлдвэрлэж чадахгүй нэгэн адил нэг улс байгалийн болон хүний нөөцөөр хамгийн баян байлаа ч ганцаар оршин тогтох боломжгүй юм. Бүхий л улс орнууд олон улсын худалдаанд оролцож байдаг. Нэгэнт улс орнууд



Тулгуур ойлголт

Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг олон улсын худалдаа гэнэ.

харилцан худалдаа хийж байгаа болохоор гадаад худалдаа нь гадагшлах (экспорт) болон дотогшлох (импорт) хоёр ургалтай байна.

Гадаад худалдаа нь тухайн улс ашиг, орлогоо зузаатгах, эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлэх

нэг чухал хүчин зүйл болдог. Экспортын өсөлт нь эх орны бүтээгдэхүүний хувьд зах зээлийг өргөтгэж байгаа тул тухайн орны хувьд ашигтай. Импортын бараа нь эх орны үйлдвэрийн бараатай өрсөлдөж улмаар үндэсний үйлдвэрлэлийг шахах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй гэж үздэгээс импортыг хүмүүс ихэнхдээ дутуу үнэлдэг. Аливаа орны хэрэглэгчдэд барааны импорт ашигтай тул түүнийг бас онцолж авч үзэх ёстой.



Үйл ажиллагаа 4.7. Та дор дурдсан дүгнэлтүүдтэй санал нийлэх үү? Эсвэл, танд өөр хувилбар байна уу? Энэ талаар үндэслэлээ тайлбарлаарай.

1. Өнөөдөр манай орны хувьд үйлдвэрлэлийн орчин үеийн техник, технологийг зөвхөн гадаад орнуудаас оруулж ирэх боломжтой.
2. Мөн өндөр чанартай хэрэглээний барааг гадаад орнуудаас оруулж ирэх боломжтой.
3. Японы цахилгаан бараа, автомашин эсвэл Герман гутал, Франц үнэртэй ус хэрэглэгчдийн сайн сайхан аж байдалд нөлөөлнө.
4. Халуун орноос жимс, кофе болон бусад тансаг барааг импортлоогүй бол тэдгээрийн талаар бид ерөөс мэдэхгүй байх байсан.

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ ГЭДЭГТ ЙОУГ ОЙЛГОХ ВЭ?



Тулгуур ойлголт

Экспорт, импортын зөрүүг гадаад худалдааны тэнцэл гэнэ. Экспорт, импортын нийлбэрийг гадаад худалдааны барааны нийт эргэлт гэнэ.

Бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогоос түүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан зардлыг хасаж үйлдвэрлэлийн ашиг, алдагдлын хэмжээг тодорхойлдгийг бид мэднэ. Гадаад худалдааны ашиг, алдагдлыг үүний нэгэн адил тооцно. Бараа, үйлчилгээг гадаадад худалдаа буюу экспортоос орлого орно. Харин импортоор оруулж ирж буй барааг авахад зардал гардаг учраас импорт нь зардлыг илэрхийлнэ.

Гадаад худалдааны орлогоос (экспорт) гадаад худалдааны зардлыг (импорт) хасаж гадаад худалдааны ашиг, алдагдлыг тодорхойлно. Экспортын орлого импортын зардлаас давж байвал өөрөөр хэлбэл, оруулж ирснээсээ ихийг гаргавал гадаад худалдааны тэнцэл нэмэх тэмдэгтэй буюу гадаад худалдаа ашигтай, харин эсрэг тохиолдолд хасах угтатай болж гадаад худалдаа алдагдалд орно.



Үйл ажиллагаа 4.8. Гадаад худалдааны нийт бараа эргэлт болон гадаад худалдааны тэнцилийг хүснэгтэд тодорхойлж асуултад хариулна уу.

№	Монгол улсын гадаад худалдаа, сая ам.доллр.						
	Үзүүлэлт	2007	2008	2010	2012	2014	2016
1	Нийт эргэлт	?	?	?	?	?	?
2	Нийт экспорт	1947.5	2534.5	2908.5	4384.7	5774.3	4916.3
3	Нийт импорт	2061.8	3244.5	3200.1	6738.4	5236.7	3358.1
4	Гадаад худалдааны +ашиг (- алдагдал)	?	?	?	?	?	?

- a. Гадаад худалдааны нийт бараа эргэлт гэж юуг ойлгох вэ? Түүний хэмжээг хэрхэн тодорхойлж байна вэ?
- b. Гадаад худалдааны ашгийн хэмжээг (алдагдлын хэмжээг) хэрхэн тодорхойлж байна вэ?
- c. Өмнөх ангиудад судалсан нийгэм, эдийн засгийн үзэгдлийн динамик хандлагад шинжилгээ хийдэг аргачлалыг ашиглан сүүлийн 6 жилийн байдлаарх Монгол улсын гадаад худалдааны дараах динамик үзүүлэлтүүдийг тооцож дүгнэлт хийнэ үү. Үүнд:
 - Нийт экспорт, импорт, нийт бараа эргэлтийн абсолют өөрчлөлт
 - Хэлхээ ба суурь өсөлтийн хурд, цэвэр өсөлтийн хурд, жилийн дундаж өсөлтийн хурд (Суурь өсөлтийн хурдыг тооцоходоо 2007 оныг суурь он болгон аваарай)
- d. Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтийн өөрчлөлтөд экспорт, импортын аль нь илүү хүчтэй нөлөө үзүүлж байна вэ? Үүний шалтгаан нь юу вэ?



Үйл ажиллагаа 4.9. Дараах хүснэгтэд дурдсан гадаад худалдааны экспорт, импортын зэрэг болон сөрөг талыг эргэцүүлэн үндэслэл нь юу байж болохыг тайлбарлаарай.

Гадаад худалдаа нь түүнд оролцогдын хувьд бараг бүгдэд нь ашигтай мэт байдаг ч үнэн хэрэгтээ улс орнууд олон улсын худалдаанаас хожсон нь ч бий, хожигдсон нь ч бий.

	Эерэг тал	Сөрөг тал
Экспортын хувьд	“Бараагаа экспортолж байгаа орон болон тэнд ажиллагсад экспортын өсөлтөөс хожно” гэсний үндэслэл нь юу вэ?	“Барааг экспортолсноор дотоодод тухайн барааны хомсдол үүсэж улмаар хэрэглэгчид хохирч болно” гэсний үндэслэл нь юу вэ?
Импортын хувьд	“Импорт нэмэгдсэнээр эх орны барааг бодвол арай хямд бөгөөд чанарын хувьд илүү байж болох импортын барааг хэрэглэх боломжтой болдог учраас хэрэглэгчид болон компаниуд хожиж болно” гэсний үндэслэл нь юу вэ?	“Импорт нэмэгдсэнээр дотоодын зах зээлд түүнтэй ижил төрлийн бараа үйлдвэрлэж байгаа эх орны үйлдвэрлэгчид хохирдог. Өөрөөр хэлбэл, дотоодын үйлдвэрлэгчдийг гадаадын үйлдвэрлэгчид шахаж эхэлнэ” гэсний үндэслэл нь юу вэ?

ГАДААД ХУДАЛДААГ ЯМАР БОДЛОГООР ЗОХИЦУУЛДАГ ВЭ?

Протекционист буюу гадаад худалдааны хамгаалах бодлогын зорилго юу вэ?

Аж үйлдвэр нь өрсөлдөх чадвараар сул, хөгжих байгаа улс орнууд гадаад худалдааны хамгаалах бодлогыг (протекционост бодлого) онцгой чухалд үздэг. Энэ бодлого нь гадаадын өрсөлдөөнийг дааж чадахааргүй, дөнгөх хөл дээрээ босож байгаа эдийн засгийн шинэхэн салбаруудыг хамгаалахад зайлшгүй хэрэгтэй юм.

Импортын бараанд тавигдах хамгийн чухал шаардлага нь тэдгээрийн чанар, хэрэглээний шинж чанар юм. Импортын бараа нь чанарын хувьд давуу байж чадаж байгаа бол бага зэргийн үнэтэй байсан ч эх орны ижилт төрлийн барааг шахаж чадна. Энэ дарамтаас дотоодын үйлдвэрлэлийг хамгаалахын тулд гадаад худалдааны саад болох татвар болон хязгаарлалтуудыг байнга хэрэглэдэг байна. Үүний тулд:

- Гаднаас оруулж ирж байгаа бараанд ногдуулах гаалийн татварыг нэмэгдүүлж болно. Уг татвар нь импортын барааны үнэ дээр нэмж тусгагддаг учраас импортын барааны өрсөлдөх чадварыг сулруулдаг.
- Тодорхой төрлийн барааны импортод гаалийн хязгаарлалт буюу квот тогтооно. Жишээ нь, тухайн улс орнууд жилд оруулж ирэх барааны тоо хэмжээг 20 мянган ширхэгээс эсвэл, 100,0 сая төгрөгөөс хэтрүүлэхгүй байх гэх мэт. Импортын барааг үйлдвэрлэж байгаа орны үнээс доогуур үнээр худалддаг демпингтэй тэмцэхэд импортын татварыг хэрэглэх нь нэлээд зохимжтой юм. Демпинг нь үйлдвэрлэгчид гадаад орнуудын шинэ зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж дараа нь үнээс өсгөх зорилготой түр зуурын арга хэмжээ юм.

Үүний эсрэгээр тодорхой төрлийн барааны импортод гаалийн хөнгөлөлт үзүүлж болно. Үүнд тухайн улсын техник, технологийн хөгжилд зайлшгүй шаардлагатай бөгөөд үйлдвэрлэлийн зардалд өндөр хувь эзэлдэг бараа хамаарна.

Үнэд хяналт тавьсаар байгаа зарим орнуудад протекционист бодлогын эсрэг гэж хэлж болохоор импортыг бус харин экспортыг мөн тийм хэмжээний татвар болон хязгаарлалт тогтоо замаар барьж байх бодлого хэрэгжүүлэх нь бий. Үүний гол санаа нь дотооддо барааны хомдолтой байгаа улс орнууд дотоодын хэрэглэгчдийг гадаадын барааны хэрэглээнд хэт “хошуурахгүй” байх, импортыг хязгаарлахад оршино.

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БОДЛОГО ЯМАР ОНЦЛОГТОЙ ВЭ?

Энэ нь протекционист бодлогын эсрэг бодлого юм. Чөлөөт худалдааны бодлого нь гадаад худалдаанд төр оролцох ёсгүй, тэр нь чөлөөт зах зээлийн жамаар тухайлбал, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, өрсөлдөөний хуулиар хөгжих ёстой гэсэн зарчмыг баримталдаг учраас татварыг бууруулах, бусад хязгаарлалтуудыг үгүй болгоход чиглэгддэг. Чөлөөт худалдааны бодлого нь улс орны үйлдвэрлэгчдийн хоорондын



Тулгуур ойлголт

Бусад улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогцыг **гадаад худалдааны бодлого** гэж нэрлэнэ. Гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх арга, механизмууд нь гаалийн татвар, гаалийн хөнгөлөлт, гаалийн хязгаарлалт болно

өрсөлдөөнийг тэтгэдэг гэж үздэг. Гэвч бүрэн чөлөөт худалдаа гэж амьдрал дээр бараг байдаггүй. Улс орон бүр хөгжлийнхөө онцлогийг харгалзан чөлөөт худалдааг зохих хязгаарлалттайгаар хэрэгжүүлдэг.

Барааг гадаадаас импортлохын тулд бидэнд гадаадын валют хэрэгтэй, үүнийг эх орны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг экспортлох замаар олж авна.

Бусад орны валютын хэрэгцээг хангаж байхын тулд аль ч оронд валютын зах зээл бий. Тэнд нэг хэсэг валютын өөр нэг хэсэг валюттай харьцах ханш тогтох байдаг. Үндэсний валютын ханш өсөхөд дотоодын хэрэглэгчдийн хувьд импортын бараа хямдарч, экспортлогчид өөрийн бүтээгдэхүүнийг борлуулахад хүндрэл үснэ. Үндэсний валютын ханш буурахад экспортын бараа илүү их өрсөлдөх чадвартай болж, харин эх орны хэрэглэгчдийн хувьд импортын бараа үнэтэй болно. Аль ч улсын Төв банкнаас зах зээлд валютын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар (валютын интервенц) валютын ханшийг зохицуулж байдаг.



Үйл ажиллагаа 4.10. Дараах хүснэгтэд ажиллаж асуултад хариулаарай.

- Хүснэгтэд дурдсан гадаад худалдааны хязгаарлах бодлого явуулах шалтгаануудыг өөрийн улс орны нөхцөлтэй холбон тайлбарлаарай.

№	Хязгаарлах бодлого явуулах шалтгаанууд	Тайлбар
1	Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах	
2	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	
3	Дотоодын хөгжиж буй салбаруудыг дэмжих	
4	Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх	
5	Гаалийн татварын орлогоор улсын төсвийг нэмэгдүүлэх	
6	Олон улсын зах зээлийн эрсдэлээс хамгаалах	

- Манай орны үйлдвэрлэлийн аль салбарт гадаад худалдааны хамгаалах бодлого хэрэгтэй вэ? Түүний муу тал нь юу байж болох вэ?
- Манай төрөөс ямар бүтээгдэхүүн, үйлчилгээнд гадаад худалдааны протекционист бодлогыг хэрэгжүүлэх нь зөв гэж бодож байна вэ? Яагаад?



Гэртээ хийгээрэй.

- Дараах хүснэгтэд ашиглан Монгол улсын гадаад худалдааны өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тодорхойлж, түүний өнөөгийн бүтцийг сайжруулах чиглэлээрх даалгавруудыг гүйцэтгээрэй.

Шинжилгээний дараалал:

- Монгол улсын гадаад худалдааны өнөөгийн байдлыг голлох улсуудаар судалж тайлбар, дүгнэлт хийнэ үү.
- Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийг голлох болон бусад улсуудаар тодорхойлно уу
- Гадаад худалдааны нийт бараа эргэлтэд голлох орнуудын эзлэх хувь хэмжээг он тус бүрээр тодорхойлж секторон диаграммаар илэрхийлнэ үү.
- Гадаад худалдааны нийт бараа эргэлтэд голлох улс орнуудын эзлэх хувь хэмжээнд гарч байгаа өөрчлөлтүүдийг тооцож тайлбар хийнэ үү.
- Гадаад худалдааны нийт бараа эргэлтийг баганан диаграммаар илэрхийлж тайлбарлаарай.

№	Улсууд	Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт, голлох улсаар, сая ам, доллар.			
		2010 он		2017 он	
		Мөнгөн дүн	%	Мөнгөн дүн	%
1	АНУ	164.9	?	149.7	?
2	ОХУ	1129.4	?	936.2	?
3	БНХАУ	3442,7	?	4962.8	?
4	Швейцарь	7.1	?	240.7	?
5	Их Британи	87.3	?	585.4	?
6	Япон	199.2	?	344.7	?
7	ХБНГУ	109.3	?	163.7	?
	Бүгд, голлох улсаар	?	?	?	?
	Бүгд, бусад орноор	?	?	?	?
	Гадаад худалдааны нийт эргэлт	6108.6	100.0	8274.5	100.0

2. Дараах хүснэгтүүдийг ашиглан Монгол улсын гадаад худалдааны экспорт, импортын өнөөгийн байдлыг голлох улсуудаар шинжилж тайлбар, дүгнэлт хийнэ үү. Үүнд:
- Монгол улсын гадаад худалдааны экспорт, импортын хэмжээг голлох болон бусад улсуудаар тодорхойлно уу.
 - Монгол улсын гадаад худалдааны экспортод, импортод голлох улс орнуудын эзлэх хувь хэмжээг он тус бүрээр дээр тодорхойлж баганан (бүтцийн) диаграммаар илэрхийлнэ үү.
 - Гадаад худалдааны экспорт, импортод голлох улс орнуудын эзлэх хувь хэмжээнд гарч байгаа өөрчлөлтүүдийг тооцож тайлбар хийнэ үү.
 - Гадаад худалдааны экспорт, импортыг баганан диаграммар илэрхийлж тайлбар хийнэ үү.
 - Монгол улсын гадаад худалдааны экспорт, импортын талаарх мэдээллийг харьцуулан шинжилж манай улсын гадаад худалдааны өнөөгийн бүтцийг сайжруулах чиглэлээр санал боловсруулна уу.

№	Улсууд	Монгол улсын гадаад худалдааны экспорт, голлох улсаар, сая ам.доллар			
		2010 он		2017 он	
		Мөнгөн дүн	%	Мөнгөн дүн	%
1	АНУ	6.0	?	10.5	?
2	ОХУ	82.7	?	55.8	?
3	БНХАУ	2466.4	?	3901.6	?
4	Швейцарь	2.9	?	230.7	?
5	Их Британи	67.4	?	557.2	?
6	Япон	2.7	?	14.0	?
7	ХБНГУ	22.1	?	43.4	?
8	Итали	31.8	?	33.6	?
9	Сингапур	2.5	?	16.9	?
	Бүгд, голлох улсаар	?	?	?	?
	Бүгд, бусад орноор	?	?	?	?
	Нийт экспорт	2908.5	100.0	4916.3	100.0

№	Улсууд	Монгол улсын гадаад худалдааны импорт, голлох улсаар, сая ам.доллар			
		2010 он		2018 он	
		Мөнгөн дүн	%	Мөнгөн дүн	%
1	АНУ	158,9	?	139,2	?
2	ОХУ	1046,7	?	880,4	?
3	БНХАУ	976,2	?	1061,2	?
4	Япон	196,5	?	330,6	?
5	ХБНГУ	87,2	?	120,3	?
6	БНСУ	181,8	?	197,9	?
	Бусад	?	?	?	?
	Бүгд	3200,1	100,0	3358,1	100,0


3. Эдийн засгийн дараах ойлголтуудыг агуулгатай нь зөв холбоорой.

Үндсэн ойлголт		Aгуулга
a	Валютын ханш	1 Валютын ханш нь гадаадын мөнгөний эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдож байдаг бөгөөд ханш нь чөлөөтэй ёсёж, буурч байж болно
б	Валютын хөвөгч ханш	2 Төв банк өөрийн валютын нөөцөөс зардал гарган валютыг худалдан авна.
в	Валютын тогтмол ханш	3 Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ.
г	Валютын девальваци	4 Төв банкнаас валютын арилжааны ханшийг өсгөх
д	Валютын интервенц	5 Чөлөөтэй ёсёж буурдаггүй валютын ханш
е	Валютын ревальваци	6 Валютын тогтсон өртгийг төрөөс бууруулах

4. Гадаад худалдааны дараах үйл явцыг үр дагавартай нь зөв холбоорой.

Үндсэн ойлголт		Aгуулга
1. Улс орны экспорт нь	1	Гадаад валютын эрэлтийг бий болгоно.
2. Улс орны импорт нь	2	Гадаад валютын нийлүүлэлтийг бий болгоно.
	3	Хилийн чандад тухайн орны үндэсний валютын эрэлтийг бий болгоно.
	4	Хилийн чанадад тухайн орны үндэсний валютын нийлүүлэлтийг бий болгоно.

5. Гадаад худалдааны дараах онолуудын гол үзэл баримтлалыг товч тэмдэглээрэй.

Туйлын давуу талын онол	Харьцангуй давуу талын онол
	
Адам Смит	Дэвид Рикардо

СЭДЭВ 4.4 ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН ГЭДЭГТ ЮУГ ОЙЛГОХ ВЭ?

Бид бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд газар, хөдөлмөр, капитал зэрэг хүчин зүйлс зайлшгүй хэрэгтэйг мэдэх билээ. Тэгвэл тухайн улсын хилээр бараа, үйлчилгээнээс гадна үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг тухайлбал, хөдөлмөр болон капиталыг (газраас бусад) гаргаж болно.

 Үйл ажиллагаа 4.11. Дараах мэдээлэлд дүн шинжилгээ хийж дор дурдсан асуултад хариулаарай.	
Хөдөлмөр экспортолдог орнууд	Капитал импортолдог орнууд
Хөдөлмөр экспортолдог орнуудад голдуу нэг хүнд ногдох орлогын түвшнээр доогуур эсвэл ажилгүйдлийн түвшин өндөр орнууд орно.	Капиталыг импортолдог орнуудад үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийн түвшнээр дорой, байгалийн баялаг ихтэй, голдуу буурай хөгжилтэй орнууд орно.
Хөдөлмөрийн экспорт Монголд	
Монгол улсын нийт 50,0 орчим мянган иргэн Солонгос, АНУ, Герман, Швейцарь зэрэг олон улсад цагаачлан хөдөлмөр эрхэлж байна.	
Капиталын импорт Монголд	
Монголын эдийн засагт оруулж буй гадаадын хөрөнгө оруулалтын үндсэн хэлбэр нь хамтарсан үйлдвэрүүд барьж байгуулах явдал юм. Гадаадын хөрөнгө оруулагчид экспортын чадавх өндөртэй уул уурхай, хурдан есөлттэй байгаа харилцаа холбооны салбар болон санхүү-зээл, худалдаа, үйлчилгээний салбаруудад хөрөнгө оруулахыг илүүд үзэж байна.	
Монгол улсад 1990 оноос хойш гадаадын 112 орны 13 мянга гаруй аж ахуйн нэгж, 16 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийжээ. Үүний 72.5 хувь нь уул уурхай, геологи, газрын тосны салбарт, 17.8 хувь нь худалдаа, нийтийн хоолны салбарт ногдож байна. Эдгээр нь дэлхийд ашиг, орлогоороо тэргүүлэгч салбарууд юм. Монгол улсын ДНБ-ий 20 хувь, экспортын 80 хувийг уул уурхайн салбар эзэлж байна. Монгол улс зөвхөн ашигт малтмал, гадаадын хөрөнгө оруулалтаас хэт хамаарсан эдийн засгийн бүтэцтэй болжээ.	
<ol style="list-style-type: none"> Хөгжингүй орнууд хөдөлмөр болон капиталын алийг нь импортолж алийг нь экспортолж байна вэ? Буурай хөгжилтэй орнууд хөдөлмөр болон капиталын алийг нь импортолж, алийг нь экспортолж байна? Манай орны хувьд хөдөлмөр болон капиталын алийг нь экспортолж, алийг нь импортолж байна вэ? Эдгээрийн шалтгаан нь ю байж болох вэ? 	

Монгол улсын хувьд	
<ul style="list-style-type: none"> Монгол улс нэг хүнд ногдох УНО-ын түвшнээр дунджаас доогуур орлоготой орны ангилалд багтаж байна. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан судалгаагаар манай улсын өрсөлдөх чадвар 138 орноос 102-т бичигдэж байна. Монголд хөдөлмөрийн насны 10 хүн тутмын 1 нь ажилгүй байна. 	<p>Монгол улс ашигт малтмалын нөөцөөр дэлхийд эхний 10-т жагсдаг бөгөөд манай оронд 80 төрлийн ашигт малтмалын 1170 орд, 8 мянга гаруй илрэл бүртгэгдсэн байдаг. Үүнд алтны 1619, мөнгөний 227 мянга, зэсийн 36.3 сая, төмрийн хүдрийн 660 сая, цайрын 5.9 сая, нефтийн 250 сая орчим тонн нөөц батлагдаад байна. Мөн нүүрсний 175 тэрбум тонн таамаг нөөцтэй.</p>
<ol style="list-style-type: none"> Бид хэрэглэгч орноос үйлдвэрлэгч орон болохын тулд өнөөдөр юу хийх ёстой, маргаашийн зорилт юу байж болох талаар хэлэлцүүлэг хийж дүгнэлт гаргана уу. Хенри Боклийн хэлсэн “Хуучин цагт байгаль нь өгөөжтэй орнууд хамгийн баян байлаа, өнөө үед хүн нь илүү бүтээлч улс орнууд хамгаас баян ажээ” гэсэн үгийн утгыг тайлбарлана уу. 	

Олон улс оронд тухайн улс орны иргэдэд тааламжтай бус санагддаг ажилд гадаадын ажилчдыг ажиллуулдаг. Герман дахь туркууд, Франц дахь арабууд, Америк дахь мексикчүүд, Солонгос дахь монголчууд гэх мэт. Энэ үед хүмүүс хэл, соёл, арьс өнгөний ялгаатай орчинд ажиллана, зарим үед нутгийн иргэдийн дургүйцлийг хүргэдэг гээд хөдөлмөрийн цагаачлал нь тодорхой хэмжээний бэрхшээлийг дагуулна.

Капитал нь үйлдвэрлэлийн хамгийн хөдөлгөөнтэй хүчин зүйл бөгөөд түүнийг экспортлох, импортлоход бэрхшээлгүй. Үйлдвэрлэлийн хөгжлийн явцад барааг экспортолдог байсан бол эдүгээ капиталын экспорт хүчээ авч байна. Барааг гадагш гаргаснаар нэг л удаа ашиг олох боломжтой байдаг бол капиталыг гаргаснаар олон дахин ашиг хүртэх боломж бүрддэг. Эхлээд өндөр хөгжилтэй улс орнууд буурай хөгжилтэй улсууд руу капиталыг гаргаж байсан бол капиталын хөдөлгөөн нь эдүгээ бүх улс орныг хамрах хандлагатай болжээ.

КАПИТАЛЫН ЭКСПОРТЫН ҮНДСЭН ХЭЛБЭР НЬ ЮУ ВЭ? ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ГЭДЭГТ ЙОУГ ОЙЛГОХ ВЭ?



Тулгуур ойлголт

Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрийн газар байгуулах эсвэл худалдан авч болно. Үүнийг **гадаадын шууд хөрөнгө оруулалт** гэнэ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) болон эдийн засгийн өсөлт хоёрын хооронд эерэг хамааралтай гэж үздэг боловч хөгжингүй орнуудын хувьд эерэг хамааралтай бол хөгжиж буй орнуудын хувьд ерөнхийдөө эерэг хамааралтай, зарим судлаачид ямар ч нөлөөгүй гэж судалгаагаар тогтоосон байдаг. Зарим эрдэмтэд гадаадын шууд хөрөнгө оруулалт богино хугацаанд дотоодын пүүс, компаниудын үйл ажиллагаанд зах зээлийн хэмжээг нь багасган улмаар бүрэн хүчин чадлаараа ажиллахад нь сэргэөр нөлөөлдөг, харин урт хугацаанд эерэг нөлөө үзүүлж болох юм гэсэн дүгнэлтэд хүрчээ. Гэхдээ, энэ нь дотоодын болон гадаадын компаниудын ашиглаж буй технологийн зөрүүтэй холбоотой юм байна. Хэрэв, дотоодын компани гадаадын технологийг эзэмших чадвар сайн буюу технологийн зөрүү бага байх тусам эерэг нөлөө нь илүү

оруулалт богино хугацаанд дотоодын пүүс, компаниудын үйл ажиллагаанд зах зээлийн хэмжээг нь багасган улмаар бүрэн хүчин чадлаараа ажиллахад нь сэргэөр нөлөөлдөг, харин урт хугацаанд эерэг нөлөө үзүүлж болох юм гэсэн дүгнэлтэд хүрчээ. Гэхдээ, энэ нь дотоодын болон гадаадын компаниудын ашиглаж буй технологийн зөрүүтэй холбоотой юм байна. Хэрэв, дотоодын компани гадаадын технологийг эзэмших чадвар сайн буюу технологийн зөрүү бага байх тусам эерэг нөлөө нь илүү

байдаг бол зөрүү хэт их бол эерэг нөлөөг олж харахад хүндрэлтэй байдаг гэжээ. Манай судлаачид ДНБ-ий өсөлтийн 10 орчим хувь нь ГШХО-тай холбоотой гэсэн дүгнэлт хийжээ.

Шууд хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийг хянах боломж олгодог хөрөнгө оруулалтын хэлбэр бөгөөд тэр нь хувьцаат компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авах замаар хэрэгждэг. Ер нь хувьцаат компанийн нийт хувьцааны 10-15%-ийг “гартaa оруулсан” байхад л хянах бололцоо бүрддэг гэж үздэг. Компани, үйлдвэрийг байгуулсан улс орондоо үйлдвэрлэл явуулж дараа нь бүтээгдэхүүнээ зөвхөн тухайн орноос гадна хаана ашигтай байна тэнд зарж болно.

Капиталын шилжилт хөдөлгөөн нь оруулж, гаргаж байгаа аль аль талдаа ашигтай байх зарчмитай ч капиталыг экспортлогч болон импортлогч талуудын хооронд ашиг сонирхлын зөрчил байнга үүсэж байдаг. Тухайлбал, экспортлогч нь оруулсан капиталаасаа олох ашгийг хамгийн их болгохыг зорьдог бол импортлогч нь авч үлдэх үр ашгаа мөн л хамгийн их байлгахыг эрмэлзэнэ. Түүгээр зогсохгүй капитал экспортлогч талаас эдийн засгийн болон улс төрийн элдэв төрлийн дарамт учруулах боломжтой тул түүнд хожих магадлал нь илүү өндөр байдаг.



Үйл ажиллагаа 4.12. Та бүхэн дараах мэдээлэлд дүн шинжилгээ хийж асуултад хариулаарай.

ГШХО нь эзэндээ ямар ашигтай вэ?

- 1. Үйлдвэрлэлийн зардлыг хэмнэх.** Хямд ажиллах хүч болон түүхий эд бүхий улс оруууд руу капиталыг экспортолсноор тэд ашиг, орлогоо илүү нэмэгдүүлэх боломжтой болно. Зөвхөн манайд төдийгүй бүх дэлхийн томоохон дэлгүүрүүдэд зарагдаж байгаа алдартай фирмүүдийн бараг бүх хувцсыг тухайн орондоо бус бусад орууладад үйлдвэрлэж байна. Энэ нь мөн тээврийн зардлыг хэмнэнэ.
- 2. Үйлдвэр байгуулж байгаа орны зах зээлд өөрийн байр суурийг бататгах, зах зээлээ өргөжүүлэх.** Жишээ нь, Англи дахь Японы үйлдвэрийг удирдаж байгаа хүмүүс Английн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг Японд байгаагаас илүү сайн мэдэх боломжтой. Иймээс англичуудын таашаалд нийцүүлэн тэдэнд зориулсан шинэ загварын автомашиныг үйлдвэрлэх зэргээр тэдэнд илүү их нөлөөлөх боломжтой.
- 3. Зарим орууладад барааны импортод маш хүчтэй тавьдаг протекционист хязгаарлалтуудыг тойрч гарах.** Англид байгаа Японы үйлдвэрт үйлдвэрлэсэн автомашинд ямар нэгэн гаалийн татвар төлөхгүй. Энэ нь протекционизмийн бодлогын сул талыг батлах нэг жишээ юм.
 - а. Монгол руу чиглэсэн Хятад, Турк, Канад, Япон, Өмнөд Солонгосын хөрөнгө оруулагчдын идэвхжилгийг та бүхэн хэрхэн тайлбарлаж болох вэ? Хариултын хувилбаруудаас сонгож, үндэслэлийг тайлбарлаарай.
 - Үйлдвэрлэлээс олох ашгийн хэмжээгээ нэмэгдүүлэх
 - Бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зардлыг бууруулах
 - Үйлдвэрлэлийн зардлыг бууруулах
 - Шинэ зах зээл эзэмших
 - Тэргүүний технологи олж авах
 - Бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд илүү ойртуулах
- б. Манай оронд хэрэглэж байгаа импортын хязгаарлалт болон татвар, хураамж нь тус улсуудаас орж ирэх шууд хөрөнгө оруулалтын хэмжээнд хэрхэн нөлөөлж болох вэ? Та бүхэн үйлдвэрлэлийн аль салбарын ямар бүтээгдэхүүнд гадаад худалдааны ямар бодлого баримтлах хэрэгтэй гэж бодож байна вэ?

**Үйл ажиллагаа 4.13. Багаар ажиллаарай.**

Дэд бүтцийн хөгжил, аж үйлдвэржсэн байдал, компаниудын нягтрал зэрэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалтад эерэгээр нөлөөлж байхад улс төрийн эрсдэл, эдийн засгийн тогтвортой байдал зэрэг нь гадаадын хөрөнгө оруулалтад саад тогтор болдог байна. Дэлхийн банк Япон улсын 173 үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагч нарын дунд хийсэн судалгаагаар гадаадын шууд хөрөнгө оруулалтад дараах хүчин зүйлсийг хамгийн чухал нөлөөтэй гэж үзжээ. Үүнд:

- Зах зээлийн хэмжээ (гадаадын шууд хөрөнгө оруулалтын хамгийн хүчтэй, эерэг тодорхойлогч)
- Хөдөлмөрийн хөлс
- Тухайн орны гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаарх бодлого

Үйлдвэрийн газраа гадаад улсад байгуулах шийдвэр гаргах гэж байгаа хүн яагаад эдгээр хүчин зүйлсийг хамгийн чухал гэж үзсэн бэ?

**Үйл ажиллагаа 4.14. Та бүхэн манай улсын ГШХО-ын 70,0 орчим хувийг эзэлж байгаа уул уурхайн салбар дахь ГШХО-ын талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж асуултад хариулаарай.****Уул уурхайн салбар дахь ГШХО нь түүнийг оруулж ирж буй улсдаа ямар үр дагавартай вэ?**

Зөрөг үр дагавар	Сөрөг үр дагавар
<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбар Монгол улсын ДНБ-ий 20 хувь, экспортын 80 хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн өсөлтийн чухал хүчин зүйл болж байна. • Улсын төсвийн орлогын ихээхэн хувийг уул уурхайн салбараас бүрдүүлдэг. Энэ нь төсвийн байгууллагын санхүү, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх төрийн үүрэгт чухал хувь нэмэртэй • Гадаадын уул уурхайн компанийд манай улсын олон мянган хүн ажил эрхэлж байна. • Дотоодын үндэсний үйлдвэрлэгчид гаднын компанийн ашиглаж буй технологийг хуулах замаар бүтээмжийг өсгөх боломжтой • Тухайн орны дотоодод өрсөлдөөний дарамт өсөж дотоодын үндэсний үйлдвэрлэгчид өөрийн эзэмшиж байгаа технологи, нөөцөө илүү үр ашигтай зарцуулах эсвэл илүү дэвшилтэй технологи хайх зайлшгүй шаардлага бий болдог. 	<ul style="list-style-type: none"> • Монгол улс зөвхөн ашигт малтмал, гадаадын хөрөнгө оруулалтаас хэт хамаарсан эдийн засгийн бүтэцтэй, үндэсний үйлдвэрлэлийн хөгжлөөр дорой, нэг ёсны хэрэглэгч орон болон хувирч байна. • Уул уурхайгаас хамаарсан эдийн засгийн өсөлт иргэдийн амьжиргаанд нөлөө үзүүлэхгүй байна. • Байгаль орчинд сэргэөр нөлөөлж бэлчээрийн талбайг хомсдуулж уламжлалт МАА-н салбарын хөгжлийг saatuuлагч хүчин зүйл болж байна. • Олон улсын корпорациудын сонирхол нь үндсэндээ боловсруулах аж үйлдвэрүүдэд капитал хуримтлуулахдаа бус хөгжиж байгаа орнуудын ашигт малтмалыг боловсруулахад чиглэгддэг учраас гаднын компаниуд эх орны үйлдвэрлэгчдийн өрсөлдөгч болж дотоодын ижил, төстэй уул уурхайн үйлдвэрлэлийг шахаж байна. • Ажилчдын цалин бусад орнуудтай харьцуулахад доогуур байгаа нь ажиллах хүчиний мөлжлэгийн шинжтэй байна.

- | | |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ul style="list-style-type: none"> Тухайн улсын ажиллах хүчин шинэ техник, арга барилд суралцахад нөлөөлнө. Тэд хожим үндэсний компанид ажилд орох эсвэл өөрсдийн бизнесээ эхлэх зэргээр ур чадвараа дамжуулна. Гадаадын үйлдвэрүүдэд дотоодын компаниуд зарим нэг бүтээгдэхүүнийг нийлүүлэх, янз бүрийн үйлчилгээ үзүүлэх зэргээр орлогоо нэмэгдүүлэх, цашид хөгжих боломж бий болно. Гаднын компани дотоодын нийлүүлэгчдээс найдвартай, чанарын өндөр түвшинд хийгдсэн бүтээгдэхүүнийг шаардах ба энэ нь тэдэнд бүтээгдэхүүнээ сайжруулах эсвэл шинээр санаачлах шаардлага гарна. Үйлдвэрлэлийн орчин үеийн удирдлага, зохион байгуулалтын аргад суралцана. | <ul style="list-style-type: none"> Гадаадын хөрөнгө оруулагчид байгалийн нөхөгддөггүй баялагт тооцогдох ашигт малтмалыг олборлохын төлөө хэт хошуурч байгаа нь урт хугацаанд баялагийг үр ашигтай ашиглах боломжийг угүй хийж байна. Гадаадын зарим үйлдвэрийн газрууд бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд бус, зөвхөн гадаадад гаргахад зориулж үйлдвэрлэдэг нь дотоодын хэрэглэгчид хямд бараагаар үйлчлүүлэх боломжкоо алддаг Гадаадын зарим үйлдвэрийн газрууд тухайн орноос нийлүүлэх боломжтой, тухайн орны эдийн засгийг дэмжих боломжтой байсан үйлдвэрлэлийн түүхий эд болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг орон нутгийн үйлдвэрүүдээс бус гадаадаас оруулж ирж байгаа нь үндэсний энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шахаж байна. |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

- Хүснэгт дэх-ийн оронд өөрийн үзэл бодлоор нэмж хариулаарай.
- Уул уурхайн салбар дахь ГШХО-тай холбоотой гарч болох ээрэг болон сөрөг дагаврыг хүлээн зөвшөөрч байна уу? Таны бодлоор аль тал нь “илүү жин” татаж байна вэ? Асуудлыг шийдвэрлэхийн тулд, бидэнд ямар зохицуулалт хэрэгтэй вэ?
- Та бүхний амьдарч байгаа орон нутаг (аймаг, нийслэл, сум, дүүрэг)-т ГШХО-тай ямар нэртэй, ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниуд үйл ажиллагаа явуулж байна вэ? Тэд хот, дүүрэг, орон нутгийн хөгжилд ямар ээрэг болон сөрөг нөлөө үзүүлж байгааг эргэцүүлэн бодож дүгнэлт хийгээрэй.

Сүүлийн 10-15 жилийн дотор хөгжиж байгаа орнуудад гадаадаас оруулж ирэх хөрөнгийн хэмжээ эрс өсөж байна. Тэдгээрийн дэлхийн импортод эзлэх хувь 23-40 хүртэл хувиар, шууд хөрөнгө оруулалт бараг 6 дахин өсөв. Дэлхийн улс орнууд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж тэдний оруулж буй түүхий эд болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг хэд, хэдэн жилээр импортын татвараас чөлөөлөх болон бусад хөнгөлөлтүүд үзүүлдэг. Гадаадын үйлдвэрүүдийг байршуулахын тулд зориуд эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулдаг бөгөөд тэнд байгаа үйлдвэрийн газруудад гадаад худалдааны хязгаарлалтуудыг хэрэглэдэггүй. Учир нь орон нутгийн компаниудад олон улсын хүчтэй том корпорациудад байдаг шиг үйлдвэр барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх хөрөнгө тэр бүр байдаггүй.

Монгол улс эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэгдсэн гадаадын капиталыг бүхий л хэлбэрээр ашиглахыг эрмэлзэж байна. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд гадаадаас нэг тэрбум гаруй долларын хөнгөлөлттэй зээл, мөн тийм хэмжээний

буцалтгүй тусламж авчээ. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татварын хөнгөлөлтөөр дэмжиж, үйл ажиллагааных нь тогтвортой байдлыг хангах зорилгоор томоохон хөрөнгө оруулагч нартай тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд уул уурхайн томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж нээгдэж байна. Гадаадын хөрөнгө оруулалт нь зэрэг ба сөрөг талтай байна. Тухайн тохиолдолд аль нь чухал гэдгийг улс бүрийн Засгийн газар шийдэх ёстай. Иймд улс төрийн бодлого чухал үүрэгтэй. Эдүгээ даяарчлал, олон улсын хөдөлмөрийн хуваарь улам гүнзгийрснээр төрөлжилт, хоршилт, түүнчлэн үндэстэн дамнасан корпорацуудын хөгжил зэрэг нь улс хоорондын капиталын хөдөлгөөнийг улам идэвхжүүлж байна.

Манай улсын ГШХО-ын хэмжээгээрээ уул, уурхайн салбарын дараа худалдаа, нийтийн хоолны салбар орно. Сүүлийн жилүүдэд нийтийн хоолны салбарт гадаадын хөрөнгө оруулагчид хүчтэй түрэн орж ирж байна. Ялангуяа томоохонд тооцогдох, орлого өндөртэй хэрэглэгчдэд зориулсан нийтийн хоолны газрууд голдуу гадаадын харьят эзэнтэй байдаг гэдгийг бид мэдэх билээ. Энэ нь тухайн салбарын ашиг орлогоос хамаардаг. Тодруулбал, материаллаг үйлдвэрлэлийн салбарт ашигт ажиллагааны түвшин 10-20 орчим хувь байдаг бол худалдаа, нийтийн хоолны салбарт энэ үзүүлэлт 60,0-70,0, түүнээс дээш хувьтай байдаг.

Хамгийн үнэлгээ сайтай хоолны үндсэн түүхий эд нь мах гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг. Тэгвэл, манай орон 3 сая гаруй хүн амтай, 1500,0 гаруй мянган km^2 уудам нутагтай, 66,0 сая толгой малтай, байгаль орчин нь экологийн хувьд харьцангуй цэвэр, түмэн зүйлийн ургамал, ногоо тарих бүрэн боломжтой билээ. Тэгвэл, бид яагаад гадаадынхантай өрсөлдөхүйц хэмжээнд дотоодын нийтийн хоолны салбараа хөгжүүлж болохгүй гэж? Иргэдийнхээ орлогыг дотооддоо үлдээж тэр их хэмжээний ашигийг өөрсдөө хүртэх боломжгүй ю? Бид хоолны нарийн технологийг эзэмших боломжгүй ю? Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээгээ дэмжихийн тулд бид юу хийх ёстай вэ? Ер нь гадаадын барааг худалдан авах нь тухайн оронд ажилгүйдлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болдог гэдэгтэй та санал нийлэх үү? Энэ нь ямар учиртай болохыг тайлбарлаарай.

АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТҮВШНИЙГ ЯЖ ТООЦДОГ ВЭ? ТҮҮНИЙ ҮНДСЭН САНАА ЮУ ВЭ?

Ашигт ажиллагааны түвшин нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх маш чухал үзүүлэлт юм. Түүнийг тодорхойлоходоо үйлдвэрлэлээс олох ашигийн хэмжээг, үйлдвэрлэлийн нийт зардал харьцуулж хувиар илэрхийлнэ. Үүнд:

$$\text{Ашигт ажиллагааны түвшин, \%} = \frac{\text{Ашигт ажиллагааны түвшин}}{\text{Үйлдвэрлэлийн зардал}} \times 100\%$$

Энэ үзүүлэлт нь тухайн үйлдвэрлэгч хэдэн төгрөгийн зардал гаргаж хэдэн төгрөгийн ашиг олж вэ гэдгийг илэрхийлнэ. Жишээ нь, ашигт ажиллагааны түвшин 20,0% тай тэнцүү бол үйлдвэрлэгч 100 төгрөгийн зардал гаргаад 20 төгрөгийн ашиг олжээ гэж тайлбарлана.



Гэртээ хийгээрэй.

- Та бүхэн ашигт ажиллагааны түвшнийг тооцдог аргыг ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй.

Багш нь Эрдэнээ, Солонго нарт А, Б гэсэн компанийн эдийн засгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, аль компани нь илүү үр дүнтэй ажиллаж байгааг тодорхойлох даалгавар өгчээ.

- Б компани А компаниас илүү их ашиг олж байгаа учраас илүү сайн ажилласан гэж Эрдэнээ хариулжээ.
- А компани Б компаниас илүү бага зардал гаргаж байгаа учраас А компани илүү сайн ажилласан гэж Солонгоо хариулжээ.

Багш эдгээр хариултуудыг зөв хэмээн үзэх үндэсгүй. Учир нь, хүчин чадлаар том компанийн хувьд зардал болоод ашгийн хэмжээ харьцангуй их бол жижиг компанийн хувьд зардал болоод ашгийн хэмжээ харьцангуй бага гарах нь ойлгомжтой. Иймээс үйлдвэрлэлийн зардал болон ашгийн абсолют үзүүлэлтээр тухайн компанийн үйл ажиллагааг дүгнэх нь учир дутагдалтай. Та бүхэн асуултад зөв хариулт өгнө үү.

	Эдийн засгийн үзүүлэлтүүд	Тэмдэглэгээ	А компани	Б компани
1	Үйлдвэрлэлийн нийт зардал, мян. төг.	$T C$	20 000.0	50 000.0
2	Үйлдвэрлэлээс олох ашгийн хэмжээ, сая төг.	π	10 000.0	15 000.0
3	Ашигт ажиллагааны түвшин,%	r	?	?

- Монгол дахь хөдөлмөрийн экспортын үр дагаврыг эерэг болон сөрөг талаас нь авч үзэж дүгнэлт хийгээрэй.

Монгол дахь хөдөлмөрийн экспортын үр дагавар

Эерэг үр дагавар	Сөрөг үр дагавар

ПОРТФЕЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЯМАР ОНЦЛОГТОЙ ВЭ?

Портфелийн хөрөнгө оруулалтыг гадаадын компанийг хянах зорилгоор бус харин үнэт цааснаас ногдол ашиг болон үнэт цаасны ханшны өсөлтөөс орлого олохын тулд хийдэг. Гэхдээ үнэт цаасны ханшны өсөлтөөс орлого олохыг илүү чухалд үзнэ. Бид өмнөх ангидаа хөрөнгийн бирж дээр хэрхэн “Тоглож” мөнгө олж болох тухай ярилцаж байсныг энд сэргээн санаад илүүдэхгүй.


Портфелийн хөрөнгө оруулалт нь компаниуд болон тухайн улсын хувьд дэлхий нийтийн хөрөнгийг ашиглах боломж олгодог учраас капитал импортолж байгаа орондоо маш ашигтай. Портфелийн хөрөнгө оруулалт нь урт хугацаанд, илүү найдвартай байж чадах хөрөнгө оруулалт бөгөөд шууд хөрөнгө оруулалттай харьцуулахад хөрвөх чадвар өндөр байдгаараа давуу талтай юм. Үнэт цаас худалдан авагч тодорхой нэгэн компанийн үнэт цаасны 10%-аас дээш хувийг эзэмшиж болохгүй юм.

Найдвартай, хангалттай өндөр орлого өгдөг гэдгээр нь төрийн үнэт цаасны зах зээлийг монгол дахь гадаадын портфелийн хөрөнгө оруулагчид сонирхдог. 1997 оны байдлаар гадаадын хөрөнгө оруулагчдад Засгийн Газрын богино хугацааны бондын 1/5 нь ногдож байгаа гэсэн мэдээ байна. Сүүлийн үед манай улсын уул уурхайн томоохон компаниуд гадаадын портфелийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор гадаад орнуудын хөрөнгийн биржүүд дээр хувьцаагаа зарж эхэлж байна.



Үйл ажиллагаа 4.15. Капиталын экспортын үндсэн хэлбэрүүд, тэдгээрийн агуулгыг дараах бүдүүвчээр илэрхийлээрэй.

Капиталын экспортын үндсэн хэлбэрүүд



ҮНДЭСТЭН ДАМНАСАН КОРПОРАЦ ЯМАР ОНЦЛОГТОЙ ВЭ?

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дунд үндэстэн дамнасан корпорацууд үүсэж дэлхийн хэмжээнд тархан байршдаг. Анхны ийм корпорацууд нь хөгжиж байгаа орнуудад байршсан АНУ, Английн компаниуд байжээ. Тэд бусдын үйлдвэрлэсэн эд ангийг цуглувулж угсардаг байжээ. Жишээ нь, АНУ-ын “Форд Моторс” компани эд анги угсардаг үйлдвэрээ ΘΑΒΗΥ, Филиппин, ΒΗΧΑΥ-ын Тайван, ХБНГУ зэрэг 18 улсад байгуулсныг энд дурдаж болно.



Тулгуур ойлголт

Хоёр болон түүнээс дээш улсад үйлдвэрлэл эсвэл үйлчилгээгээ явуулдаг салбартай корпорацыг **үндэстэн дамнасан корпорац** гэнэ.

Үндэстэн дамнасан корпорац нь янз бүрийн орнуудын давуу талыг ашиглан өөрийн хүрээнд олон улсын хөдөлмөрийн хуваарийг зохион байгуулах боломжтой байдаг. Жишээ нь, компьютер үйлдвэрлэдэг Японы компани микросхемийг АНУ-д хийлгээд дараа нь түүнд нимгэн алтан утас суулгах ажлыг хөдөлмөрийн зардал багатай Малайз,

Сингапур гэх мэт орнуудад илгээдэг. Цаашид хагас боловсруулсан бүтээгдэхүүнээ АНУ-руу эргүүлэн аваачиж, дараагийн боловсруулалтад оруулдаг байна. Энэ бүхэн бүтээгдэхүүнийг аль болох бага зардлаар үйлдвэрлэж, аль болох их ашиг олох, шинэ зах зээлд нэвтрэхийн төлөөх үйл явц юм.

Үндэстэн дамнасан корпорацуудад дэлхийн аж үйлдвэрлэлийн 50 хувь ногддог гэсэн мэдээлэл бий бөгөөд өнөөдөр хэд, хэдэн улсуудын төсвийг нийлүүлснээс ч илүү санхүүгийн чадавхтай асар том хэмжээний үндэстэн дамнасан корпорацууд бий болжээ. Тэдгээр нь олон улсын харилцаа, орон нутгийн эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлж, даяаршилд чухал үүрэг гүйцэтгэх боллоо.

Үндэстэн дамнасан корпорацын үйл ажиллагаанд ээрэг болон сөрөг талууд бий. Тэд дэлхийн шинжлэх ухаан, туршилт, судалгаа, зохион бүтээх үйл ажиллагаанд жинтэй хувь нэмрээ оруулж байгаа бөгөөд бүртгэгдсэн нийт патентын 80 хувь нь энэ чиглэлийн ажлын санхүүжилтэд ногдож байна. Үүний жишээ нь Адиdas, Майкрософт компаниуд болно. Өнөөдөр үндэстэн дамнасан банк, даатгал, аудит, харилцаа холбооны компаниуд бий болсоор байна.



Үйл ажиллагаа 4.16. Асуултад хариулаарай.

БНСУ-ын үндэстэн дамнасан “Акира” корпорац БНХАУ-д өөрийн цахилгаан барааны угсрах үйлдвэр байгуулжээ. Өмнөд Солонгос болон хятадын хувьд байж болох ээрэг болон сөрөг үр дагавруудыг нэрлэнэ үү.

СЭДЭВ 4.5 ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Төрийн эдийн засгийн бодлого нь тухайн орны эдийн засгийг хөгжүүлж, иргэдийн сайн сайхан аж байдлыг дээшлүүлэхэд чиглэдэг болохыг бид мэдлээ. Тэгвэл, тухайн улс эдийн засгийн хөгжлөөр ямар түвшинд байгааг хэмжих зайлшгүй шаардлага гарна. Мэдээж энд эдийн засгийн өсөлтийн үзүүлэлт чухал.

Бид өмнөх ангидаа ДНБ гэж ямар үзүүлэлт болох, түүнийг хэрхэн тооцдог талаар зохих мэдлэгтэй болсон билээ. Тэгвэл, эдийн засгийн өсөлтийг тодорхойлоходоо дараах хоёр үзүүлэлтийг ашигладгийг сэргээн санаарай. Үүнд:

1. Бодит ДНБ-ний өсөлт. Энэ нь тухайн улсын эдийн засгийн чадавхыг харуулдаг.
2. Нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлт. Энэ нь тухайн улсын иргэдийн амьжирагааны түвшинг илтгэнэ.

Харин улс орны эдийн засгийн өсөлтийн хурдыг дараах аргачлалаар тодорхойлно. Үүнд:

$$\text{ЭЗӨ} = \frac{\text{ДНБ тайлан-ДНБ суурь}}{\text{ДНБ суурь}} \times 100\%$$



Бүдүүвч 4.1 Эдийн засаг, байгаль орчин, нийгэм-соёл бол тогтвортой хөгжлийн тулгуун гурван чулуу юм.

Эндээс үзвэл эдийн засгийн өсөлтийн хурдыг хувиар илэрхийлдэг байна.

Өнгөрсөн 100 жил дэлхийн улс орнууд зөвхөн эдийн засгийн өсөлтөөр аливаа хөгжлийг төсөөлж, эдийн засгаа хурдасгахыг эрмэлзэж байсан бол сүүлийн жилүүдэд хүний хөгжлийн үзүүлэлтийг баримтлах хандлага давамгайлж байна.

1992 онд Бразилийн Рио де Жанейро хотод НҮБ-ын Байгаль орчин, хөгжлийн дээд хэмжээний бага хурал болсноос хойш тогтвортой хөгжил гэдэг ойлголт дэлхийд өргөн дэлгэрсэн аж. Тогтвортой хөгжил гэдгийг НҮБ-ээс гаргасан Байгаль орчин, хөгжлийн талаарх тунхаглалд “Ирээдүй хойч

үеийнхний өөрсдийн хэрэгцээгээ хангахуйц чадварыг алдагдуулахгүйгээр өнөө үеийнхний шаардлагад нийцсэн хөгжлийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Өнөө үеийнхэнд хойч үеийнхээ хэрэгцээнд зориулан байгалийн нөөц баялаг, байгаль орчноо хамгаалж, өвлүүлэх нэн чухал үүрэг бий. Ялангуяа байгалийн нөөц баялагтаа тулгуурлаж хөгжих хандлагатай байгаа манай улсын хувьд энэ үргээ бүрэн биелүүлэх шаардлагатай нь ойлгомжтой. Тиймээс ч дэлхийн улс орнуудын бодлого нь байгалийн нөөцийн үр ашигтай зарцуулалт, байгаль орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлсэн, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн тогтолцоог бий болгоход чиглэгдэж байна.

Эдийн засаг өссөн ч ядуурал, ажилгүйдлийн түвшин буураагүй, орлогын тэгш бус байдал өөрчлөгдөөгүй бол тухайн улсын эдийн засгийг хөгжсөн гэж үзэхгүй. Иймээс сүүлийн жилүүдэд эдийн засгийн тогтвортой өсөлт, орлогын тэгш байдлыг хамтад нь авч үзэх хандлага зонхиlj байна. Эдийн засгийн өсөлт нь байгаль орчны бохирдол, хүн амын орлогын тэгш бус хуваарилалт, технологийн дэвшилтэй холбоотойгоор ажилгүйдэл, үндэсний үнэт зүйлсийг алдагдуулах зэргээр нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлэх боллоо.

Эдийн засгийн хөгжил нь эдийн засгийн өсөлтийг бодвол илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд дараах үзүүлэлтүүдтэй холбогдоно. Үүнд:

1. Амьжирааны түвшин дээшилсэн
2. Эдийн засаг өссөн
3. Аж үйлдвэржилт болон бүтцийн өөрчлөлт бий болсон
4. Эдийн засгийн бие даасан байдал нэмэгдсэн
5. Ядуурлын түвшин буурсан
6. Тогтвортой өсөлт бий болсон
7. Хүний хөгжил сайжирсан



Үйл ажиллагаа 4.17. Багаар гүйцэтгээрэй.

1. Дэлхийн банкны атласын аргаар нэг хүнд ногдох YHO-д үндэслэн улс орнуудыг орлогын түвшнээр дараах үндсэн 4 бүлэгт хувааж байгаа бөгөөд манай улс орлогын аль бүлэгт хамарагдаж байна вэ? Үүнд:
 - Бага орлоготой, 1.005\$-оос бага;
 - Дунджаас доогуур орлоготой, 1.006–3.955\$;
 - Дунджаас дээгүүр орлоготой, 3.956–12.235\$;
 - Өндөр орлоготой, 12.236\$ ба түүнээс дээш
2. Манай улсын YHO-ын хэмжээг дараах загвар хүснэгтийг ашиглан холбогдох сайтаас авч, баганан диаграммаар илэрхийлж, ямар хандлагатай байгааг тайлбарлана уу.

Монгол улсын хувьд нэг хүнд ногдох YHO

Үзүүлэлт	2016	2017	2018	Жилийн өсөлтийн дундаж хурд
YHO, ам.доллараар.				



Гэртээ хийгээрэй. Эх сурвалжтай ажиллаарай

(World Happiness Report сайтын 2017 оны тайлан)

1. Дундаж наслалтаар дэлхийд тэргүүлдэг орнуудыг нэрлэж, манай улсын хувьд энэ үзүүлэлт ямар түвшинд байгааг мэдэж, дундаж наслалтад нөлөөлдөг хүчин зүйлсийг ач холбогдоор нь эрэмбэлж бичээрэй.
2. Аз жаргалын индексээр манай орон дэлхийн нийт хэдэн орны хэдэд жагсаж байна вэ?
3. Банкны зээлийн хүүгийн түвшин хөгжингүй орнуудад, хөгжик байгаа орнуудад, манай оронд ямар түвшинд байна вэ? Энэ үзүүлэлтийг яагаад олон улсын түвшинд авч үзэж байна вэ?
4. Сэдвийн хүрээнд дараах чиглэлээр нэмэлт мэдээлэл цуглуулж мэдлэгээ баяжуулаарай. Үүнд:
 - a. Та бүхэн Европын Холбооноос гадна дэлхийн худалдаанд бодит хувь нэмэр оруулж байгаа бус нутгийн өөр ямар байгууллага байдаг, тэдгээрт ямар улсууд хамарагддаг болохыг нэрлэнэ үү.
 - b. Газрын зураг дээр эдийн засгийн интеграцийн бүлэглэлд багтаж байгаа улс орнуудын байршлыг тодорхойлж, бүсчлэх оролдлого хийгээрэй.

ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ИНТЕГРАЦИ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ЯМАР НӨЛӨӨ ҮЗҮҮЛДЭГ ВЭ?



Тулгуур ойлголт

Дэлхийн улс орнуудын хооронд бүтээгдэхүүн солилцох явцад үүсж байгаа харилцааг **дэлхийн зах зээл** гэнэ.

Интеграцигэдэг нь бусчлэх, нэгдэх гэсэн латин үгнээс гаралтай үг юм. Олон улсын худалдаа болон үндэстэн дамнасан корпорацийн үйл ажиллагаа буюу бараа болон капиталын урсгал янз бүрийн орнуудын эдийн засгийг нягт холбодог. Иймээс нэг орны гадаад худалдааны бодлого нь бусад орнуудад шууд болон дамнаанд байдаа нөлөөлнө.

Улс орнуудын хоорондын интеграцийн эдийн засгийн утга санааг тухайн орны харьцангуй давуу талыг ашиглан бараа солилцох, зах зээлийг өргөтгөх, хамгийн ашигтай салбарт үйлдвэрлэлийн нөөцийг чөлөөтэй шилжүүлэх замаар тэдгээр улсуудын эдийн засгийн өсөлтийг дээшлүүлэхэд чиглэдэг гэж ойлгож болно.

Бүсийн эдийн засгийн интеграци хэд хэдэн үе шаттайгаар өрнөдөг.

- Эхлээд худалдааны чөлөөт бус бий болно. Өөрөөр хэлбэл, гаалийн татвар, импортын квот болон улс хоорондын худалдааны бусад саадыг үгүй болгоно. Харин худалдааны чөлөөт бусийн холбоонд нэгдээгүй бусад улсаас орж ирж байгаа бараанд гаалийн тарифыг мөрддөг.
- Интеграцийн дээд шат болох “Нэгдсэн зах зээл” бий болсон үед зөвхөн бараа, үйлчилгээ төдийгүй мөн хөдөлмөр, капитал зэрэг үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг чөлөөтэй нэвтрүүлнэ. Энэ нь нэгдсэн зах зээлд хамарагдаж байгаа орны ажиллах хүч аль ч оронд чөлөөтэй хөдөлмөр эрхэлнэ гэсэн үг.

Орчин цагийн дэлхийн зах зээлийн хөгжлийн нэг онцлог нь бус нутгийн шинжтэй худалдааны томоохон бүлэглэлүүд бий болж байгаа явдал юм. Ийм бүлэглэлүүдэд

эдийн засгийн хамтын ажиллагаанаас илүүтэй худалдааны харилцаа давамгайлж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд хил хязгааргүй мэт болж худалдаа, тээвэр, ажиллах хүч ихээхэн хэмжээгээр шилжих болжээ. Энэ нь улс орнуудын эдийн засгийг улам нэг нэгнээсээ хамааралтай болгож байна. Үүний шалтгаан нь чөлөөт эдийн засагтай холбоотой. Энд Европын холбоо болон бус нутгуудын эдийн засгийг нэгтгэсэн байгууллагуудын нөлөө их юм.

Олон улсын эдийн засагт улс орнуудын эзлэх байр суурийг дараах шалгуураар тодорхойлж байна. Үүнд:

1. Эдийн засгийн хөгжлийн түвшин
2. Эдийн засгийн бүтэц
3. Эдийн засгийн өсөлтийн төрөл
4. Гадаад эдийн засгийн хэлбэр

ДАЯАРШИЛ УЛС ОРНУУДЫН ХӨГЖИЛД ЯМАР ҮР ДАГАВАРТАЙ ВЭ?

Даяаршил (globalization) гэдэг нь дэлхийн улс орнууд эдийн засаг, санхүү, улс төр, хэл, соёл, техник технологийн салбарын хүрээнд нэгдэн нягтралтадаа үйл явц юм. Даяаршил гүнзгийрэх тусам дэлхийн улс орнуудын эдийн засаг, хамтын ажиллагааны агуулга, хэлбэр баяжин тэлж, дэлхийн эдийн засаг гэсэн нэгдмэл тогтолцоо бүрэлдэн бий болох үйл явц лавширсаар байна. Ийм нөхцөлд аль ч улсын хувьд гадаад өртөнцийн хаалттай, тусгаарлагдмал байдлаар хөгжих бололцоогүй, хүссэн ч хүсээгүй ч олон улсын эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцох шаардлагатай болов. Энэ нь олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа нь үндэсний эдийн засгийн хөгжил, дэвшлийн нэг гол хүчин зүйл болсныг харуулж байна. Цаашид даяаршил дэлхийн хэмжээнд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл хэвээр байх бөгөөд харин түүний эерэг, сөрөг талуудыг тодруулан авч үзэж байна. Үүнд:

- Даяаршил хүрээгээ тэлэхийн хэрээр түүнээс ихийг хүсэн хүлээж их зүйл хожих байх гэж найдаж байсан улс орнууд, ард түмний сэтгэл санаа тавгүйтэж эхлэв.
- Эдийн засгийн хөгжлийн зогсонги байдал, хүн амын хөгшрөлт, эрүүл мэндийн доройтол зэрэгт даяаршлыг буруутгах болжээ.
- Даяаршил нь хүмүүст бус компаниудад ашиг тусаа өгдөг бөгөөд ажлын байрыг үгүй хийж, байгаль орчныг хордуулж, соёлын олон төрөл зүйлд заналхийлж, гуравдагч өртөнцийг зарцалж, улс хоорондын тэгш бус байдлыг гүнзгийрүүлж байна гэсэн үзэл ч байна.
- Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын үеэр явуулсан саяхны судалгаанаас үзвэл дэлхийн хэмжээний интеграци нь эдийн засгийн өсөлт, худалдаанд зарим талаар аюул, занал учруулахаар байгаа боловч нийтэд нь авч үзвэл хүн бүхэнд тусалж байна гэж үзэхээр байгаа юм.
- Судалгаанаас үзэхэд, одоогийн байдлаар дэлхийн хэмжээнд эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанаас асар их хэмжээний орлого олоход хүргэж байгаа зэрэг сөрөг нөлөө илэрч байна.

- Түүнчлэн дэлхийн хэмжээнд жил бүр 500 орчим тэрбум долларыг авлига, хээл хахуульд зардаг гэсэн тооцоо байна. Энэ бол дэлхийн хэмжээний ДНБ-ий нэг хувьтай тэнцэж байгаа ба энэ хэмжээгээр эдийн засгийн өсөлтийн хурдац, хөрөнгө оруулалт, ашиг орлого буурсан гэсэн үг юм.
- Олон улсын хэмжээнд “Мөнгө угаах” үйл ажиллагаа эрчимжиж бус нутаг дахь хүчирхийллийг санхүүжүүлэх үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байна.

Улс орнууд даяаршлын эдгээр сөрөг нөлөөг хэрхэн давж, тогтвортой хөгжлөө хадгалж үлдэх вэ гэдэгт ухаан санаагаа уралдуулах боллоо.



Үйл ажиллагаа 4.18. Асуултад хариулаарай.

- Эдийн засгийн хөгжлийг юу гэж ойлгох вэ? Эл хөгжлийн эх үүсвэр нь юу вэ?
- Хүн амын хурдаатай өсөлт нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж болох вэ? Түүнийг зэрэг болон сөрөг талаас тайлбарлаарай
- Байгаль орчинтой зохицсон хөгжил гэж юуг хэлэх вэ?
- Манай улсын боловсролын тогтолцоо нь эдийн засгийн хөгжилд зэрэгээр нөлөөлж чадаж байна уу? Үгүй юу? Яагаад?
- Зохиолч Стендалийн хэлсэн “Хүн энэ хорвоо ертөнц дээр баяжихын тулд биш жаргахын тулд амьд явдаг” гэсэн үгийн учрыг тайлбарлана уу.
- Манай оронд үзүүлж буй гадаад орнуудын эдийн засгийн тусlamжийн нөлөө ямар байна гэж бодож байна вэ? Гадаадын зээл, тусlamжийг авах хэрэгтэй юу? Хэрэгтэй бол ямар хэлбэрээр авах нь ашигтай вэ?



Гэртээ хийгээрэй.

Өгөгдсөн мэдээллийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Судлаачид ойрын жилүүдэд дэлхийн хэмжээнд гарч болох өөрчлөлтүүдийг нэрлэжээ. Тэдгээрээс заримыг дурдвал:

- Газрыг эрчимтэй ашиглаж, тариалангийн талбайн үргжил шим муудаж, халуун орны ой сөнөж устах аюул нүүрлэж, байгаль орчны доройтол цаашид ч гэсэн үргэлжилсээр байх төлөвтэй.
- Хөгжиж байгаа орнуудын хувьд хүн амын хэт өсөлт, эдийн засгийн хөгжил, хотжилт түргэссэнтэй холбоотойгоор байгаль орчныг хамгаалах, экологийн доройтолтой тэмцэх олон асуудалтай тулгарна.
- Томоохон хотод агаарын бохирдлын асуудал ихээхэн бэрхшээл үүсгэнэ. Агаарын бохирдлыг бууруулах үүднээс технологийн дэвшлийг ашиглан эрчим хүч бага хэрэглэх буюу гибрид машин үйлдвэрлэх, нар, салхины эрчим хүчийг ашиглах, байгалийн хийг ашиглах чиглэлээр ихэд анхаарах болно.
- Боловсролын хэрэгцээ улам бүр 500 орчим тэрбум долларыг авлига, хээл хахуульд зардаг гэсэн тооцоо байна. Энэ бол дэлхийн хэмжээний ДНБ-ий нэг хувьтай тэнцэж байгаа ба энэ хэмжээгээр эдийн засгийн өсөлтийн хурдац, хөрөнгө оруулалт, ашиг орлого буурсан гэсэн үг юм.

Дээрх өөрчлөлт тус бүрээр тодорхой тайлбар бүхий жишээ бичээрэй.

Даяаршил Монгол улсын хөгжилд ямар үр дагавар үзүүлж байгаа талаар мэдээлэл цуглуулан танилцуулга бэлтгээрэй

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Ta бүхэн Х ангийн “Эдийн засаг” бүлгийн агуулгыг үргэлжлүүлэн, XI ангидaa төрийн макро эдийн засгийн бодлого, түүний мөн чанар, макро эдийн засгийн асуудлууд болох ажилгүйдэл, инфляцийн эдийн засаг болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг судаллаа. Мөн гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын мөн чанар, эдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар ойлголттой боллоо. Дүгнэлт хичээлээр та бүхэн бүлгийн агуулгад нийцсэн даалгавруудыг гүйцэтгэж мэдлэг, чадвараа бататгаарай.

I. ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭЭРЭЙ.



- Төрийн эдийн засгийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга механизмуудыг нэрлэж зорилго, үр дүнг хүснэгтэд бичнэ үү.

Төрийн эдийн засгийн бодлого	Сангийн бодлого	Мөнгө, зээлийн бодлого	Гадаад худалдааны бодлого
Агуулга	Улсын орлого, зарлагыг өөрчилнэ	Гүйлгээнд байх мөнгөний тоо хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлнэ	Бусад улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг гаалийн бодлогоор зохицуулна
Арга, механизм	?	?	?
Зорилго	?	?	?
Үр дүн	?		



- Эдийн засгийн ухааны дараах үндсэн ойлголтуудыг агуулгаар нь зөв тохируулаарай.

	Үндсэн ойлголт		Агуулга
а	Экспорт	1	Чөлөөт худалдаанд тавих хязгаарлалт
б	Импорт	2	Импортолж байгаа бараанд ногдуулах татвар
в	Протекционизм	3	Бусад орны иргэд болон ААН-үүдээс бидний худалдан авч байгаа бараа, үйлчилгээ
г	Импортын татвар	4	Бусад орноос оруулж ирж байгаа барааны тоо хэмжээнд тавих хязгаарлалтууд
д	Импортын хязгаарлалт	5	Барааг гадаадын зах зээлд өөрийн өртгөөс нь доогуур үнээр худалдах
е	Демпинг	6	Төрийн ямар нэгэн оролцоогүйгээр олон улсын хооронд хийгдэх арилжаа
ж	Чөлөөт худалдаа	7	Нэг улс бусад улс орны иргэд, ААН-үүдэд бараа, үйлчилгээ худалдах



3. Мэдээллийг уншиж, гол санааг дараах хүснэгтэд илэрхийлээрэй.

- Европын орнуудад мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр гадаад болон дотоод эрэлт өсөж, нийт үйлдвэрлэл нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг нь дэмжив.
- БНХАУ-аас явуулсан хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн салбарыг дэмжих бодлогын дүнд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр жижиглэн худалдаа, цахилгааны үйлдвэрлэл нэмэгдэж, ажилгүйдэл буурсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжжээ.
- АНУ-ын бизнесийн салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдэж, дотоод эрэлт өсөж, хувийн хэрэглээний зардал тэлсэн нь эдийн засгийн өсөлтөд ээрэг нөлөө үзүүлэв.

Аль улс	Хэрэгжүүлсэн бодлого	Хэрэгжүүлсэн арга хэрэгсэл	Үр дагавар
.....



4. Даалгаврыг гүйцэтгээрэй.

Дараах загвар хүснэгтийг ашиглан мэдээлэл цуглуюулж, Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тодорхойлох, шинжилгээ хийх даалгавруудыг гүйцэтгээрэй. Үүнд:

- Монгол дахь хөрөнгө оруулалтын бүтцийг, үйлдвэрлэлийн салбараар тодорхойлж, графикаар илэрхийлээрэй.
- Хөрөнгө оруулагч гол орнуудын хөрөнгө оруулалтын хэмжээ болон бүтцийг тодорхойлж, графикаар илэрхийлээрэй.
- Аль улс, эдийн засгийн ямар салбарт илүү их хөрөнгө оруулалт хийж байгааг мэдээллийн янз бүрийн эх сурвалжийг ашиглан тодорхойлж, дүгнэлт хийнэ үү. Мэдээллийг графикаар илэрхийлж тайлбарлаарай.
- Шинжилгээнд үндэслэн манай улс гадаадын хөрөнгө оруулалтад ямар бодлого баримтлах хэрэгтэй вэ? гэсэн асуултад өөрийн байр сууриа илэрхийлээрэй.

Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ, эдийн засгийн салбаруудаар

№	Эдийн засгийн салбарууд	Хөрөнгө оруулалтын хэмжээ (сая ам. доллар)	Нийт дунд эзлэх хувь (%)
	Бүгд		100.0

Монгол дахь хөрөнгө оруулалт, улсуудаар

№	Улсууд	Хөрөнгө оруулалтын хэмжээ (сая ам. доллар)	Нийт дунд эзлэх хувь (%)
	Бүгд		100.0

Монгол дахь хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн салбар болон улсаар

№	Улсууд	Хөрөнгө оруулалт хийсэн үйлдвэрлэлийн голлох салбарууд	Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ам. доллар.
Бүгд			



5. Баримтыг шинжлээрэй

Монгол улсын экспортын талаас илүү хувийг зэсийн хүдэр, алт, түүхий нүүрс, нефть эзэлж байна. Энэ нь Монгол улс бусад орнуудтай харьцуулахад түүхий эдийн үйлдвэрлэлээр илүү давуу талтай байгааг нотолж байгаа хэдий ч боловсруулаагүй түүхий эдээ худалдах нь ашиггүй юм. Яагаад гэвэл, түүхий эдийг боловсруулж худалдсанаас олох нэмүү өртөг буюу ашиг манай оронд биш манай түүхий эдийг худалдан авч байгаа тэр оронд шингэж байна. Харин манай улс нефть биш бензин эсвэл масло, зэсийн хүдэр бус зэс утас, сэлбэг, материал үйлдвэрлэж худалдах нь ашигтай. Гэхдээ үүний тулд эдгээр барааны чанар дэлхийн стандартад нийцсэн байх учиртай.

Монгол улс өнөөдөр дэлхийн 146 оронтой худалдаа хийж гадаад худалдааны нийт эргэлт 8.3 тэрбум ам.долларт хүрчээ. Манай улсын экспортын хэмжээ жил ирэх тутам өсөж, дэлхийн 60 орчим улсад бараа, бүтээгдэхүүн экспортолж байгаа бөгөөд эхний 5 байрыг Хятад, Их Британи, Швейцарь, ХБНГУ, ОХУ зэрэг улсууд эзэлж байна. Экспортоор орж ирж байгаа бүх орлогыг үндсэн ганц, хоёр бараанаас бүрдүүлж байгаа бол энэ нь маш аюултай юм. Монгол улсын экспортын орлого нь жишээ нь, зэс, нүүрс, алтны дэлхийн зах зээлийн үнийн түвшнээс хүчтэй хамаардаг. Тухайлбал, эдгээрийн үнэ дэлхийн зах зээлд унаснаар манай орны гадаад худалдааны байр суурь хүчтэй суларч энэ хэмжээгээр эдийн засаг доройтдог.

Монгол улс өнөөдөр дэлхийн 120 гаруй улсаас бүтээгдэхүүн импортолж байгаа бөгөөд эхний 5 байрыг Хятад, АНУ, ОХУ, Япон улсууд эзэлж байна. Сүүлийн жилүүдэд импортын хэмжээ экспортын өсөлтөөс илүү хурдацтай өсөж байгаа нь нэг талаас дотоодод уул уурхай, дэд бутцийн салбарын томоохон бүтээн байгуулалт, төслүүд хэрэгжиж, тэдгээрт шаардлагатай машин, техник, тоног төхөөрөмж болон дизель түлшний импорт өсөж байгаатай холбоотой байна.

Асуулт:

- “Гадаад худалдааны эргэлт” ойлголтыг тодорхойлно уу.
- Манай улсын гадаад худалдаанд анхаарал татсан ямар асуудлууд байна вэ?
- Монгол улсын гадаад худалдааны үр ашигийг дээшлүүлэхийн тулд бид юу хийх ёстой вэ?
- Багаар ярилцаж, багийн гишүүн бурийн санаа бодлыг сонсож, хэлэлцүүлэг хийгээрэй.

Эсээ бичих даалгавар

Зөвлөмж:

- Дараах эх сурвалжаас нэгийг сонгон утга санааг ойлгон уншаарай.
- Эх сурвалжийн гол санааг баримт нотолгоонд тулгуурлан задлан шинжилж эсээний сэдвээ томьёолоорой.
- Эсээ бичих асуудлын хүрээнд баримт, мэдээлэл цуглуулан эсээгээ бичээрэй

Эсээнд ашиглах эх сурвалж:

1. **АНУ:** АНУ-ын эдийн засаг 2017 оны эцэст 2.5 хувиар, хэрэглээний үнийн индекс 2.1 хувиар өссөн байна. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрааас хойш бодлогын хүг 2015 оны 12 дугаар сард анх удаа нэмэгдүүлж байсан бол 2017.03.22-нд 0.25 нэгжээр, 2017.06.14-нд 0.25 нэгжээр тус тус нэмэгдүүлж 1.25 хувьд хүргээд байна. Ажилгүйдлийн түвшний хувьд 2018 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 4.1 хувьтай гарч, түүхэн доод түвшинд хэвээр хадгалагдаж байгаа ба татварын шинэчилсэн бодлогын (татвар бууруулах) нөлөөгөөр хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг эрчимжих, гадаад худалдааны алдагдал нэмэгдэх төлөвтэй байна
2. **ОХУ:** ОХУ-ын эдийн засаг 2017 онд 1.5 хувь өсөж, сүүлийн 3 жилд анх удаа өсөлт үзүүллээ. Үүнд Европын холбооноос олон төрлийн хүнсний бүтээгдэхүүний импортыг хориглосонтой холбоотойгоор дотоодын үйлдвэрлэл сэргэсэн болон газрын тосны үнэ өсөж баррель нь 70 ам.долларт хүрсэн зэрэг нь голлон нөлөөлжээ. Хэрэглээний үнийн индекс 2015 оны 8 дугаар сараас саарсан байна. ОХУ-ын бонд, үнэт цаасны төлөв бусад шилжилтийн эдийн засагтай болон газрын тосонд суурилсан эдийн засагтай орнуудтай харьцуулахад харьцангуй сайн байгаа тул төв банк бодлогын хүүгээ бууруулах нөхцөл бүрдэж байна.
3. **Европын орнуудад** мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр гадаад болон дотоод эрэлт өсөж, нийт үйлдвэрлэл нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг нь дэмжив.
4. **БНХАУ-аас явуулсан** хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн салбаруудыг дэмжих бодлогын дүнд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр жижиглэн худалдаа, цахилгааны үйлдвэрлэл нэмэгдэж, ажилгүйдэл буурсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжжээ.

Эх сурвалж: <http://bloombergtv.mn>

Эргэцүүлэх асуулт:

- а) Дээрх эх сурвалжийн баримтын мэдээллийг нэг бүрчлэн уншиж, ямар нийтлэг сэдэв, асуудал хөндсөн болохыг тодорхойлно уу.
- б) Эдийн засгийн мэдлэг, ойлголтоо ашиглан, дээрх орнууд төрийн эдийн засгийн ямар бодлого хэрэгжүүлсэн, түүний үр дагаврын талаар дүн шинжилгээ хийж, дүгнэлт бичнэ үү.
- в) Төрийн улс орны өнөөгийн эдийн засгийн нөхцөлд ямар бодлого, яагаад чухал болох талаар байр сууриа илэрхийлнэ үү.
- г) Ямар шинэ мэдлэг, ойлголтыг улам гүнзгийрүүлж хаанаас, хэний тусламжтайгаар судлах шаардлагатай вэ?

II. ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ.



1. Богино хариулт бичих даалгавар:

1. Гүйлгээн дэх мөнгөний тоо хэмжээ, зээлийн хүүний хэмжээтэй..... хамааралтай.
2. Сангийн бодлого ба мөнгө зээлийн бодлогын үед бондыг....., зорилгоор ашигладаг.
3. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх сангийн бодлогын арга хэрэгсэл нь мөнгөний бодлогын арга хэрэгсэл нь болно.
4. Сангийн бодлого болон мөнгө, зээлийн бодлогын арга хэрэгсэл нь өөр өөр боловч зорилго нь хоёулаа чиглэнэ.
5. Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг гэнэ.
6. Улсын төсөв нь гэсэн бүрдэл хэсэгтэй.
7. Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэй эргүүлэн төлөхийн баталгаа болох үнэт цаасыг гэнэ.




2. Зөв хариултыг сонгоно уу.

1. Төр эдийн засгаа тогтвортжуулахын тулд хэд хэдэн бодлогыг авч хэрэгжүүлдэг. Тэгвэл эдгэрээс төрийн эдийн засгийн үндсэн хоёр бодлого нь аль вэ?
 - Сангийн ба мөнгө зээлийн бодлого
 - Татварын ба ажил эрхлэлтийн бодлого
 - Хүүгийн ба гадаад худалдааны бодлого
 - Гаалийн ба хөрөнгө оруулалтын бодлого
2. Цэгийн оронд тохиорох хариултыг олно уу? Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг төрийн гэнэ.

а.Хүүгийн бодлого	б.Сангийн,төсвийн бодлого
в.Мөнгө,зээлийн бодлого	г.Татварын бодлого
3. Төр татвараас гадна тодорхой төрлийн барааны импортод хязгаарлалт буюу квот тогтоож өгөх тохиолдол байдаг. Жишээ нь: Тухайн оронд жилд орох барааны тоо хэмжээг 20 мянган ширхэгээс, 100 сая төгрөгөөс хэтрүүлэхгүй байх гэх мэт. Ийм арга хэмжээг гадаад худалдааны ямар бодлого гэж нэрлэдэг вэ?

а.Капиталын бодлого	б.Демпинг
в.Санхүү мөнгөний бодлого	г Протекционист бодлого
4. Олон улсын эдийн засагт улс орнуудын эзлэх байр суурийг тодорхойлдог шалгууруудыг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

а.Эдийн засгийн бодлого	б.Эдийн засгийн хөгжлийн түвшин
в.Эдийн засгийн бүтэц	г.Эдийн засгийн өсөлтийн төрөл



Суралцахуйн зорилт	Тулгуур ойлголт
<p>Улс төрийн үйл явц</p> <p>а. Иргэний нийгэм түүний мөн чанар, үндсэн шинжийн тухай судлан өөрийн үүрэг, оролцоог тодорхойлох</p> <p>б. Сонгууль, сонгуулийн үндсэн зарчим, сонгуулийн системийн тухай эх сурвалжид үндэслэн тодорхойлж, улс төрийн ухамсартай сонголт хийх ач холбогдлыг шүүн тунгаа</p> <p>в. Орчин үеийн нийгэм, улс төрийн үйл явцад нөлөөлж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөөг бодит жишээгээр хэлэлцэн, дүгнэлт хийх</p> <p>Улс төрийн институт</p> <p>а. Улс төрийн систем, түүний бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүдийг Монголын улс төрийн систем, түүний шийдвэр гаргах үйл явцад тулгуурлан тодорхойлох</p> <p>б. Улс төрийн институтууд болох парламент, улс төрийн нам, сонирхлын бүлгийг үйл ажиллагаа, чиг үүргээр нь ангилан, холбоо хамаарлыг задлан шинжлэх, дүгнэх</p>	<ul style="list-style-type: none"> Иргэний нийгэм Сонгууль, сонгуулийн систем Улс төрийн үйл явц Хэвлэл мэдээллийн хэрэгсэл Улс төрийн систем Улс төрийн институт Улс төрийн нам Сонирхлын бүлэг

СЭДЭВ 5.1 ИРГЭНИЙ НИЙГЭМ, ТҮҮНИЙ МӨН ЧАНАР, ҮНДСЭН ШИНЖ



Үйл ажиллагаа 5.1. Харилцаан ярилцаарай.

Монгол улсын Үндсэн хууль (1992) –д “Монголын ард түмэн бид: ... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн заасан байдаг.

Асуулт:

1. Хүмүүнлэг байна гэж юуг хэлэх вэ?
2. Иргэний ардчилсан нийгэм гэж ямар нийгмийг хэлэх вэ?
3. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийзэм байгуулахад бид ямар үүрэг, оролцоотой вэ?



R.Дарендорьф
(Rolf Dahrendorf)
1929 - 2009

Иргэний нийгмийн тухай ойлголт бүр эртний Грек, Ромын үед үүсжээ. Харин XVIII зууны сүүл, XX зууны эхэн үед “Иргэний нийгэм” гэдэг ойлголт нь улс төрийн шинжлэх ухааны тусгай бие даасан ойлголт болж эхэлжээ. Иргэний гэсэн үг нь латин хэлний “civilis” буюу соёлтой гэсэн үгнээс үүсэлтэй. Г.Гегель “Иргэний нийгэм нь төрөөс үл хамаарах өөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагдаг хувь хүмүүс, анги, бүлэг, институтуудын нийлбэр цогц юм” гэсэн байдаг.

Харин Р.Дарендорьф “Аливаа зүйлийг хийж бүтээнэ гэдэг нь өчүүхэн ч атугай бусадтай чөлөөтэй хамтран ажиллана гэсэн үг. Энэ нь чөлөөт эвсэл холбоо болон байгууллагуудын сүлжилдсэн ертөнц болж дараа нь бие даасан институтууд бий болоход хүргэдэг. Иргэний нийгэм нь улс төрийн болон нийгмийн харилцааг хөгжүүлэгч, нийгмийн бүлэглэлүүдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд оролцох оролцоог идэвхжүүлэгч механизм юм.



Тулгуур ойлголт

“Төр, эдийн засаг, гэр бүлээс анgid орших нийгмийн хүрээг **иргэний нийгэм** гэнэ”
Р.Путнам

Энэ бүхнээс харахад иргэний нийгэм бол иргэд төрийг хянаж, төрд хариуцлага хүлээлгэж чаддаг хүмүүсийн нэгдлийг хэлж байгаа юм. Энгийнээр иргэний нийгэм гэдэг нь “хүмүүс хамтран нэгдэж, үзэл бодлын хүрээгээрээ өөрсдөө зохион байгуулагдах”-ыг хэлэх ба үйл ажиллагаандаа дараах зорилтуудыг мөрдлөг болгодог байна.

Үүнд:

- Тулгарч буй асуудлаа шийдвэрлэхээр төрийн бодлогод нөлөөлөх
- Нийгмийн нөөцөөс хүртэх арга замыг олоход хүмүүст дэмжлэг үзүүлэх
- Нийгмийн амьдралд оролцох, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг хүмүүст олгох зэрэг багтана.

Иргэний нийгмийн түгээмэл буюу хамгийн гол шинжүүдийг дараах байдлаар тоймлон гаргаж болно. Үүнд:

- Иргэдийнхээ арьс өнгө, үндэс угсаа, нийгмийн байдлыг ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эрх, үүрэг, хариуцлагын зохистой нэгдэлд нь хуулийн хүрээнд хүн болгонд адил тэгшээр эдлүүлдэг байх.
- Эрх мэдлийг зохистой хуваарилан тэнцвэржүүлж, нийгмийн харилцааг зохицуулах, эрх зүйт төрийг төлөвшүүлэх. Энэ хүрээнд шийдвэр гаргах үйл явц болон гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихад иргэний нийгмийн оролцоог хангах, механизмыг бий болгох, бизнесийн байгууллагууд болон буяны байгууллагуудын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих үйл явцыг хурдасгах зорилгоор төрөөс татварын болон бусад хэлбэрийн урамшууллын бодлого хэрэгжүүлэх, төрөөс болон донор байгууллагуудын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх.
- Эдийн засгийн хувьд чөлөөт үйлдвэрлэл, хувийн худалдаа, үйлчилгээний шударгаар өрсөлдөх нөхцөлийг хангасан зах зээлийн эрүүл саруул тогтолцоог хөгжүүлэх, түүнд нийцсэн төлөвлөлт, зохион байгуулалтын уян хатан арга хэмжээ хэрэгжих таатай орчин бүрдүүлэх.
- Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэдийн оролцооны эрх, эрх чөлөөг баталгаажуулсан хууль эрх зүйн орчин бүрдүүлэх. Энэ хүрээнд чөлөөтэй хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөний нэгдмэл орон зайл бий болгох, улс төрийн олон намыг хүлээн зөвшөөрөх, шударга өрсөлдөөнт сонгуулийн системийг бий болгох, хувийн өмчид тулгуурласан өрсөлдөөнт зах зээлийн нийгмийг бий болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Иргэний нийгмийн хөгжил төлөвшил нь улс төрийн дэглэм, уламжлалт соёл, шашин, зан заншил, улс төрийн соёл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Иргэний нийгэм нь хувь хүний эрх ашгийг илүү илэрхийлдэг бол төр нийтийн эрх ашгийг хамгаалдаг. Тэгвэл төр, иргэний нийгмийн түншлэлийн үр дүнд жирийн иргэн сайхан амьдардаг нийгэм бий болдог.



Үйл ажиллагаа 5.2. Эх сурвалжтай ажиллаарай.

Монгол сурагчийг Шведээс албадан гаргахыг эсэргүүцсэн 1000 гаруй сургачийн жагсаал

2017 оны 02 дугаар сарын 15-нд Шведийн Стокгольм хот дахь гурван ахлах сургуулийн нийт 1000 гаруй сурагч И.Жаргалсайхан хүүг Шведээс албадан гаргах болсонтой холбогдуулж хичээл хаялт зарлаж, эсэргүүцлийн жагсаал хийлээ. Итгэлтийн Жаргалсайхан буюу Жагаа энэ жил 18 нас хүрч, Швед улсад амьдрах эрх нь дуусгавар болсон тул тус улсын шүүхээс албадан гаргах шийдвэр гаргаад байгаа аж. Гэвч түүний наиз нэхөд, хамт суралцагчдын зүгээс шүүхийн энэ шийдвэрийг эсэргүүцэн, жагсаал хийх болжээ. Жагсаалд Global, Rytmus, Kulturama зэрэг гурван ахлах сургуулийнхан оролцон “Жагаа үлдэх ёстой” хэмээх уриа лоозон барин жагсжээ. Өчигдөр болсон жагсаалд 1000 давсан оюутан сурагч оролцсон байна. Жагсаал энэ хэвээр үргэлжилж, өнөөдөр ч мөн өөр сургуулийнхан Жагааг үлдээх эрхийн төлөө тэмцэхээ илэрхийлжээ.

Ахлах сургуулийн сурагчид хоёр цаг орчим гадаа цуглаж, цагаан хоолой, микрофон ашиглан үзэл бодлоо илэрхийлж, тэмцжээ. Сурагчид “Гэртээ тавтай морил, хэн байх нь хамаагүй, энд бид чамайг хүлээж авах болно” гэжээ.


Клаудиа: “Нөхөрлөл бол бидэнд байгаа хамгийн чухал зүйл. Нөхөрлөл, эв нэгдэл бол биднийг ялалтад хүргэх хамгийн чухал зэвсэг. Манай сургуульд өөр өөр төрлийн олон хүн байдаг ч бид нэгнийхээ төлөө босож зогсох ёстой. Энэ бидний ирээдүйд ч маш чухал. Бидний дараагийн хийх ёстой зүйл бол Жагаагийн төлөө санал өгөх юм” гэсэн байна.

Эх сурвалж: www.socialisterna.org, <http://globalperspektiv.se>, <http://www.politism.se>

Асуулт:

1. Сурагчдад ийм төрлийн жагсаал цуглаан хийж, шаардлага таевх эрх бий юу?
2. Шаардлагад ямар үндэслэл байна вэ?
3. Хэрэв Монголд ийм тохиолдол гарвал хэрхэн шийдэх бол?
4. Дүрд тоглож асуудлыг шийдвэрлээрэй. Дүрд тоглохдоо ахлах сургуулийн сурагчдад 2-3 хүн, Жагаа, Шүүхийн төлөөлөл гэсэн дүрүүдээр асуудлыг шийдвэрлээрэй.

Иргэний нийгэм төлөвших орчныг төрийн бодлогоор зохицуулах ёстой. Ингэж байж сая иргэний нийгэм төлөвшиж, оршин тогтдог нь дэлхийн ардчилал өндөр хөгжсөн болон харьцангуй богино хугацаанд иргэний нийгмийн бие даасан хувилбаруудыг бий болгосон орнуудын туршлагаас харагддаг.



Бүдүүвч 5.1. Иргэний нийгмийг төлөвшүүлэх төрийн бодлогын хүрээ

**Гэртээ хийгээрэй. Мэдээлэл бэлтгэж ирнэ үү.**

Танай сургууль эсвэл зэргэлдээ сургууль дээр хүүхдийн, эцэг эхийн, багш нарын нийтлэг эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг клуб, холбоо, эвсэл байгаа эсэхийг судлан тэдгээрийн чиглэл, гол үйл ажиллагааг сурвалжлан, ангидаа танилцуулна уу.

**Нэмж судлаарай**

- УТБА-ын лекцийн эмхэтгэл. УТБА. УБ., 2001
- Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. УБ., 2010

СЭДЭВ 5.2 СОНГУУЛЬ, СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО**Үйл ажиллагаа 5.3. Үнэлгээ хийх.**

Та бүхний амьдарч байгаа газраас сонгогдсон сум, дүүрэг, аймаг, нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч, УИХ-ын гишүүний талаар хэр мэдэх вэ? Аль нэг сонгогдсон албан тушаалтныг үнэлнэ үү.

Сонгогдсон албан тушаалтныг үнэлэх аргачлал

№	Шалгуур	Үнэлгээ			
		4	3	2	1
1	Та бүхнийг төлөөлөх үүргээ хэр зэрэг биелүүлж байгаа эсэх				
2	Тухайн хүний ажил мэргэжлийн ур чадвар нь тухайн сонгогдсон албан тушаалд тохирох эсэх				
3	Олон нийтийн дунд нэр хүндтэй эсэх				
4	Амлалтаа биелүүлдэг эсэх				

Ард түмэн засгийн эрх барихын мөн чанар нь чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийг тогтмол хугацаанд явуулж өөрсдийн төр засаг, төлөөлөгчдийг сонгодогт байгаа юм. Сонгууль гэдэг үг нь сонгох, сонгогдох гэсэн хоёр үйл үгийг өөртөө агуулсан нэр үг юм. Сонгууль зөвхөн улс төрийн хүрээнд бус бидний өдөр тутмын амьдралд ч явагдаж байдаг. Хүүхдүүд та бүхний төлөөлөл ангийн дарга, сурагчдын өөрөө удирдах байгууллагын дарга, гишүүн, сум дүүрэг, аймаг нийслэлийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүн зэрэг албан тушаалд ажилладаг. Эдгээр төлөөлөлд хүүхэд бүхэн нэр дэвшин сонгогдох, ямар нэгэн дарамт шахалтгүйгээр өөрийн дэмжиж буй хэн нэгнийг сонгох эрх нээлттэй байдаг.

СОНГУУЛЬ, СОНГУУЛИЙН ЗАРЧИМ

Орчин үеийн сонгуулийн үүслийг төлөөллийн ардчиллын үзэл санаа хэрэгжиж эхэлсэн үетэй холбон авч үздэг. Аль ч улс оронд төрийн эрх мэдэл дээд тэнгэрээс эх сурвалжтай хэмээн үзэж байсан үе бий. Харин XVII зуунаас баруун Европт төрийн эрх мэдэл тагцхүү ард түмнээс, тэдний итгэл, зөвшөөрлөөс үүсэлтэй гэсэн үзэл баримтлал давамгайлах болсон. Францын болон Америкийн хувьсгалаар иргэн бүр


тэгш эрхтэй хэмээн тунхаглаж, энэ үеэс л хууль тогтоох байгууллагад нийгмийн янз бүрийн төлөөллийг сонгох болжээ.

Эхэн үедээ сонгууль ямагт цөөнхийн хэрэг байсан боловч иргэдийн сонгуулийн эрх аажмаар өргөжсөөр ирэв. Өнөөдөр дэлхийн олон улс оронд сонгуулийн бүх нийтийн, тэгш эрхийг хүлээн зөвшөөрч байгаа нь ардчиллыг тодорхойлох чухал шинж боловч дангаараа түүний баталгаа болохгүй юм.

Улс төрийн сонгуулийн мөн чанар нь санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийхэд оршдог. Сонгуулийн зайлшгүй нөхцөл бол сонголтын альтернатив боломж юм. Энэ нь иргэд хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч эсвэл улс төрийн нам, эвслээс сонголт хийдэгт сонгуулийн утга учир оршино. Иргэн хүн ямар нэгэн албан тушаалд хэн нэгний дарамт шахалт, нөлөөлөлд өртөлгүйгээр чөлөөтэй сонгогдох эрхтэй байх явдал бол ардчилсан сонгуулийн чухал онцлог юм.

Энэ бүхнээс, хүмүүс ямар зорилгоор сонгууль явуулдаг юм бэ, яагаад сонгуульд илүү ач холбогдол өгдөг вэ, хүмүүсийн амьдралд сонгууль ямар ач холбогдолтой юм бэ зэрэг асуулт урган гардаг.

Сонгууль бол ард түмэн өөрсдөө төрийг удирдах зохион байгуулалтын арга, хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн засаглалын гол эх сурвалж болох ард түмний төлөөлөл гагцхүү сонгуулиар л баталгааждаг. Ийм учраас сонгууль ардчилсан, чөлөөт, шударга байх ёстой.



Бүдүүвч 5.2. Сонгуулийн эрх

Эдүгээ дэлхийн бараг л бүх улсад сонгууль явуулдаг болсон хэдий ч ихэнх тохиолдолд хэлбэрийн тал нь голлож байна. Иймээс жинхэнэ сонгуулийг хэлбэр төдийгөөс ялгахын тулд “чөлөөт ардчилсан” гэж тодотгодог.

Ардчилсан сонгуулийн зарчим:

- Бүх нийтээр оролцох зарчим. Нас, хүйс, яс үндэс, гарал угсаа, мэргэжил, хэл, санхүүгийн чадвар, үзэл бодлоос үл шалтгаалан бүгд оролцдог байх.
- Сонгуульд тэгш оролцох зарчим. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх.
- Саналыг шууд өгөх зарчим. Сонгуулийн эцсийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг байх.
- Чөлөөтэй сонгох зарчим. Сонгуульд оролцоходо чөлөөтэй сонголтоо хийн, саналаа чөлөөтэй илэрхийлэх бүхий л бололцоогоор хангагдах.
- Саналаа нууцаар гаргах зарчим. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдлыг хангах зэрэг багтана.



Тулгуур ойлголт

Сонгууль гэдэг нь хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч, улс төрийн нам, эвслээс иргэн хүн тэгш эрхтэйгээр сонголтоо өөрийн биеэр, чөлөөтэй хийж, үр дүн нь шууд гардаг улс төрийн сонголт юм.


боловсон бөгөөд 1951 он хүртэл энэ нь зөвхөн “ангийн” сонгууль байв. Энэ үед язгууртнууд, лам нар сонгууль өгөх эрхгүй байлаа. 1951 оноос бүх нийтийн, тэгш, шууд болон санал нууцаар хураах зарчмын үндсэн дээр сонгууль явуулах болсон ч ардчилсан шинжийг агуулж байгаагүй юм. Сонгогчид албан ёсоор дээрээс санал болгосон нэг л нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх ёстай байв. Нэр дэвшигчийн эсрэг санал өгөхийг эс тооцвол өөр сонголт хийх ямар ч боломж байсангүй. Сонгуулт албан тушаалд хэн тавигдах нь санал хураалтаас бүр өмнө эрх баригч намын дээд удирдлагын хүрээнд шийддэг байв.

Зөвхөн Монголд л ийм байсан биш юм. Ардчилсан бус дэглэм, нэг намын ноёрхлын үед явагддаг аливаа сонгууль иймэрхүү нийтлэг дүр зурагтай байдаг. 1990 оноос Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээр иргэний сонгох болон сонгогдох эрх, ардчилсан сонгуулийн зарчмыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоо баталгаажуулсан.

Хэдийгээр сонгох, сонгогдох нь ардчилсан нийгэмд амьдарч буй иргэн бүрийн нийтлэг эрх боловч улс төрийн сонгуульд оролцох эрхэд зарим нэг шалгуурыг тавьдаг. Энэхүү шалгуур нь тухайн иргэний сонгуулийн эрх, эрх чөлөөг хааж буй хэрэг биш харин тухайн хүн нас, бие, сэтгэхүйн хувьд сонгох болон сонгогдох боломжтой эсэхийг тодорхойлж буй хэрэг юм.

Монголчууд бидний хувьд өөрийн гэсэн сонгуулийн түүхтэй. Түүх сөхөн үзэхэд XIII зууны үед эзэн хааныг сонгодог байжээ. Гэхдээ сонгох болон сонгогдох эрх нь өмнө бичсэнчлэн, цөөнхийн хүрээнд буюу алтан ургийн язгууртнуудад л хадгалагдаж байсан юм.

Бид төрийн эрх барих төлөөллийн байгууллагыг 1924 оноос эхлэн сонгох



Зураг 5.1. Чингис хаан, түүний залгамжлагчид

Улс төрийн сонгуулийн эрхийн шалгуур	
Сонгох эрхийн шалгуур	Сонгогдох эрхийн шалгуур
Нас - ихэнх улс оронд 18 нааснаас сонгох эрхийг эдэлдэг. (Зарим улс оронд 21, 22 нааснаас эдэлдэг)	Нас - Сонгогдох албан тушаалтны онцлогоос шалтгаалан ялгаатай.
Санал өгөх эрх зүйн чадамж - Хорих ял эдэлж байгаа, эрх зүйн чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд сонгох эрхгүй.	Сонгогдох эрх зүйн чадамж - Хорих ял эдэлж байгаа, эрх зүйн чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон бол сонгогдох эрхгүй. Тусгай шаардлага - Зарим үед сонгогдох албан тушаалын онцлогоос хамааран тусгай шаардлага тавьж болдог.

Монгол улсад 18 нас хүрсэн, санал өгөх эрх зүйн чадамж бүхий иргэд саналаа өгөх эрхтэй.

Монгол улсын Их Хуралд 25, Ерөнхийлөгчид 45 нас хүрсэн, санал өгөх эрх зүйн чадамж бүхий иргэн сонгогдох эрхтэй.

Монгол улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Монгол улсын угуул иргэн, сүүлийн 5 жил эх орондоо тогтвортой суурьшилтай амьдарсан байх ёстой.

Тодотгол.

“Хорих газар ял эдэлж байгаа” гэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих болон баривчлах ял эдэлж байгаа болон хорих ял эдлэхээс зайлсхийж явваа, хорих байгууллагаас түр чөлөөтөөр гарсан иргэнийг ...

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 2012. 3.1.6 дахь заалт

“Эрх зүйн чадамжгүй” гэдэг нь сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцдог...

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 2012. 3.1.6 дахь заалт



Үйл ажиллагаа 5.4. Үнэлгээ хийнэ үү.

Дараах тохиолдлыг сайтар уншаад, сонгууль өгөх боломжтой эсэхийг үндэслэл гарган тодорхойлно уу.

Нөхцөл	Сонгуульд оролцох боломжтой	Сонгууль оролцох боломжгүй	Яагаад?
Иргэн Бат сонгууль болохоос 3 хоногийн өмнө хотод сувилалд хэвтэж эмчлүүлэхээр ирсэн.			
Дулмаа Японд байгалийн ухааны чиглэлээр суралцдаг. Эх орондоо сонгууль өгөхөөр 1 сарын өмнө иржээ.			
19 настай Б саналаа өгөх гээд сонгуулийн байранд очтол сонгогчдын нэrsийн жагсаалтад нэр нь байхгүй байсан.			
Иргэн Э сонгууль өгөхөөр иргэний үнэмлэхгүй очжээ.			

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО


Сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, парламентын суудал хуваарилах арга, дүрэм, журмын цогцыг сонгуулийн тогтолцоо гэдэг. Дэлхийн улс орнуудад сонгуулийн тогтолцооны мажоритари буюу олонхоор тооцох, пропорциональ буюу хувь тэнцүүлэх хоёр үндсэн аргыг хэрэглэдэг. Эдгээр нь дор бүрдээ олон хувилбартай. Улс орнууд энэ хоёр тогтолцооны аль нэг хувилбараар, эсхүл хоёуланг нь хослуулан сонгуулияа зохион байгуулдаг.

Сонгуулийн тогтолцоо	
Мажоритари тогтолцоо	Пропорциональ тогтолцоо
Харьцангуй олонхын саналаар сонгох. Өрсөлдөгчдөөсөө илүү санал авсан нь ялдаг. Дотроо энгийн олонх, үнэмлэхүй олонх, харьцангуй олонх гэсэн аргатай. Энгийн олонх – 50-аас дээш хувийн санал авсан, харьцангуй олонх – хамгийн олон санал авсан, үнэмлэхүй олонх – нийт саналын $\frac{3}{4}$ буюу 75 хувь, эсвэл $\frac{2}{3}$ буюу 66 хувиас дээш санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцох арга. АНУ, Англи, Франц, Энэтхэг, Мексик зэрэг орнууд үнэмлэхүй олонхын аргыг хэрэглэдэг.	Намын нэрээр санал хурааж авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилдаг тогтолцоо. Нам дотроо нэрийн жагсаалтаар парламентын гишүүдийг бүрдүүлдэг. Нам, эсвэл суудал авахын тулд тогтоосон босго давах ёстой. Герман, Бельги, Дани, Австри, Швед, Япон зэрэг улс орнууд энэ аргаар сонгуулиа зохион байгуулдаг.
Холимог тогтолцоо	
Мажоритари болон пропорциональ тогтолцооны аль алиных нь онцлог шинжийг хадгалсан холимог тогтолцоо юм.	



Зураг 5.2. Сонгуулийн санал авах байр
парламентын судллын олонхыг авах тохиолдол гарна.

Энэ нь хоёр нам эсвэл зонхилох нэг намын тогтолцоо төлөвшихдэд нөлөөлдөг. Шинээр гарч ирж буй болон жижиг намд ашигтай. Парламентын гишүүд тойргийн сонгогчдоосоо хараат байдалтай, нутгийн хүнийг сонгох сэтгэл зүйн хандлага их, парламентын гишүүн нам хоёрын хоорондын хариуцлагын зарчим алдагдах зэрэг үр дагавартай.



Зураг 5.3. Саналын хуудас 2012 он

Мажоритари тогтолцоо нь өөрийн гэсэн давуу болон сул талуудтай. Тухайлбал: Өрсөлдөгчөөсөө олон санал авсан улс төрийн намд дангаараа Засгийн газар байгуулах боломжийг тулхүү олгодог. Энэ нь Засгийн газрыг илүү тогтвортой байлгахад нөлөөлдөг.

Улс төрийн намууд парламентад эзлэх судллын хувь нь нийт сонгогчоос авсан саналын хувиас ихээхэн зөрүүтэй байдаг. Харьцангуй олонхын саналаар сонгох үед энэ зөрүү улам их болдог. Улс орны хэмжээнд цөөнхийн дэмжлэг хүлээж буй нам

Сонгогчдын санал үлэмж хэмжээгээр “гээгддэг”. Сонгогдож чадаагүй нэр дэвшигчдийн төлөө саналаа өгсөн иргэд төлөөлөлгүй хоцорно.

Пропорциональ төлөөллийн тогтолцооны хувьд өөрийн гэсэн онцлогтой. Энэхүү тогтолцоо нь улс төрийн намуудыг бодлогын өрсөлдөөнд дуудаж, төлөвшүүлдэг, жендерийн болон угсаатны бүлгийн төлөөлөл, оролцоог дэмждэг, олон намын тогтолцоо төлөвшихдэд эерэг нөлөөтэй.

Мөн нийгэмд оршин буй олон янзын үзэл бодол, сонирхол парламентад бодитой төлөөлөгдөн, хүчний харьцаанд тусгалaa олдог, санал үл гээгдэх зарчим үйлчилдэг. Сонгогчдын тодорхой хэсгийн дэмжлэг авсан улс төрийн нам парламентад суудал авах боломжтой тул олон намын тогтолцоо төлөвшихөд нөлөөлнө.

Парламентад хэт олон нам төлөөлөгдөх магадлалтай байдаг нь эцэстээ нэгдсэн шийдвэр, зөвшилцөлд хүрэхэд бэрхшээлтэй болгодог. Бие даан нэр дэвшигчид сонгогох магадлал хязгаарлагдмал, орон нутгийн төлөөлөл хангах чадвар сул байдаг.



Үйл ажиллагаа 5.5. Дүн шинжилгээ хийгээрэй.

Баримт:

- 1992 оны УИХ-ын сонгуульд МАХН (одоогийн МАН) нийт сонгогчдын 53%-ийн санал авсан ч парламентын суудлын 92,1% буюу 70-ыг авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 47%-ийн санал авсан хэдий ч парламентад дөнгөж 6 суудал авч байсан.
- 2000 оны УИХ-ын сонгуульд МАХН (одоогийн МАН) нийт сонгогчдын 52%-ийн санал авсан ч парламентын суудлын 94,7% буюу 72-ыг авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 48%-ийн санал авсан хэдий ч парламентад дөнгөж 4 суудал авч байжээ.
- 2016 оны УИХ-ын сонгуульд МАН нийт сонгогчдын 45,69%-ийн санал авсан ч парламентын суудлын 85,5% буюу 65-ыг авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 54,31%-ийн санал авсан хэдий ч парламентад 11 суудал авч байжээ.

Асуулт:

1. Энэ З баримт сонгуулийн ямар тогтолцооны онцлогийг харуулсан бэ?
2. Сонгогчдын саналыг их авсан ч парламентын суудал бага авч байгаа шалтгааныг тайлбарлана уу.
3. Дээрх З сонгуульд намуудын авсан саналд тулгуурлан пропорциональ төлөөллийн аргаар хувь тэнцүүлж 76 суудалд хуваарилж, тоог гаргана уу.

УИХ-ын болон бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль можаритари тогтолцооны харьцангуй олонхын арга, хэлбэрээр явагддаг бөгөөд 2012 онд анх удаа холимог системийг ашиглан сонгуулийг зохион байгуулсан. Энэ нь УИХ-ын 76 гишүүний 48 нь можаритари тогтолцооны харьцангуй олонхын саналаар сонгогдож, үлдсэн 28 нь пропорциональ тогтолцооны (намуудын сонгогчдоос авсан саналын хувьд тэнцүүлэн суудал олгох) системээр зохион байгуулагддаг. 2016 оноос дахин можаритари тогтолцооны харьцангуй олонхын арга, хэлбэрээр зохион байгуулж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгууль мажоритари тогтолцооны энгийн олонхын (50+1) арга, хэлбэрээр явагддаг.

Сонгуулийг зохион байгуулах, санал хураах, санал тоолох, сонгуулийн үр дүнг нэгтгэх, нийтэд танилцуулах үүргийг сонгуулийн төв байгууллага хариуцдаг. Монгол улсад Сонгуулийн Ерөнхий хороо энэхүү үүргийг гүйцэтгэдэг бөгөөд хуулийн дагуу, шударга, хараат бус ажиллах үүрэг хүлээсэн байгууллага юм.

Иргэний
үнэмлэхээ авч
сонгуулийн
байранд ирнэ.

Үнэмлэхийг
сонгогчдын
нэрийн
жагсаалттай
харьцуулна.

Саналын
хуудас
авна.

Саналаа
өгнө.

Саналын
хайрцагт
/машинд/
саналаа
хийнэ.

Чөлөөт шударга сонгуулийн гол зүйл бол нууц санал хураалт

Бүдүүвч 5.3. Сонгуульд санал өгөх үйл явц

Ардчилсан сонгуулийг амжилттай явуулахад ард иргэд хүлээцтэй байж бусдын үзэл бодлыг хүлээн авах зохицой уур амьсгал бүрдүүлэх нь чухал. Өөрөөр хэлбэл, улс төрийн хүлээцтэй байдал хамгийн чухал байдаг бөгөөд энэ нь хүмүүс үзэл бодол үл нийлэх өөр хүмүүстэй ярилцах, сонгуулийн сурталчилгаа, жагсаал цуглаанд оролцох, эвлэлдэн нэгдэх боломжтой байхыг хэлдэг.

Хүмүүс бусдын хууль ёсны улс төрийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, хүлээцтэй хандахгүй бол бүх иргэдийн оролцоог хангах ардчилсан ёс зөрчигдөнө. Улс төрийн үл тэвчих байдал нь дур зоргоороо авирлах явдалд хүргэж ардчилсан үйл явцыг бэрхшээлтэй болгодог.

Улс төрийн намууд, тэдгээрийн удирдагчид сонгуульд өрсөлдсөний дараа үр дүнг нь хүлээн зөвшөөрч чаддаг байвал ардчилал амжилтад хүрдэг. Чөлөөт шударга сонгуулийн дараа засгийн эрхийг алдсан болон авах гээд чадаагүй хэн ч ялагдлыг хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ нь нэг талаас нийгэмд шударга ёсыг хангах, нөгөө талаас иргэдийнхээ сонголтыг хүндэтгэж буй явдал юм.



Үйл ажиллагаа 5.6. Эх сурвалжтай ажиллаарай.

Монгол улсын Их Хурлын сонгуулийн дүн (1992-2016)

№	Сонгууль	1992	1996	2000	2004	2008	2012	2016
1	Сонгуулийн насны хүний тоо	1.202.704	1.212.549	1.364.862	1.472.372	1.607.825	1.882.035	1.911.047
2	Санал өгсөн сонгогчийн хувь	95.6	92.1	82.4	82.2	76.46	67.28	74.35
3	Хүчинтэй саналын хуудасны хувь	94.0	95.6	97.5	98.5	98.38	100	98.26

4	Сонгуульд оролцсон нам эвсэл	8 нам 2 эвсэл	5 нам 2 эвсэл	13 нам 3 эвсэл	7 нам 1 эвсэл	12 нам 1 эвсэл	11 нам 2 эвсэл	12 нам 3 эвсэл
5	Нийт нэр дэвшигч	293	302	602	244	356	544	429
6	Бие даан нэр дэвшигч	18	35	27	15	45	26	69

1. Сонгогчдын тоо болон сонгогчдын ирцийг харьцуулан өөрчлөлтийг дүгнээрэй.
2. Сонгуульд оролцсон нам эвсэл болон нэр дэвшигчдийн тооны өөрчлөлтийг гаргаарай.
3. Санал өгсэн сонгогчдын тоо болон хүчинтэй саналын хуудасны тоог оноор харьцуулаарай.
4. Сонгуулийн тогтолцооноос хамаарч нэр дэвшигчдийг тоо хэрхэн өөрчлөгдсөнийг дүгнээрэй.
5. Хийсэн шинжилгээгээ хүснэгт, графикаар илэрхийлээрэй.



Гэртээ хийгээрэй.

1. Таны оршин суугаа газар УИХ-ын сонгуулийн хэддүгээр тойротг багтах вэ?
2. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн хэдэн сонгогчийн санаалаар сонгогдоныг олж мэдэж тайлбарлана уу.
3. Танай тойротг 2012, 2016 онуудад хэн, хэн нэр дэвшиж байсан, 2012 оны УИХ-ын сонгуульд улс төрийн намын нэрээр авсан саналд намуудын авсан саналыг олж, харьцуулан дүгнэнэ үү.

Aшиглах материал: CEX-ны www.gec.gov.mn



Нэмж судлаарай

- УТБА-ын лекцийн эмхэтгэл. УТБА. УБ., 2001
- Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. УБ., 2010

СЭДЭВ 5.3

ОРЧИН ҮЕИЙН НИЙГЭМ, УЛС ТӨРИЙН ҮЙЛ ЯВЦАД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ



Үйл ажиллагаа 5.7. Эргэцүүлэн ярилцаарай.

1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд юу ордог вэ?
2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ямар ач холбогдолтой вэ?
3. Сошиал медиа гэж юу вэ? Таны амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?

Хэвлэл мэдээлэл гэж юу вэ?

Нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэргийг хэвлэл мэдээлэл гэдэг. Мэдээлэл нь үнэн бодитой, тогтмол, шуурхай, хүртээмжтэй, багтаамж сайтай, идэвхтэй, ашигтай, чиглэсэн зорилготой байдал.

Дэлхий дахинд тогтмол хэвлэл 300 жилийн турш олон нийтийн мэдээллийн хэрэгслийн (ОНМХ) үүргийг дангаараа гүйцэтгэж байсан бөгөөд кино, радио, телевизий болсноор ОНМХ-ийн цоо шинэ систем бий болжээ. Орчин үед цахим хэвлэл эрчимтэй хөгжиж, мэдээллийн шинэ орон зай, боломжийг нээж, хэрэглэгчдийн тоо эрэс нэмэгдэж байна.

Хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг

Хэвлэл мэдээлэл нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангадаг тул ялангуяа, хэвлэлийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн үнэт зүйлийн салшгүй хэсэг юм. Өнөөгийн нийгэмд хэвлэл мэдээлэл нь онцгой үүрэгтэй бөгөөд түүнийг дөрөв дэх засаглал гэдэг.

Өнөө үед олон нийтийн мэдээллийн хэрэгслийг улс төрийн зүгээс хувийн ашиг сонирхолд ашиглах, Засгийн газрын алдааг илчлэн улмаар түүнийг татан буулгах асуудлыг хөндөх, мөн Засгийн газрын шинэтгэлийн бодлогыг сурталчлах зэрэг зерэг, сөрөг үйл ажиллагааг явуулдаг хэмээн тайлбарладаг. Нийгэмд хэвлэл мэдээлэл болон сэтгүүлчид төр, түүний эрх баригчдад бус олон түмэнд үйлчилж, нийгмийн хоточ нохой байж, эрх мэдлийг хянах үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс ч хэвлэл мэдээлэл нь олон түмний эрх ашгийн үүднээс нийгэмд болж буй үйл явцыг цаг тухайд нь үнэн зөв, шуурхай хүргэх үүрэгтэй. Мөн олон нийтийн үзэл бодлоо илэрхийлэх индэр байх ёстой.

Хэвлэл мэдээлэл нь дэлхийн болон тухайн улс орны улс төр, эдийн засаг, соёлын үйл явцын талаарх мэдээллийг цаг алдалгүй ард түмэнд хүргэх үүрэг гүйцэтгэж байдал.

Хэвлэл мэдээлэл (mass media)	Сошиал медиа (Social media)
	



Үйл ажиллагаа 5.8. Баримтыг задлан шинжлээрэй.

2015 оны “Ардчилсан засаглал” судалгааны дүнгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөллийг авч үзвэл, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улс төрөөс хараат бус байдаг гэдэгтэй судалгаанд хамрагдсан иргэдийн 42.6 хувь нь санал нийлдэггүй, 23.0 хувь нь дунд зэрэг буюу өмнөх онтой харьцуулахад тус тус 1.9 пунктээр өссөн, харин 8.3 хувь нь санал нийлдэг гэж хариулсан ба өмнөх оноос 3.5 пунктээр буурсан байна. Мөн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс нэлзээд хараат байна гэж иргэдийн дийлэнх үзэж байгаа нь нийт авбал зохих онооны дөнгөж тавны нэгийг авч байгаагаар илэрхийлэгдэж байна.

Эх сурвалж:http://1212.mn.Cover_2014-2015.pdf&ln=Mn

Асуулт:

1. Эх сурвалж ямар асуудлыг хөндөж байна вэ?
2. Үг асуудлын талаар өөрийн байр сууриа илэрхийлнэ үү
3. Төр засгийн зүгээс энэ асуудлыг шийдвэрлэх ямар бодлого явуулах шаардлагатай гэж үзэж байна вэ?
4. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд иргэд, улс төрийн бусад байгууллага ямар үүрэг, оролцоотой вэ?

Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл нь дараах түгээмэл гурван үндсэн үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:

- Мэдээлэл олгох
- Иргэдэд өөрийн гэсэн санаа бодол төлөвшүүлэхэд оролцон туслах
- Хяналт шалгалт, шүүмжлэл өрнүүлэх
- Цэнгээн баясгах, боловсрол олгох гэсэн чиг үүрэгтэй байдаг.

Олон нийтийн хэвлэл мэдээлэл нь аль болох бүрэн бүтэн, үнэн зөв, бодитой, ойлгомжтойгоор мэдээллээ хүргэх хэрэгтэй. Ингэснээр иргэд нийгэмд болж байгаа бүхий л үйл явдалтай танилцах, дүн шинжилгээ хийж, өөрийн байр сууринаас үнэлэлт дүгнэлт өгөх, байр сууриа илэрхийлэх боломжийг олгодог.

Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл нь ард түмэнд үнэн зөв мэдээлэл хүргэхэд дараах зарчмуудыг мөрдөнө.

- Нэг хүний эрх ашгийн төлөө бус олон түмний тулд үнэн зөв мэдээлэл дамжуулах
- Нас хүйс, шашин шүтлэг, боловсролын түвшинг харгалзахгүйгээр бүх нийтэд тэгш хүргэх боломжийг нь хуулиар хангах
- Ард түмний дуу хоолой болох
- Хэвлэл мэдээллийн ажилтнууд болон сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах

Эдгээрийг мөрдлөг болгосноор хэвлэл мэдээлэл нь бүрэн утгаараа иргэдийн дуу хоолой болох учиртай.



Үйл ажиллагаа 5.9. Баримтыг уншиж, шинжилгээ хийж, асуултад хариулаарай.

2016 оны судалгаагаар Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг гэж судалгаанд хамрагдагсад 49.3 оноо өгсөн нь өмнөх оноос 8.1-ээр буурсан байна. Мөн иргэдийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад итгэх итгэл Монголын үндэсний телевизэд 90, үндэсний радио, орон нутгийн телевизэд 80, хувийн телевизэд 78, өдөр тутмын хэвлэлд 68, FM радиод 60 гэсэн үнэлгээ өгсөн нь өнгөрсөн оноос 1-6 оноогоор буурсан байна.

Харин шар хэвлэлийн хувьд 34 оноо буюу өмнөх оноо 4-өөр буурсан нь шар хэвлэлд итгэдэггүй хэвээр байгааг харуулж байна. 2015 онд иргэдийн хэвлэл мэдээллийн байгууллагад итгэх итгэл 80 оноо өгсөн нь өмнөх оныхосс 6 оноогоор буурсан байна.

Асуулт

1. Энд ямар асуудал хөндөгдөж байна вэ?
2. Хэвлэл мэдээлэл цргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?
3. Энэ асуудлыг шийдвэх төрийн бодлогын хувилбар дэвшүүлж давуу болон суп талыг тодорхойлоорой
4. Төрийн сонгосон бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарлаарай.



Гэртээ хийгээрэй.

Мэдээлэл бэлтгэн ирж танилцуулаарай.

- Төрийн гэр бүл болон найз нөхдийн хүрээнд гар утасны ухаалаг хэрэглээний талаар судалгаа хийн, илтгэл бэлтгэж, танилцуулна уу.



Нэмж судлаарай

- Хэвлэлийн Хурээлэн. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. УБ., 2015, 2016, 2017

СЭДЭВ 5.4 УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ

УЛС ТӨРИЙН СИСТЕМ, ТҮҮНИЙ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН



Тулгуур ойлголт

Улс төрийн систем гэж нийгэмд засаглалыг зохион байгуулан, нийгмийн баялгийг хуваарилан байршуулах арга хэрэгслүүд, эрх зүйн хийгээд улс төрийн хэм хэмжээ, дэг журмын цогц, төр, улс төр, иргэд нийгмийн байгууллагуудын нэгдэл юм.

улс төрийн дэд институт бүр өөр өөрийн чиг үүрэгтэй байдаг.

Улс төрийн систем бол нийгмийн системийн нэгэн дэд систем юм. Эрх мэдлийн үндсэн дээр нийт олны даган биелүүлэх шийдвэрийг гаргаж байдаг нийгмийн хүрээ юм. Мөн нийгэм болон түүний бүлгүүдийн хамтын зорилго, сонирхлыг тодорхойлон хэрэгжүүлж байдаг парламент, засгийн газар, шүүх, улстөрийн намууд, сонирхлын бүлэг зэрэг улс төрийн дэд институттээр дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Тэдгээр

Нийгмийн бүлэг, институт бүр нийтийг хамарсан аливаа шийдвэрийг өөртөө ашигтайгаар гаргахын төлөө өөрийг төлөөлсөн улс төр, олон нийтийн бүлэг, эвсэл, хөдөлгөөн зэргээр дамжуулан идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Ингэснээр эрх мэдлийнхээ үндсэн дээр нийт иргэдийн даган биелүүлэх шийдвэрийг гаргаж байдаг. Улс төрийн системийн тухай онолыг боловсруулахад ихээхэн хувь нэмэр оруулсан сэтгэгчид бол улс төр судлаач Д.Истон, Г.Алмонд нар юм.


Улс төрийн дэд системүүд

Улс төрийн системийн бүрдэл хэсгүүд буюу оролт, хувиралт, гаралт, эргэх холбоо, тэдгээрийг бодит байдал дээр хэрэгжүүлэгчид болох иргэд, сонирхлын бүлгүүд, улс төрийн нам, төр, хэвлэл мэдээлэл зэрэг нь хоорондоо харилцан хамааралтай бөгөөд тасралтгүй гинжин хэлхээ холбоотой байдаг. Улс төрийн систем нь түүнийг бүрдүүлэгч дэд системүүдийн чиг үүргээрээ холбогдсон нэгдэл. Үүнд:

- Тогтолцооны (институционал) дэд систем
- Мэдээлэл - харилцаа (коммуникаци)-ны дэд систем
- Хэм хэмжээ - зохицуулалтын дэд систем

Тогтолцооны (институциональ) дэд систем

Аливаа систем «оролт», «хувиралт», «гаралт», «эргэх холбоо» гэсэн хэсгээс бүрддэг ба улс төрийн системийн хувьд «оролт» нь олон түмний шаардлага, дэмжлэг, «гаралт» нь шийдвэр, үйлдэл юм.



Будууч 5.4. Улс төрийн системийн загвар (Д.Истон)

ОРОЛТ-д хамаарах шаардлага гэдэг нь улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологийн, эдийн засгийн, соёлын зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд юм. Тухайн нийгмийн онцлогоос шалтгаалан шаардлага нь олон янз байдаг. Улс төрийн систем оршин тогтнож, үйлчлэхэд зөвхөн шаардлага хангалттай бус дэмжлэг бас хэрэгтэй болдог.

Дэмжлэг нь оролцооны ба бодит гэсэн хоёр хэлбэртэй. Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх, тодорхой бодлого, шийдвэрийг дэмжих буйгаа илэрхийлэх зэрэг нь оролцооны дэмжлэгийн жишээ юм. Бодитой дэмжлэгт татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль журмыг дагаж мөрдөх, төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэн үзэх зэрэг орно. Үнэт зүйлсийн хуваарилалт зөв явагдаж байгаа бол дэмжлэг нь голлож, урвуу явагдвал шаардлага нь голлоно.

Улс төрийн систем шаардлага, дэмжлэг буюу оролтыг шийдвэр, үйлдэл буюу ГАРАЛТ болгож хувиргана. Шийдвэр, үйлдэл нь төрийн бодлогын тодорхой илрэл

болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа зэрэг болно. Орж буй хүчин зүйлийг гаралт болгож хувиргахдаа улс төрийн систем нь зорилгодоо хүрэх үүднээс нийгмийн нөөцийг дайчилж, нийгмийн гишүүдийн хүч чармайлтыг зохицуулалтаар хангана.

Гаралт нь энэхүү харилцан үйлдэл бүхий үйл явцын эцсийн цэг биш, тасралтгүй үргэлжлэх орчлын нэг л үе шат болно. Орчлын энэ үйлдлийг ЭРГЭХ ХОЛБОО гэж нэрлэдэг. Энэ нь улс төрийн системд хувьсан өөрчлөгдж буй орчинд зохицох, шинэчлэх, өөрийгөө хадгалах бололцоог олгодог. Тэрчлэн эргэх холбоо нь нийгмийн хурцадмал, тогтвортгүй байдлын арилгах гол механизмын үүргийг гүйцэтгэгдээрээ онцлогтой.



Үйл ажиллагаа 5.10. Баримтыг уншиж, шинжилгээ хийж, асуултад хариулаарай.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй байгаль хамгаалах иргэний нийгмийн хөдөлгөөнүүд, ард иргэдийн шаардлага, эсэргүүцэл, хөдөлгөөний үр дүнд 2009 оны 07 дугаар сарын 16-нд “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг батлан гаргасан. 2015 онд бизнес эрхлэгчид, уурхай эрхлэгчдийн хүсэлт, шаардлагын дагуу уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

1. Дээрх эхийг анхааралтай уншаад, улс төрийн системийн *Д.Истоны* загварыг ашиглан, тайлбар хийж, харилцан ярилцана уу.

Негеө талаар улс төрийн систем нь:

1. Сонирхол илэрхийлэх үйл ажиллагаа бөгөөд нийгмийн гишүүд, бүлгийн ашиг сонирхлыг тодорхой арга хэрэгслийн тусламжтайгаар илэрхийлдэг. /Сонирхлын бүлгүүд, иргэний хөдөлгөөн, ТББ гэх мэт орно/
2. Сонирхлыг нэгтгэх үйл ажиллагаа бөгөөд бүх сонирхлыг бүрэн хангах бололцоо нийгэмд байдаггүй тул тэдгээрийг нэгтгэн бодлого боловсруулах үүрэг хүлээдэг. /Улс төрийн нам, эвслүүд орно/
3. Сонирхлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа бөгөөд бодлогыг нийтээр дагаж мөрдөх шийдвэрт тусгуулж, түүнийг улс төрийн засгийн эрх мэдлээр биелүүлэх үүрэгтэй. /Үүнд төр орно/

Мэдээлэл - харилцааны дэд систем

Мэдээлэл-харилцааны дэд систем нь улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох, төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах «сувгийн» үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү дэд системийн ач холбогдол асар их бөгөөд улс төрийн системийн үйлчлэл нь хүмүүсийн авч буй мэдээллийн түвшин, хүрээнээс ихэд шалтгаалдаг. Хүмүүс тодорхой мэдээлэл, мэдлэгтэй байж л улс төрийн аливаа үйлдлийг үнэлэх боломжтой. Мэдээллийн хэрэгсэл эрх чөлөөтэй байна гэдэг нь зөвхөн тунхаглаж, бахархдаг зүйл гэхээсээ илүү хувь хүнд сонголт хийх эрхийг өөрт нь олгож байгаагийн гол баталгаа болдог.

Негеө талаас мэдээлэл хүний үзэл бодолд нөлөөлж, өөрчилдөг тул үүнийг ашиглан төрийн зүгээс үзэл бодол тулгах маш том механизм үйлчилж, хүнийг хариуцлагагүй, идэвхгүй байр сууринд аваачих тал байдаг. Иргэд нь мэдээлэл олж авах, хайх эрхээ

эдлэх болон шийдвэр гаргагч институтын зүгээс мэдээллээр хангах сувгийг бүрэн баталгаажуулж өгч чадсан тохиолдолд улс төрийн системийн энэ дэд систем үр ашигтай үйлчилдэг байна.

Хэм хэмжээ-зохицуулалтын дэд систем

Хэм хэмжээ-зохицуулалтын дэд систем нь улс төрийн амьдрал дахь хүмүүсийн үйл байдал болон бусад объектын чиг үүргийг тодорхойлох хэм хэмжээнээс бүрдэх бөгөөд дадал заншлын, хууль зүйн гэж ангилна.

Ардчилсан нийгэмд улс төрийн нам, сонирхлын бүлгээр дамжин улс төрийн амьдралд оролцох хүмүүсийн оролцоог дадал заншлын хэм хэмжээ гэж үзнэ.

Хууль зүйн хэм хэмжээ нь хууль тогтоох үйл явцыг тодорхойлж үг хэлэх, саналаа илэрхийлэх, эвсэн нэгдэх зэрэг эрхийг тогтооно. Энэхүү хоёр төрлийн хэм хэмжээ нь улс төрийн харилцан нөлөөлөл, үйлдлийг бэхжүүлэхэд чиглэдэг бөгөөд эдгээргүйгээр эмх замбараагүй байдал үүсэх магадлалтай байдаг байна.

Улс төрийн системийн чиг үүрэг

Уг асуудлыг Г.Алмонд нарийн судалжээ. Тэрээр улс төрийн системийн үндсэн хоёр бүлэг болох “оролт”, “гаралт”-ын чиг үүрэг байдгийг тодорхойлсон юм. Үүнд:



Бүдүүвч. 5.5. Улс төрийн системийн загвар

Оролтын чиг үүргийг үндсэндээ төрийн бус дэд систем гүйцэтгэдэг бол гаралтын чиг үүрэг гарцаагүй төрийн мэдэлд байдаг. Гэхдээ энэ чиг үүргүүд нь уламжлалт хаант засагтай болон нэг хүний дарангуйллын үед систем дэх “оролт” бүрэн утгаар илэрч чадахгүй, иргэд зөвхөн “гаралт”-ыг “эргэх холбоо”-гүйгээр шахам хүлээн авдаг. Харин парламентат ёс, ардчилал дэлгэрсэн улс орнуудад бүрэн утгаар хэрэгжих бололцоотой юм.



Гэртээ хийгээрэй.

Өөрийн амьдардаг баг, хорооны эсвэл сум, дүүргийн Засаг даргын шийдвэр хэрхэн, ямар замаар гардаг талаар судалж, ангидаа харилцан ярилцаарай.



Нэмж судлаарай

- УТБА-ын лекцийн эмхэтгэл. УБ., 2001
- Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. УБ., 2010

УЛС ТӨРИЙН ИНСТИТУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЧИГ ҮҮРЭГ


Сонирхлын бүлэг



Үйл ажиллагаа 5.11. Эргэцүүлэн ярилцаарай.

Танай ангийн сурагчдын дотор дугуйлан, секц, клубт хэчинээн сурагчид хамрагдаж байна вэ? Сурагчид өөрсдийн сонирхлоороо нэгдэж чадсан уу? Ярилцаарай?

Бид өмнөх сэдвээр улс төрийн системийн талаар судалж, улс төрийн үйл явцад нийтийн эрх ашиг, сонирхлыг илэрхийлдэг, нэгтгэдэг, хэрэгжүүлдэг бие даасан институт (бүтэц) байдаг талаар судалсан. Энэ нь төрийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулахад чухал нөлөө үзүүлдэг тухай үзснийг эргэн санацаа.




Бүдүүсч. 5.6. Улс төрийн системийн институтуудын чиг үүрэг

Хүмүүс бидний сонирхол, хүсэл эрмэлзэл нь тодорхой шалтгаан, сэдэл дээр нэгддэг. Жишээ нь: Хүүхдүүд та бүхэн аяллаар явах, спортоор хичээллэх, сурагчдын өөрийн удирдлагын байгууллагад ажиллах сонирхол зэрэг нь тэдний өөрсдийгөө хөгжүүлэх сэдэл, шалтгаан дээр тулгуурлан нэгдэж болно. Харин өөрсдийг нь нэгтгэж буй зүйлийнхээ талаар ямар нэгэн шийдвэр гаргуулах, өөрсдийн эрх ашгийг хамгаалах, дуу хоолойгоо илэрхийлэх шаардлага зүй ёсоор урган гардаг. Хүмүүс ганц нэгээрээ өөрийн дуу хоолойгоо илэрхийлэх нь төвөгтэй, үр дүн багатай учир хоорондоо нэгдэх, зохион байгуулалтад орох шаардлагаас үүдэн сонирхлын бүлгүүд бий болдог.

Сонирхлын бүлэг гэдэг бол хувийн эрх ашгийн төлөө бус, бүлгийн буюу нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор иргэдээс сайн дураар үүсгэн байгуулсан байгууллага, хөдөлгөөн юм. Сонирхлын бүлгүүд ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд янз бүрийн үйл ажиллагаа явуулж байдаг. Зарим тохиолдолд сонирхлын бүлгийг лобби бүлэг хэмээн явцууруулан ойлгодог. Сонирхлын бүлгийн үйл ажиллагааны нэгээхэн хэсэг нь лобби хийх явдал байдаг.


Онцгой ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад сонирхлын бүлгүүд зорилго, чиглэл бүхий нөлөө үзүүлэхийг “Лоббизм” гэдэг. Энэ нь англиар үүдний өрөө гэсэн утгатай бөгөөд XVII зууны 40-өөд оноос Их Британий парламентын ордны барилгын хонгил, хүлээх өрөөг лобби хэмээн хэлдэг байсан, үүгээр төлөөлөгчид саналаа өгөхөөр явахдаа нэгдсэн хуралдаанд оролцох эрхгүй сонирхогч хүмүүстэй уулздаг газар нь байжээ.



Зураг 5.4. Сонирхлын бүлгийн үйл ажиллагааны олон янз байдал

Сонирхлын бүлэг нь орон нутгийн болон үндэсний, зарим үед олон улсын түвшинд ажилладаг ба үйл ажиллагааны хүрээ, чиглэлээр нь дараах хэсгүүдэд хуваадаг. Үүнд:

- Амралт, чөлөөт цагийн бүлэгт: Биеийн тамирын, соёл, ёс заншлын өвийг хамгаалах, цэцэрлэг эрхлэгчдийн (цэцэг жимс, мод таригчдын), амьтан тэжээгчдийн, нийтийн дугуйлан болоод сонирхогчдын холбоо, клубууд (марк цуглуулагчдын, төгөлдөр хуурчдын, хөл бөмбөг сонирхогчдын фен клуб гэх мэт)
- Эдийн засаг, аж ахуй, үйлдвэрлэгчдийн бүлэгт: Эдийн засаг, бизнесийн бүхий л салбарын эвсэл холбоод, ажил олгогчдын болон ажил хайгчдын холбоо, мэргэжлийн холбоод, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүд,
- Шинжлэх ухаан, соёл, урлаг, боловсролын бүлэгт: Боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх бүх эвсэл холбоод, урлаг, соёл, шинжлэх ухааны холбоо, судалгааны нийгэмлэг, санггууд,
- Нийгмийн асуудал болон эрүүл мэндийн бүлэгт: Нийгмийн халамж, эмэгтэйчүүдийн байгууллага, хүүхэд, залуучууд, ахмадын холбоо, гадаад иргэд, цагаач иргэд, дүрвэгчдийн нийгэмлэг, холбоо,
- Үзэл суртал, шашны чиглэлийн бүлэгт: Сүм хийд, шашны байгууллагууд, нийгэм, улс төрийн эвсэл холбоод тус тус багтдаг.



Бүдүүвч 5.7. Сонирхол илэрхийлэх үйл ажиллагаа

Сонирхлын бүлгийн хэв шинжийн олон ангилал байдаг бөгөөд Америкийн улс төр судлаач А.Алмонд сонирхлын бүлгийг өөрсдийнх нь өвөрмөц байдал, дотоод зохион байгуулалтаас хамааран доорх дөрвөн хэв шинжид ангилсан байдаг. Үүнд:

Бүлгийн хэв шинж	Онцлог:
Аномик	Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт, бослого, үймээнийг хэлдэг.
Эвсэл холбооны (associational)	Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай бүлэг
Эвсэл холбооны бус (non associational)	Зохион байгуулалтгүй боловч аномик бүлгээс ялгаатай нь хүмүүс голдуу яс үндэс, угсаа гарал, арьс өнгө, шашин шүтлэг, нас, хүйс зэрэг нийтлэгээрээ хамрагддаг.
Байгуулагажсан (institutional)	Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектийн шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулдаг.

Сонирхлын бүлгийн тавьж байгаа зорилгын шинж чанар нь түүний хэрэгжилтэд зохих нөлөө үзүүлнэ. Зорилго бодитой бус, биелэх боломжгүй байвал мэдээж амжилтад хүрэхгүй. Харин бодитой хэрэгжих боломжтой зорилгын хэрэгжилт нь тухайн үед төрөөс явуулж байгаа бодлого, үйл ажиллагаатай нийцэж байгаа үед амжилттай болох магадлалтай. Харин зорилго төрийн бодлого, үйл ажиллагаатай зөрчилдөж байх юм бол түүнийг хэрэгжүүлэх нь төдийлөн хялбар биш байна. Бүлгийн тавьж буй зорилго нь олон нийтийн санаа бодол, үнэт зүйлд нийцтэй бол тэдний дэмжлэгийг авах ба нийцгүй бол дэмжлэг авахгүйгээр барахгүй эсэргүүцэл дургүйцлийг ч төрүүлдэг.

Сонирхлын бүлгийн үйл ажиллагаа нь түүний чиг үүргээр илэрнэ. Тэдгээрийн дотроос нийгэм дэх олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах (артикуляци) нь үндсэн чиг үүрэг болдог. Үүний дараа сонирхлын бүлэг нь явцуу олон шаардлагыг цэгцлэн, нэгтгэн боловсруулах бөгөөд үүнийг сонирхлын агрегаци гэдэг.

Сонирхлын артикуляци нь бүлгийн шаардлагыг хэрхэн илрүүлж гаргаснаас ихээхэн хамаардаг бөгөөд тодорхой бус, сэтгэл хөдлөлийн аястай шаардлагыг улс төрийн шаардлага болгон нэгтгэхэд төвөгтэй байдаг. Нөгөө талаас бүлгийн түгээмэл эрх ашиг, сонирхлыг нэгтгэн боловсруулж дэвшүүлсэн шаардлага нь төрийн байгууллагын зүгээс хүлээн авч, оновчтой шийдвэр гаргахад эерэг нөлөөтэй байдаг. Иймээс сонирхлын бүлгийн доторх эв нэгдэл чухал ач холбогдолтой юм. Үүнтэй холбогдож, сонирхлын бүлгийн интеграцийн чиг үүрэг яригдах бөгөөд энэ нь бүлгийн гишүүдийн сонирхлыг нэг үзүүрт чиглүүлэх буюу нэгтгэхэд чиглэнэ. Сонирхлын бүлэг эрх ашиг, сонирхлоо нэгтгэж чадсанаар улс төрийн шийдвэрт тусгуулж чаддаг.

ХХ зууны дунд үе хүртэл сонирхлын бүлгийг ашиг сонирхлоо парламентын гишүүдэд дарамт үзүүлэх байдлаар тусгуулдаг хэмээн ойлгодог байв. Орчин үед сонирхлын бүлэг нь маш олон арга замаар энэхүү зорилгоо хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Асуудлаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, ард түмний дэмжлэгийг авсны үндсэн дээр парламентаар хялбархан шийдвэрлүүлэх,
- Том хэмжээний эсэргүүцлийн жагсаал цуглаан зохион байгуулах,
- Ямар нэгэн асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд нам эрх бүхий албан тушаалтанд сонгуулийн болоод бусад үед санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсвэл үзүүлэхгүй гэдгээ илэрхийлэх,
- Мэдээллийг хянаж түүнд дүн шинжилгээ хийх,
- Заргалдах (Энэ тактикийг ихэвчлэн хүч султай сонирхлын бүлгүүд ашигладаг) зэрэг арга замууд нэлээд түгээмэл байна.



Бүдүүеч 5.8. Сонирхлын бүлгийн чиг үүрэг



Үйл ажиллагаа 5.12. Хэлэлцүүлэг хийгээрэй.

Засгийн Газраас танай сургуулийн ойролцоо арьс ширний үйлдвэр барихаар шийджээ. Танай сургуулийнхан энэ бол хүүхдийн эрүүл, аюулгүй амьдрах эрхийг зөрчиж байна хэмээн эсэргүүцэв. Арьс ширний үйлдвэрийн асуудал хариуцсан Засгийн Газрын түшмэл танай сургуулийн 2 төлөөлөгчийг хүлээн авч уулзахаар болжээ.

Асуулт

1. Уулзаж буй 2 талын ярилцлагыг дүрд тоглох аргаар үзүүлнэ үү.
2. Танай сургуулийн хамт олон ямар үндэслэл гаргах вэ?
3. Засгийн Газрын шийдвэрийг өөрчлүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?



Зураг 5.5. УИХ-ын чуулганы танхим

Дэлхийн зарим улс оронд сонирхлын бүлэг нь парламенттай хэрхэн харилцдаг болохыг авч үзье.

Герман улсад Бундестагийн үйл ажиллагааныхаа журмын 7-р зүйлд дэд хороо болоод ажлын хэсэг нь сонирхлын бүлгээс мэргэжлийн хувьд заавар зөвлөгөө авч болохыг зөвшөөрсөн байдаг. Харин АНУ-д сонирхлын бүлгүүд нь мужийн засаг захиргаатай зөвшилцэлд хүрч чадахгүй байгаа нөхцөлд уг асуудлаа нийт улсын хэмжээнд

дэлгэн тавьж хуулиар шийдвэрлүүлэх жишээтэй. Их Британид сонирхлын бүлгүүд нь гүйцэтгэх засаглалтай холбогддогийнхоо хувьд яамдын сайдууд болон иргэний төлөөлөгч нартай харилцдаг. ОХУ болоод Зүүн европын орнуудад сонирхлын бүлэг нь ихэвчлэн бизнесийн сонирхол дээр түшиглэдэг.

Аливаа ардчилсан орны улс төрийн бодлого үйл ажиллагаанд сонирхлын бүлгээр дамжуулан иргэдийн эрх ашиг тодорхой хэмжээгээр тусгагдсан байдаг бөгөөд сонирхлын бүлэг нь хувь хүмүүсийн хүсэл сонирхлыг илүүтэй тусгасан байдгаараа ямар нэгэн байгууллага, хүчинээс хараат бус, харьцангуй биеэ даасан шинжтэйгээр улс төр, нийгмийн амьдралд оролцож, жирийн иргэдийн аж амьдралтай холбоотой асуудалд гол анхаарлаа хандуулдаг учраас иргэдэд хамгийн ойр дэт субъект юм.



Үйл ажиллагаа 5.13. Багаар ажиллаарай.

1. Та бүхэн клуб байгуулах талаараа саналаа гаргана уу.
2. Клубийн нэр, зорилго юу вэ?
3. Клубийн үйл ажиллагааны чиглэл?
4. Клубийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хийх ажлуудаа төлөвлөөрэй.

УЛС ТӨРИЙН НАМ



Үйл ажиллагаа 5.14. Эрэгцүүлэн ярилцаарай.

1. Монгол улсын нийгмийн амьдралд улс төрийн намууд ямар эерэг болон сөрөг нөлөө үзүүлж байна вэ?
2. Улс төрийн намууд байхын ач холбогдол юу вэ?
3. Хэрэв улс төрийн нам байхгүй бол юу болох бол?

Ардчилсан улс төрийн тогтолцоонд үйлдвэрчний эвлэл, залуучууд болон эмэгтэйчүүдийн байгууллага, олон нийтийн эвсэл, хөдөлгөөн, холбоо, улс төрийн нам зэрэг олон нийтийн байгууллагууд чухал байр суурийг эзэлдэг. Тэдгээр олон нийтийн байгууллага нь иргэний суурь эрхийн нэг болсон эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөөр тодорхойлогдож байдаг. “Сонирхлын бүлэг” нь иргэдийн эрх ашиг, сонирхлыг янз бүрийн арга, хэлбэрээр илэрхийлэхээр зорьж ажилладаг талаар бид судалсан. Харин улс төрийн нам бол иргэд сайн дураар эвлэлдэн нэгдэж, засгийн эрхийг авахыг эрмэлзэж улс төрийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага. Улс төрийн нам нь нийгэмд оршин буй олон янзын эрх ашиг, сонирхлыг нэгтгэн илэрхийлж байгаагаараа сонирхлын бүлэгтэй төстэй, нөгөө талаас салангид, явцуу шинжтэй сонирхлуудыг нэгтгэн, улмаар засгийн эрхийг авсан тохиолдолд тэдгээр сонирхлыг хэрэгжүүлэхээр зорьж ажилладаг онцлогтой.



Зураг 5.6. Английн хувьсгалын үйл явц

Түүхэн үүднээс намын үүслийг XVII зууны сүүл XVIII зууны эхэн үед хамааруулдаг. Энэ үед Баруун Европ, АНУ-д засаглалын шинэ харилцаа бүхий улс төрийн систем үүсэж эхэлсэн түүхтэй. Иймд улс төрийн намын үүсэл нь Франц, Английн хувьсгалууд, АНУ-ыг байгуулах тэмцэл, хөдөлгөөн зэрэгтэй холбогддог. Бүгд найрамдах төрийн шинэ хэлбэр тогтох үйл явцад олон нийтийг төлөөлөх, засаглалыг зохион байгуулах байгууллага үүссэн нь улс төрийн нам юм.

Нам бүрэлдэн бий болсноор улс төрийн системийн хөгжлийн нэгэн чухал үе шат болж хаант засаглалын эрх мэдлийг хязгаарлах, улс төрийн амьдралд төлөөллийн системийг хөгжүүлэх, бүх нийтийн сонгох эрхийг бэхжүүлэхэд дэвшил авчирсан юм.

Улс төрийн нам гэдэг нь улс орны хөгжлийн бодлогыг хамтын зарчмаар тодорхойлж, хэрэгжүүлж, улс төрийн хамтын хариуцлага хүлээх чадвартай иргэдийн эвлэлдэн нэгдсэн байгууллага юм. Үүнийг тайлбарлавал:

- Улс орны хөгжлийн бодлогыг хамтын зарчмаар тодорхойлох. Улс орныг хөгжүүлэх бодлогыг өөрийн үнэт зүйлд тулгуурлан олон нийтийн оролцоотойгоор боловсруулах,
- Боловсруулсан бодлогоо хэрэгжүүлэхийн тулд сонгуульд өрсөлдөн олонхын дэмжлэг авч хэрэгжүүлэх,
- Бодлогоо хэрэгжүүлэхдээ алдаа гаргах, биелэлтийг нь бүрэн хангаж чадахгүй бол улс төрийн хариуцлага хүлээх чадвартай байх,
- Иргэд өөрсдийн үзэл бодол, сонирхлоороо сайн дурын үндсэн дээр чөлөөтэй эвлэлдэн нэгдсэн байгууллага болохыг тус тус илэрхийлж байдаг.

Улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зориг, нийтлэг эрх ашиг, сонирхлыг илэрхийлдэг иргэдийн чөлөөт нэгдэл тул арчиллын үнэт зүйлс болсон сайн дураараа эвлэлдэн нэгдэж үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн оролцоот хамтын шийдвэрийг гаргадаг байх асуудалтай зайлшгүй тулгардаг.

Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх үүрэг

- Улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх - Өмнө хэлсэнчлэн улс орноо хөгжүүлэх бодлогыг боловсруулан сонгуульд өрсөлдөж ялалт байгуулан түүнийгээ хэрэгжүүлэх.
- Улс төрчдийг бэлтгэж, чадавхжуулан нэр дэвшиүүлэх - Улс орныхоо хөгжлийн төлөө санаа тавьж зүтгэн хөдөлмөрлөдөг, үнэнч шударга, чадварлаг, нийтийн эрх ашгийг дээдэлсэн улс төрчдийг бэлтгэх, нэр дэвшиүүлэх
- Бодлогын хэрэгжилтээ тайлагнах, хариуцлага хүлээх - Хэрэгжүүлсэн бодлогоо олон нийтийн өмнө тайлагнаж, алдаа гаргасан бол хариуцлага хүлээж чаддаг байх.
- Намын дотоод арчиллыг хангах - Намын дотоод бүх үйл ажиллагаа арчилсан зарчмаар явагддаг байх
- Иргэдийн оролцоог хангах - Намын болон улс орны талаарх асуудлыг шийдэхэд иргэдийн оролцох боломжийг хангах зэрэг болно.

Нийгэмд хэчнээн тооны улс төрийн намууд эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа, эсхүл засаглалд ойр байгаагаар нь нэг намын, хоёр намын, олон намын тогтолцоо гэж ангилдаг.



Зураг 5.7. 1990 оноос өмнөх баярын жагсаал



Зураг 5.8. АНУ-ын Арчилсан нам,
Бүгд найрамдах намын бэлгэ тэмдэг

Нэг намын тогтолцоо - Зөвхөн нэг нам дангаар ноёрхож, төрийн эрх мэдлийг барих ба бусад нам, хөдөлгөөнийг хориглодог тогтолцоо. Жишээ нь: хуучин ЗХУ болон социалист гэгдэж байсан орнууд ийм хэлбэрийн намын тогтолцоотой байсан. Монгол улс 1921-1990 онд нэг намын тогтолцоо бүхий байсан.

Хоёр намын тогтолцоо - Тухайн улс оронд засгийн эрх мэдлийг хүлээн авч хэрэгжүүлэх чадвартай хоёр намаас бүрддэг, сонгуульд нэг нам нь ялахад нөгөө нь сөрөг хүчин болж харилцан засгийн эрх мэдлийг авч хэрэгжүүлж байдаг. Энэ үед улс оронд өөр жижиг намууд оршдог боловч тэд сонгуульд ялж засгийн эрх мэдлийг авах боломжгүй байдаг. Жишээ нь: Үүнд АНУ болон Их Британийн намын тогтолцоог багтаадаг.



Зураг 5.9. 2012 онд УИХ-д суудал авч байсан зарим намын бэлгэ тэмдэг

Олон намын тогтолцоо – Улс төрийн амьдралд хэд, хэдэн нам идэвхтэй оролцож, засгийн эрх мэдлийн төлөө өрсөлдөж байдаг. 1990 оноос Монгол улс олон намын тогтолцоонд шилжсэн.

Олон намын тогтолцооны ач холбогдол:

- Олонхын дэмжлэг авсан улс төрийн нам засаглалыг хэрэгжүүлдэг.
- Цөөнхийн дэмжлэг авсан нам нь эрх баригч намыг хянаж ажилладаг.
- Нэг нам ноёрхо боломжийг хязгаарладаг.
- Засаглалын тэнцвэрийг хадгалах нөхцөл бүрддэг.
- Олон ургалч үзлийг дэмждэг.
- Хүний эрхийг хангадаг гэх мэт.

Улс төрийн олон нам байх нь ардчиллын хөгжилд шууд дэмжлэг болж байдаг. Учир нь иргэдийн олон талт байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь улс төрийн олон нам байгуулагдах, хөгжлийн өрсөлдөхүйц бодлого боловсруулах, бодлогоо олон нийтэд танилцуулах, сонгогчдоос дэмжлэг авах боломж олгож байдаг. Хэрэв улс төрийн олон нам байхгүй бол чөлөөт шударга өрсөлдөөн гэж байхгүй, улмаар иргэдийн улс орны хөгжлийн талаарх үзэл бодлыг нэгтгэх, илэрхийлэх, хэрэгжүүлэх боломжгүй болгосноор ардчилал бодитой орших баталгаагүй болдог.

Олон намын шударга өрсөлдөөн нь чөлөөт, ардчилсан сонгуулийн зарчимд тулгуурладаг. Сонгууль нь улс төрийн намын өрсөлдөөнийг шударга зохион байгуулах арга хэрэгсэл бөгөөд нийгмийн хөгжилтэй зэрэгцэн улам боловсронгуй болсоор байна. Аливаа улс орон сонгуулийн арга, хэлбэрээ оновчтой сонгож, тогтвортой хэрэгжүүлсний үр дүнд намууд төлөвшдөг.

Монгол улсад 1990 оны 05 дугаар сарын 10-нд анх Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль батлагдан МАХН, МҮДН, МЧХН, МоАН, МСДН, МНН-уудыг тус тус албан ёсоор бүртгүүлж, улс төрийн үйл ажиллагаа явуулах эрхийг олгосон байдаг. Ингэж гурав дөрөвхөн сарын өмнө ганц МАХН-тай байсан Монгол улсад улс төрийн олон нам улсын Дээд Шүүхэд бүртгүүлж, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн байна.

Улс төрийн нам нь гишүүд, дэмжигчидгүйгээр иргэдийн оролцоо, нийгмийн төлөөллийг хангаж, засаглалыг хэрэгжүүлэх боломжгүй юм. Намын гишүүн хэмээх ойлголт анх баруун Европт үүссэн бөгөөд өдөр тутмын бичгийн хэлэнд “дагагчид, баримтлагчид” гэсэн үгтэй адил хэрэглэгдэж байсан. Хожим дэмжигчдээс ялгах үүднээс гишүүн гэж нэрлэх болсон байна.

- **Намын гишүүн** гэж хувийн улс төрийн байр сууриндаа тулгуурлан улс төрийн намын үнэт зүйл, үзэл суртлыг зөвшөөрч намд элссэн хувь хүнийг хэлнэ.

- **Дэмжигч** нь намын үзэл суртлыг зөвшөөрч сонгуулийн үед намын мөрийн хөтөлбөрийн төлөө саналаа өгдөг чөлөөт иргэд бөгөөд нам доторх бүлгүүд болон зохион байгуулалтаас гадна байдаг.



Бүдүүвч 5.9. Гишүүд, дэмжигчдийн улс төрийн намд оруулдаг хувь нэмэр

Улс төрийн нам оршин байж, үйл ажиллагаагаа тогтмол явуулах нэг үндэс бол мөнгө санхүү юм. Намууд санхүүжилтээ гишүүдийн татвар, хандив, төрийн санхүүжилт, намын үйл ажиллагаанаас олох орлого, намын сонин, сэтгүүл, номын худалдаа зэргээр бүрдүүлдэг. Улс төрийн намууд улс орноо хөгжүүлэх оновчтой бодлогыг боловсруулж ард олноор хүлээн зөвшөөрүүлэн түүнийгээ хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг. Хэрэв нам үүргээ биелүүлж эс чадваас тэд нийтийн өмнө хариуцлага хүлээх хэрэгтэй болдог.

Улс төрийн намд хүлээлгэх хариуцлагад:

- Төрийн санхүүжилтыг багасгах, хасах
- Мөнгөн торгууль буюу захирагааны арга хэмжээ авах
- Эрүүгийн хариуцлага хүлээлгэх /хууль зөрчсөн тохиолдопд/
- Улс төрийн хариуцлага хүлээлгэх
- Улс төрийн сонгуульд оролцох эрхийг хязгаарлах,
- Улс төрийн намыг татан буулгах зэрэг болно.

Улс төрийн намын хувьд хамгийн том шийтгэл бол тодорхой хугацаагаар улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх эсвэл бүрмөсөн хасах юм. Учир нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг хэрэгжүүлэх, засгийн эрхийг авах төлөө өрсөлдөх нь улс төрийн намын зорилго юм. Улс төрийн үзэл суртлын ялгаатай байдал, намуудын өрсөлдөөн, хүний эрх, эрх чөлөөнд тулгуурласан ялгаатай бодлогыг боловсруулах зэрэг нь олон намын тогтолцоо байхын үндэс юм.



Үйл ажиллагаа 5.15. Дүн шинжилгээ хийгээрэй.

“Нээлттэй” намын зохион байгуулагчид хотын зөвлөлийн танхимд цуглаан хийхийг хүсчээ. “Чөлөөт үг” нам нь хотын зөвлөлд илүү олон суудал эзэлдэг давуу байдлаа ашиглан, бас ойролцоо дүүргийн оршин суугчдын олонх нь энэ намыг дэмждэг учир хотын танхимд цуглаан хийлгэхийг хүссэнгүй. Тэд “Нээлттэй” нам энэ танхимд цуглаан хийвэл эмх замбараагүй байдал гарч болзошгүй гэж сануулав.

Асуулт:

- “Чөлөөт үг” нам ардчилсан сонгуулиар орон нутгийн эрх мэдлийг авсан тохиолдолд хотын танхумыг хэрхэн ашиглахыг хянах ёстой юу? Үндэслэлтэй хариулт бэлтгэнэ үү.
- “Чөлөөт үг” нам хотын танхум ашиглаулахаас татгалзсаны хариуд “Нээлттэй” нам, түүний гишүүд юу хийх ёстой вэ?

**Гэртээ хийгээрэй.****Асуулт**

- Улс төрийн нам сонирхлын бүлгээс юугаараа ялгаатай вэ?
- Намын тогтолцоонуудын давуу ба сул талыг тодорхойлно уу.
- Намуудын нийгэмд гүйцэтгэх үүрэг та нарын бодлоор ямар түвшинд байгааг дүгнэн ярилцана уу.

**Нэмж судлаарай**

- УТБА-ын лекцийн эмхэтгэл. УБ., 2001
- Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. УБ., 2010

**БҮЛГИЙН ДҮГНЭЛТ**

Ардчилсан нийгмийн дэд институтууд нь нийгэм, улс төрийн зүй зохиуст шаардлагыг хангах үүднээс олон нийтийн сонирхлыг илэрхийлэх, нэгтгэх, хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд бид сонирхлын бүлэг болон улс төрийн намын тухай та бүхэнд танилцууллаа.

Сонирхлын бүлгүүд нь өөрсдөө илүү ашигтай, тохиромжтой шийдвэр гаргуулах зорилгоор улс төрийн болон төрийн байгууллагуудад нөлөө үзүүлэхийг эрмэлзэх нийтлэг ашиг сонирхлын үндсэн дээр нэгдсэн иргэдийн нэгдэл юм. Сонирхлын бүлгүүд нийгэмд ашиг сонирхлоо нэгтгэх, илэрхийлэх, мэдээлэх үүрэг хүлээж байдаг. Өөрөөр хэлбэл, бүлгийн болон нийтийн хүсэл, сонирхлыг нэгтгэн, төр засгийн байгууллагуудад хүргэж ажилладаг юм.

Харин улс төрийн нам нь улс төрийн институт болохын хувьд түүний хэрэгжүүлэх үүрэг нь илүү өргөн хүрээтэй юм. Үүнд, төлөөллийн, элитийг төлөвшигүүлэх, дайчлах, зорилгоо томъёолох, сонирхлыг нэгтгэх, илэрхийлэх, нийгэмшүүлэх болон албадах, засгийн газрыг байгуулах зэрэг үүргийг гүйцэтгэдэг болно. Мөн улс төрийн эрх мэдлийг авах, ардчилсан засгийг байгуулах, төрийн бодлогыг тодорхойлох, сонирхлын бүлгүүдийн сонирхлыг нэгтгэн тусгах, хангах зэрэг үүрэгтэй болно.

Парламентын ардчилалтай улсад намууд сонгуульд оролцож засгийн эрхийн төлөө шударгаар өрсөлддөг. Сонгууль нь намуудад засгийн эрхийг атгуулж, хуулиар заагдсан хугацаанд засаглалыг зохион байгуулах эрхийг олгодог. Иймд сонгууль ардчилсан, чөлөөт, шударга, бүх нийтийн, тэгш оролцоот байхыг шаарддаг. Учир нь чөлөөт, шударга сонгууль нь ардчиллын үндэс юм.

Сонгуульд ялалт байгуулсан намууд парламентыг бүрдүүлэн сонгуулиар дэмжлэг авсан хөгжлийн бодлогыг төрийн бодлого болгон хувиргадаг. Мөн парламентад олонх болсон, эсхүл олон суудал авсан улс төрийн намууд хамтран гүйцэтгэх засаглал буюу засгийн газраа байгуулж төрийн бодлогыг хэрэгжүүлдэг. Сонгуулийн үр дүн гүйцэтгэх засаглал болох засгийн газрыг бүрдүүлэхэд бас нөлөөлдөг. Парламентын бүгд найрамдах улсад засгийн газрын Ерөнхий сайдаар сонгуульд ялсан, парламентад олонхын суудал авсан намын лидер эсвэл намын эвслийн тэргүүн томилогддог. Ерөнхийлөгчийн засаглалтай улсад парламентад олонх болсон намаас, эсхүл бүх нийтийн сонгуулиар ерөнхийлөгчөө шуд сонгож ялалт байгуулсан намын хөтөлбөрийг төрийн бодлого болгон хувиргаж хэрэгжүүлдэг.

Бид бүхний энэхүү бүлэг сэдвээр үзэж буй иргэний нийгэм, сонгууль, хэвлэл мэдээлэл, улс төрийн систем, сонирхлын бүлэг, улс төрийн нам, төр зэрэг нь ардчиллын үнэт зүйлс бөгөөд тэдгээрийн бодитой оршин байх үндэс, арга, үйл ажиллагаа, үр дүн зэрэг нь ардчиллыг хэмжих шалгуур, ардчиллыг хөгжүүлэх үндэс юм.

I. ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭЭРЭЙ



Судалгаа хийгээрэй.

1. Дурын өдөр тутмын сонин, сэтгүүлийн дугаарыг уншиж судлан улс төрийн намуудын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хөндсөн мэдээллийг олоорой.
2. Намуудтай холбоотой мэдээлэл яагаад чухал болохыг тайлбарлаарай.
3. Хүмүүсийн амьдралд улс төрийн нам хэрхэн нөлөөлж байгаа талаар санал асуулгын аргаар мэдээлэл цуглуулж дүгнэлт бичнэ үү.
4. Хэрэв чи улс төрийн намын лидер байсан бол яаж шийдвэрлэх талаар өөрийн байр суурияа үндэслэл, нотолгоотой тайлбарлаарай.
5. Тухайн асуудлыг сонирхож байгаа бусад хүмүүсийг татан оролцуулах зорилгоор цахим мэдээллийн сан /wiki/ үүсгээрэй.
6. Тус тусдаа байгаа хувийн итгэл үнэмшил, байр суурийг бүлгийн байр сууринаас авч үзэх боломжийг бүрдүүлж, ангийн хэлэлцүүлэг хийгээрэй.

II. ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ



Асуултад хариулаарай.

Асуулт

1. Иргэд ямар замаар улс төрд нөлөөлөх боломжтой вэ?
2. Улс төрийн оролцоо юунаас эхэлдэг вэ?
3. Хэвлэл мэдээллээс өөрөөр үзэл бодлоо илэрхийлэх ямар арга зам байдаг вэ?
4. Иргэдийн үүсгэл санаачилгын хөдөлгөөн гэж юу вэ?
5. 1990 оноос өмнө бид сонгуульд хэрхэн оролцож байсан бэ?
6. Ардчилсан, шударга сонгууль гэж юуг хэлэх вэ? Үндсэн зарчмуудыг нь тайлбарлаарай.
7. Сонгоч та ямар эрхтэй вэ?
8. Сонгочийн эрхийн талаар танилцуулга хийгээрэй.
9. Бид сонгуульд яагаад идэвхтэй оролцох ёстой вэ?

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА



Суралцахуйн зорилт	Тулгуур ойлголт
Монгол улс ба ОУХ-ны улс бус оролцогч <ol style="list-style-type: none"> Олон улсын харилцааны улс бус оролцогч тус бүрийн үйл ажиллагааны онцлог, уялдаа холбоог тодорхойлж, үзэл бодлоо илэрхийлэх Улс бус оролцогчдын талаар жишээ, эх сурвалжийг судлан, өөрийн улсын амьдралд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, үнэлэлт өгөх 	<ul style="list-style-type: none"> - Олон улсын харилцаа - Олон улсын харилцааны улс бус оролцогч - Олон улсын эрх зүй - “Гуравдагч хөрш”-ийн бодлого - “Төвийг сахих” бодлого - “Зөвлөн хүч”-ний бодлого
Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоо <ol style="list-style-type: none"> Монгол улсын “гуравдагч хөрш”-тэй харилцах, “төвийг сахих” гадаад бодлогын талаар төрөөс батлан гаргасан баримт бичгийг судлан, ач холбогдлыг тодорхойлох Монгол улс ба НҮБ, бусад олон улсын байгууллагын хамтын ажиллагааны талаар мэдээлэл цуглуулсан, шинжилж, үнэлэлт өгөх 	
Монгол улсын гадаад харилцааны “зөвлөн хүч”-ний бодлого <ol style="list-style-type: none"> Монгол улсын “зөвлөн хүч”-ний бодлогын агуулга, чиглэлийг асуудал шийдвэрлэх замаар судлан, тайлбарлах Монгол улсын боловсрол, соёл, спорт, хүмүүнлэгийн гадаад харилцааны үйл ажиллагааны талаар эх сурвалжийг судлан, байр сууриа илэрхийлэх 	

СЭДЭВ 6.1 ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ УЛС БУС ОРОЛЦОГЧ

Даяаршлын үе нь иргэн бүрийг олон улсын харилцааны талаар ойлголт, мэдлэг, мэдээлэлтэй байхыг шаардаж байна. Та бүхэн 10 дугаар ангидаа олон улсын харилцааны үндсэн оролцогч болох тусгаар улсын талаар дэлгэрэнгүй судалсан. Тухайлбал, Монгол улсын гадаад бодлого, Монгол улс олон улсын харилцааны оролцогч болох, манай улсаас хөршүүдтэйгээ харилцах бодлого, иргэн гадаад харилцаанд хэрхэн оролцдог талаар мэдсэн билээ. Мөн та бүхэн Монгол улсын зүгээс болон иргэний зүгээс явуулж буй гадаад харилцааны бодит үйл явдлыг шинжлэн тайлбар хийх, ач холбогдлыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт хийх арга аргачлалд суралцаж, тодорхой чадвараа хөгжүүлсэн. Энэ бүх мэдлэг, чадвар тань 11 дүгээр ангидаа олон улсын харилцааны улс бус оролцогч, олон улсын эрх зүй, “гуравдагч хөрш”-ийн бодлого, “төвийг сахих” бодлого, “зөөлөн хүч”-ний бодлого зэргийг гүнзгийрүүлэн судлахад суурь дэвсгэр болно.

Та бүхэн энэ бүлэг сэдвийг судалснаар олон улсын харилцаа, аливаа улсын гадаад харилцаа нь улс үндэстний аюулгүй байдалтай холбоотой болохыг гүнзгий ойлгож, түүнийг баримт, үйл явдал, эх сурвалжид үндэслэн тайлбарлах замаар үзэл бодлоо илэрхийлэх, үнэлэлт дүгнэлт өгөх чадвараа хөгжүүлэх болно. Олон улсын харилцааг улс төр, эрх зүй, эдийн засаг, соёл зэрэг нийгмийн бусад салбаруудтай уялдаа холбоонд авч үзэж, сэдэв, асуудлыг салбар дундын хандлагаар судлан, мэдлэг, чадвараа хөгжүүлэхийг хичээгээрэй.



Үйл ажиллагаа 6.1. Олон улсын харилцааны талаар та бүхэн юу мэдэх вэ?

- Дараах тулгуур ойлголтыг тайлбарлана уу.
 - Олон улсын харилцаа
 - Олон улсын харилцааны улс оролцогч
 - Олон улсын харилцааны улс бус оролцогч
 - Иргэн оролцогч
 - Хөрш улсуудын харилцаа
- Хүснэгтийн дагуу тэмдэглэл хийнэ үү.

Олон улсын харилцааны талаар

мэдсэн зүйл	мэдэхийг хүсэж буй зүйл

- Хүснэгтэд хийсэн тэмдэглэлээ бусдадаа танилцуулаарай.




Тулгуур ойлголт

Улс бус оролцогч: Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид, олон улсын байгууллагыг хамруулан үздэг.

Олон улсын харилцааны улс бус оролцогчид гэдэгт юуг ойлгох вэ?

Дэлхий дахин улам бүр даяаршиж, хувь хүн, байгууллага ч улсаа төлөөлөн ОУХ-нд оролцох боллоо. Мөн бие дааж ОУХ-нд оролцдог төрийн бус байгууллагууд олон байна.

Энэ бүхэн нь ОУХ-нд улс бус оролцогчийн гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж буйг харуулж буй хэрэг бөгөөд эдүгээ ОУХ-ны систем нь төрийн болон төрийн бус байгууллага хоорондын харилцаанд тулгуурлах боллоо. Жишээ нь, ОУХ-ны улс бус оролцогч болох ХБНГУ-ын Берлин хотод төвтэй олон улсын “Транспаренси Интернэшл” байгууллагаас дэлхийн улс орнуудын авлигын индексийг судалгаагаар тодорхойлж, дэлхий нийтэд мэдээлдэг. Энэ байгууллагаас гаргасан судалгааны мэдээлэлд тулгуурлан Монгол улсын Засгийн газар, төрийн байгууллагууд үйл ажиллагаанд дахинэлт хийж, Монгол улсын нийгмийн тулгамдсан асуудал болох авлигатай тэмцэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Яг үүнтэй ижил зарчмаар дэлхийн бусад улс орнууд авлига, ядуурал, тэгш бус хөгжлийн талаар гаргасан улс бус оролцогчдын судалгаанд тулгуурлан өөрийн улсын бодлогоо засаж залруулах арга хэмжээ авч байдаг нь улс, улс бус оролцогчдын хамтын ажиллагааны бодит жишээ юм. Өнөөгийн олон улсын харилцаанд улс бус оролцогчийн үзүүлж буй нөлөө, үйл ажиллагааны цар хүрээ өргөн болсон нь өсөн нэмэгдэж буй даяаршлын нөлөөтэй холбоотой. Иймээс улс бус оролцогчдыг танин мэдэх нь чухал юм.



Бүдүүвч 6.1. Улс бус оролцогчдыг ангилах нь

Олон улсын төрийн бус байгууллага: (ОУТТБ) Төрийн бус байгууллага нь хувийн, сайн дурын үндсэн дээр бий болсон, үүрэг даалгаварт чиглэсэн олон нийтийн байгууллага юм. ТББ-ууд нь үндэстэн дамнасан нийгэм, хүмүүнлэгийн асуудлуудад байнга анхаарч ажилладаг. Жишээ нь, тэгш бус хөгжлийн ялгааг бууруулах, хүний эрхийг хангах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэх мэт. Олон улсын харилцаанд оролцох ТББ-ын үйл ажиллагаа идэвхжсэнээр иргэний нийгмийн байгууллагууд хүчтэй хөгжиж байна.

Үндэстэн дамнасан корпорац (ҮДК): Олон улсын харилцаа даяаршихын хэрээр олон улсын улс төр, эдийн засгийн харилцаанд ихээхэн нөлөө үзүүлэх болсон субъектын нэг ҮДК юм. Энэ нь хоёр болон түүнээс олон улсад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг корпорациуд (компани) юм. Тэдний аж үйлдвэр, санхүүгийн нөөц, бүтээгдэхүүн нэг орноос нөгөөд маш түргэн шилжиж байдаг нь улс орнуудын эдийн засагт эерэг, сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал, манай улсад үйл ажиллагаа явуулж буй Оюутолгой ХХК-ийн үйл ажиллагаа зогсоход хурвэл Монгол улсын төдийгүй гол худалдан авагч Хятад улсын зэсийн зах зээлд нөлөө үзүүлнэ. Үүнээс үүдэн манай улсын гадаад худалдаанаас хүртэх орлого буурах тул энэ нь иргэдийн амьдралд ч нөлөөлөх эрсдэлтэй. Иймээс ҮДК-ын үйл ажиллагаанд олон улсын эрх зүйн зохицуулалт зайлшгүй хэрэгтэй болдог.

Хувь хүмүүс: Энэ бол засгийн газрыг төлөөлөхгүй энгийн иргэд юм. Жишээ нь, Нобелийн энх тайвны шагналыг хүртсэн, Буддын шашны тэргүүн XIV Далай лам, Ромын Пап лам зэрэг шашны удирдагчид, Билл Гейтс, Жорж Сорос зэрэг томоохон сангийн тэргүүнүүд, Осама Бин Ладен асан зэрэг террорист ч орж болно.

Шашны бүлгүүд: Дэлхийд түгээмэл тархсан буддын шашин, ислам, христын гэх мэт голлох шашны төв, байгууллагаас гадна олон шашны урсгал, чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүлгэм олон улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Жишээ нь, манай улсад Далай лам айлчлах болсонтой холбогдуулан Хятад улстай харилцах харилцаанд үл ойлголцол үүсэж байсан.

Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл: 1991 оны Персийн булангийн үйл явцын талаар CNN дайны талбараас шуурхай мэдээ хүргэнсээр дэлхийн улс орнуудад бодит мэдээллийг газар дээрээс нь шууд хүргэх эхлэл болсон. Хожим интернэт бий болсноор хэвлэл мэдээллийн хэрэгсэл улам бүр өргөжиж цахим хэрэгслээр дамжуулан иргэд олон улсын харилцааны үйл явдлын талаарх сэтгэгдлээ чөлөөтэй илэрхийлэх орчин бүрдсэн. Өдгөө цахим мэдээллийн хэрэгслүүд, олон улсын хэвлэл мэдээллийн төрөлжсөн байгууллагууд, сонин, зурагтын сүлжээ олон улсын улс бус оролцогчдын нэг чухал төлөөлөл болоход хүрэв.

Гэмт хэргийн сүлжээ, байгууллагууд: Олон улсын хэмжээнд мансууруулах бодис, санхүүгийн луйвар, өндөр технологийн хulgай, хүний наймаа, террорист халдлага түгээмэл үйлчилдэг. Зохион байгуулалттай бүлгүүд хэд хэдэн улс оронд үйлчилдэг олон төрлийн гэмт хэргийн үйл ажиллагаанд ихэвчлэн оролцдог. Эдгээр гэмт хэрэг нь улс хоорондын хил дамнан эсвэл үндэстэн дамнан үйлчилдэг тул улс орнууд ОУБ болох интерполоор дамжуулан гэмт хэргийн эсрэг хамтран тэмцэж байна.

Террорист ба зэвсэгт бүлэглэлүүд: Терроризм нь үзэл сурталжсан хүчирхийлэлд үндэслэсэн системтэйгээр хэрэглэгддэг, тэмцлийн хурц, сөрөг арга хэлбэр бөгөөд улс төрийн зорилго бүхий алан хядах үзэл бодол, бодлого, үйл ажиллагааг бүхэлд нь хэлж болно. Террорист байгууллага ХХ зууны сүүлээс эхлэн олон улсын харилцааны улс бус оролцогчийн нэг болсон. Террорист байгууллагуудын хамгийн алдартай нь 1980-аад онд Осама Бин Ладены байгуулсан Аль-Каида юм.



Үйл ажиллагаа 6.2. Баримтыг шинжлээрэй.

- Ярилцлагыг уншаад асуултад хариулна уу.

Монгол улсын гадаад бодлогын алтан аргамжааг богиносгож болохгүй

Олон улсын, бус нутгийн нэгдлүүд тодорхой зорилгын дор байгуулагддаг. Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага (ШХАБ) ямар зорилготой байгуулагдаж, ямар үр дүн гаргаж ирсэн нэгдэл вэ?

ШХАБ анх 1996 онд “Шанхайн Тав” нэртэй байгуулагдаа оролцогч орнуудын хил орчимд цэргийн итгэлцлийг гүнзгийрүүлэх, хил орчмын цэргийн хүчний тоог багасгах зорилго тавьсан байдаг. Угтаа бол Исламын хэт даврагсдын өдөөн хатгалгаар ямар нэг үл ойлголцол үүсэж, хил орчимд будилаан, зэвсэгт мөргөлдөөн гарахаас сэргийлэх үүрэгтэй байж. 1997 онд ШХАБ-ын хүрээнд ОХУ, БНХАУ-ын удирдагчид дэлхий “олон туйлт” байх ёстой гэж тунхагласан. Эндээс үзвэл ШХАБ нь дотогшоогоо бол Дундад Азийн орнуудыг Орос, Хятад хоёр талаас нь хашиж, тэндээс терроризмын аюул занал гаргуулахгүй байх, гадагшаагаа бол АНУ тэргүүтэй барууныг сөргүүлэн ажиллах шинэ туйлт бий болгох үүрэг хүлээсэн байгаа юм. Өнгөрсөн хугацаанд ШХАБ нэг хэсэг улсын бүлэглэлээс олон улсын байгууллага болж, гишүүн орны too 6-аас 8 болж өргөжсөн, дан цэрэг-аюулгүй байдлын чиглэлтэй байснаа одоо бүх чиглэлийн салбарыг хамарсан зорилготой болсон байна. Байгууллагаа тэлэх, гадаад харилцаагаа өргөтгөн бэхжүүлэх, гадна талдаа хүлээн зөвшөөрүүлэх тал дээр төвлөрч ажилласнаас биш яг эдийн засгийн үр өгөөжтэй хийсэн ажил юу байгааг мэдэхгүй байна.

Эх сурвалж: www.trends.mn Ахмад дипломатч С. Бадралтай хийсэн ярилцлагаас

Асуулт:

- Ахмад дипломатчийн ярилцлагаас ШХАБ-ын талаар ямар мэдээлэл авав?
- Тэрээр ШХАБ-ын талаар ямар байр суурь илэрхийлсэн бэ?
- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй улс бус оролцогчдын талаар мэдээлэл цуглуулж, танилцуулаарай.

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА НЬ ОЛОН УЛСЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ЯМАР ЯЛГААТАЙ ВЭ?


Улс бус оролцогчдын төлөөллөөс хүч, нөлөө бүхий олон улсын байгууллага, олон улсын төрийн бус байгууллагын талаар тодруулан авч үзье. Улс бус оролцогчдын дотроос олон улсын байгууллага (ОУБ), олон улсын ТТБ-ыг сайтар ялгаж ойлгох нь танин мэдэхүйн болон практик ач холбогдолтой юм. Тухайлбал, та бүхэн эдгээр байгууллагын талаар мэдсэнээр тэдгээрийн явуулж буй үйл ажиллагаанд оролцох эсэхээ шийдэх, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх боломжтой.

ОУБ, олон улсын ТББ хоёр нь дараах ялгаатай. Үүнд:

- Бүтэц, зохион байгуулалтын хувьд харилцан адилгүй. Тухайлбал, ОУБ нь улс орнуудад илүү нээлттэй, байгууллагын бүтэцтэй, гишүүн улс орнуудын эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах чиглэлд түлхүү анхаардаг. Харин олон улсын ТББ нь иргэн, байгууллагад түлхүү нээлттэй, сайн дурын шинжтэй, иргэний нийгмийн олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- Зорилго, чиглэлийн хувьд харилцан адилгүй. Тухайлбал, ОУБ нь улс орны асуудалд түлхүү анхаардаг бол олон улсын ТББ нь тодорхой, чиглэл, хүрээнд зорилго тавьж хэрэгжүүлдэг байна.
- Мөн үүсгэн байгуулагчийн хувьд ялгаатай байх тал бий. Тухайлбал, ОУБ-ыг засгийн газрууд хамтран байгуулдаг. Жишээ нь, НҮБ, Европын Холбоо, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ), Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ) зэргийг улс орны засгийн газрын түвшинд хэлэлцэн байгуулсан. Харин олон улсын ТББ-ыг хувь хүн, иргэн, бүлэг, байгууллага байгуулах боломжтой. Үүний жишээ нь, Соросын сан юм.

Дээр дурдсан ялгаатай талууд байхын зэрэгцээ нийтлэг зүйл бас бий. Тухайлбал, аль аль нь дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг дээдлэх, нийтлэг эрх ашгаа хамгаалах, үйл ажиллагаагаараа дамжуулан хүчээ нэгтгэх, цар хүрээгээ өргөжүүлэхэд анхаарч байна.

ОУБ болон олон улсын ТББ-ыг үйл ажиллагааны цар хүрээ, үүсгэн байгуулагчаар нь дараах байдлаар ангилж болно.



Бүдүүвч 6.2. Олон улсын байгууллага болон ОУТББ-ын ангилал

НҮБ нь улс бус оролцогчийн хувьд ОУБ-ын ангилалд хамаарах бөгөөд гишүүд нь улс орнууд байдаг тул үйл ажиллагааны хамрах хүрээ, нөлөөлөл нь улс орнууттай шууд холбогдоно. Энэ утгаар үйл ажиллагааны цар хүрээгээрээ глобал түвшний оролцогч болдог. Өөрөөр хэлбэл, олон улсын харилцааны үндсэн оролцогч болох улс орнууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр улс бус оролцогч НҮБ-ыг байгуулж, асуудлаа хамтран хэлэлцэж, шийдвэрлэх арга замыг хамтран тодорхойлоод дагаж мөрддөг. Үүний тод жишээ бол 2015 онд НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн баталсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030” юм.

НҮБ-ын гишүүн орнууд уг үзэл баримтлалд тулгуурлан 2030 он хүртэл тогтвортой хөгжих бодлогоо шинээр тодорхойлон хэрэгжүүлж байна. Энэхүү тогтвортой хөгжлийн хүрээнд дэлхийн улс орнууд 2030 он хүртэл 17 зорилтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн юм.



Үйл ажиллагаа 6.3. Даалгаерыг гүйцэтгээрэй.

1. Дараах ойлголтыг тайлбарлана уу.
 - а) Олон улсын байгууллага
 - б) Олон улсын төрийн бус байгууллага
2. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийг уншаад дараах асуултын дагуу ярилцана уу. (<http://www.legalinfo.mn/annex/details/7105?lawid=11725>)
 - а) Монгол улс яагаад энэ баримт бичгийг баталсан бэ?
 - б) Монгол улс тогтвортой хөгжлөө хангах чиглэлээр ямар зорилт тавьсан бэ?
3. Монголд үйл ажиллагаа явуулж буй олон улсын ТББ-ын салбар болох Эмнэсти Интернейшнл байгууллагын үйл ажиллагааны талаар а) мэдээлэл цуглуулаарай б) цуглуулсан мэдээллээ нэгтгэж танилцуулга бэлтгээрэй. (www.amnesty.mn)

Цуглуулах мэдээллийн агуулга:

- Байгууллагын зорилго
- Байгууллагын түүх
- Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, манай улсад зохион байгуулсан гол гол үйл ажиллагаа, түүний үр дүн

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ УЛС БУС ОРОЛЦОГЧИД ЯМАР ЭРХ ХЭМЖЭЭТЭЙ ВЭ?

ОУБ нь өөрийн гэсэн нутаг дэвсгэргүй учир заавал өөрийн гишүүн аль нэг улсын нутаг дэвсгэр дээр байрлаж, үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэхдээ ажилтан хөлслөх, байшин барилга худалдаж авах зэргээр дотоодын эрх зүйн харилцаанд оролцож, дотоодын эрх зүйн субъект болдог. Мөн ОУБ нь оролцогч улс орны хувьд олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор, тэдний зөвшүүлэлтээр байгуулдаг тул олон улсын эрх зүйн субъект болдог. ОУБ нь эрх зүйн субъект болох талаар:

- НҮБ-ын Дүрмийн 104-р зүйлд “НҮБ нь өөрийн гишүүн орны нутаг дэвсгэр дээр үүргээ гүйцэтгэх болон зорилгодоо хүрэх шаардлагатай эрх зүйн чадамжийг эдэлнэ” гэжээ.
- Далайн эрх зүйн 1982 оны конвенцид “Олон Улсын Далайн Байгууллага нь олон улсын эрх зүйн субъект мөн бөгөөд өөрийн үүргийг хэрэгжүүлж, зорилгодоо хүрэхэд шаардагдах эрх зүйн чадамжтай байна” гэж заасан байдаг.

Гэхдээ ОУБ нь хязгаарлагдмал хүрээнд, зөвхөн өөрийн үйл ажиллагааны зорилготой холбоотой асуудлаар эрх зүйн чадамж эдэлдэг. Тухайлбал:



Тулгуур ойлголт

Олон улсын эрх зүй гэдэг нь ОУХ-нд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоо юм. Олон улсын эрх зүй нь олон улсын харилцааны оролцогчдын хоорондын харилцааг зохицуулахаас гадна түүний хэвийн байдлыг хангах, энэ харилцааг хангах, хамгаалах үүрэгтэй.

- Зөвхөн өөрсдийн дүрмийн хүрээнд эрх эдэлж, үүрэг хүлээдэг.
- Зөвхөн өөрсдийн эрхэлдэг ажлын хүрээнд тодорхой асуудлаар хэлэлцээр байгуулна.
- ОУБ шүүхээс зөвхөн зөвлөмж хүсэх эрхтэй.

ОУБ нь эрх зүйн хувьд:

- ОУ-ын эрх зүйн субъект чанараараа олон улсын харилцаанд оролцох;
- Гишүүн нь улс гүрэн байх, тухайлбал, үүсгэн байгуулсан үндсэн баримт бичигтэй байх;
- Тодорхой нийтлэг зорилгын үүднээс байгуулагдах;
- Эрх, үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг нь хариуцан явуулдаг дотоод механизмтай байх;
- Зорилго, үйл ажиллагааны чиглэл нь ОУ-ын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцэж, гишүүн улсын бүрэн тэгш эрхийг хүндэтгэх үндсэн дээр хэрэгжих шаардлагыг хангасан байх учиртай.

ОУБ нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй. Үүнд:

- Дипломат харилцаанд оролцож өөрийн эрх хэмжээний хүрээнд хэлэлцээ хийх, олон улсын гэрээ байгуулах эрхтэй.
- Улс орнуудад төлөөлөгчөө суулгах эрхтэй.
- Учирсан хохирлын талаар зарга нэхэх эрхтэй.
- Гэрээ байгуулан ажиллагчдыг хөлслөх эрхтэй.
- Газар нутагт нь үйл ажиллагаа эрхэлж буй улсынхаа хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдийн эрхийг эдэлнэ.
- ОУ-ын эрх зүйг зөрчсөний төлөө, мөн өөрийн болон ажилтныхаа буруутай үйлдлээр бусдад хохирол учруулсны төлөө хариуцлага хүлээнэ.
- ОУБ бүр мөнгөн хөрөнгөтэй байна.
- Улсын дотоод хэрэгт оролцохыг бүх талаар цээрлэх, хууль тогтоомж, дэг журмыг нь хүндэтгэн дагах үүрэгтэй.



Үйл ажиллагаа 6.4. Даалгаврыг гүйцэтгээрэй.

- Хүснэгтийн дагуу ялгааг тодорхойлно уу.

ОУХ-ны улс бус оролцогч	Бүрэн эрхт улс

1. ОУБ яагаад эрх зүйн субъект болдог вэ?
2. ОУБ нь эрх зүйн харилцаанд оролцохдоо ямар эрх эдэлж, ямар үүрэг хүлээдэг вэ?



Үйл ажиллагаа 6.5. ОУБ-ын талаар та бүхэн юу мэдэх вэ?

1. Өөрийн сайн мэддэг ОУБ-ыг жагсаан бичнэ үү.
 - а) Жагсаасан ОУБ-аа ангилна уу.
 - б) Ямар шалгуураар ангилснаа тайлбарлана уу.
2. ОУБ олон улсын эрх зүйн субъект болох тухай онолын ойлголттой танилцаад, асуултад хариулна уу.

№	Онолын чиглэл	Үндсэн үзэл баримтлал
1.	Реалист онол	ОУХ-ны тоглогчид нь зөвхөн үндэсний бүрэн эрхт улсууд байдаг.
2.	Либерал онол	ОУХ-ны үндсэн тоглогч бүрэн эрхт улс дангаар биш түүнээс гадна ОУБ, томоохон компаниуд, үндэсний болон бусад нийгэмлэг, хувь хүмүүс ОУХ-д оролцож байдаг.
3.	Марксист онол	ОУХ-ны үндсэн тоглогчид нь нийгмийн ангиуд байна.
4.	Неомарксист онол	ОУХ нь нийгмийн тодорхой анги бүлэглэлүүдийн харилцааны үр дүн юм.
5.	Неореалист онол	ОУХ-ны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, эвсэл байна.
6.	Неолиберал онол	ОУХ-ны бүрэн эрхт субъектүүд нь бүрэн эрхт улс, үндэстэн дамнасан корпорацууд, ЗГ-ын бус байгууллагууд, хувь хүмүүс байдаг.

1. Онолын чиглэлүүд нь ОУХ-ны улс бус оролцогчийн талаар ямар байр суурийг баримталж байна вэ?
2. Улс бус оролцогчийн талаарх онолын чиглэлүүдийн хоёр гол ялгааг тодорхойлно уу.
3. Улс бус оролцогчийн талаарх онолын тайлбартай танилцаж, тэднийг ялгааг тодорхойлсноор улс бус оролцогчийн талаар та юу мэдэж авав?
4. Дараах шийдлээр мэтгэлцэнэ үү.

Шийдэл: “Ихэнх улс орон ОУБ-д олон улсын эрх зүйн субъект байх эрх олгохоос татгалздаг. Учир нь ОУБ бүрэн эрхт улсаас илүү их эрх мэдэлтэй, бие даасан болно гэж болгоомжилдог.”



Гэртээ хийгээрэй.

1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ОУХ-ны улс бус оролцогчдын талаар мэдээлэл цуглуулаарай.
2. Цуглуулсан мэдээллээ дараах дарааллын дагуу танилцуулахад бэлтгээрэй.

Үүнд:

- a) Тухайн оролцогчийн үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл
- b) Байгуулагдсан түүх
- c) Монгол улсад явуулж буй үйл ажиллагаа, түүний үр дүн, ач холбогдол



Нэмж судлаарай

- <http://consul.mn/041ubdtg.php>
- <https://immigration.gov.mn/> -ээрэг цахим хуудсыг ашиглаарай.

СЭДЭВ 6.2 МОНГОЛ УЛС БА ОУХ-НЫ УЛС БУС ОРОЛЦОГЧДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

1990 оноос хойш нээлттэй, энхийг эрхэмлэсэн бие даасан гадаад бодлого баримтлах болсноор Монгол улсын гадаад харилцаа эрс идэвхжиж, олон улсын хамтын нийгэмлэгийн энх тайванч бодлогыг туштай дэмжиж зохих хувь нэмрээ оруулсаар байна. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын үндсэн агуулгыг олон тулгуурт бодлогоор тайлбарладаг. Тухайлбал, гадаад бодлогын 6 тулгуур чиглэлийг тодорхойлсон байдаг. Эдгээрээс 4 нь улс бус оролцогчидтой харилцах харилцааг тодорхойлдог. Үүнд Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (АПЕК), Зүүн Өмнөд Азийн бус нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АСЕАН), Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн (ЭҮНХ), НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН)-ийн орнууд зэрэг хуучин социалист системийн уламжлалт харилцаатай бус нутгийн байгууллагуудтай харилцах харилцааг тодорхой зааж өгчээ.

- Хөрш орнуудтайгаа найрсгаар тэнцвэртэй харилцах;
- Азийн бус нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох;
- Өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх;
- Хөгжих буй орнуудтай нийтлэг зорилтын үүднээс бодит боломжийн хэмжээнд хамтран ажиллах;
- НҮБ болон түүний төрөлжсөн салбарууд, ОУВС, ДБ, АХБ-тай хамтран ажиллах;
- Социализмын дараах орнууд, ТУХН-ийн орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх;

Бүдүүвч 6.3. Монгол улсын гадаад бодлогын 6 тулгуур чиглэл

Монгол улс гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бус нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд туштай хүчин чармайлт гаргах” талаар заасан.

Тухайлбал:

- Ардчиллыг бэхжүүлэх;
- Цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсэг дэлгэрүүлэхтэй, олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх;
- НҮБ-ийн энхийг дэмжих, сахиулах, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцох;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгаль орчны доройтлоос хамгаалах, гоц халдварт өвчний тархалтаас сэргийлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтыг дэмжин оролцоход ямагт бэлэн байх зэрэг бодлогууд багтана.



Бүдүүгээч 6.4. Монгол улсын гадаад бодлогод голлох бүс нутаг, улс орнууд

- **Зүүн Хойд Ази:** Монгол улс Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудалд ихээхэн анхаарал тавьж, хоёр Солонгостой найрсаг харилцаатай байхыг эрхэмлэдэг. Гэвч энэ бүс нутагт ашиг сонирхлын зөрөлдөөнтэй олон асуудал байдаг. Тус бүс нутгийн орнууд болох ОХУ, БНХАУ, АНУ, Канад, Япон, БНСУ, БНАСАУ зэрэг улсын бодлогоос бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагаа шууд хамаарлтай юм.
- **Төв ба Евро Ази:** Энэ бол ОУХ-нд түүхэн уламжлалтай геополитикийн нөлөө бүхий бүс нутаг бөгөөд ОХУ, Хятадын нөлөө ихтэй. ШХАБ, Евразийн эдийн засгийн холбоо (ЕЭЗХ) зэрэг бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах нь ирээдүйд манай улсад чухал ач холбогдолтой байх болно.
- **Зүүн ба зүүн өмнөд Ази:** Ази, Номхон далайн орнуудын нэг хэсгийг хамарна. Монгол улс 1998 онд АСЕАН-ны улс төр, аюулгүй байдлын асуудлаарх яриа хэлэлцээний үйл явц болох АСЕАН-ны Бүсийн чуулга (АРФ)-д гишүүнээр элсэж, 2005 онд АСЕАН-ны Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд нэгдсэн.

Улс орнуудын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч, аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ орчин бүрэлдэж байгаа өнөөгийн нөхцөлд Монгол улсаас олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд явуулах бодлого, олон талт дипломат ажиллагааны ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байна. Дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ОУБ-үүд, ялангуяа, НҮБ чухал үүрэгтэй. Иймд Монгол улс НҮБ-ын үйл ажиллагаанд улам бүр идэвх, санаачилгатай оролцож байна. Тухайлбал, Ерөнхий Ассамблейн 63-р чуулганы дэд даргаар (2008-2009), ЮНЕСКО-ийн гүйцэтгэх зөвлөлд гишүүнээр (2007-2011), Олон улсын худалдааны эрх зүйн комиссын гишүүнээр (2004-2010), Олон улсын атомын энергийн агентлагийн захирагчдын зөвлөлийн гишүүнээр (2009-2011) тус тус сонгогдон амжилттай ажилласан юм.

Монгол улс 2011 оны 7-р сараас Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг (АОХН)-ийг 2 жилийн хугацаагаар даргалан ажилласан. Эдүгээ АОХН-ийн удирдах зөвлөлд 25 орон нэгдэж ороод байгаа. Ийнхүү Монгол улс дэлхий нийтийн ба бүс нутгийн олон улсын харилцаанд бие даан оролцогч чухал субъект гэдгээ нотлон харуулсаар байгаа билээ.



Үйл ажиллагаа 6.6. Баримтыг уншаад асуултад хариулаарай.

1. Монголд төвтэй далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төв

Монгол улсын санаачилсан анхны олон улсын Засгийн газар хоорондын байгууллага болох Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын бүлэг 2006 онд Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын (ХБО) олон улсын судалгааны төвийг Улаанбаатарт байгуулах санаачилгыг гаргаж байжээ. Монгол улсын Засгийн газар, Гадаад харилцааны яам, дипломатчид идэвхтэй ажиллаж, Далайд гарцгүй ХБО-ын олон улсын судалгааны төвийг Улаанбаатар хотод байгуулах асуудлыг НҮБ-ын тогтоол, шийдвэр болон олон улсын хэмжээний хурлын баримт бичгүүдэд тусгах, НҮБ болон бусад далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дэмжлэгийг авах чиглэлээр идэвхтэй ажиллаж, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009 онд Монгол улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр тус төвийн шавыг тавьсан. Дэлхийд далайд гарцгүй хөгжиж байгаа статустай 32 орон байдаг. Далайд гарцгүй орнууд хөгжлийн хувьд үндсэндээ далайд гарцтай орнуудаас 20 хувиар хоцрогдсон байдаг гэсэн судалгаа бий.

Далайд гарцгүй ХБО-ын олон улсын судалгааны төвийг үүсгэн байгуулах тухай олон талт хэлэлцээрийг одоогийн байдлаар Армян, Афганистан, Балба, Буркина Фасо, Бутан, Казахстан, Киргиз, Лаос, Парагвай, Тажикистан, Этиоп улсын Засгийн газар соёрхон баталсан байна. Бидний зүгээс бусад 20 улсад элсэхийг уриалж байгаа билээ. Одоогийн байдлаар судалгааны төв олон улсын донор байгууллагууд, далайд гарцгүй хөгжсөн орнуудын дэмжлэгээр санхүүжилтээ шийдэж байна. НҮБ-ын мандаттай байгууллага гэдэг утгаараа бас санхүүжилт орж ирдэг.

Монгол улсын Засгийн газрын зүгээс далайд гарцгүй ХБО-ын олон улсын судалгааны төвийг үүсгэн байгуулахад манлайлж олон улсын түвшинд амласны дагуу 1 сая ам.долларын хандив өгсөн.

(Эх сурвалж: <https://ikon.mn/n/1b92>

Асуулт:

1. Монгол улс ямар ОУБ-ыг, яагаад байгуулах болов?
2. Монгол улс олсад ямар манлайлал үзүүлсэн бэ?
3. Манай улсын санаачилгаар байгуулагдсан энэхүү ОУБ нь манай улсад болон бусад улс орны хувьд ямар ач холбогдолтой вэ?

2. Мэдээлэл

2018 оны байдлаар Монгол улсад гадаадын ТББ-ын болон ОУБ-ын нийт 90 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна. Эрх зүйн зохицуулалтын хийдэлтэй байдал нь ТББ-уудын идэвхтэй ажиллах боломжийг хязгаарлаж байгаа төдийгүй санхүүжилтүүн хувьд гадаад улс, донор байгууллагын хараат болгох, улмаар аливаа хууль бус үйл ажиллагаанд татагдан оролцох магадлалтай хэмээн нийгмийн зүгээс үл итгэх хандлагыг бий болгоход нөлөөлж байна гэж зарим судлаачид үздэг байна.
(эх сурвалж: <https://ikon.mn/n/19ub>)

Асуулт:

1. Мэдээллээс юунд холбогдох, ямар статистик баримтыг олж мэдсэн бэ?
2. Мэдээллээс үзэхэд судлаачид ОУБ болон олон улсын ТББ-ын талаар ямар байр суурьтай байна вэ?
3. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ОУБ болон олон улсын ТББ-ын талаар та ямар хандлага, байр суурьтай байдаг вэ?

СЭДЭВ 6.3 МОНГОЛ УЛСЫН “ГУРАВДАГЧ ХӨРШ”-ИЙН БОДЛОГО

“ГУРАВДАГЧ ХӨРШ”-ИЙН БОДЛОГО ГЭЖ ЮУ ВЭ?



Үйл ажиллагаа 6.7. Эх сурвалжтай ажиллаарай.

“Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-аас

Хоёр. Улс төрийн гадаад харилцааны бодлого 14.2.АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

Гурав. Эдийн засгийн гадаад харилцааны бодлого: 19. Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ эрх тэгш, харилцан ашигтай байх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг чанд мөрдөнө. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ.

Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/annex/?lawid=6163>

Асуулт:

1. “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын заалтууд гуравдагч хөршийн бодлоготой ямар холбоотой байгааг тодорхойлно уу.
2. Монгол улс яагаад “гуравдагч хөрш”-ийн бодлогыг гадаад харилцаандaa баримтлах болсон бэ?
3. Монгол улсын гадаад харилцааны “гуравдагч хөрш”-ийн бодлогын зорилго, ач холбогдлыг Та хэрхэн тодорхойлох вэ?

Монгол улсын гадаад харилцааны бодлого нь улс орны тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахад чиглээд зогсохгүй улс орны өмнө тулгарч буй нийгэм, эдийн засгийн зорилтуудыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх зорилготой. Монгол улсын Үндсэн хуульд “Монгол улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол улс Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээ бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэж заасан нь Монгол улсын гадаад харилцааны гол зарчим юм. Монгол улсын Гадаад бодлогын 1994, 2011 оны үзэл баримтлалд гадаад бодлогын зарчмыг дэлгэрэнгүй тодорхойлоходоо: “Монгол улс аливаа улстай харилцаадаа бие биеийн бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтоно бүрэн эрхийг хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, хүч үл хэрэглэх, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, эрх тэгш харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг НҮБ-ын Дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хэм хэмжээг удирдлага болгоно” гэж заасан байдаг.

Аливаа улсын гадаад бодлогын орчныг гадаад, дотоод хэмээн хувааж үздэг. Монголын тухайд түүний гадаад орчны хөрш орнуудын, бүс нутгийн, глобал хэмээн турван түвшинд авч үзэх нь зохимжтой. Хөрш улс хоорондын харилцаа Монгол улсын газар нутаг, эдийн засаг, батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэж ирсэн түүхтэй. Хоёр гүрний хооронд стратегийн түншлэлийн харилцаа

хөгжиж, итгэлцэл нэмэгдсэн өнөөгийн байдал нь Монгол улсын гадаад орчинд нааштай нөлөөлж, таатай нөхцөл бүрдүүлж байна.

Дэлхийн улс орнуудын харилцан хамаарал лавширч, улс төр, эдийн засгийн интеграци гүнзгийрч, даяаршил олон улсын харилцааны хөгжлийн үндсэн хандлага болсон нь ХХI зууны глобал орчныг тодорхойлж байна. Монголын гадаад орчинд шууд нөлөөлсөн глобал хүчин зүйл гэвэл социалист системийн задрал, ЗХУ-ын бутрал, үүнээс улбаалсан “хүйтэн дайн”-ы төгсгөл байсан юм. Үүний үр дүнд Монгол улс харьцангуй бие даасан гадаад бодлого явуулж, АНУ, Япон зэрэг Өрнөдийн орнуудтай стратегийн түншлэлийн харилцаа бүхий ардчилсан чиг баримжаяа бүхий улс болов. Монгол улсын аюулгүй байдал хоёр хөрш улсаасаа шууд хамааралтай ч 1990 оноос Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц эхэлж, нээлттэй гадаад бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Монголчууд геополитикийн таагүй байдлыг зөөллөх зорилгоор “олон тулгуурт бодлого” баримтлан явуулахаа зарласны үр дүнд өдгөө бид дэлхийн 164 улстай дипломат харилцаа тогтоож, Засгийн газар хоорондын 54 байгууллагын гишүүн болж, олон улсын 154 олон талт гэрээнд нэгдэн орсон байна.

Монгол улс хоёр хөрштэй, харьцангуй буурай хөгжилтэй, жижиг эдийн засагтай тул бусдын улс төр, эдийн засгийн нөлөө, нөөлөгт амархан өртөмхий, нөлөөний савалгаа ихтэй байдаг онцлогтой. Тиймээс үүнийг тогтвортжуулж, харьцааг тэнцвэржүүлэх үүднээс бусад хөршийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн бодит оролцоо, нөлөө, сонирхлыг илүү хурдацтай, далацтай нэмэгдүүлэх бодлого барина гэсэн үг юм. Том гүрнүүдийн хүрээлэлд байдаг жижиг орны хувьд аюулгүй байдлаа хангах хэд хэдэн хувилбар байдаг. Тухайлбал, төвийг сахих, эсвэл тусгаарлан зожигрох, тэнцвэрт харилцаа барих, аль нэг хүчирхэг гүрэнтэй эвсэх замаар өөрийгөө хамгаалуулах зэрэг хэлбэр байдаг. Хил залгаа хоёрхон хөрштэй манай орны хувьд нэгэнтэй нь эвсэн нөгөөгийнх нь эсрэг байх нь ямар үр дагавартай болохыг бид өөрийн улсын түүхээс мэднэ. Иймээс манай орчин үеийн гадаад бодлогын нэг том ололт нь хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах чиг бодлогыг баримталж, тууштай хэрэгжүүлснээр Монгол улсын аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангахад оршино.

Монгол улс гуравдагч хөрш гэдгийг газар зүйн ойлголтын хувьд бус, харин улс төр, эдийн засгийн гуравдагч хөрш байх бүлэг оронтой харилцах утгаар нь авч үзэж байна. Олноо өргөгдсөн Богд хаант засгийн үед Хятад, Оросын нөлөөг тэнцвэржүүлэх зорилгоор бусад улс гүрнүүдтэй дипломат харилцаа тогтоохоор оролдож байсан нь Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын суурь байжээ. Гуравдагч хөрш гэдэг ойлголт нь аль нэг тодорхой гуравдагч орныг хэлж байгаа хэрэг биш юм. Харин Монгол улс зөвхөн хоёр хөршийн хамаарал дор байх ёсгүй, хоёр хөршийн нөлөөллийн зохих тэнцвэрийг хадгалахад гуравдагч хүч буюу гуравдагч хөршийн нөлөөлөл байх ёстой гэсэн үзэл санаанаас улбаатайгаар 1990 оноос баримталж ирсэн шинэ бодлого юм. “Гуравдагч хөрш” гэдэг ойлголт нь Монголын ардчилал, нийгэм, эдийн засгийн хөгжлийг тууштай дэмжигч, дорвитой хандивлагч улс орныг багтаадаг. Гуравдагч хөршийн бодлогоор Монгол улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил давхар хангагдаж байдаг. Хоёрхон хөрштэй Монгол улс “Гуравдагч хөрш”-ийн үзэл санааг буй болгож, 2010 онд шинэчлэгдэн батлагдсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг,

соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” гэж заасан. Монгол улсын хувьд гадаад байдлаа урт хугацаанд тэнцвэртэй байлгах, улс үндэснийхээ эрх ашгийг хамгаалах, харилцаж буй улсуудын ашиг сонирхлыг тэнцвэртэй байлгах үүднээс “туравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлдэг. Ингэснээр олон улсын харилцаанд итгэлцлийг бүрдүүлж, бус нутгийн тогтвортой байдлыг хангаж энх тайванч, харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хоёр хөршийнхөө итгэлийг олж авсан нь чухал ололт юм.



Тулгуур ойлголт

Гуравдагч хөршийн бодлого
гэдэг нь Монгол улс зөвхөн хоёр хөршийн хамаарал дор байх ёсгүй, хоёр хөршийн нөлөөллийн зохих тэнцвэрийг хадгалахад туравдагч хүч буюу туравдагч хөршийн нөлөөлөл байх ёстой гэсэн үзэл санааны үүднээс 1990 оноос баримталж ирсэн шинэ бодлого юм.

Монгол улсын Их Хурлын 2011 онд баталсан Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол улсын улс төрийн гадаад бодлогын нэг хэсэг нь “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “туравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” гэж заасан. Монгол улс уг бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өндөр хөгжилтэй орнуудтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа,

хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлж байна. Их гүрнүүд хүчний тэнцвэрийн харьцаагаар биш, харин стратегийн гэсэн тодотголтой түншлэлээр тохиролцох хандлага олон улсын харилцаанд давамгайлж байна. Стратегийн харилцааг зорилго, агуулгаар нь гурван түвшинд хувааж байна.

Түншлэлийн харилцаатай улсууд

Ангилал	Иж бүрэн стратегийн түншлэл	Стратегийн түншлэл	Иж бүрэн түншлэл	Өргөн хүрээтэй түншлэл
Монгол улс	1 улс: БНХАУ	3 улс: ОХУ, Япон, Энэтхэг	4 улс: БНСУ, АНУ, Герман, Турк	2 улс: Канад, Австрали

Эх сурвалж: ГХЯ-ны цахим хуудас http://www.mfa.gov.mn/?page_id=16273

Стратегийн хамтын ажиллагаа нь улс гүрнүүд хэтийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх арга замаа харилцан мэдээлж, бодлогоо зохицуулан нэгдмэл үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Гэтэл стратегийн түншлэл нь том гүрнүүд зорилго, арга хэрэгслээ харилцан мэдээлэхээр хязгаарлагддаг болно. Харин стратегийн харилцаатай улс гүрнүүд зөвхөн зорилгоо харилцан мэдээлэхээс хэтэрдэггүй байна. Иймд “стратегийн түншлэл” гэдэг нь холбоотон ч биш, “ах дүүгийн харилцаа” ч биш харин эдгээрийн хоорондох томьёолол юм. Түншлэлийн харилцаа нь бага улсад аль нэгийг өрөөсгөлөөр дагахгүй байх, бусадтай тэнцвэртэй харилцах улмаас олон тулгууртай болох боломж олгох давуу талтай юм.

МОНГОЛ УЛС “ГУРАВДАГЧ ХӨРШ”-ТЭЙГЭЭ ХЭРХЭН ХАМТРАН АЖИЛЛАДАГ ВЭ?

Монгол улс ба АНУ-ын харилцаа

Монгол улс 1990-ээд оноос чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих үед хамгийн түрүүнд харилцаж эхэлсэн улсын нэг нь АНУ бөгөөд манай улсын тэргүүлэх гуравдагч хөрш орон. Түүхээс үзэхэд Олноо өргөгдсөн Монгол улсын эзэн хаан VIII Бодг 1913- 1914 оны үед АНУ-тай яриа хэлэлцээ хийх зорилгоор төлөөлөгч илгээж байв. 1944 оны 7 дугаар сарын 2-нд хоёр өдөр АНУ-ын дэд ерөнхийлөгч Хэнри Уолс өнөөгийн нийслэл Улаанбаатар хотод айлчилж байжээ.




Хоёр орны орчин үеийн хамтын ажиллагаа нь АНУ-ын ерөнхийлөгч Роналд Рэйганы засгийн үед буюу 1987 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр хоёр улс “Харилцан ойлголцох санамж бичиг”-т гарын үсэг зурж, дипломат харилцаа эхэлсэн. Үүнээс нэг жилийн дараа 1988 онд АНУ-ын Элчин сайдын яам Улаанбаатар хотод байгуулагджээ. Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд хоёр орон дараах чиглэлээр хамтран ажиллаж иржээ. Үүнд: ардчилал, хүний эрхийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, зах зээлийн эдийн засгийг дэмжих бодлого боловсруулах, олон нийтийн болон батлан хамгаалахын хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, бус нутагт болзошгүй аюулаас сэргийлэх, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх зэрэг салбарууд хамрагджээ.

АНУ-ын дэмжлэг, буцалтгүй тусламжаар боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг зэрэг салбарт олон төсөл, хөтөлбөр амжилттай хэрэгжсэн байна. 2001 оноос хоёр орон батлан хамгаалах салбарт хамтран ажиллах болжээ. АНУ-аас Монголын зэвсэгт хүчний шинэчлэлийг дэмжиж олон улсын энхийг сахиулах болон дотоодын цэргийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чадамжтай болгох зорилгоор сургагч нарыг илгээж байв. 2003 оноос Таван толгойн цэргийн бэлтгэлийн баазад “Хaanы эрэлд” цэргийн хамтарсан сургуулилалт хэрэгжүүлж эхэлжээ. АНУ-ын Энхтайвны корпусын анхны сайн дурын ажилтнууд монгол хүүхэд, залуусыг англи хэл сурахад чухал дэмжлэг үзүүлсэн байдаг. Монголын 350 гаруй залуус дэлхийд алдартай АНУ-ын Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж АНУ-д боловсрол эзэмшсэн байна.

(<https://mn.usembassy.gov/mn/news-events-mn/> дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.)

Монгол улс ба Япон улсын харилцаа



Монгол улс Япон улстай 1972 оны 2 дугаар сарын 24-нд дипломат харилцаа тогтоосон түүхтэй. Тухайн үед хоёр улсын нийгмийн байгуулал, үзэл суртлаар ялгаатай байсан социализмын үед хамтын ажиллагааны үндэс тавигдсан байдаг. Тухайлбал, хоёр талын Парламентын төлөөлөгчид 1974 оноос харилцан айлчилж, БНМАУ-ын ГЯЯ-ны сайд М.Дүгэrsүрэн 1987 онд Японд, Япон Улсын Гадаад хэргийн сайд С.Уно 1989 онд Монголд, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Д.Содном 1990 онд

Японд тус тус айлчилж байжээ. Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн 1990-ээд оноос хоёр улсын харилцаа эрчимтэй хөгжикж ирэв. Япон Улс Монголын ардчиллыг хамгийн түрүүнд, хамгийн тууштай дэмжсэн улсуудын нэг билээ. Япон Улсын Ерөнхий сайд Т.Кайфү 1991 онд Монголд айлчилсан нь ардчилсан хувьсгалаас хойш барууны жишгээр хөгжсөн орнуудаас Засгийн газрын тэргүүний түвшин дэх анхны айлчлал болов. Уг айлчлалаар Ерөнхий сайд Т.Кайфү Монголын ардчилал, шинэчлэлийг зөвхөн хоёр талын хүрээнд төдийгүй олон улсын түвшинд дэмжиж ажиллахаа илэрхийлсэн байдал.

Япон Улсын Засгийн газар 1991 оноос Монгол улсын хүнс, нийтийн тээвэр, холбоо, эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд, соёл зэрэг бүхий л салбарт зээл, тусlamж хамгийн их үзүүлж ирсэн улс юм. Мөн Япон Улс 1991 оноос Дэлхийн банктай хамтран Монголд хандивлагчдын уулзалтыг Токио хотноо 10 удаа санаачлан зохион байгуулж, техникийн хамтын ажиллагааны тусlamж үзүүлж ирсэн нь Монгол улсын шинэ хөгжлийн суурийг тавихад үлэмж хувь нэмэр болсон юм.

(https://www.mn.emb-japan.go.jp/itpr_mn/birelation.html дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.)



Үйл ажиллагаа 6.8. Мэдээллийг уншаад асуултад хариулна уу.

Коосэн сургалтын хөтөлбөр


Улс орны эдийн засгийн хөгжилд инженер, технологийн мэргэжилтэй боловсон хүчиний гүйцэтгэх үүрэг асар их бөгөөд энэ чиглэлийн их сургуулиудын сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг бэхжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарт хэрэгцээтэй байгаа мэргэжилтэй боловсон хүчинийг бэлтгэх, тэдний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшшуулэхэд тодорхой хугацаа шаардагдаг. Монгол улсын хувьд эдийн засгийн хөгжлийн тэргүүн эгнээнд зогсон, аж үйлдвэрийн салбарт ажиллах инженер, технологийн мэргэжилтнүүдийг түргэн хугацаанд бэлтгэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Энэхүү хэрэгцээг хангах, аж үйлдвэрийн салбарын чадварлаг боловсон хүчинийг бэлтгэх үүднээс инженер, технологийн чиглэлээр мэргэжил эзэмших хүсэлтэй заплууруудад Японы Коосэн сургуульд суралцах боломжийг олгох зорилгоор “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд Коосэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уг төслөөр Монгол улсын боловсролын шинэ стандартад нийцүүлэн боловсролын чанарыг дээшлүүлэх буюу арга зүйг сайжруулахын тулд ерөнхий боловсролын сургуулийн 1-ээс 9-р ангиин сурагчдад ордог математик, хүн байгаль, хүн орчин, хими, физик, мэдээлэл зүй, төсөлт ажил гэсэн хичээлийн арга зүйн зөвлөмжийг боловсруулсан. Их, дээд сургуулийн багш нар, мэргэжилтнүүдийн хамтран боловсруулсан эдгээр зөвлөмжийг загвар сургуулиуд дээр туршин сайжруулсанар хүүхдийн бие даан суралцах чадварыг илрүүлэн, хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйг шинэчлэн боловсруулахыг зорьж байна.

<http://www.mjeed.edu.mn/index.php>

Асуулт:

1. Монгол улс болон Япон улс ямар чиглэлээр хамтран ажиллаж байна вэ?
2. Энэхүү хамтын ажиллагаа нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжил болон хувь хүний хөгжилд ямар ач холбогдолтойг тодорхойлно уу.
3. Япон улсын түүхээс та юу мэдэх вэ?
4. Японы JAICA байгууллагын талаар мэдээлэл цуглуулж, танилцуулна уу.

Монгол улс ба БНСУ-ын харилцаа



Монгол, БНСУ нь олон зуун жилийн харилцааны түүхтэй Азийн орнууд юм. Харин орчин үеийн дипломат харилцаа 1990 онд тогтжээ. БНСУ 1990 онд Улаанбаатар хотноо, 1991 онд Сөүл хотноо Монгол улс тус тус ЭСЯ-аа нээжээ. Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогод БНСУ нь хүндтэй байрыг эзэлдэг юм. 2011 онд хоёр улсын харилцаа “иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хүрсэн. Монгол

улс, БНСУ-ны Засгийн газар хоорондын хамтарсан хороо, Монгол, БНСУ-ын парламентын найрамдлын бүлэг зэрэг хоёр талын харилцааны механизмын бүрдсэн төдийгүй ГХЯ-ны Азийн газрын дарга нарын зөвлөлдөх уулзалтын механизмтай. Мөн Хүнс, ХАА, Хөнгөн үйлдвэрийн Яам, ХНХЯ, БСШУЯ хоорондын бодлогын зөвлөлдөх уулзалт явагддаг. БНСУ нь Монгол улсын худалдааны Хятад, Орос, Японы дараа ордог дөрөв дэх түвш юм.

Манай улсаас голчлон молибдений хүдэр, баяжмал, мал амьтны үс, хялгас зэрэг байдаг бол БНСУ-аас газрын тосны бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа, машин, тоног төхөөрөмжийг импортолдог байна. БНСУ-ын Хууль зүйн яамны Цагааччалын албаны мэдээгээр 2016 оны байдлаар Монгол улсын 35091 иргэн урт болон богино хугацаагаар байнга оршин суудаг гэжээ. БНСУ-д манай улсын 46312 иргэн зорчсон байна. Монгол улсын 30 000 гаруй иргэн тус улсад урт болон богино хугацаагаар байнга оршин сууж байна.

(<http://overseas.mofa.go.kr/mn-mn/index.do> дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.)

Монгол улс ба Турк улсын харилцаа



Монгол улс, БНТУ-ын хооронд 1969 оны 6 дугаар сарын 24-нд дипломат харилцаа тогтоож, Туркийн тал 1996 оноос Улаанбаатарт, Монгол улс 1997 оноос Анкарад ЭСЯ нээн ажиллуулж байна. БНТУ нь Монгол улсад олон салбар, чиглэлээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж хамтран ажилладаг. Тухайлбал, хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл; хот суурин газрын хөгжлийн төлөвлөлт;

ус, ус цэвэрлэх байгууламж, ойжуулалт; жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил; дэд бүтэц; эрчим хүч; тээвэр; боловсрол, соёл, шинжлэх ухаан, аялал жуучлал, эрүүл мэнд зэрэг салбарууд голчилдог.

Турк улсын олон улсын хөгжлийн агентлаг “ТИКА”-гийн шугамаар 1994 оноос эхлэн нийт 30 сая амдолларын техникийн тусгамж үзүүлжээ. Хархорин-Хөшөө цайдамын 46 км авто зам барих, Түрэгийн хөшөө дурсгалыг сэргээн хамгаалах тесөл, Орхоны хөндийд Дэлхийн соёлын өвийн музей байгуулах, Улсын клиникийн төв эмнэлгийн дэргэд цусны төв байгуулах, МУИС-д Турк судлалын тэнхим байгуулах, “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим архив”, “Монгол, Туркийн найрамдлын цэцэрлэгт хүрээлэн” зэрэг 30 орчим хөтөлбөр, төсөл хэрэгжүүлсэн. Монгол улсад Туркийн хөрөнгө оруулалттай 63 компани бүртгэгдсэнээс 52 нь худалдаа, нийтийн хоолны салбарт байна.

(<http://ulaanbaatar.emb.mfa.gov.tr/Mission/Index> дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.)



Үйл ажиллагаа 6.9. Даалгаврыг гүйцэтгээрэй.

1. Хүснэгтийг бөглөнө үү.

Гуравдагч хөрш	Тухайн улсын товч танилцуулга	Хамтран ажиллах чиглэл	Монгол улсад үзүүлсэн дэмжлэг тусламж

2. Цахим эх сурвалжаас Монгол улсын “гуравдагч хөрш” орнуудын талаарх мэдээллийг дэлгэрүүлэн уншиж, танилцуулга (газрын зураг ашиглаарай) хийнэ үү. Дараах холбоосоор орж элчин сайдын яамдын хаяг, цахим хаягийг аваарай.
- http://mongolembassy.com/index.php?option=com_content&view=article&id=55&Itemid=140&lang=mn&ckattempt=1
3. Монгол улсын “гуравдагч хөрш” орнуудын зүгээс тус улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөс сонгон судална уу.



Үйл ажиллагаа 6.10. Ярилцлагыг уншиж, гуравдагч хөрш орнуудтай харилцах харилцаа хөршүүдтэй харилцах бодлогоос ямар ялгаатай байх талаар саналаа солилцоорой.

- Ерөнхий сайд тун удахгүй ОХУ-д айлчлахаар төлөвлөж байна. Энэ айлчлалаас ямар үр дүн хүлээж байна вэ? Хойд хөршийн тухайд мөн Владивостокийн форумын үеэр яригдсан хэлэлцээ, зөвшилцлүүдийг дурдах хэрэгтэй болов уу?
- Гадаад бодлогынхоо үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх чухал айлчлал бол ОХУ-д хийх Ерөнхий сайдын айлчлал. Энэ айлчлалаар Эдийн засгийн коридор, дэд бүтэц зэрэг бүх том асуудлууд яригдана. Яах аргагүй хойд хөрштэй Монголын томоохон төслүүд уялдаж байгаа. Хоёр хөршийн хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал хөгжих байгаа тохиолдолд бид бодлогоо уялдуулах ёстой. Энэ талаараа их чухал ач холбогдолтой айлчлал болно. Владивостокийн форумын үеэр 100 тэрбум рублийн зээлийн асуудлууд, эрчим хүч, дэд бүтцийн чиглэлийн хамтын ажиллагааны төсөл арга хэмжээнүүд яригдсан. Үүнийг бодитой ажил болгох талаас мөн одоогийн айлчлалаар ярина. Бодлого маань нэгдмэл, залгамж чанартай шүү дээ. Хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийн харилцааг шинэ түвшинд гаргаж хөгжүүлэх үүд хаалгыг нээх үүднээс энэ чиглэлд гол анхаарлаа хандуулж байгаа.

- Гуравдагч хөрш орнуудтайгаа харилцах харилцаа мөн манай улсын гадаад бодлогоод голлох үүрэгтэй. БНСУ, Японд өндөр дээд хэмжээний айлчлал хийж, АНУ-ын МСК-ийн хоёр дахь компакт гэрээг эцэслэхээр тохирч, БНЭУ-ын Гадаад хэргийн сайд мөн манайд айлчиллаа. Эдгээр айлчлалуудын дүнд харилцаа хэрхэн идэвхэжсэн гэж та дүгнэж байна вэ?

Бидэнд итгэх итгэл энэ улсуудад байгаа учраас үүний илэрхийлэл болж БНСУ-ын айлчлалаар 500 сая ам.доллар, Японы айлчлалаар 850 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг тохиролцсон. БНЭУ-ын Гадаад хэргийн сайд тус улсаас олгох 1 тэрбум ам.доллараар санхүүжүүлэх Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажлыг түргэтгэж, мэдээллийн технологи, боловсрол, соёл, эрүүл мэндийн чиглэлээр хамтрах олон ач холбогдолтой тохиролцоо хийлзэ. Бид “Кибер-Ази” сэдвээр хамтарсан хурал хийхээр тохирсон. АНУ-ын Мянганы сорилын сангийн хоёрдугаар компакт гэрээгээр 350 сая ам.долларын буцалтгүй тусламж орж ирнэ. АНУ маш олон улс оронтой ажиллах байгаа ч Монголд ийм хэмжээний тусламж үзүүлж байгаа нь бидэнд итгэж буйн илрэл юм. Монголын эдийн засгийг хүнд байдлаас гаргахад энэхүү дэмжлэг чухал түлхэц үзүүлнэ.

(эх суреалж: <http://www.mfa.gov.mn>)

СЭДЭВ 6.4 | ЗӨӨЛӨН ХҮЧНИЙ БОДЛОГО



Үйл ажиллагаа 6.11. Эх сурвалжтай ажиллаарай.

- “Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлогын зорилго нь үндэсний соёл иргэншил, өвөрмөц өв уламжлалаа дэлхийн соёлын нийтлэг ололттой хослуулан хөгжүүлэх, түүх, соёлын үнэт зүйлээ хамгаалах, сэргээх, түүхэн шалтгаанаар гадаадад гарсан эд өлгийн зүйлийг сурвалжлан олоход чиглэсэн хамтын ажиллагаа хөгжүүлэх, нийгэм, хүмүүнлэгийн салбарын шууд харилцаанд тус дөхөм үзүүлэх явдал мөн.

Эх сурвалж: Гадаад Бодлогын үзэл баримтлал, 2010

Асуулт:


- Соёлын нөлөө улс төр, эдийн засгийн хүчин зүйлтэй хэрхэн холбогдох вэ?
- Үндэсний хэл, соёлын үнэ цэн юугаар, хэрхэн хэмжигдэх вэ?
- Зөөлөн хүчний онолыг анх Жозеф Най олон улсын харилцааны практикт нэвтрүүлсэн юм. Соёл, улс төрийн үнэт зүйлс болон төрөөс хэрэгжүүлж буй бодлогоор бусад улс оронд нөлөөлөн, тэдний сэтгэлийг татаж, дэмжлэгийг авах замаар өөрийн талд оруулан олон улсын хамтын нийгэмлэг дэх итгэл болон нэр хүндийг олох боломж нь зөөлөн хүчний бодлогын гол онцлог юм. Хамгийн гол нь бусад улсын ард иргэд тухайн улсын соёлд сонирхолтой байх, хэрэгжүүлж буй гадаад, дотоод бодлого ёс зүйтэй харагдах нь чухал юм. Зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлснээр бага эрсдэлээр, нэр хүндтэйгээр, өөрийн ашиг сонирхолдоо нийцсэн амжилтыг авчрах бүрэн боломжтой гэж үздэг.

Эх сурвалж: Г.Баасанхүү ба бусад. “Олон улсын харилцаа ба даяаршил”, УБ. 2016., 127 дахь тал

Асуулт :

- Жозеф Най яагаад зөөлөн хүчний бодлого чухал гэж үзсэн бэ?

Олон улсын харилцаанд оролцогч улс орнууд өөрийн хүч чадавхаас хамаарч хатуу, зөөлөн хүчний бодлого, стратегийг сонгодог. Хүч гэсэн ойлголтод цэргээс гадна эдийн засаг, технологи, соёл иргэншлийн бүх хэлбэр орно. Бага улсууд эрх зүйн хүчинд түлхүү ач холбогдол өгдөг гэдэг утгаараа НҮБ зэрэг олон улсын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж түүний ивээл дор аливаа үйл ажиллагаанд оролцохыг эрмэлздэг.



Жозеф Самуэль Най 1937 онд төрсөн. АНУ-ын улс төр, олон улсын харилцааны шинжлэх ухааны нэрт эрдэмтэн юм. 1964 оноос Харвардад багшилж эхэлсэн бөгөөд Харвардын харьяа Кеннедийн нэрэмжит Төрийн удирдлагын сургуулийн захирал байжээ. Тэрээр эрдэмтэн Роберт Коэхэнтэй хамтран 1977 онд олон улсын харилцааны неолиберал онолын чиглэлээр “Хүч чадавх ба харилцан хамаарал” гэсэн алдарт бүтээлээ туурвисан. Тэд хамтран цогц харилцан хамаарлын онолоо цаашид хөгжүүлсэн юм. Тэрээр бүтээлдээ хатуу, зөөлөн хүчний ялгааг тайлбарлаж, зөөлөн хүчний онолыг анх удаа дэвшүүлж, хүлээн зөвшөөрүүлсэн эрдэмтэн юм. Клинтоны засаглалын жилүүдэд түүний ухаалаг



Тулгуур ойлголт

Зөөлөн хүч гэдэг нь албадлага, урамшууллаар бус харин бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсэж буй үр дүнд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадвар юм.

хүчний бодлогыг сайшаан дэмжсэн байдаг. Жозеф Най нь АНУ-ын Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яамны бодлогын зөвлөлийн гишүүнээр ажилладаг. 2011 оны олон улсын TRIP судалгааны байгууллагаас гаргасан судалгаагаар ХХ зууны олон улсын харилцааны салбар шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан 1700 эрдэмтдээс түүний нэр зургаад эрэмбэлэгдсэн байна.



Тулгуур ойлголт

Хатуу хүч гэдэг нь их гүрнүүд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэхийг хэлнэ.

Бага улсуудын хүчийг дутуу үнэлж болохгүй бөгөөд тэд олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүд мөн. Бага улсуудын гадаад бодлогын дээр дурдсан хязгаарлалтууд Монгол улсын хувьд ч мөн адил үйлчилдэг. Улс орнуудын хүч чадавх газар нутгийн хэмжээ, байгалийн баялаг, хүн амын тоо, эдийн засгийн хөгжил, технологи, аж үйлдвэрийн чадавх, хүчтэй засаглал, цэрэг, зэвсэгт хүчний чадамжаар тодорхойлгодно. Хэдий чинээ эдгээр нөөц их байна, төдий чинээ улс орнууд хатуу хүчний буюу хүчинд дулдуудсан бодлого хэрэгжүүлдэг. Хүч чадавхыг тодорхойлох нөөц хэдий чинээ бага байна, төдий чинээ улс орнууд зөөлөн хүчний бодлогыг чухалчилж, энхийг эрхэмлэсэн, нээлттэй гадаад бодлого баримталдаг.

ОУХ-нд бага улсууд зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлдэг онцлогтой. Хатуу хүч буюу цэрэг, зэвсэг, стратегийн илт давуу талдаа түшиглэн АНУ, БНХАУ, ОХУ зэрэг томоохон их гүрнүүдийн хэрэгжүүлэх бодлогод өртөгдхөх, аюулгүй байдлын тэнцвэр алдагдах аюултай тул зөөлөн хүчний бодлого нь харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх суурь нөхцөл бүрдүүлэх гол хөшүүрэг болдог. Тиймээс улс орнууд хатуу, зөөлөн хүчний бодлогыг хослуулсан ухаалаг хүчний бодлогын стратегийг түлхүү сонгож байна.

Бага улсуудын хүчийг дутуу үнэлж болохгүй бөгөөд тэд олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүд мөн. Бага улсуудын гадаад бодлогын дээр дурдсан хязгаарлалтууд Монгол улсын хувьд ч мөн адил үйлчилдэг. Улс орнуудын хүч чадавх газар нутгийн хэмжээ, байгалийн баялаг, хүн амын тоо, эдийн засгийн хөгжил, технологи, аж үйлдвэрийн чадавх, хүчтэй засаглал, цэрэг, зэвсэгт хүчний чадамжаар тодорхойлгодно. Хэдий чинээ эдгээр нөөц их байна, төдий чинээ улс орнууд хатуу хүчний буюу хүчинд дулдуудсан бодлого хэрэгжүүлдэг. Хүч чадавхыг тодорхойлох нөөц хэдий чинээ бага байна, төдий чинээ улс орнууд зөөлөн хүчний бодлогыг чухалчилж, энхийг эрхэмлэсэн, нээлттэй гадаад бодлого баримталдаг.



Тулгуур ойлголт

Ухаалаг хүчний бодлого нь улс өөрийн үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улстэр, стратеги, эдийн засаг, соёл зэрэг бүх арга хэрэгслээ тэнцвэртэй хоршуулах чадвар юм.

Зарчмын ялгаа	Хатуу хүч		Зөөлөн хүч	
	Захирах чадвар		Сэтгэл татах чадвар	
Үйлдлийн төрөл	Албадлага	Удирдамж	Зорилгыг өөрчлөн чиглүүлэх	Сэтгэл татам байдал
Өндөр хамааралтай хүчний үндэс	Цэргийн хүч, эдийн засгийн хориг	Эдийн засгийн хүч урамшуулалт	Үнэмшил Тогтолцоо	Үнэт зүйлс Соёл, төрийн бодлого

Зураг. Хатуу, зөөлөн хүчний ялгаа

Сүүлийн жилүүдэд зөөлөн болон хатуу хүчийг хослуулан ухаалаг хүчний бодлогыг хэрэгжүүлэх нь их гүрний амжилттай гадаад бодлогын арга хэрэгсэл гэж үзэх болов. Учир нь өнөө үед олон улсын харилцаанд хатуу хүч буюу цэрэг, эдийн засгийн хүч ач холбогдолтой хэвээр байгаа ч хэрэглэх, боломж нөхцөл нь хумигдсаар байна. Учир нь даяаршлын нөлөөгөөр харилцан хамаарал дээд зэргээр идэвхтэй хөгжиж буй өнөө үед үндэстэн дамнасан улс бус тоглогчид идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсон тул тэдгээрт шууд бус нөлөөлөх илүү ухаалаг арга, бодлогыг хэрэгжүүлэхд хүргэж байна. Орчин үед олон нийт ялангуяа, глобал харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн сүлжээгээр

өөрийн ард түмэн төдийгүй дэлхийн улс гүрнүүдийн олон нийтийн санаа бодолд шууд бусаар нөлөөлөх боломж бүрдсэн нь зөвлөн хүчний бодлогын үнэ цэнийг нэмэгдүүлж байна. Сүүлийн жилүүдэд хүмүүнлэгийн байгууллагуудын тоо хурдацтай өсөж, засгийн газартай бүх түвшинд, хүнд төвөгтэй нөхцөлд ч хүмүүнлэгийн чиглэлээр хамтран ажиллах болов.



Үйл ажиллагаа 6.12. Мэдээллийг уншаад асуултад хариулаарай.

Соёлын дипломат ажиллагаа



Соёлын дипломат ажиллагаа гэдэг бол улсуудын харилцааг бэхжүүлэх, нийгэм, соёлын хамтын ажиллагааг бататгах буюу үндэсний эрх ашгаа хөхиүлэн дэмжих зорилгоор үзэл санаа, үнэт зүйл, уламжлал, соёлын бусад талуудын солилцоон дээр үндэслэдэг буюу тэдгээрийг ашиглан явуулдаг үйл ажиллагаа мөн.

Эдийн засгийн дипломат ажиллагаа



Хоёр болон олон талт үйл ажиллагаанд тулгуурлан улс орныхоо худалдаа, эдийн засгийн ашиг сонирхлыг дипломат аргаар хангах явдал юм. Дэлхийн улс орнууд Гадаад бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа тэргүүлэх чиглэлийн ач холбогдол өгч, анхаарах болсон. Энэ бүхэнтэй уялдуулан ихэнх улс орнууд эдийн засгийн болон худалдааны дипломат бодлогын чиглэлээр үндэсний ашиг сонирхлоо хамгаалах мэдлэг, ур чадвартай боловсон хүчин бэлтгэхэд анхаарах болсон.

Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа



Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа гэдэг нь хүнлэг байх ёс суртахууныг эрхэмлэн ямар ч үед, аль ч нөхцөлд ядарч зүдэрсэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг дээдэлж, тэдний ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулахыг шийдвэр гаргагчид болон манлайлагчдад уриалах, тэднийг ятган үнэмшүүлэх явдал юм. Хүмүүнлэгийн дипломат харилцаа нь хүмүүнлэгийн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдэд олон нийт, төрийн дэмжлэг, нөөцийг дайчлах, эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээг хангах үр дүнтэй түншлэлийг дэмжих зорилготой.

Цахим дипломат ажиллагаа



Цахим дипломат ажиллагаа гэдэг нь Instagram, Facebook, Google+, Youtube, Twitter зэрэг цахим сүлжээгээр дамжуулан бусдад нөлөөлөх, өөрийн орны гадаад харилцааны бодлогыг сурталчлах, өөрийн орны талаар эерэг сэтгэгдэл бий болгох үйл ажиллагаа юм. Ингэхдээ гадаад харилцааны яамны албан ёсны цахим хуудсыг нээн, иргэдэд хэрэгтэй бүх мэдээ, мэдээллийг хямд, шуурхай хүргэх цахим дипломат үйл ажиллагааг улс орнууд идэвхжүүлж эхэллээ.

Асуулт:

1. Дипломат ажиллагааны хэлбэр, хамрах хүрээний талаар бодлоо илэрхийлнэ үү.
2. Дипломат ажиллагааны гол онцлог, ач холбогдол нь юу вэ?

Аливаа улсын гадаад бодлогоо хэрэгжүүлэх зөвлөн хүчний нөөц, боломжийг тодорхойлох хэд хэдэн хүчин зүйл байна. Тухайлбал, Монгол улсын төрийн институцийн хөгжлийн түүхэн үе шат, уламжлалт тогтсон хэв маяг, соёл иргэншил, зан заншлын хэм хэмжээнд тулгуурлан орчин цагийн бизнес, инновацийн дэвшил,

боловсролын үнэт зүйлстэй хослуулан оновчтой ашиглах ур чадварыг эзэмших явдал чухалд тооцогдож байна.



Бүдүүвч 6.5 Зөөлөн хүчиний төрлүүд

Монгол улс зөөлөн хүчиний бодлогод ихээхэнач холбогдолтөгч хэрэгжүүлсээр ирсний үр дүнд өнөөгийн байдлаар Монгол улсаас ЮНЕСКО-гийн хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад 7, яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад 6, “Дэлхийн дурсамж” хөтөлбөрт 4, дэлхийн соёлын өвд 3, дэлхийн байгалийн өвд 1, нийт 21 өвийг бүртгүүлээд байна. Монгол улс хамгийн их өв бүртгүүлсэн орнуудын жагсаалтад өвийн тоогоороо дээрээсээ VII байранд жагсжээ.

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах арга хэмжээ 1997 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд жил бүр 16 улсад оюутан, магистрант, докторант суралцуулахаар илгээдэг. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд гадаадын 30 гаруй орны их, дээд сургуульд нийт 1000 гаруй хүнийг суралцуулсан байна. Жил бүр 100 гаруй хүн гадагшаа суралцахаар явдаг байна. Тухайлбал, 2011-2012 оны хичээлийн жилд гадаадын их, дээд сургуульд элсэн суралцсан 117 хүнд тэтгэлэг олгожээ. Манай 3000 гаруй иргэн хоёр талын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байна. Гадаадад суралцсан монгол залуус шинэ цагийн боловсрол, мэдлэг, ур чадварыг эзэмшин, эх орондоо ирж салбар бүрд амжилттай ажиллаж байна.

Монгол улс гадаад бодлогын үзэл баримтлалдаа соёл, хүмүүнлэгийн салбарын гадаад бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

1. Түүх, соёлын дурсгалт болон үнэт зүйл, байгалийн өвийг хамгаалах, сэргээх талаар гадаад улс, ЮНЕСКО, олон улсын холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж, дэлхийн соёлын болон байгалийн өв сангийн бүртгэлд өөрийн биет, биет бус өвийг хамруулахыг зорих;
2. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад ойртуулан сайжруулах, энэ талаар ахиц дэвшилд хүрсэн улсуудын туршлагыг судалж хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх;
3. Үндэсний хөгжилд нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг хөгжингүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
4. Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

5. Бусад улс дахь монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

Аливаа улсын гадаад бодлого нь хэзээд тухайн улсын хувьд нэн таатай гадаад орчин, нөхцөл байдлыг бүрдүүлж байх үндсэн зорилготой байдаг. Тиймээс зөвлөн хүчний бодлогыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2016 оны 2 дугаар тогтоолд Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрт 4 чиглэлийг тэргүүлэх хэмээн заагаад, Монгол улсыг гадаадад сурталчлахдаа тэргүүн ээлжинд доорх чиглэлээр явуулна хэмээн тодорхойлжээ. Үүнд:

1. түүх, соёл, урлаг;
2. аялал жуулчлал;
3. үндэсний брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ;
4. спорт, олон улсын арга хэмжээ.



Үйл ажиллагаа 6.13. Мэдээлэлтэй ажиллаарай.

Монгол улсын иргэнийг соёлын элчээр томилоход дараах шаардлага тавигдана. Үүнд:

1. Нобел, Оскарын шагналтан, эсхүл үүнтэй дүйцэх хэмжээний олон улсын шагналтан байх
2. Олимпын аварга тамирчин байх
3. Сумо бөхийн макуучи зиндаанд хамгийн олон түрүүлсэн тамирчин байх
4. Олимп, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний медалтай тамирчин байх
5. Дэлхийн эхний тавьд эрэмблэгдсэн театрт тоглож буй хөгжимчин, бүжигчин, жүжигчин байх
6. Гадаад улсад 10 жилээс дээш хугацаанд оршин сууж буй, соёл, урлаг, спорт, хүмүүнлэг, түүхийн чиглэлээр ажилласан туршлагатай, тухайн улсад болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсэн иргэн байх

Эх сурваж: Соёлын элчийн тухай журмаас

Асуулт :

1. Соёлын элч гэж хэн бэ?
2. Соёлын элчийг сонгоход яагаад тусгайлсан шаардлага тавьдаг вэ?
3. Монгол улсын соёлын элчүүдийн талаар мэдээлэл цуглуулж, танилцуулна уу.



Үйл ажиллагаа 6.14. Баримтыг шинжилж, тайлбарлаарай.

“Дэлхийн монголчууд” хөтөлбөр

Хилийн чанадад байгаа монгол иргэд хэл, соёлоо өвлөн хадгалах нөхцөлийг баталгаажуулах, Монгол улсыг гадаадад сурталчлахад татан оролцуулах, монголчуудын холбоог нэгдмэл болгох, санхүүжилтийн тогтолцоог олон улсын түвшинд хүргэж, алсын харааг оновчтой тодорхойлсон. Улмаар НҮБ-д бүртгэлтэй үндэсний хосгүй үнэт зүйлд тулгуурласан үндэстний холбоо (Дэлхийн Монголчуудын чуулган) болгон хөгжүүлэх зорилт тавигдаж байна. Монгол хэл, соёл, урлаг, зан заншлыг тээгч ард түмнүүдийн соёлын солилцоо, харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, Монгол улсыг Монгол судлалын төв болгох зорилгоор дэлхийн монгол судлаачдыг дэмжих, дэлхийн өвд бүртгүүлсэн монголын соёлын өвийг хамгаалах талаар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь энэхүү “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болжээ. Хөтөлбөрийн зорилго нь хилийн чанадад байгаа монгол иргэдэд чиглэсэн цогц бодлогыг боловсруулах, Үндсэн хуульд заасан тэдгээрийн эрхийг баталгаажуулах, монгол хэл, соёл, урлаг, зан заншлыг тээгч ард түмнүүдийн соёлын солилцоо, харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдийн зүгээс эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Судалгаа

Монгол улсын талаар ямар ойлголттой болох талаар дэлхийн 36 улсын иргэдийн дунд өнгөрсөн онд нэгэн судалгаа хийжээ. Судалгаанд хамрагдсан орнуудын 80 хувь нь Монгол гэж улс байдгийг огт мэддэггүй бол улдсэн 20 хувь нь сонсож байсан гэжээ. Түүгээр зогсохгүй тэдгээр 20 хувийн гуравны хоёр нь бидний Өвөр монгол гэж боддог аж. Тэгэхээр монголчуудыг дэлхий хэн гэж харж байна вэ? Ардчилсан, эрх чөлөөт нийгэмд хөл тавиад 28 жил болж буй бид чухам юу хүсэж мөрөөддөг, мөрөөдлийнхөө төлөө хэрхэн тэмцэж чаддаг ард түмэн юм бол. Монголчуудад нэгдмэл зорилго, алсын хараа байна уу? Олон улсын хэллэгээр “National Identity” буюу үндэсний адилсал, үнэт зүйл, эв нэгдэл, зорилго тэмүүлэл юу байх вэ зэрэг асуултын хариу одоог хүртэл тодорхойгүй байна. Дэлхийн улс орнуудад өөрсдийн брэндийг бий болгож, “National Identity” буюу үндэсний адилслыг тодорхойлон бараа, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээл дээр таниулж, дагаад эдийн засгaa сайжруулах боломжийг эрэлхийлж байна. Тиймээс энэ сэдвийг Монголын эдийн засгийн 2018 оны форумын хүрээнд “Монгол улсын брэндинг” сэдвийн дор бид эдийн засгийн аварга том гүрнүүд болох хоёр хөршдөө, цаашлаад дэлхийн зах зээлд юу санал болгож байна вэ?

Эх сурвалж: <https://newspress.mn/v1/p/news/4478>

Асуулт:

1. Эх сурвалжаас ямар мэдээлэл олж авсан бэ?
2. Судалгаагаар ямар асуудлыг дэвшүүлсэн бэ? Үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ?
3. “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийн ач холбогдлыг тодорхойлно уу.

БҮЛГИЙН ДУГНЭЛТ

Сурагч та бүхэн Олон улсын харилцаа бүлгийг судаллаа. Энэхүү бүлгийг судалснаар:

- Монгол улсын “гуравдагч хөрш”-тэй харилцах, “төвийг сахих” болон “зөвлөн хүч”-ний (боловсрол, соёл, спорт, хүмүүнлэг г.м) гадаад бодлогын талаар танин мэдэж;
- Монгол улсын “гуравдагч хөрш”-тэй харилцах, “төвийг сахих” болон “зөвлөн хүч”-ний (боловсрол, соёл, спорт, хүмүүнлэг г.м) бодлогын талаар баримт, эх сурвалжийг судлан, өөрийн болон улс орны амьдралд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, үнэлэлт өгч, үзэл бодол, байр сууриа илэрхийлж;
- Монгол улсын гадаад бодлогыг тайлбарлах, асуудал шийдвэрлэх чадвараа хөгжүүлсэн гэдэгт итгэж байна.

Олон улсын харилцаа нь улс орны гадаад бодлого, үндэсний аюулгүй байдал, ард түмний эрх, эрх ашигтай холбоотой олон талт, нарийн төвөгтэй үйл явц бөгөөд энэ талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй байж, дүн шинжилгээ, тайлбар хийх арга барил, чадвартай байх нь иргэн хүний үнэт чанар, үүрэг юм. Ингэснээр та улс орныхоо гадаад харилцааны оролцогч байхад бэлтгэх төдийгүй ийм төрлийн харилцаанд оролцохдоо нэн тэргүүнд улс орныхоо аюулгүй байдал, ард түмнийхээ болон өөрийн эрх, эрх ашигийг хангах, хамгаалах болно. Мөн улам бүр даяаршиж буй дэлхий ертөнцөд өөрийн орон зайгаа бүтээх, хамгаалахад гадаад харилцааны талаарх мэдлэг, чадвар тань туслах болно.

Дараах даалгавруудыг гүйцэтгэж, мэдлэг, чадвараа бататгаарай.

I. ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭЭРЭЙ.



1. Баримтыг шинжлээд асуултад хариулаарай.

Түрк зөвлөн хүчний бодлогын хувьд хамгийн их маргаантай ч олон улсад тэргүүлэх байр суурьтай явдаг “БНТУ-ын гадаад харилцаа нь өөрийн гэсэн өвөрмөц хэв шинжтэй. Гадаад харилцааны бодлого хэрэгжихэд хөрш зэргэлдээ орууд нь нөлөөлсөн. Найман улстай хиллэдэг. Түрк улс Европын улсуудтай түлхүү хамтарч ажилладаг. Түрк улсад Зөвлөн хүчний бодлогын маргаан бий. Зарим эрдэмтэд “хүчирхэг улс орнуудыг ирээдүйд өөрийн болго гэсэн стратегийн бодлогыг бий болгосон байдаг. Түрк улс дэлхийн томоохон улс орнуудын зөвлөн хүчний бодлогоороо тэргүүлэх байр суурьтай явдаг. Исламын шашинтай орнуудын хөгжлийн загвар болж чадсан улс гэдэг”. Хүн амын 98 хувь нь Исламын шашинтай мөртлөө Зөвлөн хүчний бодлогын үр дүн сайн гарсан юм. Европт хандсан Зөвлөн хүчний бодлого нь соёлын аялал жуулчлал. Тухайлбал, нэг өдөрт хоёр сая гаруй хүн орж, гарч байдаг. Учир нь маш хямд өртөгтэй, хөнгөлөлт үзүүлдэг байна. Эдгээр нь ихээхэн нөлөөлдөг. Африкт чиглэсэн бодлого бий. Исламын шашинтай хүмүүсийг үнэ төлбөргүй сургах зэрэг аргыг хэрэглэдэг. Мөн Азид чиглэсэн бодлого дээр анхаарал хандуулдаг” гэж байв.

МУИС-ийн Ази судлалын тэнхимиийн профессор, доктор Ц.Баттулга

БНСУ олон улсад нэр хүндээ өсгөх, ард түмнээ оролцуулах гэсэн үзэл баримтлалтай. Солонгосын зөвлөн хүчний бодлого хамгийн ихээр илэрч гардаг нь олон нийтийн дипломат ажиллагаатай холбоотой. Солонгосын зөвлөн хүчний бодлогыг илэрхийлэх хоёр том ажиллагаа бий. Нэгдүгээрт, дунд хүчний улсын бодлого. Хоёрдугаарт, олон нийтийн дипломат ажиллагаа. Олон нийтийн дипломат бодлого зөвлөн хүчиний зорилготой адил. Тодруулбал, өөрийн улсын зорилго, агуулж буй бодлого төдийгүй үзэл баримтлал, соёлын талаарх ойлголтыг дээшлүүлэхийн тулд Засгийн газраас гадаад улсын олон нийттэй харилцан ойлголцох үйл явц юм. Олон нийтийн дипломат ажиллагаа бол шинэ зүйл биш ч гэсэн тодорхой хэмжээгээр явагдаа ирсэн. Солонгос улс Олон нийтийн дипломат ажиллагааны хуулийг 2016 онд баталсан. Үүний үндсэн зорилго нь ард түмэнтэйгээ хамтдаа, дэлхий нийттэй ойлголцох, сэтгэл татам БНСУ гэж тодорхойлдог. Нэг ёсондоо олон улсын үнэлэмж, олон улсад нэр хүндээ өсгөх, ард түмнийг оролцуулах гэсэн үзэл баримтлалтай. Ард иргэд гэдгийг ихээхэн онцолдог. Дэд бүтцийг олон улсын түвшинд байгуулах ёстой гэдэг дээр анхаардаг. Орчин үе ба уламжлалыг хослуулж чадсан улс”

МУИС-ийн Ази судлалын тэнхимиийн багш, докторант

Б.Оюунцэцэг

Дээрх судлаачдын үзэлд задлан шинжлэл хийж, дараах асуултын дагуу дүн шинжилгээ хийнэ үү.

- “Зөвлөн хүчний бодлого” ойлголтыг тодорхойлно уу. Зөвлөн хүчиний ямар төрлүүд дурдагдсан байна вэ?
- Ухаалаг хүчиний бодлого гэж юу вэ? Мэдээллээс эш татан тайлбарлана уу?
- Гуравдагч хөршөөр ямар улс орнуудыг дурдсан байна вэ, яагаад гуравдагч хөрш гэж үзэж байгаагаа тайлбарлана уу.
- Өөрийн мэдлэг, ойлголтоо ашиглаад аль орны зөвлөн хүчиний бодлого чухал нөлөөтэй болохыг нотлон тайлбарлана уу.
- Манай улсын хувьд зөвлөн хүчиний ямар бодлого, чиглэл баримтлах нь илүү чухал вэ? Үүнийг хэрхэн хэрэгжүүлбэл илүү ач холбогдолтой вэ?

2. Судалгаа хийгээрэй. Судалгааг гүйцэтгэх удирдамж

Судалгааны хүрээ сэдэв:

1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, тэдгээрийн Монгол улсын хөгжилд оруулж буй хувь нэмэр
2. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд ба Монгол улсын хамтын ажиллагаа, түүний үр өгөөж
3. Монгол улсын боловсролын чиглэлээр явуулж буй гадаад харилцаа, түүний таны амьдралд үзүүлэх нелөө

Судалгааны үе шат:

- I. Дээрх сэдвээс аль нэгийг сонгож, тулгамдаж байгаа гол асуудлыг олж, судлах зүйлийг тодорхойлно.
- II. Холбогдох хүмүүс, бичвэр болон дижитал гэх мэт мэдээллийн олон төрлийн эх сурвалжаас баримт, нотолгоо цуглуулна.
- III. Цуглуулсан материалдаа дүн шинжилгээ хийнэ.
- IV. Асуудлыг шийдэх гарц, шийдлийг тодорхойлж, давуу ба сул талыг үнэлнэ.
- V. Судалгааны тайлан илтгэл боловсруулж, танилцуулна.

Санамж:

1. Бүлгийг судалж эхлэхэд судалгааны сэдэвийг сонгосон байна.
2. Судалгааг хийхдээ сурах бичгийн “Нийгэм, нийгмийн харилцаа” бүлгээр судалсан нийгмийн судалгааны арга зүйгээс сонгож, багшдаа болон ангидаа урьдчилан танилцуулна.
3. Бүлгийн төгсгөлд судалгааны үр дүнгээ танилцуулж, үнэлүүлнэ
4. Судалгааг багаар гүйцэтгэж болно.

Судалгааны даалгаврын үнэлгээ:

Судалгааны даалгаврын үнэлгээ нь явцын болон бүлгийн эцсийн үнэлгээнд тооцогдоно. Явцын үнэлгээ нь судалгааны явцыг танилцуулах, хэлэлцүүлэх ажлын үнэлгээ байна.

- Эцсийн үнэлгээ нь судалгааны үр дүнгийн танилцуулга байна.

3. Эсээ бичээрэй

Зааварчилгаа:

- Эсээнд ашиглах эх сурвалжийг уншиж судлан, утгыг бүрэн ойлгох
- Гол санаа, ойлголт, нотолгоог задлан шинжлэх, эсээнд хөндөх үндсэн асуудлаа оновчтой томъёолж, дэвшүүлэх
- Доорх чиглүүлэх асуултын дагуу цэгтэй, үндэслэлтэй хариулж бичих

Эсээнд ашиглах эх сурвалж:

1. Монголчууд хэзээнээс цөөхүүлээ байсан ч дэлхийн түүхэнд эзэнт гүрнийг байгуулж, урт хугацаанд PAX Mongolica гэж нэрлэгдэх дэлхийн дэг журмыг тогтоож, өнөөг хүртэл тогтвортой ирсний цаана, зэр зэвсэг биш, хөрөнгө хүч биш харин эзэн Чингис хааны морь зэвсэгийн хүчийг зөөлөн хүчний бодлоготой, зохицуулж, ашиглаж байсны гавьяа. Их засаг хууль, шашны хүлцэл, хөрш орнуудаас залагдан Монголын төрд хүчээ өгч байсан мэргэд гээд..... түүхийн олон баримт, эх сурвалжууд бий. М.Батчимэг “Шатрын өрөг дэх Монгол улс” 2012 он
2. “Чингис хаан зүг бүрд элч томилж, ил үндэстнийг илбэн дагуулах зар бичиг тараахдаа ер сүрдүүлж далайлгах хэмээдэггүй. Энэ нь эрт үеийн харгис эздийнхтэй адилгүй” Персийн түүх Жүүвейни
3. “Олон улсын харилцаан дахь эмх цэгцүй, дээд засаглалгүй байдлыг олон улсын дэг журам, эрх зүй, хэм хэмжээ, эдийн засгийн харилцаан хамаарал, боловсрол, соёлоор дамжуулан засаж болно ”European Journal of International Relations.issue 2010.
- a) Дээрх эх сурвалж, баримтын мэдээллийг нэг бүрчлэн сайн уншиж, холбоо хамаарлыг олж, ямар нийтлэг сэдэв, асуудал хөндсэн болохыг тодорхойлно.
- b) Олон улсын харилцааны мэдлэг, ойлголтоо ашиглан уг асуудалд задлан шинжилж, гол хүчин зүйлийг нэмэлт жишээ, баримтаар баяжуулан тайлбарлана.
- v) Цаашид улам боловсронгуй болгох нь олон улсын харилцаанд яагаад чухал болохыг дүгнэн бично.
- g) Бусад сурагчид, багшийн саналд тулгуурлан сайжруулна. Өөрийн цахим хуудсанд байрлуулж, бусдын санал, дүгнэлтийг авна уу.

II. ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭЭРЭЙ.



Сорил даалгавар

1. Улс бус оролцогч гэж юу вэ?
2. ОУХ-нд улс бус оролцогчийн гүйцэтгэх үүрэг, үр нөлөө улам бүр нэмэгдэх болсон үндсэн 2-3 шалтгааныг сонгож, жишээ гарган тайлбарлана уу.
3. ОУБ засгийн газрын байгууллагаас ямар ялгаатай вэ? Төрийн хариултаа жишээгээр тайлбарлана уу.
4. Гуравдагч хөрш гэдэг нь аль нэг гуравдагч орныг хэлж буй хэрэг биш, харин улс төр, эдийн засаг, геополитик, аюулгүй байдлын хүрээг хамарсан өргөн ойлголт юм гэсэн тодорхойлолтыг баримт, жишээ татаж, тайлбарлана уу.
5. Манай улсын эдийн засгийн харилцаа хөгжлийн хэрээр дэлхийн олон орны хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж, үндэстэн дамнасан гадаадын компаниуд олноороо улс орны эдийн засагт оролцох болсон учир шалтгааныг тайлбарлаж бичнэ үү.
6. Гуравдагч хөршийн бодлого, хөрш улсын бодлогоос ямар ялгаатай вэ? Үндэслэл, нотолгоо гарган тайлбарлана уу.
7. Зөөлөн хүчиний бодлогын гол чиглэлийг нэрлэж, жишээ татан тайлбарлана уу.
8. Монгол улсын гадаад бодлогод 1990 оноос хойш өргөн хэрэглэгдэх болсон гол нэр томъёо юу вэ?
 - A. Гуравдагч хөрш В.Оюун санааны хөрш С. Хөрш орон D. Хоёр хөршийн харилцаа
9. 1992 оны Үндсэн хуулиар Монгол улс гадаад бодлогын үзэл баримтлалын үндсэн агуулгаа баталсан ба тэрхүү агуулгад үл тохиорох бодомжийг олно уу.
 - A. Тусгаар тогтносон В. Энхийг эрхэмлэсэн С. Олон тулгуурт D. Бие даасан
10. Монгол улс нь олон улсын харилцааны нэгэн оролцогч мөн. Монгол улс нь 20 орчим олон улсын байгууллагын гишүүн бөгөөд 10 орчим олон улсын байгууллагатай эрчимтэй хамтран ажилладаг. 2015 оны байдлаар Монголд Улс дэлхийн 181 оронтой дипломат харилцаатай. Гадаадын 31 оронд Монгол улсын Элчин сайдын яам болон гадаадын 8 оронд 11 Ерөнхий Консулын газрууд, 5 Консулын төлөөлөгч үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн үүнээс гадна Монгол улсын 75 Өргөмжит консул гадаад орнуудад үйл ажиллагаагаа явуулж байна. Улаанбаатарт гадаадын 23 орны Элчин сайдын яам, орон нутагт гадаадын 3 Ерөнхий консулын газар үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол улсын энгийн паспорттай иргэд дэлхийн 19 оронд визгүй зорчиж байгаа бөгөөд албан, дипломат паспорттай иргэд дэлхийн 45 оронд визгүй зорчиж байна.
 - a. Тоон өгөгдөл дун шинжилгээ хийж, гадаад бодлогын стратегийг тодорхойлно уу.
 - b. ОУБ -ын өсөлтийг харуулсан диаграмм зохиож, дүгнэлт бичнэ үү.
 - c. Дипломат төлөөлөгчийн газруудын орон зайн өөрчлөлтөд юу нөлөөлсөн бэ?
 - d. Монгол улсын иргэдийн 19 оронд визгүй зорчдог гуравдагч хөршийн орнуудаас өөрийн хамгийн сайн мэдэх 5 орныг нэрлэн бичнэ үү
11. Америкийн мэргэжлийн сагсан бөмбөгийн од, “ахмад” тамирчин Деннис Родман дэлхий нийтийн анхаарлын төвд эргэн ирээд баагүй хугацаа өнгөрч байна. Өдгөө 54 настай, хэдийнээ зодог тайлсан тэрээр энэ удаа уран гоё тогтолцоор биш, АНУ-ын түүхэн дайсан, дэлхийн хамгийн хаалттай улс гэгддэг Хойд Солонгосын дарангуйлагч хэмээн цоллуулаад буй залуу удирдагч Ким Чен Ун болон түүний гэр бүлийнхэнтэй биечлэн уулзаад зогсохгүй, дотно нөхөрлөж чадсан цорын ганц америк хүн гэдгээрээ анхаарал татаад байгаа билээ. Албан ёсны баримтаар Деннис Родман Хойд Солонгост хэд хэдэн удаа айлчилж, тус улсын үндэсний сагсан бөмбөгийн шигшээ багтай “Пхеньян дахь том тэсрэлт” нэртэй нөхөрсөг тогтолц зохион байгуулж байсан билээ.
 1. Деннис Родман олон улсын харилцааны оролцогч мөн эсэхийг тайлбарлан бичнэ үү.
 2. Улс орнуудын Засгийн газар улс үндэстнийхээ харилцаанд урлаг, спорт, соёлын төлөөлөгчдөө татан оролцуулах болсон гол шалтгаан юу вэ?

НОМ ЗҮЙ

1. Ч.Алтангэрэл, Л.Алтанзаяа, Н.Мягмарцоож ба бусад. Нийгмийн ухаан, VI Сурах бичиг. УБ., 2014
2. Н.Ашфорд. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. УБ., 2007
3. Г.Баасанхүү ба бусад. Олон улсын харилцааны үндэс ба даяаршил. УБ., 2016
4. Ф.Бастия Хууль, УБ., 2008
5. М.Батсуурь, Ч.Өнөрбаяр. Эрх зүйт ёс УБ., 2010
6. Б.Батчуулун. Эрх чөлөөний дайсан. УБ., 2010
7. Боаз Д. Либертарианизм эхлэн суралцах бичиг (Хувь хүний эрх чөлөөний философи), УБ., 2005
8. Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 2016.
9. Ж.Бор. Жижиг улсын аюулгүй байдал: өнөө ба ирээдүй., УБ., 2001
10. А.Гидденс. Социологи. УБ., 2006.
11. П.С. Гуревич. Соёл судлал I, II дэвтэр УБ., 2012
12. Х.Гундсамбуу. Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (ХХ зуун). УБ., 2001.
13. В.А. Канке Философи. Сурах бичиг. УБ., 2009
14. Н.Лүндэндорж, Төрийн онол, УБ., 2008
15. МУЗГ, НҮБХХ. Монгол улсын хүний хөгжлийн илтгэл. 2016
16. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал 2011
17. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010
18. Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал УБ, 2011-2017
19. Ш.Монтеське, Хуулийн амин сүнс, УБ., 2015
20. Л. Мизес Либерализм, УБ., 2006
21. МУИС. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2010
22. О.Мөнхбат. Нийгмийн социаль бүтцийн социологи. УБ., 2000
23. МУЗГ. НҮБХХ. Монгол улсын хүний хөгжлийн илтгэл. УБ., 2016
24. Д. Нарантуяа. Чанарын аргын судалгаа. УБ., 2012
25. О.Өнөрцэцэг Олон улсын эрх зүй УБ., 2015
26. О.Пүрэв, Г.Сайнхишиг ба бусад. Нийгмийн ухаан-ХI анги. УБ., 2009
27. Ц.Пүрэв. Монголын нийгмийг социологиор шинжлэхүй. УБ., 2013
28. Жан Жак Руссо, “Нийгмийн гэрээ”, УБ., 2016
29. Н.Смелзер. Социологи. УБ., 2018.
30. Соёлын бодлого, соёл урлагийн байгууллагын санхүүжилт. УБ., 2003
31. С.Түмэндэлгэр, Д.Бямбажав, Д.Болормаа. Сургалтын үнэлгээний олон хувилбарууд: Нийгмийн тухайн мэдлэг хичээлийн жишээн дээр. УБ., 2006
32. УИХ. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
33. УТБА-ын лекцийн эмхэтгэл. УБ., 2001
34. Удирдлагын академи. Улаанбаатар хотын дунд давхрааны судалгаа. УБ., 2017
35. YCX. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. УБ., 2010
36. YCX. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. УБ., 2011
37. YCX. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. УБ., 2012
38. ФСЭХ. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013
39. Э.Фромм. Эрх чөлөөнөөс дайжихуй. УБ. 2010
40. Хүйсийн тэгш эрхийн төв. Т.Амаржаргал, С.Түмэндэлгэр. Жендерийн тэгш эрх хөгжлийн агуулга болох нь УБ., 2008
41. ХЭҮК. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын тухай илтгэл УБ., 2010-2017
42. Хүний эрхийг хамгаалагчид: Хүний эрхийг хамгаалах эрхийг баталгаажуулах нь УБ., 2007
43. Хүний эрхийн тайлбар толь, ХЭҮК, 2012 он
44. Э.Чулуунцэцэг, Эрх зүйн онол гарын авлага, УБ., 2017

45. Шинэ институцийн эдийн засаг., ред. Ч.Нарантуяа УБ., 2009
46. О. Шпенглер. Закат Европы \Европын доройтол\ Т.1, М.,1993.
47. Ж.Е.Штиглиц, Төрийн эдийн засгийн онол. УБ., 2009
48. ХЭХТ. Жендэр судлалын бүтээлийн эмхэтгэл. УБ., 2006
49. ЮНЕСКО-гийн Дэлхий дахины тайлан илтгэл “Соёлын төрөл зүйл соёл хоорондын харилцааг тэтгэхүү” Люксембург., 2009
50. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. УБ., 2012

Гадаад хэлээр

1. Brinkerhoff D, White L. Sociology. 3rd edition. 1991. WEST publishing company.
2. Cambridge International AS and A Level Global Perspectives & Research 9239 syllabus
3. Harold R. Kerbo. Social Stratification and Inequality: Class conflict in Historical Comparative, and Global Perspective. Fourth edition. 2000. McGraw Hill.
4. John Baylis. The Globalization of World Politics: An Introduction to International Relations, 2008
5. M.Rotbard, Power and market, 1970
6. Vander Zanden J. The Social Experience: An Introduction to Sociology. 1999. McGraw-Hill.

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
3. Францын “Хүний болон иргэний эрхийн тунхаг бичиг”, 1789 он
4. Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 1992 он
5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль, 1997 он
6. Иргэний хууль, 2002 он
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
8. Эрүүгийн хууль, 2015 он
9. Зөрчлийн тухай хууль, 2017 он
10. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2003 он
11. Зохиогчийн болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, 2006 он
12. Патентийн тухай хууль, 2006 он
13. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966 он
14. Эдийн засаг, нийгэм, соёлынэрхийн олон улсын пакт, 1966 он
15. Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөр, 2015 он
16. “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, 2012 он

Цахим эх сурвалж

1. YCX. Эрхийн нийгэм эдийн засгийн судалгаа. <http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/HSES/dataset>
2. YCX. Ажиллах хүчний судалгаа. <http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/LFS/dataset>
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. Цалин хөлсний бүтцийн судалгаа. <http://rilsp.gov.mn/studies-mn/labor/>
4. МУИС, Эдийн засгийн хүрээлэнгийн цахим номын сан. <http://www.eri.mn/library>
5. Нээлттэй нийгэм форум. Цахим номын сан. http://www.openforum.mn/index.php?sel=resource&menu_id=3
6. Хараат бус судалгааны хүрээлэн. Судалгааны тайлангууд. <http://www.irim.mn/other-reports>
7. www.socialisterna.org,
8. <http://globalperspektiv.se>,
9. <http://www.politism.se>
10. <http://www.gec.gov.mn>
11. <http://1212.mn>.